



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ БОЛОН ОЙН ГАЗАР
ДАХЬ ПРОЦЕССЫН ДАХИН
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭ**

ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ БОЛОН ОЙН ГАЗАР ХИЙГДСЭН ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

ТАЙЛАН

Танилцсан:	МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	Э.ОДБАЯР
	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	С.ОДОНТУЯА
Хянасан:	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА	Ч.ӨНӨРБАЯР
Эмхэтгэсэн:	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газар	
Оролцогчид:	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар Шинжлэх ухааны байгууллагууд Бусад байгаль орчны салбарын төв, орон нутгийн байгууллагууд	

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газар дахь процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан Төслийн удирдлагын баг энэхүү тайланг боловсруулав.

2025 оны 05 дугаар сар.

ГАРЧИГ

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	X
Хүснэгтийн жагсаалт.....	xii
Зургийн жагсаалт.....	xiii
УДИРТГАЛ.....	16
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	17
Төслийн зорилго, хамрах хүрээ.....	17
Төслийн удирдлагын баг, зохион байгуулалт.....	18
Баримтлах зарчим.....	18
Төрийн цахим үйлчилгээний хэрэгжүүлэлт.....	20
Арга зүй.....	1
1 БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР, ТОГТОЛЦОО.....	10
1.1 Байгаль орчны өнөөгийн нөхцөл байдал.....	10
1.2 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг 13	
1.3 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг.....	16
1.4 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа Улсын төсөвт болон Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бүтэц, чиг үүрэг, орон тоо.....	18
2 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ БУЮУ AS-IS.....	21
2.1 БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	21
2.1.1 Монгол Урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийн чиг хандлага.....	21
2.1.2 Монгол Улсын байгаль орчны чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц.....	22
2.1.3 Байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ.....	27
2.1.4 Байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, түүний уялдаа.....	38
2.1.5 Салбар дундын уялдаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал.....	48
2.1.6 Туршлага, сургамж.....	56
2.2 САНХҮҮЖИЛТ.....	63
2.2.1 Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, үр дүн.....	63
2.2.2 Олон улсын төсөл хөтөлбөр, түүний үр дүн.....	71
2.3 ХҮНИЙ НӨӨЦ.....	75
2.3.1 Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт.....	75
2.3.2 Байгаль орчны салбарын хүчний нөөцийн өнөөгийн байдал.....	75
2.3.3 Байгаль орчны салбарын албан хаагчдын бүтээмжийн судалгаа.....	84
2.4 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ.....	111
2.4.1 Төрийн үйлчилгээний эрх зүйн орчны шинжилгээ.....	111
2.4.2 Зөвшөөрөл олгох процесс зураглалын шинжилгээ.....	117
2.4.3 Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо.....	125
2.4.4 Иргэн, ААНБ-ын судалгаа.....	135
2.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН САН.....	167
2.6 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....	170
2.7 ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА.....	179
3. ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН САНАЛ БУЮУ ТО-ВЕ..	190

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	205
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	214
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	221
ХАВСРАЛТ.....	223
1. Төслийн удирдлагын багийн бүрэлдэхүүн.....	224
2. Тусгай зөвшөөрлийн процесс зураглал.....	228
3. Тоон мэдээллүүд.....	332
4. Судалгааны дэлгэрэнгүй.....	358
4.1. Судалгааны удирдамж, асуулгын хуудас.....	358
4.2. Судалгааны үр дүнгийн хүснэгт.....	386

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, иргэдэд шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ хүргэх, цахим засаглал болон дижитал шилжилтийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн билээ.

Эдгээр зорилтууд нь Засгийн газраас баримталж буй тэргүүлэх зорилтын нэг болох төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэх үйл ажиллагааны үндэс суурь болж байна.

Энэхүү бодлогын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газарт төрийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Процессын дахин инженерчлэлийн судалгааг хийж, гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд салбарын хууль, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, төрийн үйлчилгээний цахимжуулалт болон байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчлолд суурилсан инновацлаг шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагыг тодорхойлон шийдлийг санал болгохыг зорьсон юм.

Салбарын бодлого, стратеги, мэдээллийн урсгал, хүний нөөц, үйл ажиллагааны уялдаа холбоо зэрэг олон хүчин зүйлсийг нарийвчлан судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Үүний үр дүнг үндэслэн салбарын хэмжээнд эрх зүйн болон бодлого, үйл ажиллагааны цогц шинэчлэл хийх, зөвхөн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэл, төрийн үйлчилгээний хүртээмжид эерэг нөлөө үзүүлэхүйц шийдлүүдийг боловсруулаад байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, 2030 он гэхэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассемблейн индэр дээрээс амласан зорилтыг биелүүлэхэд шаардлагатай цахим хяналт, дата удирдлагын систем, олон талт оролцогчдын уялдааг хангах GovTech шийдлийг санал болгосон. Энэ нь илүү үр дүнтэй зохион байгуулалт, ил тод байдал, иргэдийн оролцоог хангахад чухал алхам болох юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах, байгууллагын бүтцийг оновчтой болгох, мэдээлэл солилцооны урсгалыг сайжруулах зэрэг тодорхой шийдлүүдийг боловсруулсан бөгөөд эдгээр нь бусад төрийн байгууллагад хэрэгжүүлж болохуйц арга зүйн санал, жишиг болох боломжтой юм.

Эдгээр шийдлийг боловсруулахдаа тус салбарын төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, байгууллагын соёл, ажиллах орчны нөхцөл, тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлс нь төрийн бүтээмжид хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан судалсан болно.

Өнөө үед төрийн байгууллагууд “design thinking” буюу загварчлан сэтгэх арга зүй болон бусад орчин үеийн хандлагыг ашиглан төрийн үйлчилгээний загварыг сайжруулах, зорилтот бүлгийн иргэдэд хүртээмжтэй болгоход анхаарч байна.

Иймд төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цахим ур чадварыг хөгжүүлэх, инновацыг дэмжих талаарх зөвлөмжүүдийг судалгааны тайланд тусгасан болно.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн хамтарсан ажлын хэсэг, судалгаанд оролцогч яам, агентлагийн албан хаагчид, байгаль орчны салбарын нийт хамт олон, иргэд, аж ахуйн нэгжүүд, эрдэмтэн судлаачид, дотоодын болон олон улсын байгууллагын төлөөлөлд талархал илэрхийлье.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах” эрхийг хангах төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд энэхүү процессын дахин

инженерчлэл нь чухал ач холбогдолтой өөрчлөлт, шинэчлэлийн эхлэл болж, бодит үр дүнг гарна гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН САЙД,
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Э.ОДБАЯР

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОУАС	Байгаль орчин, уур амьсгалын сан
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
ДЦГ	Дархан цаазат газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХБ	Ногоон хөгжлийн бодлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОГ	Ойн газар
ПДИ	Процессын дахин инженерчлэл
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УИХ	Улсын Их Хурал

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Процесс	Процесс нь нэг ба түүнээс дээш орцыг хүлээн авч, үйлчлүүлэгчид үнэ цэнтэй гарц бий болгож буй багц үйл ажиллагаа юм. Тодорхой, давтагдмал, тодорхойлох боломжтой байхын зэрэгцээ орц, гарцын элементүүд нь хэмжигдэхүйц байх ёстой.
Алсын хараа	Зорилтот процессын стратегийн зорилго
Үйлчлүүлэгч	Эцсийн гарц, үр дүнг хүлээх хэрэглэгч, мөн нэгжүүд
Хэмжүүр	Шийдвэрлэх хугацааг богиносгох, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, ажил, үйлчилгээний тоо гэх мэт
Орчны шинжилгээ	Өөрчлөгдөж буй орчны нөхцөлд байгууллага оршин тогтнох, өсөж хөгжихөд нөлөөлдөг хүчин зүйлсэд шинжилгээ хийх, түүнчлэн өөрчлөлтийн хамрах хүрээ, хурд, онцлог, ялгаа зэргийг олон талаас системтэй судлах үйл явцыг илэрхийлнэ.
Оролцогч талуудын шинжилгээ	Оролцогч талууд нь байгууллагад шууд, шууд бус хэлбэрээр нөлөөлж байдаг гол субъектүүд бөгөөд талуудыг үр дүнтэй удирдаж, зохицуулалт хийхийн тулд тэдний зүгээс тавих шаардлага, эрэлт хэрэгцээг системтэй шинжлэх үйл явц юм.
Стратеги	Байгууллагын дотоод, гадаад орчны нөхцөл байдлыг харгалзан тухайн байгууллага тавьсан зорилгодоо хүрэхэд төвлөрөх ёстой үйлчлүүлэгч, үнэт зүйл, ажил үйлчилгээ, үйл ажиллагааг ханган нийлүүлэх зэрэгт хамгийн тохирох арга барилыг сонгож буй зүйл
AS-IS зураглал	Дахин инженерчлэл хийхээс өмнөх сайжруулах шаардлагатай төрийн үйлчилгээний ажлын урсгал, үйл явцын зураглалыг гаргах
KPI	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд: төрийн байгууллагын бүтэц, албан хаагчдын ажлын үр дүн, түүнчлэн тэдний ажлын үйл ажиллагаа, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг үнэлэхэд чиглэсэн үзүүлэлтүүд
TO-BE зураглал	Дахин инженерчлэлийн үйл явцын үр дүнд бий болсон бүх өөрчлөлтийг урсгал зураглал хэлбэрээр тусгасан төрийн үйлчилгээг цаашид зохион байгуулах санал
Чиг үүрэг	Төрөөс тогтмол гүйцэтгэж буй ажил үүрэг
Ерөнхий чиг үүрэг	Яам, газар, алба, товчооны түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг, мөн төсвийн систем дэх хөтөлбөрийн түвшний чиг үүрэг (Жишээ нь: байгууллагын удирдлага, цахим засаглал гэх мэт)
Үндсэн чиг үүрэг	Яамны хэлтэс, багийн түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг, ингэхдээ харьяа дээд шатлалын ерөнхий чиг үүргийг гүйцэтгэх нарийвчилсан чиг үүрэг (Жишээ нь: байгууллагын тогтолцоо, зохион байгуулалтын систем гэх мэт)
Дэд чиг үүрэг	Хууль тогтоомж, зохион байгуулалт зэргийг хийх эрх зүйн үндэслэл, бүртгэл мэдээлэл ангилах шалгуурыг харгалзан тодорхойлсон чиг үүрэг (Жишээ нь: байгууллага, ажиллах хүчний удирдлагын тогтолцооны судалгаа, үйл ажиллагаа гэх мэт)
Бүтэц	Ажил үүрэг, ажлын даалгавар гүйцэтгэх явцад шаардагдах эрх үүрэг, оролцоо, хүлээх хариуцлагыг хуваарилж, шийдвэр гаргах арга хэлбэрийг тогтоож буй тухайн байгууллагын үндсэн зохион байгуулалт
EPI	Environmental Performance Index- Байгаль орчны гүйцэтгэлийн индекс нь улс орнуудын засгийн газраас явуулж буй байгаль орчны бодлогын хэрэгжилтийг хэмжиж, харьцуулан үнэлдэг индекс юм.
Эрсдэл	Зорилтыг тодорхой бус болгож байгаа үр нөлөө
Эрсдэлийн менежмент	Эрсдэлийг хянах, удирдахад чиглэсэн байгууллагаас авч хэрэгжүүлж буй зохицуулалтын үйл ажиллагаа.

Зөвшөөрөл	Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг хэлнэ.
Энгийн зөвшөөрөл	Нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулах
Тусгай зөвшөөрөл	Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулах

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Эрсдэл тохиолдох магадлалын үнэлгээ	6
Хүснэгт 2. Эрсдэлийн үр нөлөө	7
Хүснэгт 3. Эрсдэлийн дулааны матриц	7
Хүснэгт 4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, чиглэл	13
Хүснэгт 5. Яамны стратегийн чиг үүрэг	15
Хүснэгт 6. Ойн газрын стратегийн чиглэл	17
Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил	22
Хүснэгт 8. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил	23
Хүснэгт 9. Олон улсын худалдаа ба зэрлэг амьтны хамгаалах чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил	24
Хүснэгт 10. Химийн бодис, аюултай хаягдлын зохицуулалтын чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил	24
Хүснэгт 11. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичиг	32
Хүснэгт 12. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдын батласан эрх зүйн баримт бичиг	33
Хүснэгт 13. Бусад эрх зүйн баримт бичиг	33
Хүснэгт 14. Хуулиар эрх олгогдсон боловч батлагдаагүй эрх зүйн актын төрөл, батлах субъектын харьцуулалт:	34
Хүснэгт 15. Байгаль орчны багц хуулиар эрх олгогдсон эрх зүйн акт	35
Хүснэгт 16. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжилтийн үнэлгээ бодлогын баримт бичгийн төрлөөр	40
Хүснэгт 17. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах баримт бичгүүд, 4 ангиллаар	44
Хүснэгт 18. Яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт хуулиар тусгайлан заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байдал	46
Хүснэгт 19. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, оролцоо	49
Хүснэгт 20. Байгаль орчны салбарын зардлын бүтэц	65
Хүснэгт 21. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт ба хэрэгжилт (2015–2023)	66
Хүснэгт 22. Байгаль орчны татвар, татварын орлогын төрлөөр	69
Хүснэгт 23. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслүүд /сая төгрөг/	72
Хүснэгт 24. БОУАӨЯ-ны чиг үүргийн шинжилгээнд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл (2025 оны 04 дүгээр сарын 17-ны байдлаар)	76
Хүснэгт 25. БОУАӨЯ-ны газар, хэлтсүүдийн чиг үүргийн уялдаа, оролцооны RACI	78
Хүснэгт 26. RACI шинжилгээний дүгнэлт, зөвлөмж	78
Хүснэгт 27. Ойн газрын чиг үүргийн шинжилгээнд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл (2025 оны 04 дүгээр сарын 17-ны байдлаар)	82
Хүснэгт 28. Ойн газрын хэлтсүүдийн чиг үүргийн уялдаа, оролцооны RACI	82
Хүснэгт 29. RACI чиг үүргийн давхцал (хувиар)	83
Хүснэгт 30. Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	93
Хүснэгт 31. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	95
Хүснэгт 32. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар	95
Хүснэгт 33. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	97
Хүснэгт 34. Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	97
Хүснэгт 35. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	99
Хүснэгт 36. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	99
Хүснэгт 37. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	101
Хүснэгт 38. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	101
Хүснэгт 39. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	103
Хүснэгт 40. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	103
Хүснэгт 41. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ажилтанг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	105
Хүснэгт 42. Гадаад орчинтой холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	105
Хүснэгт 43. Гадаад орчинтой холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл	106
Хүснэгт 44. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын гадаад орчин бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс	106
Хүснэгт 45. Эрх зүйн баримт бичгүүдийн нийцэл	111
Хүснэгт 46. Тусгай зөвшөөрлийн жагсаалт, эрх бүхий байгууллагаас олгож буй тооны харьцуулалт	113
Хүснэгт 47. Энгийн зөвшөөрлийн жагсаалт, эрх бүхий байгууллагаас олгож буй тооны харьцуулалт	114
Хүснэгт 48. Тусгай зөвшөөрөл	115
Хүснэгт 49. Энгийн зөвшөөрөл	116
Хүснэгт 50. Процессын зураглалын ерөнхий мэдээлэл	118
Хүснэгт 51. Асуудлын ангилал	125

Хүснэгт 52. Учрах эрсдэлийн давтамж.....	131
Хүснэгт 53. Учрах эрсдэлийн нөлөөлөл.....	132
Хүснэгт 54. Эрсдэлийн дэд ангилал.....	132
Хүснэгт 55. Процесс/тусгай зөвшөөрөлд бүртгэгдсэн эрсдэлийн түвшин.....	133
Хүснэгт 56. Байгаль орчны салбарын эрсдэлийн дулааны матриц.....	134
Хүснэгт 57. Үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээ, төрөл, хувиар.....	138
Хүснэгт 58. Үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой үнэлгээ, төрөл, хувиар.....	139
Хүснэгт 59. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагад өгсөн үнэлгээ, төрөл, хувиар.....	140
Хүснэгт 60. Тусгай зөвшөөрлийн төрөл, хамрагдсан аж ахуйн нэгж.....	140
Хүснэгт 61. Илэрч байгаа асуудлууд.....	167
Хүснэгт 62. Суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх тооцоо.....	171
Хүснэгт 63. Мод, сөөгийн үрийн нөөц.....	174
Хүснэгт 64. Тарьц, суулгацын нөөц.....	175
Хүснэгт 65. Улс орнуудын харьцуулсан байдал.....	179
Хүснэгт 66. БНХАУ-ын Экологи, байгаль орчны яамны бүтэц, салбарын тогтолцоо.....	181
Хүснэгт 67. Японы байгаль орчны яамны бүтэц, салбарын тогтолцоо.....	183
Хүснэгт 68. Японы байгаль орчны үндсэн төлөвлөгөө.....	183
Хүснэгт 69. Экологи, байгалийн нөөцийн яам.....	184
Хүснэгт 70. Усны нөөц, усжуулалтын яам.....	185
Хүснэгт 71. ХБНГУ-ын Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яамны бүтэц.....	186
Хүснэгт 72. Монгол Улсын Байгаль орчны салбарын хуулиуд (2024 он).....	193
Хүснэгт 73. Оновчтой процессын ерөнхий загварын тайлбар.....	202

Зургийн жагсаалт

Зураг 1. Иргэн-төвтэй, шуурхай, хүртээмжтэй, төрийн нэгдсэн цахим үйлчилгээг хөгжүүлэх Процессын дахин инженерчлэлийн алсын хараа.....	17
Зураг 2. Процессын дахин инженерчлэлийн зарчим.....	19
Зураг 3. Байгаль орчин, уу амьсгалын өөрчлөлтийн салбарын оролцогчдын хүрээ.....	20
Зураг 4. Төрийн албан шинэчлэлийн дөрвөн үе шат.....	1
Зураг 5. Процессын дахин инженерчлэлийн үе шат.....	2
Зураг 6. Цахим засаглалын 4 багана.....	2
Зураг 7. Процессын төрөл, шинж чанар.....	3
Зураг 8. Процесс шинжилгээ ба бизнес процесс загварчлал.....	3
Зураг 9. Процессын дахин инженерчлэлийн хүрээнд дүн шинжилгээ хийх хүрээ.....	4
Зураг 10. Дөрвөн талбайн зураглал.....	5
Зураг 11. Эрсдэлийн үнэлгээний ангилал.....	8
Зураг 12. Монгол орны ой, усны сан бүхий газрын тархалт.....	10
Зураг 13. Монгол Улсын Цаг уурын өөрчлөлтийн үзүүлэлт (Climate Change EPI) 2022-2024.....	11
Зураг 14. Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, 2024.....	12
Зураг 15. Бодлогын зорилгын оноо, Уур амьсгалын өөрчлөлт, Хүрээлэн буй орчны эрүүл мэнд болон Экосистемийн тогтвортой байдал.....	12
Зураг 16. БОУАӨЯ-ны бүтэц.....	14
Зураг 17. БОУАӨЯ-ны бүтэц, харьяа байгууллагуудаар.....	14
Зураг 18. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын бүтэц.....	16
Зураг 19. Олон Улсын конвенцууд.....	26
Зураг 20. Яамны нийтлэг чиг үүрэг.....	29
Зураг 21. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын гол 4 хуулиар оноосон чиг үүрэг.....	29
Зураг 22. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын гол 4 хуулиар оноосон чиг үүрэг.....	29
Зураг 23. Хөтөлбөрт тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зорилт, чиг үүрэг.....	31
Зураг 24. Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин.....	32
Зураг 25. Батлагдаагүй эрх зүйн баримт бичгийн зохицуулах харилцаа.....	34
Зураг 26. Батлах субъект.....	35
Зураг 27. Ойн тухай хуульд заасан чиг үүрэг.....	36
Зураг 28. Хөтөлбөрт тусгагдсан Ойн газрын зорилт, чиг үүрэг.....	37
Зураг 29. Байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогын баримт бичгүүд.....	38
Зураг 30. Урт, дунд, богино бодлогын баримт бичигт туссан салбарын асуудлаарх тоон судалгаа.....	38
Зураг 31. Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиг үүргийн хэмжээнд туссан зорилго, зорилтын тоон схем.....	39
Зураг 32. Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгээр батлагдсан шалгуур үзүүлэлтэд хийсэн шинжилгээний дүгнэлт.....	39
Зураг 33. Урт, дунд бодлогын баримт бичгийн уялдаа.....	40
Зураг 34. Алсын хараа-2050 Зорилго 2-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ.....	41
Зураг 35. Алсын хараа-2050 Зорилго 6-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ.....	42
Зураг 36. Алсын хараа-2050 Зорилго 9-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ.....	42
Зураг 37. Алсын хараа-2050 туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ.....	43
Зураг 38. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах баримт бичгүүд.....	43
Зураг 39. Бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний тоо (ангиллаар).....	45
Зураг 40. Орчны бохирдолын тодорхойлолт.....	45

Зураг 41. Бодлогын уялдаа холбоо-бодлого-хууль-төлөвлөлтийн уялдааг хангах процессын шинжилгээ.....	46
Зураг 42. Цөлжилттэй тэмцэх бодлого, төлөвлөлтийн уялдаа.....	47
Зураг 43. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах салбар дундын бодлого, зохицуулалтыг хангах Үндэсний зөвлөл, хороо	51
Зураг 44. Усны үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн	51
Зураг 45. Уур амьсгалын Үндэсний хорооны бүрэлдэхүүн.....	52
Зураг 46. Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн.....	54
Зураг 47. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн.....	55
Зураг 48. Судалгаа ба ойн менежментийн мэдээллийн урсгал	60
Зураг 49. Судалгааны байгууллагын судалгааны ажлын үр дүн ашиглах нь	62
Зураг 50. Салбарын урсгал зардлын бүтэц, 2015–2023 оны дунджаар.....	65
Зураг 51. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/.....	68
Зураг 52. БНАТ-ийн орлогын гүйцэтгэл, хэрэгжүүлсэн БОХНСАХ-ний тоо болон зардлын гүйцэтгэлийн харьцуулсан үзүүлэлт, тэрбум төгрөг	68
Зураг 53. ДНБ-д нийт татвар, Байгаль орчны татварын эзлэх хувь	70
Зураг 54. Татварын бодлогын дэмжлэг-Ойн салбарт	70
Зураг 55. Гадны зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээлэл	71
Зураг 56. Байгаль орчны байгууллага, хүний нөөцийн мэдээллийн сангийн бүтэц.....	75
Зураг 57. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүний нөөцийн хөдөлгөөн /2018-2025 он/.....	79
Зураг 58. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, байгууллагын төрлөөр, эзлэх хувиар.....	84
Зураг 59. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, хүйс, насны бүлэг, хувиар	85
Зураг 60. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, хүйс, ажилласан жил, хувиар	85
Зураг 61. 5 хүртэлх жил ажилласан хамрагдсан албан хаагчид, албан тушаалын ангилал, хувиар	85
Зураг 62. Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид, албан хаагчдад эзлэх хувь	86
Зураг 63. Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид, албан тушаалын ангиллаар	86
Зураг 64. Ажлын үр дүнгээ тодорхойлсон байдал, хувиар	87
Зураг 65. Хөдөлмөрийн бүтээмжийн үнэлгээ, 34 үзүүлэлтээр.....	88
Зураг 66. Ач холбогдлын харьцангуй индекс, бүлгээр.....	88
Зураг 67. Ач холбогдлын харьцангуй индекс, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт	89
Зураг 68. Ач холбогдлын харьцангуй индекс-1, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт, байгууллагаар	90
Зураг 69. Ач холбогдлын харьцангуй индекс-2, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт, байгууллагаар	91
Зураг 70. Ач холбогдлын харьцангуй индекс-1, албан тушаалаар	92
Зураг 71. Ач холбогдлын харьцангуй индекс-2, албан тушаалаар	93
Зураг 72. Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар	93
Зураг 73. Удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл.....	94
Зураг 74. Удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	94
Зураг 75. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар.....	95
Зураг 76. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл	96
Зураг 77. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	96
Зураг 78. Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	97
Зураг 79. Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл.....	98
Зураг 80. Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	98
Зураг 81. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар	99
Зураг 82. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл	100
Зураг 83. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	100
Зураг 84. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар.....	101
Зураг 85. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл	102
Зураг 86. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар	102
Зураг 87. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар	103
Зураг 88. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл	104
Зураг 89. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	104
Зураг 90. Гадаад орчинтой холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар	105
Зураг 91. Гадаад орчинтой холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар.....	106
Зураг 92. Өөрийн хийж буй ажилдаа сэтгэл ханамжтай байдал, хувиар.....	107
Зураг 93. Байгууллагын бүтэц оновчтой зохион байгуулагдсан эсэх, хувиар	107
Зураг 94. Байгууллагын чиг үүрэг оновчтой эсэх, хувиар	108
Зураг 95. Байгууллагын албан хаагчдын ажил үүрэг давхардалтай эсэх, хувиар	108
Зураг 96. Дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааны үнэлгээ, хувиар	109
Зураг 97. Сэтгэл ханамжгүй нэг албан хаагчын үзүүлэх нөлөө.....	109
Зураг 98. Тусгай болон энгийн зөвшөөрөл.....	113
Зураг 99. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл.....	119

Зураг 100. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл.....	121
Зураг 101. Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	123
Зураг 102. Дата эх сурвалж.....	125
Зураг 103. Бүртгэсэн асуудлын төрөл	126
Зураг 104. Албан хаагч эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг.....	128
Зураг 105. Сургалт зохион байгуулж байсан эсэх	128
Зураг 106. Сургалтын хэрэгцээ байгаа эсэх	128
Зураг 107. Хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтан, хэлтэс байдаг эсэх.....	129
Зураг 108. Байгууллага нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авдаг эсэх.....	129
Зураг 109. Гүйцэтгэж буй чиг үүрэг эрсдэлд өртөх магадлал хэр байдаг эсэх.....	129
Зураг 110. Ажиллаж буй байгууллагад эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалт байх шаардлагатай эсэх	130
Зураг 111. Чиг үүргээ хэрэгжүүлэхэд ямар эрсдэл учирч байгаа вэ?	130
Зураг 112. Учирч болох хамгийн өндөр магадлалтай эрсдэлийг тодруулсан байдал	131
Зураг 113. Эрсдэлийн ангилал.....	132
Зураг 114. Эрсдэлийн түвшин.....	133
Зураг 115. Хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллага, төрөл, хувиар.....	136
Зураг 116. Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ын байгаль орчны чиглэлээр хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллага, хувиар	136
Зураг 117. Хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллагаас авсан үйлчилгээ, хувиар.....	137
Зураг 118. Хамгийн сүүлд авсан үйлчилгээг хуулийн хугацаанд авсан эсэх, хувиар	138
Зураг 119. Төрийн байгууллагаас авсан үйлчилгээ, үйлчилгээ авсан хэлбэр, хувиар	138
Зураг 120. Үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээ, хувиар	138
Зураг 121. Үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой үнэлгээ, хувиар.....	139
Зураг 122. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагатай холбоотой үнэлгээ, хувиар.....	140
Зураг 123. Өгөгдлийн менежментийн процессын төлөвшлийн үе шат	169
Зураг 124. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний биелэлт	174
Зураг 125. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний процессын ерөнхий зураглал	178
Зураг 126. ДНБ-д эзлэх байгаль орчны салбарын зардал, хувиар	180
Зураг 127. Шинэ Зеланд Улсын байгаль орчны яамны бүтэц.....	188
Зураг 128. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын байгаль орчны салбарын бодлого.....	189
Зураг 129. Ирээдүйн төлөв загвар (To-be framework).....	190
Зураг 130. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бүтцийн санал	195
Зураг 131. Байгаль орчны газрын бүтцийн санал.....	195
Зураг 132. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааны оновчилсон ерөнхий процесс.....	201
Зураг 133. Өгөгдлийн төлөвшлийн үе шат.....	218

УДИРТГАЛ

Процессын дахин инженерчлэл нь төрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тодорхойлж, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, ардчилсан нийгмийн үнэт зүйл, хүн төвтэй үзэл баримтлалд нийцсэн удирдлагын арга барилыг нэвтрүүлэх, салбарын манлайлал, бүтээмж, үр дүнг дээшлүүлэх зорилготой цогц үйл явц юм.

Энэхүү шинэчлэлийн үйл явц нь Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт тусгагдсан төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх, иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, цахим засаглалыг төлөвшүүлэх зорилтыг хангахад чиглэгдэж байна. Үүний хүрээнд төрийн байгууллагын удирдлага, бүтэц, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтыг бий болгож, ил тод, үр ашигтай, иргэн төвтэй төрийн тогтолцоог төлөвшүүлэх зорилготой болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг нь ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна” гэж заасан. Мөн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгаль орчны бохирдол, доройтлоос хамгаалуулах эрхтэй” гэж тусгасан байдаг.

Үүнтэй уялдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ойн газарт процессын дахин инженерчлэлийн судалгаа хийх чиг үүрэг бүхий “Төслийн удирдлагын баг” нь Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоол болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны А/155 дугаар тушаалын дагуу байгуулагдан ажилласан.

Судалгааны хүрээнд дараах үндсэн зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоог судлах;
- Нийслэл болон орон нутгийн зарим салбар, нэгжүүдийн төрийн үйлчилгээний нөхцөл байдлыг үнэлэх;
- Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх боломжийг судлах;
- Иргэд, аж ахуйн нэгж, төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох;
- Мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хэрэгжилтийн байдлыг үнэлэх.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхдээ олон улсад түгээмэл хэрэглэгддэг судалгааны арга зүй болох баримт бичгийн шинжилгээ, өгөгдлийн анализ, фокус болон ганцаарчилсан ярилцлага, цахим судалгаа, талбарын ажиглалт зэрэг аргуудыг ашиглалаа.

Салбарын онцлог, хууль эрх зүйн орчин, байгууллагын чиг үүргийг судалгаанд нарийвчлан авч үзсэн нь төрийн үйлчилгээ илүү уялдаа холбоотой, иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, процесс төвтэй зохион байгуулалтыг бий болгох нөхцөлийг бүрдүүлж, цахим засаглалд шилжих, үр ашигтай шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмэр оруулах юм.

Процессын дахин инженерчлэл нь төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах замаар иргэн төвтэй, уялдаа холбоотой, бүтээмжийг нэмэгдүүлсэн төрийн үйлчилгээ рүү шилжих бодит боломжийг бүрдүүлж байна. Цаашид уг үйл явцыг шат дараатайгаар хэрэгжүүлж, шинэчлэлийн бодит үр дүнд хүрэх нь нийгмийн итгэлцлийг нэмэгдүүлж, төрийн байгууллагын хариуцлага, үр нөлөөг дээшлүүлэх чухал алхам болно.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


Төслийн зорилго, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ийг баталсан бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн тодорхойлж, дахин инженерчлэлийн аргаар бүтцийн ерөнхий тогтолцоог боловсронгуй болгох зэрэг зорилгыг тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн Газар “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөртөө төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнд суртлыг бууруулах, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд төрийн байгууллагуудад процессын дахин инженерчлэл хийх ажлыг шат дараалалтай эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн “Процессын дахин инженерчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоолоор Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа Ойн газар, тэдгээрийн орон нутаг дахь зарим газар, нэгж, нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийж, санал, дүгнэлтээ Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан.

Зураг 1. Иргэн-төвтэй, шуурхай, хүртээмжтэй, төрийн нэгдсэн цахим үйлчилгээг хөгжүүлэх
Процессын дахин инженерчлэлийн алсын хараа



Эх сурвалж: World Bank GovTech Launch Report, 2020

Төслийн удирдлагын баг, зохион байгуулалт

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан Төслийн удирдлагын баг “Төрийн үйлчилгээг иргэн төвтэй, энгийн, үр ашигтай, ил тод байлгах боломжийг бүрдүүлэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, иргэд болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлж, хамрах хүрээг тогтоосон.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/173, А/484 дүгээр хамтарсан тушаалаар хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан.

Процессын дахин инженерчлэлийн ажил нь олон талын судалгаа, шинжилгээнд суурилж хийгддэг онцлогтой учраас төслийн удирдлагын багийг БОУАӨЯ, түүний харьяа Ойн газарт хийх ПДИ-ийн хүрээнд босоо тогтолцоогоор Яам олон Ойн газар гэсэн үндсэн 2 баг, хэвтээ тогтолцоогоор хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу хууль эрх зүйн орчны шинжилгээ, судалгаа, эрсдэлийн удирдлага, процесс зураглал, стратегийн гэсэн 5 багт хуваарилан зохион байгууллаа.

Зохион байгуулалтын энэ арга хэмжээний үр дүнд мэдээлэл солилцох, холбогдох багууд хамтран ажиллах нөхцөл бүрдэж, ПДИ-ийн судалгаа шинжилгээг цогц байдлаар хийх боломжтой болсон.

Түүнчлэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын “Зарим төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагад процессын дахин инженерчлэл хийхэд хамтран ажиллах тухай” 2025 оны 01/155, 01/156 тоот албан бичгийн хүрээнд Сэлэнгэ, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар болон Сумын болон сум дундын ойн ангиуд “Төслийн удирдлагын баг”-т дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Төслийн удирдлагын баг БОУАӨЯ, Ойн газар болон зарим орон нутгийн байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 115 төрийн, төрийн бус, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн 1150 хүнийг хамруулснаас 36 удаагийн фокус бүлгийн болон чанарын ярилцлага, 30 гаруй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар;
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газар;
- Усны Сав газрын захиргаа;
- Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа;
- Аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төвүүд;
- Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ;
- Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ;
- Нийслэлийн Байгаль орчны газар;
- Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар;
- Булган аймгийн Байгаль орчны газар;
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал сумдын Сумын болон сум дундын ойн анги;
- Булган аймгийн Булган, Хутаг-Өндөр сумдын Сумын болон сум дундын ойн ангиуд оролцсон болно.

Баримтлах зарчим

Процессын дахин инженерчлэлийн зарчим: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Процессын дахин инженерчлэлийн 5 зарчмыг баримталж байна (UNDP, 2021).¹ Процессын дахин инженерчлэлийг хийх зарчим нь төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг хэрэглэгч төвтэй болгох, ил тод, хурдан шуурхай, хүртээмжтэй болгоход чиглэдэг. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс төрийн байгууллагуудын ПДИ-ийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Иргэн төвтэй байх

¹ UNDP (2021), Business Process Re-engineering Manual

Үйлчилгээний бүх процессыг иргэн, хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэн дахин загварчилна. “Төрийн байгууллага нь төв биш, иргэн нь төв байх” нь гол чиглэл юм.

- Бүтээмжийг нэмэгдүүлэх

Процесс бүрийг орц, гарцын үр ашигт суурилсан байдлаар оновчилно. Давхацсан, ач холбогдолгүй, хүнд сурталтай алхмуудыг процессоос хасаж, цахимжуулах замаар бүтээмжийг нэмэгдүүлнэ.

- Нэгдсэн үйлчилгээ

Иргэд олон дахин төрийн байгууллагаар ирэхгүйгээр нэг цэгээс олон төрлийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлнэ. Үйлчилгээг нэг платформ, нэг сувгаар дамжуулан хүргэхийг зорьдог.

- Цахим шийдэл ашиглах

Технологийн дэвшлийг ашиглан үйл ажиллагааг хялбаршуулах, шуурхай болгох, гар ажиллагааг багасгах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилготой.

- Удирдлагын манлайл ба төлөвлөгөөт өөрчлөлт

Өөрчлөлт хийх үйл явц нь системтэй, тодорхой үе шаттай байна. Удирдлагын манлайлал, байгууллагын дотоод соёлыг өөрчлөх оролдлого зэрэг багтана.

- Хамтын оролцоог хангах

Олон талт оролцогчдын (үйлчлүүлэгч, төрийн албан хаагч, иргэний нийгэм, хувийн хэвшил) хамтын оролцоог хангаж, хамтран загвар гаргах. Үүнд фокус ярилцлага, санал асуулга зэрэг арга хэрэглэнэ.

- Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах

Процессын гүйцэтгэлд хяналт тавих, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх нь чухал. Тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн сайжруулалт хийнэ.

- Шинэлэг байдал, тасралтгүй сайжруулалт

Нэг удаагийн өөрчлөлт биш, байнгын хяналт шинжилгээ, тасралтгүй сайжруулалт бүхий төрийн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ. Инновац, шинэ санаачилга, уян хатан хандлагыг дэмжинэ.

Процессын дахин инженерчлэлийн зарчим: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Процессын дахин инженерчлэлийн 5 зарчмыг баримталж байна (UNDP, 2021)²

Зураг 2. Процессын дахин инженерчлэлийн зарчим




Төслийн оролцогч талууд

² UNDP (2021), Business Process Re-engineering Manual

Төслийн хүрээнд оролцогч талуудыг төрийн, төрийн бус, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллага болон процессын дахин инженерчлэлийн үйл явцад оролцох талууд гэж дараах зорилгоор бүлэглэн тодорхойлсон. Үүнд:

- Төслийн ерөнхий хамрах хүрээг тодорхойлох;
- Оролцогч талуудын сонирхлын хүрээг тодорхойлох, мэдээлэл цуглуулах;
- Төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг бүрэн хамруулах, үр дүнтэй оролцоог хангах;
- Төслийн хүрээнд бий болгохыг зорьж буй өөрчлөлт, шинэчлэлтийн талаар ойлголт, мэдээлэл өгөх зэрэг болно.

Зураг 3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын оролцогчдын хүрээ



Төрийн цахим үйлчилгээний хэрэгжүүлэлт

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.Төрийн албаны шинэчлэлийн 4.2.3.3-т “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн төрд байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ”, 4.3.1.“E-Mongolia”-блокчейн-Цахим засаглалын 4.3.1.4-т “Төрөөс иргэн, бизнест үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухааныг ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна” гэж тус тус заажээ.

Төрийн бодлогын баримт бичигт процессын дахин инженерчлэлийн тухай дурдагдах болсон нь сүүлийн жилүүдийнх боловч Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр өмнө нь хэрэгжүүлж байсан

ажлууд тодорхой түвшинд процессын дахин инженерчлэлийн шийдлийг агуулж байсныг дурдах нь зүйтэй.

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн дагуу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагааны чиглэлийг тогтоохдоо мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа" гэж заасан. Иймд, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар нь төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг удирдан манлайлан оролцох зүй ёсны субъект болно. Цаашид тус байгууллагаас процессын дахин инженерчлэлийн чиглэлээр тодорхой ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх учир ажлын үр дүнг дээшлүүлэх хүрээнд анхаарвал зохих асуудлын талаар цөөн саналыг энэ тайланд оруулж байна.

Нэгд, процессын дахин инженерчлэлийг хэрхэн ойлгох талаар ойлголтын зөрүү үүсэхээс сэргийлэх. Төрийн процессын дахин инженерчлэл (Government Process Re-engineering) хэмээх ойлголт нь бизнесийн процессын дахин инженерчлэлийн зарчим, арга хэрэгслийг ашиглан төрийн үйлчилгээнд дэвшилд хүрэхэд чиглэгддэг. Иймээс, төрийн процессын дахин инженерчлэлийг ойлгохын тулд нэн тэргүүнд Бизнесийн процессын дахин инженерчлэлийн ойлголтонд анхаарах нь зүйтэй болов уу. Технологийн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч үндэстэн дамнасан корпорациудын нэг АйБиЭм (IBM)-ийн тодорхойлсноор³ "Бизнесийн процессын дахин инженерчлэл (BPR) гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны **процессыг үндсээр нь дахин загварчлах** үйл явц бөгөөд үүний зорилго нь гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг **эрс сайжруулахад** оршино."

Хоёрт, процессын дахин инженерчлэл бол **нэг удаагийн бус** урт хугацааны хүчин чармайлт шаарддаг ажил гэдгийг анраарах. Бизнесийн процессын дахин инженерчлэл нь тухайн процессын эхнээс төгсгөл хүртэлх үйл явцыг оновчтой болгож, давхардлыг арилгахыг чухалчилдаг. Процессыг зураглах замаар нягтлан шалгаж, хамгийн оновчтой шийдэлд хүрэхийн тулд дахин загварчилж, загварыг бодитоор нэвтрүүлэн гүйцэтгэлийг хянан шаардлагатай сайжруулалтыг тухай бүр нь хийхийг шаарддаг учир Бизнесийн процессын дахин инженерчлэл нь нэг удаагийн төсөл биш, харин инноваци ба оновчлолын тасралтгүй ажиллагаа юм. Байгууллагууд байнга өөрчлөгдөж буй орчинд дасан зохицож, өрсөлдөх чадвараа хадгалахын тулд үйл явцаа тогтмол үнэлж, сайжруулж байх шаардлагатай учир процессын дахин инженерчлэлийн дараагаар үр дүнгээ тогтвортой хадгалахын тулд үргэлжлүүлэн Бизнесийн процессын менежмент (Business process management) хийх шаардлагатай.

Гуравт, процесс бүрийг дахин инженерчлэх шаардлагагүй. Бизнесийн процессын дахин инженерчлэл нь процессыг үндсээр нь дахин загварчлахад төвлөрдөг. Харин процесс бүрийг дахин загварчлах шаардлагагүй бөгөөд зарим процессын хувьд багахан сайжруулалт л шаардлагатай байх нь бий.

Төрийн цахим үйлчилгээний хэрэгжүүлэлтийн үе шатын тухай:

Процессын дахин инженерчлэлийг дараахь үе шаттайгаа гүйцэтгэж болно:

Нэгд, процессын дахин инженерчлэл хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох. Байгууллагад доорх нөхцөл байдал үүссэн бол процессын дахин инженерчлэл хийх нь зүйтэй (АйБиЭМ корпораци). Үүнд:

- Ажилдаа сэтгэл хангалуун бус байдал, ажилтнуудын шилжилт хөдөлгөөн өндөртэй бол;
- Цаг хугацаа болон нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн үйл ажиллагааны зардал өндөртэй байгаа бол;

³ Business process reengineering (BPR) is the radical redesign of business processes to achieve dramatic improvements in performance, efficiency, and effectiveness.

- Процесст технологийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлээгүй бол;
- Давхардсан, удааширсан, үр ашиггүй процесстой бол;
- Шинээр үүсэн бий болж буй нөхцөл байдалд нийцэхгүй, хуучирсан үйл ажиллагааны тогтолцоотой бол;
- Салбарын стандарт, хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтийг хангаж чадахгүй, чанар муутай бүтээгдэхүүн, үйлчилгээтэй бол;
- Хэрэглэгчид сэтгэл ханамжгүй бол;

Тухайн байгууллагын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэсэн бол хүрээг илүү хумин процессын түвшинд дахин инженерчлэл хийх хэрэгцээг тодорхойлох нь зүйтэй. Үүний тулд тухайн процессыг үнэлэх ба үнэлгээг хийх маягтын саналыг тусгай зөвшөөрлийн жишээнд хавсралтаар оруулав (Хавсралт 1). Хэрэв үнэлгээг илүү дэлгэрэнгүй гүйцэтгэх шаардлагатай гэж үзвэл АНУ-ын төрийн байгууллагуудын хэмжээнд чиг үүргийн хүрээнд боловсруулсан баримт бичгүүд (Жишээлбэл, Department of Defense Business Process Reengineering Assessment Guidance)-тэй танилцахыг санал болгож байна.

Хоёрт, зорилгыг тодорхойлох. Бизнесийн процессын дахин инженерчлэлийн дараагийн алхам нь удирдлагын түвшинд ажлын зорилго буюу хүрэх үр дүнг тодорхой, ойлгомжтойгоор тогтоох явдал юм. Дахин инженерчлэлийн хүчин чармайлтаар юу хэрэгжих ёстойг тодорхой ойлгох хэрэгтэй – жишээлбэл, хүргэх хугацааг хурдавчлуулах эсвэл хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах гэх мэт.

Гуравт, одоогийн байдлыг үнэлэх. Процессын одоогийн явцын зураглал ("As Is" Process Model)-ыг гаргана. Процессын талаар шат дамжлага бүрээр мэдээллийг цуглуулж, оролцогч талуудтай ярилцлага хийснээр үр ашиггүй байдал, саад бэрхшээл болон сайжруулах шаардлагатай талбаруудыг тодорхойлно. Процессын нөхцөл байдлыг бүрэн ойлгохын тулд гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийх нь үр дүнтэй байдаг. Одоогийн явцын зураглалыг тухайн үйлдэгч этгээд өөрийн онцлог, шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж болох боловч олон улсын хэмжээнд Business Process Model and Notation (BPMN) стандартыг түгээмэл дагадаг. Процессын зураглалыг гүйцэтгэхдээ тайлбар (Narrative)-ыг үйлдэж байх нь ажлын үр дүнг хангахад тустай байдаг. Процессын тайлбарын талаарх өөрийн саналыг Хавсралт 2-т тусгав.

Дөрөвт, зөрүүг тогтоож, боломжийг тодорхойлох. Одоогийн байдлыг бүрэн ойлгосны дараагаар одоо байгаа нөхцөл байдал болон байвал зохих үзүүлэлт хоорондын зөрүүг тогтооно. Процессын бүхий л алхмыг шинжлэн зайлшгүй шаардлагатай эсэхийг шалгана.

Тавд, оновчит процессыг загварчлах ("To Be" Process Model). Өмнөх шинжилгээнд үндэслэн байгууллагын стратегийн зорилттой нийцсэн, хоёрдугаар алхмаар тодорхойлсон зорилгыг хангах оновчит процессыг загварчилна. Илэрсэн зөрүү, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, шинэлэг шийдлүүдийг тусгасан процессыг загварчлах ба шаардлагатай тухайн процессыг бүхэлд нь шинээр төлөвлөнө.

Зургаад, загварчилсан оновчит процессыг бодитоор туршин хянаж, үр дүнг нь хэмжих бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газраас үүнтэй холбоотой эргэн хяналтыг хийнэ.

Долоод, бодит үр дүнд шинжилгээ хийж, шаардлагатай сайжруулалтыг тухай бүрд нь хийснээр байгууллагад процессын дахин инженерчлэл иргэн-төвтэй үйлчилгээн үр дүнг тогтмол нэмэгдүүлнэ.

Арга зүй

ПДИ нь төрийн үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн тодорхойлж, бүтцийг боловсронгуй болгох, ардчилсан нийгмийн хүн төвтэй үзэл баримтлалд тохирсон удирдлагын арга барилыг нэвтрүүлж, салбарын манлайллыг бэхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл явц юм.

Зураг 4. Төрийн албан шинэчлэлийн дөрвөн үе шат ⁴




Байгаль орчны салбар дахь ПДИ-ийн судалгаа, шинжилгээг хийхдээ хууль эрх зүйн орчны шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, процесс зураглалын шинжилгээ, харилцаа мэдээллийн системийн шинжилгээ, сэтгэл ханамжийн судалгаа, асуудлын шинжилгээг хийсэн.

Мөн мэдээлэл цуглуулах, үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх боломжийг судлах, төрийн албан хаагч болон иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг тогтоох, бүтэц, чиг үүргийн хуваарилалтын одоогийн тогтолцоо оновчтой эсэх, давхардал, ажлын ачаалал тэнцвэртэй эсэх, салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын нийцлийг хэрхэн хангагдаж буйг шинжилж, дүгнэлт боловсрууллаа.

Энэхүү судалгаа, шинжилгээнд доорх аргачлалыг дагуу цогцоор нь авч үзсэнээр тулгамдаж буй асуудлыг олон талаас харах, шинжлэх, учир шалтгааныг тодруулах, болзошгүй эрсдэлийг тодорхойлох, зохистой шийдлийг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой.

⁴ World Bank. (2022). Service Upgrade: The GovTech Approach to Citizen-Centered Services. Washington, DC: World Bank.

Зураг 5. Процессын дахин инженерчлэлийн үе шат



Төрийн байгууллага процессоо зөв удирдан зохион байгуулснаар үйл явцаа тодорхойлох, загварчлах, хянах, тасралтгүй сайжруулах замаар стратеги, зорилгодоо хүрэх боломжтой гэж үздэг.

Зураг 6. Цахим засаглалын 4 багана⁵



ПДИ-ийн зорилгыг тодорхойлохдоо төрийн үйлчилгээг дараах үндсэн ангиллыг баримталсан.

- Иргэн төвтэй үйлчилгээ (G2C – Government to Citizen)
- Бизнесийн үйлчилгээ (G2B – Government to Business)
- Төрийн байгууллагууд хоорондын үйлчилгээ (G2G – Government to Government)
- Засгийн газраас төрийн албан хаагчдад үзүүлэх үйлчилгээ (G2E – Government to Employee)

⁵ Dr Nirmal K Mandal, Dy General Manager, National Institute for Smart Government, Hyderabad, Government Process Re-engineering, 2015

Зураг 7. Процессын төрөл, шинж чанар

ПРОЦЕССЫН ШИНЖ ЧАНАРТАЙ	ПРОЦЕССЫН ТӨРӨЛ
<ul style="list-style-type: none"> • ОРЦ- процессыг өдөөгч мэдээлэл, шийдвэр эсвэл үйл явц • ГАРЦ- процессын үр дүнд үүсч буй мэдээлэл, шийдвэр эсвэл үйл явц • ГОЛ ОРОЛЦОГЧИД-Процессын орц, гарцын үйлчлүүлэгч, нийлүүлэгчид • ЭЗЭМШИГЧ-процессын ихэнх алхмуудыг гүйцэтгэж буй этгээд • Цаг хугацаа болон давтамж • ТЕХНОЛОГИ- процессыг хэрэгжүүлэхэд туслах технологийн шийдэл 	<ol style="list-style-type: none"> 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕСС-Бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон эцсийн хэрэглэгчид хүргэх процесс. Ихэвчлэн олон чиг үүргийг хамардаг. 2. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ПРОЦЕСС- Байгууллагын туслах процесс бөгөөд үндсэн процессуудыг дэмжих зорилготой. Ихэвчлэн тухайлсан чиг үүргийн хүрээнд хамардаг. 3. МЕНЕЖМЕНТИЙН ПРОЦЕСС-Байгууллагын хэмжээнд бүх үндсэн буюу үйл ажиллагааны туслах буюу зохион байгуулалтын үйл ажиллагааг хэмжих, хянах процесс юм.

Процессын шинжилгээ хийх олон янзын хэрэгслүүд байдаг ба эдгээрийг хоёр үндсэн ангилалд хувааж болдог. Процесс шинжилгээ ба бизнес процесс загварчлал.

Зураг 8. Процесс шинжилгээ ба бизнес процесс загварчлал.

ПРОЦЕСС ШИНЖИЛГЭЭ	ПРОЦЕСС ЗАГВАРЧЛАЛ
<p>Процессыг бүхэлд нь тогтсон үг хэллэг, аргачлал ашиглан дүрслэн харуулах арга бөгөөд нэгдсэн аргачлал, хэлийг ашигладаг.</p>	<p>Загварчлал нь процессыг сайжруулах талаар илүү мэдээлэлтэй, зөв шийдвэр гаргах боломжийг олгодог.</p>

Байгууллагууд хоорондын үйл ажиллагааны процессуудыг бүх оролцогч талууд ойлгон, хүлээн зөвшөөрч, хялбар байдлаар илэрхийлэх боломжтой тул процесс менежментэд процессын зураглал болон загварчлалыг ашигладаг. Эдгээр хоёр ойлголтыг процесс баримтжуулах хэрэгсэл гэж тайлбарладаг байна.

БОУАӨЯ-ны процессын дахин инженерчлэл хийх шинжилгээний хүрээ


БОУАӨЯ болон Ойн газарт хийх Процессын дахин инженерчлэл хийх шинжилгээний хүрээг яамны үйл ажиллагааг үр дүнд чиглүүлсэн, бүтээмжтэй, байгаль орчны менежментийн процессуудад шилжүүлэх зорилгоор боловсруулсан. Шинжилгээний хандлага нь системийн буюу цогц, уялдаа холбоотой байдалд тулгуурласан бөгөөд бодлогоос хэрэгжилт хүртэлх бүх түвшнийг хамруулахыг зорьсон.

Шинжилгээний хүрээ нь дараах үндсэн бүтэцтэй:

1. Бодлогын түвшин (хөх хүрээ):
 - Салбарын бодлого
 - Хууль тогтоомжууд
 - Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалт
 - Үндэсний зорилгын тодорхойлолт
 - Тогтвортой хөгжлийн бодлого
 - Санхүүжилтийн бодлого
2. Төлөвлөлтийн түвшин (нил өнгийн хүрээ):
 - Салбар, яамны стратеги төлөвлөлтийн хүрээ
 - Олон улсын төсөл, хөтөлбөрүүд
 - Оролцогч талууд
3. Үйл ажиллагааны түвшин (ногоон хүрээ):
 - Уур амьсгалын өөрчлөлт
 - Байгалийн нөөцийн менежмент
 - Тусгай хамгаалалттай газрууд
 - Салбар хоорондын хамтын ажиллагаа

- Биологийн олон янз байдал
- Агаар, орчны бохирдол
- 4. Процессын түвшин (улбар шар хүрээ):
 - Байгаль орчны удирдлагын үндсэн процессуудын шинжилгээ
- 5. Хэрэгжилтийн түвшин (цэнхэр хүрээ):
 - Тулгамдсан асуудлуудын тодорхойлолт
 - Хэрэгжих процессуудын тодорхойлолт

Зураг 9. Процессын дахин инженерчлэлийн хүрээнд дүн шинжилгээ хийх хүрээ



Шинжилгээний бүтэц дэх босоо тогтолцооны уялдаа холбоо нь:

- Бодлогын түвшин (хөх хүрээ): Хууль тогтоомжууд болон Монгол улсын олон улсын гэрээ конвенцууд нь эрх зүйн үндэс суурь болж дараагийн түвшин дэх үйл ажиллагааг чиглүүлнэ.
- Төлөвлөлтийн түвшин (нил өнгийн хүрээ): Бодлогын чиглэлүүд нь өөрчлөлтийн хүрээг тодорхойлогдоно.
- Үйл ажиллагааны түвшин (ногоон хүрээ): Төлөвлөлтийг тодорхой салбаруудад (байгалийн нөөц, тусгай хамгаалалттай газрууд гэх мэт) хэрхэн хэрэгжиж байгааг илэрхийлнэ.
- Процессын түвшин (улбар шар хүрээ): Үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай тодорхой процессуудыг задлан харуулна.
- Хэрэгжилтийн түвшин (цэнхэр хүрээ): Процессуудын хэрэгжилтийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлуудыг харуулна.

Шинжилгээний бүтэц дэх хэвтээ тогтолцооны уялдаа холбоо нь:

- Бодлогын хүрээн (хөх хүрээ)-д: Хууль тогтоомж → Олон улсад өгсөн үүрэг, амлалт → Зорилго тодорхойлолт → Бодлогын баримт бичиг → Санхүүжилт → Салбарын бодлого
- Төлөвлөлтийн хүрээн (нил өнгийн хүрээ)-д: Өөрчлөлтийн хүрээ тодорхойлох → төсөл, хөтөлбөрийн дэмжлэг → Оролцогч талуудын оролцоо
- Үйл ажиллагааны хүрээн (ногоон хүрээ)-д: Байгалийн нөөц → Тусгай хамгаалалттай газар → Салбар хоорондын хамтын ажиллагаа → Биологийн олон янз байдал → Агаарын бохирдол

Процессын зураглал:

Процесс зураглал нь тухайн үйл ажиллагааны үе шат бүрийг дүрслэх, үйл явцыг эхлэлээс төгсгөл хүртэлх алхмуудын дарааллыг харуулах **график хэрэгсэл** юм. Энэ нь үйл ажиллагаагаа шинжлэх, түргэтгэх, сайжруулахад тусалдаг ба нарийн төвөгтэй процессуудыг нэг хавтгай дээр хялбар харуулах боломжийг өгдөг.

Процессын зураг нь шинжлэх ухааны үүднээс үзэхэд, тодорхой, сайн бүтэцтэй байвал бизнесийн үйл ажиллагаанд үүссэн үргүй зардал болон саад бэрхшээлийг илрүүлэхэд үр дүнтэй хэрэгсэл болдог⁶.


Процесс зургийг ашиглах нь байгууллагуудын дунд харилцаа холбоо болон ойлголтыг сайжруулдаг гэж онцолсон, учир нь эдгээр нь байгууллагын бүх оролцогч талуудын ойлгоход хялбар, нийтлэг, визуаль төлөөллийг өгдөг⁷.

Байгууллагын процессын удирдлагын судалгаанд, процессын загварчлалын хэрэгслүүд, процесс зураг зэрэг нь процессийг шинэчлэхэд чухал хувь нэмэр оруулдаг гэж дурджээ. Эдгээр хэрэгслүүд нь удирдлагуудад зөвхөн одоогийн процессуудаа баримтжуулах төдийгүй, сайжруулсан процессыг төсөөлөх боломжийг олгодог бөгөөд тэдгээр нь тасралтгүй сайжруулалтын санаачлагын хамгийн чухал хэрэгсэл болж өгдөг⁸.

Процесс зураг нь үйл ажиллагааг нарийвчилсан, удирдах боломжтой жижиг хэсгүүдэд хувааж, байгууллагад алдаа эсвэл саатал гардаг газруудаа тодорхойлж, шийдэл олоход хялбар болгодог.

Процесс зураг хийхдээ дараах дөрвөн талбайн зураглалын загварыг ашигладаг.

Зураг 10. Дөрвөн талбайн зураглал



Процесс зураг нь тодорхой процессыг гүйцэтгэхэд хийгдэх алхамууд болон шийдвэрүүдийг визуал байдлаар дүрслэн, ажлын урсгал эхлэхээсээ дуусах хүртэл хэрхэн явагддагыг харуулах хэрэгсэл юм. Энэ нь үйл ажиллагааны дарааллыг ойлгоход хялбар бөгөөд тодорхой, олон тооны ажил, алдааг илрүүлж, процессуудыг оновчтой болгоход хэрэглэгддэг.

⁶ Browning, T.R. (2009). Process Flow Mapping: An introduction to lean Process Mapping. *Process Improvement Journal*, (2), 34-45.

⁷ Damelio R.(2011). The Basics of Process Mapping. CRC Press.

⁸ Hammer M., & Champy, J. (1993). Reengineering the Corporation: A Manifesto for Business Revolution. Harper Business.

Процессын гэрчилгээ: Процессын тайлбар баримт бичиг юм. Энэ нь процессын нэр, дугаар, процессын түвшин, процесст оролцогч, процессын зорилго, баримт бичгийн хэрэглэгч, нэр томъёоны тайлбар хамрах хүрээ, амжилтын түлхүүр хүчин зүйлс, процессын орц, гарц, зарцуулах хугацаа, дагалдах бичиг баримт, үүрэг, хариуцлагын матриц (RACI) болон процесс ашиглалт зэрэг мэдээллийг хамруулан баримтжуулна.

Процессын RACI (үүрэг хүлээх, хариуцах, зөвлөх, мэдээлэх талуудыг хамруулах) матриц нь процесс дахь үйл явц бүрийн үүрэг хүлээсэн бөгөөд явц, үр дүнг бий болгох үүрэгтэй оролцогчийн оролцоог тайлбарлана.

Процесст оролцогчдын оролцоог тодорхойлж буй тэмдэглэгээг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- **R** - Хариуцан хийж, гүйцэтгэх;
- **A** - Тухайн үйл явцад хариуцлага хүлээх, батлах;
- **C** - Тухайн үйл явцын талаар харилцан зөвлөлдөх, оролцох;
- **I** - Үйл явцын талаар мэдээлсэн байх зэрэг болно

Эрсдэлийн үнэлгээний арга зүй:

- Эрсдэлийн менежмент удирдамж MNS ISO 31000:2020
- Эрсдэлийн менежмент. Эрсдэлийн үнэлгээний аргууд MNS IEC 31010:2022

Байгууллага зорилгодоо хүрэхэд нөлөөлж болзошгүй тодорхойгүй байдлаас үүсэх эрсдлийг таних, үнэлэх, хариу арга хэмжээ авч, үр нөлөөг нь бууруулах, үр дүнг хянах тасралтгүй үргэлжлэх үйл явцыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тодорхойлно. Байгууллага нь өөрийн тулгамдаж буй асуудлуудаас салбарт үүсэж болзошгүй эрсдэлийг тогтоох, бүртгэх, үнэлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой эрсдэлийн шинжилгээг дараах аргаар хийсэн.

Эрсдэл тохиолдох магадлал:

Тулгамдаж буй асуудлуудаас салбарт үүсэж болзошгүй эрсдэлийг тогтоох, бүртгэх, үнэлэх зорилгоор эрсдэлийн шинжилгээг хийв. Эрсдэл тохиолдох магадлалын үнэлгээг дараах хүснэгт ашиглан тодорхойлсон ба үнэлгээний түвшинг тоон болон чанарын 5 түвшинд тодорхойлов.

Хүснэгт 1. Эрсдэл тохиолдох магадлалын үнэлгээ

Түвшин	Тодорхойлолт	Тайлбар	Магадлалын хувь	Магадлалын давтамж
5	Өндөр магадлалтай	Тохиолдож болзошгүй эсвэл байнга тохиолддог	Тохиолдох магадлал 91% , түүнээс их	Долоо хоногт 1 удаа
4	Тодорхой	Тогтмол тохиолддог	Тохиолдох магадлал 71%-90%	Сард 1 удаа
3	Магадлалтай	Зарим үе шатанд тохиолддог	Тохиолдох магадлал 31%-70%	Улиралд 1-2 удаа
2	Ховор	Бараг тохиолдож байгаагүй	Тохиолдох магадлал 10%-30%	Хагас жилд 1-2 удаа
1	Маш ховор	Хэзээ ч тохиолдоогүй	Тохиолдох магадлал 9% түүнээс бага	Жилд 2-доош удаа

Эрсдэлийн үр нөлөө :

Эрсдэлийг үнэлэх, тухайн нөхцөл байдал ямар үр дагавар авчрахыг тодорхойлоход оршдог бөгөөд үр нөлөөг хэмжихдээ тоон болон чанарын утгуудыг хослуулан ашигласан. Эрсдэлийн үр нөлөөг үнэлэхдээ төсөв, санхүүгийн эрсдэл буюу хэрэгцээ шаардлага, төсөвт учрах эрсдэл, үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалт, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын, бодлогын буюу хууль тогтоомжийн дагуу хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц болон бусад гэсэн ангиллуудыг харгалзан үзсэн.

Хүснэгт 2. Эрсдэлийн үр нөлөө

Үр нөлөө	Үнэлгээ	Төсөв, санхүүгийн эрсдэл буюу хэрэгцээ шаардлага төсөвт эзлэх хувь	Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Бодлогын буюу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц эрсдэл	Бусад
Маш өндөр	5	10 тэрбумаас дээш төсөвтэй эсхүл, төсвийн 20%-с дээш дүнтэй эрсдэл тооцох боломжтой, эсхүл хөрөнгийн бодит дутагдал, шамшигдуулалд гарсан г.м	Бодит хор нөлөө нь ихэсч, үйл ажиллагаанд ноцтой саад учруулдаг.	Ашиглагдах хууль, журам байнга өөрчлөгдөж зохицуулалтыг үндсээр нь өөрчилж шинэчлэх шаардлагатай	Ноцтой саад учруулдаг	Засгийн газар хугацаанаасаа өмнө бүрэн бүрэлдэхүүнээрээ солигдсоноор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орох, байгууллагын удирдлагын бүрэлдэхүүн өөрчлөгдөх, төлөвлөгөөт үйл ажиллагаа тасалдах, хангалттай хэмжээнд санхүү шийдэгдэхгүй байх
Өндөр	4	5-10 тэрбум төгрөгийн хооронд төсөвтэй эсхүл төсвийн 10-20% хооронд дүнтэй эрсдэл тооцох боломжтой, хөрөнгийн дутагдал гарсан.	Бодит хор нөлөө нь үргэлжлэн илэрч, үйл ажиллагаанд байнга саад учруулдаг.	Үйл ажиллагаанд ашиглагдах хуулиуд байнга өөрчлөгдөж байдаг, зохицуулалтын шаардлага байнга гардаг.	Байнга саад учруулдаг	Сайд улс төрийн нөлөөллөөр хугацаанаасаа өмнө солигдсоноор байгууллагын удирдлагын бүрэлдэхүүний тодорхой хувь өөрчлөгдөх, төлөвлөгөөт үйл ажиллагаа тодорхой хугацаагаар тасалдах, санхүүжилтийн асуудал шийдэгдэх нь удаашрах
Дунд	3	1-4 тэрбум төгрөгийн хооронд төсөвтэй эсхүл төсвийн 5-10% хооронд дүнтэй эрсдэл тооцох боломжтой.	Бодит хор нөлөө нь үе үе мэдрэгдэж, үйл ажиллагаанд заримдаа бодит саад учруулдаг.	Ашиглагдах хууль, журам цөөн боловч заримдаа өөрчлөлт, зохицуулалтын шаардлага гардаг.	Бодит саад учруулдаг	Улс төрийн нөлөөллөөр албан хаагч үндэслэлгүйгээр ажлаасаа халагдах, өөрчлөгдсөнөөс үүдэн аливаа нэгжийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, чиг үүргийн хэрэгжилт тасалдах
Бага	2	0.5-1 тэрбум төгрөгийн хооронд төсөвтэй эсхүл төсвийн 1-5% хооронд дүнтэй эрсдэл тооцох боломжтой.	Бодит хор нөлөө нь бага илэрдэг.	Ашиглагдах хууль, журам цөөн зохицуулалтын шаардлага өөрчлөгддөггүй.	Бага саад учруулдаг	Улс төрийн нөлөөллөөр албан хаагчдад ажлын ачаалал нэмэгдэх, төлөвлөгөөт бус цаг үеийн шинжтэй ажлууд нэмэгдэх
Маш бага	1	0.5 тэрбум төгрөгөөс доош төсөвтэй эсхүл төсвийн 1%-с доош дүнтэй эрсдэл тооцох боломжтой.	Бодит хор нөлөө нь анзаарагддаггүй.	Ашиглагдах хууль, журам цөөн зохицуулалтын шаардлага бага.	Саад учруулахгүй	Улс төрийн нөлөөлөл бага

Эрсдэлийн дулааны матриц буюу эрсдэлийн түвшинг тогтоох матрицыг магадлал, нөлөөллийн харьцаагаар нийт 5 түвшинд тодорхойлсон.

Хүснэгт 3. Эрсдэлийн дулааны матриц

Сөрөг эрсдэлийн матриц		Нөлөөлөл					
		1	2	3	4	5	
		Ач холбогдолгүй	Бага	Дунд зэрэг	Их хэмжээний	Аюултай	
Магадлал	5	Өндөр магадлалтай	5	10	15	20	25
	4	Тодорхой	5	8	12	16	20
	3	Магадлалтай	3	6	9	12	15
	2	Ховор	2	4	6	8	10
	1	Маш ховор	1	2	3	4	5

Эрсдэлийн түвшин нь эрсдэлийн давтамж болон үр нөлөөний харилцан хамаарлаар тогтоогдох бөгөөд эрсдэлийн давтамж, үр нөлөө, түвшин нь дараах ангиллуудтай байхаар авч үзэв:

Зураг 11. Эрсдэлийн үнэлгээний ангилал

Үнэлгээ	Эрсдэлийн давтамж	Эрсдэлийн үр нөлөө	Эрсдэлийн түвшин
1	Rare	Incidental	Minimal
2	Unlikely	Minor	Low
3	Possible	Moderate	Medium
4	Likely	Major	High
5	Almost certain	Severe	Extreme

Чанарын ярилцлагын арга зүй:

Ганцаарчилсан, фокус бүлгийн ярилцлага хийж мөн цахим судалгааг авсан:

Ганцаарчилсан ярилцлага:

Салбарын дунд байгаа зөрчилтэй асуудлыг илрүүлэх магадлал өндөртэй бөгөөд ярилцлага хийх хүндээ урьдчилан ярианыхаа чиглэлийг танилцуулах, уулзах өдөр, цагаа товлох, мэндлэх, хүндлэх ёсыг мөрдөх зэргээр аль болох таатай байхаар зохион байгуулна. Ганцаарчилсан ярилцлага нь дараах давуу талтай.

- Асуудлын талаар үнэн мэдээлэл өгөх хүнийг сонгох боломжтой.
- Оролцогч бусдын нөлөөнд автагдах боломжгүй.
- Судлаач ярилцлагад хяналт тавихад хялбар.

Фокус бүлгийн ярилцлага:

Цөөн тооны ихэвчлэн 6-9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба бүлэг хамтран тухайн сэдвийн талаар үзэл бодол ойлголтоо нэгтгэдэг.

Гол бүлгийн ярилцлага нь:

- Яриаг чиглүүлэн, сэдвийг өөрчлөх боломжтой
- Төвийг сахин, ач холбогдол, харилцан хамаарал бүхий баримтыг олж авдаг
- Асуудлын талаар зөв мэдээлэл авч болох оролцогчийг сонгох давуу талтай.

Цахим судалгаа:

Цахим судалгаа гэдэг нь интернэт орчинд буюу цахим хэрэгслүүдийг (жишээлбэл: вэбсайт, имэйл, апп, сошиал медиа зэрэг) ашиглан хийгддэг судалгааны арга юм. Энэ нь уламжлалт судалгааны (нүүр тулсан, утсаар авсан гэх мэт) аргуудаас илүү хэмнэлттэй, хурдан, өргөн хүрээг хамардаг онцлогтой.

Цахим судалгаа нь богино хугацаанд олон хүн хамруулах, газарзүйн байршлаас үл хамаарах, зардал багатай, хувийн нууцлал хамгаалагдах зэрэг олон давуу талтай юм. Судалгаанд оролцогчдын мэдээлэл, нууцлал хамгаалагдах нь хүмүүс илүү үнэн зөв, чөлөөтэй хариулах хандлагатай болгодог.

Цахим судалгаанд байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчид, үйлчилгээ авахаар хүсэлт өгсөн, үйлчилгээ авч буй иргэн, хувийн хэвшлийн мэдээллийг эх олонлог болгож ашиглана. Уг эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн оролцогч талуудын сэтгэл ханамжийг тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх юм.

Судалгааны аргачлал

Судалгааны үр дүнг зөвхөн үндэсний хэмжээнд төлөөлөхүйц байдлаар боловсруулах зорилт тавигдсан. Иймд энд бүс нутаг болон аймгийн түвшинд үр дүнг боловсруулах зорилт тавигдаагүй бөгөөд нарийвчлалын түвшин нь зөвхөн үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

Түүврийн хэмжээг тодорхойлох

Байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдаас түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцсон.

$$n = \frac{Z^2 \times N \times V}{(N - 1) \times e^2 \times Z^2}, \quad V = \left(\frac{SD}{mean} \right)^2 \quad (1)$$

Энд:

- n = түүврийн хэмжээ
- N = эх олонлогын тоо
- Z = хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга (95.0 хувь ашигласан)
- SD = стандарт алдаа (Бүсчлэлийн хувьд)
- e = алдааны хязгаар (5.0 хувь)

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг судалгаа тус бүрт нь тооцоход салбарын албан хаагчдаас 499 хамруулахаар байна.

Ач холбогдлын харьцангуй индексийг тодорхойлох

Байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдийн ач холбогдлын харьцангуй индексийг (Relative Importance Index (RII) дараах томъёоллын дагуу тооцсон.

$$RII = \frac{5n_5 + 4n_4 + 3n_3 + 2n_2 + n_1}{5(n_1 + n_2 + n_3 + n_4 + n_5)} \times 100$$

Энд:

- n = хариултын тоо хэмжээ

1 БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР, ТОГТОЛЦОО

1.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Монгол Улс нь Төв Азийн зүүн хойд хэсэгт нийт 1564.1 мянган ам дөрвөлжин километр газар нутгийг эзлэн орших бөгөөд хойд хэсгээрээ Оросын Холбооны улс (ОХУ), өмнө талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-тай хиллэдэг. Улсын хилийн нийт урт 8161.9 км, үүнээс ОХУ-тай хиллэх хилийн урт 3485 км, БНХАУ-тай хиллэх хилийн урт 4676.9 км.

Монгол улс дэлхийд нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ 17 дугаарт ордог, далайн түвшнээс дээш дунджаар 1580 м өндөрт өргөгдсөн, далайд гарцгүй орон юм. Нутгийн баруун, хойд хэсэгт нь уулархаг, ойн бүс, Зүүн хэсэгт тал хээрийн бүс, Өмнөд хэсэгт говийн бүс зонхилдог.

Хавар, зун, намар, өвөл гэсэн жилийн 4 улиралтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын дундаж температур зундаа (6-8 дугаар сард) +10°С -аас +25°С, өвөлдөө (12-2 дугаар сард) -12°С-аас -36°С орчимд хэлбэлздэг боловч агаарын үнэмлэхүй их температур +45°С, агаарын үнэмлэхүй бага температур -55°С юм.⁹

Монгол Улсын нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл, 2023 онд нийт нутгийн 69.7 хувийг хөдөө, аж ахуйн газар, 20.6 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 8.1 хувийг ойн сан бүхий газар, 0.7 хувийг хот, тосгон болон бусад суурины газар, 0.5 хувийг зам, шугам, сүлжээний газар, 0.4 хувийг усны сан бүхий газар эзэлж байна.

Зураг 12. Монгол орны ой, усны сан бүхий газрын тархалт



Монгол Улсын нийт усны нөөцөд эзлэх гадаргын усны хэмжээ 2023 оны байдлаар 98.0 хувь бөгөөд ойгоор бүрхэгдсэн талбай нийт газар нутгийн 8.2 хувийг эзэлж байна. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 80 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.4 хэмээр өссөн. Энэ нь дэлхийн агаарын дундаж температур сүүлийн 100 жилд 1.1 хэмээр өссөнөөс ойролцоогоор 2 дахин өндөр үзүүлэлт юм. Мөн 1 хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарал дэлхийн дунджаас 2.7 дахин өндөр байна.

Түүнчлэн, Монгол орны нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжсөн бөгөөд үүний 50-70 хувийг Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын газар нутаг эзэлж байна. Мөн нийт хур тунадасны хэмжээ сүүлийн 70 жилийн хугацаанд 7.3 хувиар буурсан байна¹.

⁹ Б


1961-2010 оны хооронд (49 жил) бүртгэгдсэн тэсгим хүйтний үргэлжлэх хугацаа 15 хоногоор богиноссон бол зуны аагим халууны үргэлжлэх хугацаа 24 хоногоор уртассан байна.¹⁰

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2023 онд 4484 болж, өмнөх оноос 185 (4.3%)-аар өссөн бол 2019 оноос 639 тохиолдлоор (12.5%)-өөр буурсан байна. Ой, хээрийн түймэр 2023 онд 101 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 78 (43.6%)-аар, 2019 оноос 20 (16.5%)-иор тус тус буурсан байна.¹¹

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 2024 оны 1, 2, 3, 11, 12 саруудад хүлцэх агууламжаас 0.005-0.102 мг/м³ -ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 2024 оны 1, 2, 12 саруудад хүлцэх агууламжаас 0.007-0.022 мг/м³ -ээр, РМ 10 тоосонцорын дундаж агууламж 2024 оны 1, 2, 11, 12 саруудад хүлцэх агууламжаас 0.004-0.032 мг/м³ -ээр, РМ 2.5 тоосонцрын дундаж агууламж 2024 оны 1, 2, 12 саруудад хүлцэх агууламж 0.031-0.064 мг/м³ -ээр тус тус давсан байна.¹²

Монгол Улс 2024 оны Байгаль орчны гүйцэтгэлийн индексээр (Environmental Performance Index, EPI) 37.2 оноо авч, 180 орноос 143-р байранд, Ази, Номхон далайн бүс нутагт 17-р байранд орсон байна. Энэхүү индексийн 2022, 2024 оны үзүүлэлтүүдийг харьцуулахад Монгол Улсын EPI оноо 7.6 нэгжээр өсөж, 12 байр урагшилсан хэдий ч **“агаарын бохирдол”**, **“цаг уурын өөрчлөлт”**, **“экосистемийн чадавх”** зэрэг үзүүлэлтээр дэлхийн улс орнуудаас харьцангуй доогуур байранд байгаа нь үр дүнтэй бодлого, арга хэмжээ дутмаг байгааг харуулж байна. Энэ нь Монгол Улс дэлхийн хэмжээнд байгаль орчны гүйцэтгэлийн хувьд хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 13. Монгол Улсын Цаг уурын өөрчлөлтийн үзүүлэлт (Climate Change EPI) 2022-2024




¹⁰ (НҮБ, 2022)


¹¹ Монгол улсын статистикийн эмхэтгэл-2023, ҮСХ

¹² ҮСХ, Статистик мэдээ, 2025 оны 1 дүгээр сарын 15

Зураг 14. Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, 2024¹³



Зураг 15. Бодлогын зорилгын оноо, Уур амьсгалын өөрчлөлт, Хүрээлэн буй орчны эрүүл мэнд болон Экосистемийн тогтвортой байдал



Дээрх бодлогын үндсэн зорилтуудын үнэлгээнээс харахад,

- Хүрээлэн буй орчны эрүүл мэнд: Монгол Улс 28.5 оноо авч, агаарын бохирдол, аюултай хог хаягдлын зохисгүй менежмент зэрэг олон эрсдэлт хүчин зүйлсээс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах тал дээр бэрхшээлтэй тулгарч байгааг харуулж байна.
- Экосистемийн тогтвортой байдал: Энэ ангилалд ойн бүрхэвч, усны нөөц, биологийн олон янз байдал зэрэг үзүүлэлтүүд багтдаг. Монгол Улсын оноо сул байгаа нь бэлчээрийн доройтол, экосистемийн алдагдал, тогтвортой бус газар ашиглалт зэрэг асуудал хэвээр байгааг илтгэнэ.
- Уур амьсгалын өөрчлөлт: Нүүрсээр ажилладаг эрчим хүчний эх үүсвэр болон газар ашиглалтын өөрчлөлт нь хүлэмжийн хий (GHG)-ийн ялгаралтыг нэмэгдүүлсээр байна.

Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд EPI оноог 2025 онд 58, 2030 онд 59, 2050 онд 61 болон түүнээс дээш түвшинд хүргэх зорилт тавьсан болов ч, 2024 оны бодит үзүүлэлт нь энэ зорилтод хүрэхэд хүндрэл учирч болзошгүйг илтгэж байна. Тус индексийн оноонд агаарын чанар, агаарын бохирдол, хог хаягдлын менежмент, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудлууд сөргөөр нөлөөлж байна.

¹³ <https://epi.yale.edu/measure/2024/EPI>

1.2 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь Бүгд найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1987 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Бүгд найрамдах Монгол Ард Улсын зарим яамд байгуулах тухай” 169 дүгээр зарлигаар “Байгаль орчныг хамгаалах яам”-ыг анх байгуулснаар нэгдсэн тогтолцоо, зохион байгуулалтад орж үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

Тус яам нь байгуулагдсанаас хойших өнгөрсөн 38 жилийн хугацаанд дараах байдлаар Засгийн газрын тухай хуулиар яамны албан ёсны нэр, эрхлэх чиг үүрэг өөрчлөгдөн зохион байгуулагджээ.

Хүснэгт 4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, чиглэл

Огноо	Хуулийн нэр	Яамны нэр	Чиглэл
1987 оны 12 дугаар сарын 09-ний өдөр	“БНМАУ-ын зарим яам байгуулах тухай” АИХ-ын тэргүүлэгчдийн 169 дүгээр зарлигаар	Байгаль орчныг хамгаалах яам	Чиглэлийн
1990 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр	“БНМАУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүнийг тогтоох тухай” хуулиар	Байгаль орчны хяналтын улсын хороо	Ерөнхий чиг үүрэг
1992 оны 7 дугаар сарын 30-ны өдөр	Монгол Улсын “Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчны яам	Чиглэлийн
1996 оны 7 дугаар сарын 25-ны өдөр	“Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай” хууль, Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 182 дугаар тогтоолоор	Байгаль орчны яам	Чиглэлийн
2000 оны 8 дугаар сарын 03-ны өдөр	Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчны яам	Чиглэлийн
2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр	Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчны яам	Чиглэлийн
2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр	“Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Чиглэлийн
2012 оны 8 дугаар сарын 16-ны өдөр	Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	Ерөнхий чиг үүргийн
2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр	Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Ерөнхий чиг үүргийн
2016 оны 7 дугаар сарын 21, 2020 оны 07 дугаар сарын 07,	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус тус	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Ерөнхий чиг үүргийн
2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Чиглэлийн
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр	“Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Чиглэлийн

Засгийн газрын 2012-2016 оны бүтцэд Байгаль орчин, ногоон хөгжлийн яам нэртэйгээр өөрчлөн зохион байгуулснаар дэлхий нийтэд шинэ тутам түгээн дэлгэрч байсан Ногоон хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байжээ.


Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт:

Засгийн газрын бүтэц 2013 оноос 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 27 удаа өөрчлөгдөж, өөрчлөлтийн дундаж хугацаа 162.9 хоног байна. Өөрөөр хэлбэл 5.4 сар тутам бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна. /ҮАГ-ын тайлангаас/

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хувьд 2008 оноос хойш Засгийн газрын бүтцийн тухай хуулиар 7 удаагийн өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны орон тооны хязгаарыг 122 байхаар баталж, Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу яам нь 9 газар, 10 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.


Зураг 16. БОУАӨЯ-ны бүтэц¹⁴



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяанд дараах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна:¹⁵

Зураг 17. БОУАӨЯ-ны бүтэц, харьяа байгууллагуудаар



¹⁴ БОУАӨЯ, 2024 он

¹⁵ БОУАӨЯ, 2024 он

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны стратегийн чиг үүрэг

Хүснэгт 5. Яамны стратегийн чиг үүрэг

Д/д	Газар, хэлтэс	Стратегийн чиг үүрэг
1	Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар	Улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн талаарх хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны салбарын бодлого, стандарт, техникийн шаардлага боловсруулж батлуулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох, цөлжилт, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах бодлогын удирдамжаар хангах, хүлэмжийн хийн ялгарал, бохирдлыг бууруулах инновацыг хөгжүүлж, цэвэр технологи, ногоон хөгжлийг дэмжих, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинжлэх ухаан технологийн судалгааг өргөжүүлж, судалгаа, үр дүнд суурилсан бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж, түүнийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
2	Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар	байгалийн нөөц, баялаг (газар, ус, ой, биологийн олон янз байдал)-ийн нөөцийн хэмжээ, экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоох, байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, хомстлоос сэргийлж нөхөн сэргээх, кадастрын зураглал хийх, газрын доройтлоос урьдчилан сэргийлж, цөлжилттэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, био аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, салбар дундын зохицуулалтаар хангах
3	Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар	Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн сан бүрдүүлэх талаарх бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгон хэрэгжилтийг хангах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны аудитын хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж зөвлөгөө дэмжлэг үзүүлэх
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар	Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийг хамгаалалтад авч өргөжүүлэх, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх, газрын харилцааг зохицуулах, тусгай хамгаалалттай газар нутгийн улсын сүлжээг бэхжүүлэх, ашиглалт, хамгаалалт, шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийн хэтийн хандлагыг тогтоох судалгаа хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих
5	Төрийн захиргааны удирдлагын газар	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, байгаль орчны сайн засаглалыг бэхжүүлэх, хяналт тавих, удирдлагаар хангах, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийн төсөл болон бусад шийдвэрийн төсөл боловсруулах, хууль зүйн үндэслэлийг хангуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хууль зүйн мэргэжлийн зөвлөмжөөр хангах, салбарын хууль тогтоомж, шинээр болон нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан хууль, захиргааны хэм хэмжээний актын талаар байгаль орны салбарын албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах, яамны гадагш чиглэсэн захиргааны акт, гэрээ болон захиргааны хэм хэмжээний акттай холбоотой хэрэг, маргаанд шүүх болон хууль хяналтын бусад байгууллагад яамыг төлөөлөх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх бодлого, арга хэмжээг зохион байгуулах, бүх шатны төрийн байгууллагад ногоон хөгжлийн үзэл санааг төлөвшүүлж, манлайлыг хангах
6	Гадаад хамтын ажиллагааны газар	Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, олон улсын төсөл, хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, гадаад сурталчилгаа, маркетингийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах
7	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц, төсөл, төлөвлөгөө, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлтийг бодлогын удирдамжаар чиглүүлэх, салбарын санхүү, хөрөнгө оруулалтын удирдлага, зохицуулалт, төсвийн ил тод байдлыг хангах
8	Хяналт, үнэлгээ, аудитын газар	Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэл, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах, байгаль орчны статистик мэдээлэл, мэдээллийн нэгдсэн сангийн удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх
9	Салбарын хяналтын газар	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу хэрэгжүүлж, хяналт шалгалтыг тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн төлөвлөж, иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь байгаль орчны хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгч, хүрээлэн байгаа орчинд үүсэж болзошгүй эрсдэл, сөрөг нөлөө, хохирлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг авч, хараат бус, шударга, хяналт шалгалтыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах

1.3 БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ойн газар


Ойн тухай хуульд 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2022 оны 272 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ойн газрыг байгуулахаар шийдвэрлэн, орон тооны хязгаарыг 38 байхаар баталсан.

Ойн газарт үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан, Ойн тухай хуульд 29 заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 1 заалт, Зөвшөөрлийн тухай хуульд 1 заалт тус тус эрх, үүргийг зааж өгчээ. Мөн Ойн тухай хуульд тус газрын хэрэгжүүлэх 66 чиг үүргийг заасан байна.

Эдгээр чиг үүргийн 15.2% нь бодлого боловсруулах, 24.2% нь хууль тогтоомж болон бодлого хэрэгжүүлэх, 9.1% нь зохицуулах, 7.6% нь хяналт тавих, 33.3% нь захиргааны чиг үүрэг, 10.6% нь бусад чиг үүрэг байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш хугацаанд мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжийн тоо 868 болж, 32.3 хувиар өссөн.

Зураг 18. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын бүтэц



Газрын нийт албан хаагчдын 80 хувь нь ойн аж ахуй, ой судлал, ойн инженер болон байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй албан хаагч байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/428 дугаар тушаалын хавсралтаар “Ойн мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг батлан хэрэгжүүлж, мэргэжлийн байгууллагын эрхийг олгон ажилласан байна. Мэргэжлийн эрх авсан байгууллагуудын 43 хувь нь мод үржүүлэг, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойн дагалт баялгийг хамгаалах);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойн дагалт баялгийг ашиглах);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх);
- Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах).

Ойжуулалт хөтөлбөрт 2022-2025 онуудад улсын төсвөөс олгож байгаа санхүүжилт тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2022 онд 0,3 тэрбум төг, 2023 онд 14,0 тэрбум төгрөг, 2024 онд 45.1 тэрбум төгрөг, 2025 онд 68.3 тэрбум төгрөг батлагдсан.

Жич: Процессын дахин инженерчлэл хийх явцад БОУАӨЯ-аас дээр дурдсан “Ойн мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг хуулиас давсан зохицуулалт агуулсан гэдэг үндэслэлээр хүчингүй болгосон.

Хүснэгт 6. Ойн газрын стратегийн чиглэл

Д/д	Стратегийн зорилт	Үйл ажиллагааны зорилт
1	Ойн нөөцийн судалгаа хийх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох менежмент, чадавхыг бий болгон, хомсдол, доройтлоос сэргийлэх;	<ul style="list-style-type: none"> - Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг явуулж, ойн нөөц, түүний өөрчлөлтийг тооцох - Ойн нөөц түүний хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлтийн талаарх статистик мэдээ, тайлан /үндэсний болон олон улсын түвшинд/-г гаргах - Он мэдээллийн санг эрхэлж, улирал, жил тутам мэдээллийг шинэчилж, баяжуулан, оролцогч бүх талыг мэдээллээр хангах - Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах: - Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох талаар хууль, тогтоомжийг сурталчлах, сургалт, семинар явуулах, хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах.
2	Ойн тогтвортой менежментийг нэвтрүүлж, ойг ашиглах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, экологийн болон эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх;	<ul style="list-style-type: none"> - Ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх, ойгоос гаргах бүтээгдхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, ойн нөөцөд түшиглэсэн эдийн засаг, нийгэм экологийн үр ашгийг сайжруулах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах; - Ой бүхий аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; - Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, үйлдвэрлэлийн огтлол явуулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангах; - Ойн нөөцийг иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах - Хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглах ойн нөөцийн дээд хэмжээг тогтоох санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх - Ойн баялгийг зохистой ашиглах талаар төр засгаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутаг, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын түвшинд зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах;
3	Сор шилмэл модны сайн чанарын үр бэлтгэх, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, ойжуулах үндэсний чадавхыг бий болгон ойгоор бүрхэгдсэн тайлбайн хэмжээг нэмэгдүүлэх;	<ul style="list-style-type: none"> - Ойг нөхөн сэргээх, ойжуулах, тарьц, суулгац ургуулах, модны сайн чанарын үр бэлтгэх ажлын хэмжээг нэмэгдүүлэн, арга технологийг сайжруулж, бодит хүчин чадлыг бий болгох ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах - Ойжуулалт, ойн нөхөн сэргээх ажил болон ойн аж ахуйн бусад арга хэмжээний норматив зардалд дүн шинжилгээ хийж, инфляцийн түвшинтэй уялдуулан тухай бүр өөрчлөлт оруулан шинэчилж байх - Ойг нөхөн сэргээх, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төлөвлөн улсын хэмжээнд зохион байгуулж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах - Мод, сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, тарьц, суулгац ургуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах - Ойг нөхөн сэргээх талаар технологи, норм, нормативын үндэслэл боловсруулах, батлуулах, мөрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх - Экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор байгалийн гамшиг болон хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойг нэн тэргүүнд нөхөн сэргээх
4	Ойн салбарын бүтэц зохион байгуулалт, эрх зүйн орчныг сайжруулж, сохирхогч талуудын оролцоог хангасан "Ойн сайн засаглал"-ыг бий болгох, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, салбарын шинжлэх ухаан, сургалт, боловсролын тогтолцоог сайжруулах;	<ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, ойн сайн засаглалыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох; - Агентлагийн дотоод ажлыг эрхэлж, олон нийттэй харилцах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, гадаад, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан улсын төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан хуваарийн дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах; - Жил бүр хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг экологийн тэнцвэртэй байдлыг хангах зарчимд үндэслэн төлөвлөж, нийлүүлэх бүтээгдэхүүнийг улсын болон орон нутгийн төсөв, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардал зэрэгтэй уялдуулан тооцох; - Ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар журам, дүрэм аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Сумын болон сум дундын ойн ангийг мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангах;

Цаг уур, орчны шинжилгээний газар

Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газрыг байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/32 дугаар тушаалаар “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан байна.

Дээрх хөтөлбөрийн дагуу Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс, Урьдчилан мэдээлэх хэлтэс, Архив, мэдээллийн сангийн хэлтэс, Орчны шинжилгээний хэлтэс, Санхүү, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтэс, Захиргаа аудитын хэлтэс гэсэн 6 бүтцийн нэгжтэйгээр ажиллаж байна.

ЦУОШГ-ын харьяанд Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв болон аймаг, хотын 22 Цаг уур, орчны шинжилгээний төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарт 2025 оны байдлаар 1893 албан хаагч ажиллаж байгаагийн 77 нь Цаг уур, орчны шинжилгээний газарт, 1624 нь аймаг, хотын Цаг уур, орчны шинжилгээний төвд, 98 нь Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд, 36 нь Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторит, 58 нь Нислэгийн цаг уурын төвд ажиллаж байна. Үүнээс 29 төрийн захиргааны, 1864 нь төрийн үйлчилгээний албан хаагчид байна. /Эх сурвал: Цаг уур, орчны шинжилгээний газар/

Усны газар

Засгийн газрын 2020 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрыг 38 орон тоотой байхаар баталсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/49 дугаар тушаалаар Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Усны нөөц, менежментийн хэлтэс, Ус ашиглалт, технологийн хэлтэс, Усны мониторинг, хяналт шинжилгээний хэлтэс гэсэн 4 бүтцийн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай” 110 дугаар тогтоолоор Усны газар нь төсвийн төвлөрүүлэн захирагч байсныг өөрчилж, Сав газрын захиргааны төсөв Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд шууд харьяалагдахаар болсон байна.

Усны тухай хуулийн 16^{1.3}- заасны дагуу 21 усны Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Тус газрын харьяанд 2012 оноос “Монгол-Ус” ТӨААТҮГ-ын дэргэд “Хяналтын Төв Лаборатори” нэртэйгээр байгуулагдаж, 2022 онд тус байгууллага татан буугдсантай холбоотойгоор Усны газрын харьяанд шилжиж ирсэн байна. 2024 оны байдлаар лаборатори нь эрхлэгч-1, химич шинжээч -4 гэсэн 5 орон тоотойгоор Усны хяналт шинжилгээний хэлтсийн бүтцэд төрийн захиргааны албан хаагчдын сул орон тоонд ажиллаж байна.

1.4 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа Улсын төсөвт болон Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бүтэц, чиг үүрэг, орон тоо

“Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” УТҮГ

Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолоор “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” УТҮГ-ыг байгуулж, дүрмийг баталсан байна. Тус төв нь 25 хүний орон тоотой.

Зорилго, чиглэл: “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа, шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх” эрхэм зорилгын хүрээнд “Байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх,

бохирдлыг бууруулах, саармагжуулах, нөхөн сэргээх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх сургалт, сурталчилгааг оновчтой явуулж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг хөгжүүлэх” зорилгыг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх чиг үүрэг:

- Байгаль орчны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Аливаа төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах, саармагжуулах, нөхөн сэргээх;
- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхтэй холбоотой судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгаа явуулах;
- Төв, орон нутгийн байгаль орчны ажилтан, ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судлаач, оюутан, сурагчдад байгаль орчны чиглэлийн хууль тогтоомж, журам, аргачлал, стандартыг сурталчлан таниулах;
- Байгаль орчны чиглэлээр мэдээлэл өгөх, сургах, дадлагажуулах;
- Ой, ус, ургамал, амьтан, газрын нөөц баялгийн экологи, эдийн засгийн үнэлгээ, даацын судалгаа хийж, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлого, арга хэмжээний талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- Үйлдвэрлэлийн технологийн үнэлгээ;
- Агаар, ус, хөрсний бохирдлын судалгаа;
- Монгол Улсад ашиглаж болох химийн хорт болон аюултай бодисын бүртгэл, шинжилгээ;
- Химийн хорт болон аюултай бодистой хамааралтай бохирдлын шинжилгээ, судалгаа хийх;
- Байгальд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарал багатай технологийн зөвлөмж гаргах;
- Олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ

Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 316 дугаар тогтоолоор “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ-ыг байгуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/464 дугаар тушаалаар “ЦУНБХТ” УТҮГ-ын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан бөгөөд 2 алба нийт 28 албан хаагчтай байхаар тогтоосон байна.

Тус төв нь Монгол орны цэнгэг усны нөөцийг хамгаалах, байгаль орчны бохирдол, доройтлын шалтгаан, үр нөлөөг олон нийтэд сурталчлан таниулах, байгаль орчныг хамгаалах талаар УИХ, Засгийн газар, БОУАӨЯ-наас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, олон нийтэд экологийн боловсрол олгох зорилго бүхий эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл сурталчилгааны байгууллага юм. Тус төв нь 4 үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Бүх нийтэд Экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах
2. Цэнгэг усны нөөц болон бусад байгалийн нөөц баялгийг хамгаалах
3. Судалгаа шинжилгээний ажил хийх
4. Байгаль орчны талаарх мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах

“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ТӨААТҮГ

Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан бөгөөд 28 хүний орон тоотой ажиллаж байна.

Тус төвийн дүрэмд “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь Улсын Их Хурал, Засгийн газар, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас уур амьсгалын өөрчлөлтийн талаар гаргасан төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө

санхүүжүүлэх зарчмаар ажилладаг, бие даан иргэний эрх зүйн харилцаанд ордог аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар мөн.” гэж тодорхойлсон байна.

Төвийн үйл ажиллагааны зорилго, чиглэл

1. Төв нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй уур амьсгалын талаарх бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын уялдаа холбоо, идэвх оролцоонд дэмжлэг үзүүлэх, улсын болон олон улсын хэмжээний арга хэмжээ зохион байгуулах, шинэ технологи бий болгох, нэвтрүүлэх талаар байгууллага, аж ахуйн нэгжийн идэвх санаачилгыг дэмжиж, туслалцаа үзүүлэх зорилготой.

2. Төв нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

3. Төв нь дараахь чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

3.1. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох тайлан илтгэлийг бэлтгэх;

3.2. “Уур амьсгалын ногоон сан”-тай уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр ажиллах мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэх;

3.3. Монгол Улс болон Япон Улсын Засгийн газар хоорондын “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” хэлэлцээрийн хүрээнд Хамтарсан кредит олгох механизмын нарийн бичгийн газрын үүргийг гүйцэтгэх

3.4. Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.5. уур амьсгалын нөхцөл байдал, өөрчлөлтийн чиглэлээр эдийн засаг, нийгмийн салбар дамнасан олон улсын дэмжлэг, санхүүжилт бүхий төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

3.6. “Уур амьсгалын үндэсний хороо”-нд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

3.7. Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр төрөл бүрийн судалгаа хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах;

3.8. мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

3.9. эрхлэх асуудлаараа хууль тогтоомжид нийцүүлэн гадаад, дотоодын болон олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, санамж бичиг, гэрээ хэлцэл байгуулах, мэдээлэл солилцох, түүний хэрэгжилтийг хангах, төрөл бүрийн хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулах;

3.10. хуулиар хориглоогүй бусад.

2 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ БУЮУ AS-IS

2.1 БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1.1 Монгол Урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийн чиг хандлага

Сүүлийн хориод жилд дэлхийн улс орнууд эдийн засгийн өсөлтөө эрчимжүүлэх зорилгоор үйлдвэрлэл, техник технологи, инновацын хөгжилд түлхүү анхаарч ирсэн. Гэвч энэхүү хурдацтай хөгжил нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг үлэмж хэмжээгээр ашиглахад хүргэж, үүнийг дагасан нийгэм, эдийн засгийн зардал тогтмол өсөх хандлагатай болсон байна¹⁶. Энэхүү үйлдвэрлэл, хэрэглээний өсөлт нь байгалийн нөөцийн хэт ашиглалтыг нэмэгдүүлснээр аажмаар улс орнуудын урт хугацааны хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Дэлхийн банкны мэдээллээс үзэхэд, 2019 оны байдлаар дэлхийн дундаж температур 1961-1990 оны дунджаас 0.8 хэмээр нэмэгдсэн бол Монгол Улсад 1940 оноос 2015 он хүртэлх хугацаанд агаарын дундаж температур 2.24°C-ээр нэмэгдсэн нь шороон шуурганы тоо олширч, ган гачиг болох нөхцөлийг бүрдүүлж байна.¹⁷ Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харуулж байна. Энэхүү өөрчлөлт нь байгалийн хязгаарлагдмал нөөцийн хэт ашиглалт, бэлчээрийн доройтол зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр улам даамжирч, нийгэм, эдийн засгийн зардлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, техник технологийн дэвшил дэлхий нийтийн хэмжээнд ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлыг бууруулахад тодорхой эерэг нөлөө үзүүлж байгаа боловч улс орнуудын хөгжил, орлогын ялгаатай байдал нь нийгмийн тэгш бус байдал, байгаль орчны дарамт, ажилгүйдэл зэргийг нэмэгдүүлэх хандлагыг дагуулсаар байна. Хурдацтай хөгжил дэвшлийн үр дагаварт үүсэж буй эдийн засаг, нийгэм, байгаль орчны сорилтуудыг шийдвэрлэх, дэлхийн хүн амын тогтвортой, аюулгүй, тав тухтай амьдралын нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 193 гишүүн улсын оролцоотойгоор “Тогтвортой хөгжлийн зорилго–2030” баримт бичгийг баталсан.

Монгол Улс энэхүү олон улсын бодлогын хандлагад нийцүүлэн, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөөцийн хариуцлагатай ашиглалт болон тогтвортой хөгжлийн үндсийг бэхжүүлэх зорилгоор бодлогын баримт бичгүүдийг шат дараатайгаар боловсруулсан. Үүнд, 2008 онд “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, 2016 онд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, улмаар энэхүү үзэл баримтлалд суурилсан “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2020 онд баталсан нь байгаль орчны салбарт тогтвортой хөгжил, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн үндэсний зорилт, зорилго, арга замыг тодорхойлсон. Гэсэн хэдий ч стратеги хэрэгжилтийн түвшинд бодлого, үйл ажиллагаа нь хоорондоо зөрүүтэй, салбар хоорондын уялдаа сул, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх механизмыг бүрдүүлэх, бэхжүүлэх шаардлага бий болж байна.

Эх газрын эрс тэс уур амьсгал, эмзэг экосистемтэй Монгол Улсад дулаарал уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дэлхийн дунджаас 2 (3) дахин их байна¹⁸. Цөлжилт, газрын доройтол нийт нутгийн 76.8 хувьд хүрч¹⁹, бэлчээрийн даац хэтэрч, биологийн төрөл зүйл, экосистем алдагдаж байгаа нь байгаль орчны тогтвортой байдалд ноцтой нөлөөлж байна. Усны хомсдол, агаарын бохирдол, уул уурхайн дарамттай зэрэгцэн хүний эрүүл мэнд, орон нутгийн амьжиргаа, нийгмийн тэгш байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь байгаль орчны асуудлууд нь нийгэм эдийн засгийн суурь хүчин зүйлстэй огтлолцсон, салбар дундын зангилаа асуудал гэдгийг харуулж байна.

¹⁶ United Nations. (2015). *Global Sustainable Development Report 2015 Edition*. Retrieved on April 15, 2025 from <https://www.un.org/en/development/desa/publications/global-sustainable-development-report-2015-edition.html>

¹⁷ Government of Mongolia. (2018). *Third National Communication under the UNFCCC*. Page 124. Retrieved from https://www4.unfccc.int/sites/SubmissionsStaging/NationalReports/Documents/06593841_Mongolia-NC3-2-Mongolia%20TNC%202018%20print%20version.pdf

¹⁸ Чанцалсүрэн, М.(2023). Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал. Улаанбаатар хот. ЯХИС.

¹⁹ Government of Mongolia. (2018). *Third National Communication under the UNFCCC*. Page 167. Retrieved from https://www4.unfccc.int/sites/SubmissionsStaging/NationalReports/Documents/06593841_Mongolia-NC3-2-Mongolia%20TNC%202018%20print%20version.pdf

Иймд байгаль орчны салбарын асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд салбар хоорондын уялдаа холбоо, төр, иргэдийн хамтын хариуцлагыг бэхжүүлэхэд төрөөс анхаарч байна. Ялангуяа хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуй, эрчим хүч, уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлал зэрэг салбарууд байгаль орчны нөлөөллийн гол эх үүсвэрүүдийн нэг бөгөөд эдгээр салбарын хөгжлийг байгальд ээлтэй, дасан зохицох чадвартай, хариуцлагатай хэлбэрээр төлөвлөх нь зайлшгүй юм. Цаашид эдийн засаг-экологийн хос үр ашиг бүхий хөгжлийн загваруудыг нэвтрүүлэх, бодлого төлөвлөлтийг уялдуулах, хэрэгжилтийг үнэлэх тогтолцоог сайжруулахад төрийн бодлого чиглэгдэж байна.

2.1.2 Монгол Улсын байгаль орчны чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц

Байгаль орчны салбарын хариуцаж буй нийтлэг чиг үүрэг нь дэлхийн байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хангахад Монгол Улсын оруулж буй хувь нэмрээр илэрхийлэгддэг.

Монгол Улс Биологийн төрөл зүйлийн тухай НҮБ-ын суурь конвенцод 1993 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр анх нэгдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 12 конвенц, 5 протоколыг соёрхон баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх үүргийг хүлээж, эдгээр конвенцын зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, тайланг тогтсон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Монгол Улс 2024 оны байдлаар байгаль орчны салбарын олон улсын эдгээр баримт бичигт тусгагдсан үүргүүдийг биелүүлэхээр хариуцлага хүлээсэн. Тухайлсан чиглэлээр:

- Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах;
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх;
- Олон улсын худалдаа ба зэрлэг амьтны хамгаалах;
- Химийн бодис, хортой, аюултай хог хаягдлын зохицуулалт;
- Тогтвортой хөгжил ба санхүүжилт.

1. Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах чиглэлээр

1. Биологийн олон янз байдлын тухай конвенц: Биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах, генетикийн нөөцийн ашиглалтын үр өгөөжийг шударга хуваарилах.
2. Нагоягийн протокол (Генетикийн нөөцийн ашиглалтын шударга хуваарилалт ABS): Генетикийн нөөцийг ашигласнаас үүдэлтэй ашиг орлогыг тэгш, шударга хуваарилах.
3. Картагены протокол (Биологийн аюулгүй байдал - Biosafety Protocol): Генийн өөрчлөлттэй организм (GMO)-ын аюулгүй хэрэглээг зохицуулах.

Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил

Конвенц	Үүрэг, амлалт	Хэрэгжүүлэх ажиллагаа	Шалгуур үзүүлэлт буюу хүрэх үр дүн
Биологийн олон янз байдлын тухай конвенц	<ul style="list-style-type: none"> - 2030 он гэхэд нийт газар нутгийн 30%-ийг тусгай хамгаалалтад авах - Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (NBSAP)-ийг хэрэгжүүлэх. - Ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх бодлого хэрэгжүүлэх. - Эдийн засгийн салбаруудад экосистемийн үйлчилгээний үнэлгээ хийх, ногоон хөгжлийн бодлоготой уялдуулах. 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх - Орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх - Генетикийн нөөцийг зохистой ашиглах журам боловсруулах (ABS зохицуулалт) - Зэрлэг амьтдын мониторинг, хамгааллын судалгааг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 30%-д хүрсэн эсэх. - Ховор, нэн ховор амьтдын популяцийн өсөлт 10%-иар нэмэгдсэн эсэх. - Генетикийн нөөц ашиглалтын үр өгөөжийг шударга хуваарилсан гэрээний тоо: 5-аас дээш ABS гэрээ байгуулсан эсэх.

Нагояагийн протокол (Генетикийн нөөцийн ашиглалтын шударга хуваарилалт - ABS)	<ul style="list-style-type: none"> - Генетикийн нөөцийг ашиглах, үр өгөөжийг шударга хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлэх. - Байгалийн гаралтай бүтээгдэхүүн хөгжүүлэх салбарт шударга, тэгш хуваарилалт бий болгох. - Орон нутгийн иргэдийн мэдлэг, уламжлалт арга технологийг хамгаалах. 	<ul style="list-style-type: none"> - Генетикийн нөөц ашиглах зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох - Шударга, тэгш хуваарилалтын (ABS) гэрээ боловсруулах - Орон нутгийн иргэдийн оролцоог хангах, сургалт зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан гэрээний тоо: 5-аас дээш гэрээ байгуулсан эсэх. - Генетикийн нөөцөөс орон нутгийн иргэдэд хүрсэн үр өгөөж: Шударга хуваарилсан орлогын хэмжээ.
Картагены протокол (Биологийн аюулгүй байдал - GMO)	<ul style="list-style-type: none"> - Генийн өөрчлөлттэй организм (GMO)-ын эрсдэлээс сэргийлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах. - GMO-ийн импорт, экспорт, хэрэглээг хянах. 	<ul style="list-style-type: none"> - GMO-ийн аюулгүй байдлын хяналтын системийг бүрдүүлэх - Байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарт био аюулгүй байдлыг сайжруулах - Хүнсний бүтээгдэхүүнд GMO ашиглалтын зохицуулалтыг боловсронгуй болгох 	<ul style="list-style-type: none"> - GMO-ийн хууль эрх зүйн зохицуулалт бий болсон эсэх: Био аюулгүй байдлын хууль, журмын шинэчлэлт хийгдсэн эсэх. - GMO-ийн импортын хяналт шалгалтын тоо: Жилд хяналт тавьсан импортын бүтээгдэхүүний тоо.

2. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх чиглэлээр

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (UNFCCC): Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох бодлого хэрэгжүүлэх.
- Парисын хэлэлцээр (Paris Agreement): Дэлхийн дулааралтыг 1.5°C-аас хэтрүүлэхгүй байх, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах.
- Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенц (UNCCD): Газрын доройтлыг зогсоох, цөлжилттэй тэмцэх, тогтвортой газар ашиглалт дэмжих.

Хүснэгт 8. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил

Конвенцийн нэр	Үүрэг, амлалт	Хэрэгжүүлэх ажиллагаа	Шалгуур үзүүлэлт буюу хүрэх үр дүн
Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенц (UNFCCC) ба Парисын хэлэлцээр	<ul style="list-style-type: none"> - 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7%-аар бууруулах (Үндэсний тодорхойлсон хувь нэмэр - NDC). - Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх. - Нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх зорилгоор "Тэрбум мод" санаачилгыг хэрэгжүүлэх. - Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд хамгийн их өртөх салбаруудын дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг өргөжүүлэх - Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх ("Тэрбум мод" санаачилга) - Үндэсний нүүрстөрөгчийн худалдааны механизмыг хөгжүүлэх - Уур амьсгалын дасан зохицох стратегийг боловсруулах 	<ul style="list-style-type: none"> - 2030 он хүртэл 22.7%-аар бууруулсан эсэх. - Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ - "Тэрбум мод" санаачилгын хүрээнд ойжуулсан талбайн хэмжээ - Дасан зохицох арга хэмжээ хэрэгжсэн салбаруудын тоо
Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенц (UNCCD)	<ul style="list-style-type: none"> - 2030 он гэхэд газрын доройтлыг сааруулах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх. - Бэлчээрийн талбайн 23%-ийг тогтвортой менежменттэй болгох. - Цөлжилтөд хамгийн их өртсөн бүс нутагт нөхөн сэргээх - Ган, аадар бороо зэрэг байгалийн гамшгаас үүдэлтэй нөлөөллийг багасгах арга хэмжээ авах. 	<ul style="list-style-type: none"> - Газрын доройтлыг бууруулах зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлэх - Бэлчээрийн менежментийн бодлого боловсруулж, ухаалаг мал аж ахуйг хөгжүүлэх - Цөлжилттэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах - Ган, хуурайшилттай тэмцэх усны нөөцийн удирдлагыг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээсэн бэлчээрийн хэмжээ - Тогтвортой менежменттэй газрын эзлэх хувь - Цөлжилтийн улмаас доройтсон газрын хэмжээ бууруулах хувь - Ган, хуурайшилттай тэмцэх төсөл, хөтөлбөрийн тоо

3. Олон улсын худалдаа ба зэрлэг амьтны хамгаалах чиглэлээр

- Олон улсын худалдааны ховордсон зүйлийн тухай конвенц: Ховордсон амьтан, ургамлын олон улсын худалдааг хязгаарлах, зохицуулах.
- Нүүдлийн төрөл зүйлийн тухай конвенц: Нүүдлийн зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах.
- Рамсарын конвенц (Ус намгархаг газрыг хамгаалах): Ус намгархаг газар, усны шувууд, усны экосистемийг хамгаалах.

Хүснэгт 9. Олон улсын худалдаа ба зэрлэг амьтны хамгаалах чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил

Конвенцийн нэр	Үүрэг, амлалт	Хэрэгжүүлэх ажиллагаа	Шалгуур үзүүлэлт буюу хүрэх үр дүн
Олон улсын худалдааны ховордсон зүйлийн тухай конвенц (CITES)	<ul style="list-style-type: none"> - CITES-ийн жагсаалтад орсон зүйлүүдийн хууль бус худалдааг зогсоох. - Зэрлэг амьтдын худалдааг хянах, зохицуулах. 	<ul style="list-style-type: none"> - CITES-ийн үндэсний хэрэгжилтийг хангах хууль тогтоомжийг сайжруулах. - Хил, гаалийн хяналтыг чангатгах. - Иргэдэд мэдээлэл өгөх кампанит ажил явуулах. 	<ul style="list-style-type: none"> - CITES жагсаалтад орсон зүйлүүдийн хууль бус худалдааны тохиолдлын бууралт (%). - Хууль бус худалдааны илрүүлсэн хэргийн тоо.
Нүүдлийн төрөл зүйлийн тухай конвенц	<ul style="list-style-type: none"> - Нүүдлийн шилжилт хөдөлгөөний замыг хамгаалах. - Тэдний амьдрах орчныг нөхөн сэргээх. - Бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Нүүдлийн зүйлийн мониторингийн системийг сайжруулах. - Бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх. - Орон нутгийн иргэдийг хамгааллын үйл ажиллагаанд татан оролцуулах. 	<ul style="list-style-type: none"> - Нүүдлийн зүйлийн популяцийн өсөлтийн хувь: 10%-иар нэмэгдсэн эсэх. - Хамгаалагдсан шилжилтийн замын хэмжээ (км)
Рамсарын конвенц	<ul style="list-style-type: none"> - Рамсарын гэрээнд бүртгэлтэй 11 газрыг хамгаалах. - Ус намгархаг газрын экосистемийг хамгаалах, бохирдлоос сэргийлэх. 	<ul style="list-style-type: none"> - Усны чанарын хяналт, мониторинг хийх. - Хамгаалалтын арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Рамсарын хамгаалалттай газрын эзлэх хувь - Усны чанарын мониторингийн тоо

4. Химийн бодис, аюултай хог хаягдлын зохицуулалтын чиглэлээр

- Стокхолмын конвенц (Удаан задардаг органик бохирдуулагчид - POPs): Байгаль орчинд удаан задардаг органик бохирдуулагчийн үйлдвэрлэл, хэрэглээг хязгаарлах.
- Базелийн конвенц (Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөн): Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөнийг хянах, зохицуулах.
- Роттердамын конвенц (Хортой химийн бодисын олон улсын худалдаа): Хортой химийн бодис, пестицидийн олон улсын худалдааг хянах, мэдээлэл солилцох.
- Минаматагийн конвенц (Мөнгөн усны хяналт): Мөнгөн усны хэрэглээг хязгаарлах, хүний эрүүл мэндийг хамгаалах.

Хүснэгт 10. Химийн бодис, аюултай хаягдлын зохицуулалтын чиглэлээр нэгдэн орсон гэрээ, тэдгээрээр хүлээсэн үүрэг, амлалт, хэрэгжүүлэх ажил


Конвенцийн нэр	Үүрэг, амлалт	Хэрэгжүүлэх ажиллагаа	Шалгуур үзүүлэлт буюу хүрэх үр дүн
Стокхолмын конвенц (POPs - Удаан задардаг органик бохирдуулагчид)	<ul style="list-style-type: none"> - POPs бохирдуулагчийн хэрэглээг хязгаарлах, устгах. - POPs агууламжтай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хориглох. - POPs бохирдуулагчийг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр устгах. 	<ul style="list-style-type: none"> - POPs-ийг агуулсан бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийг хянах. - Химийн бодисын зохицуулалтын хууль эрх зүйн орчныг сайжруулах. - POPs бохирдуулагч бүхий хог хаягдлыг аюулгүй устгах, менежмент хийх. 	<ul style="list-style-type: none"> - POPs ялгарлыг бууруулах хувь - POPs бүхий хог хаягдлын бүрэн аюулгүй устгасан эсэх.

<p>Базелийн конвенц (Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөн)</p>	<ul style="list-style-type: none"> - Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөнийг хянах, зохицуулах. - Аюултай хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, аюулгүй устгах. - хил дамнасан аюултай хог хаягдлын тээвэрлэлтэд хатуу зохицуулалт хийх. 	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын менежментийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх. - Аюултай хог хаягдлын экспорт, импортын хяналтыг сайжруулах. - Аюултай хог хаягдлын дахин боловсруулалт, устгалын дэд бүтцийг сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> - Аюултай хог хаягдлын хил дамнасан хөдөлгөөнийг бууруулсан хувь - Аюултай хог хаягдлын боловсруулалт, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх
<p>Роттердамын конвенц (Хортой химийн бодисын олон улсын худалдаа)</p>	<ul style="list-style-type: none"> - Хортой химийн бодис, пестицидийн олон улсын худалдааг хянах. - Импортын өмнө урьдчилан мэдээлэл солилцох тогтолцоо бий болгох. - Монгол Улсад хэрэглэхийг хориглосон хортой химийн бодисыг бүртгэх, мэдээлэх. 	<ul style="list-style-type: none"> - Химийн бодисын хяналт, бүртгэлийн системийг сайжруулах. - Хортой химийн бодисын зохицуулалтын хуулийг шинэчлэх. 	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсад импортлохыг хориглосон химийн бодисын жагсаалтыг бүрэн шинэчилсэн эсэх.
<p>Минаматагийн конвенц (Мөнгөн усны хэрэглээ, хяналт)</p>	<ul style="list-style-type: none"> - Мөнгөн усны хэрэглээг зогсоох, хязгаарлах. - Байгаль орчинд мөнгөн усны тархалтыг багасгах. - Гар аргаар алт олборлох явцад мөнгөн ус хэрэглэхийг хориглох. 	<ul style="list-style-type: none"> - Мөнгөн усны зохицуулалтын хууль, дүрмийг сайжруулах. - Орон нутгийн гар аргаар алт олборлогчдод мөнгөн усгүй технологи нэвтрүүлэх. - Байгальд хаягдсан мөнгөн усны бохирдлыг багасгах нөхөн сэргээлтийн арга хэмжээ авах. 	<ul style="list-style-type: none"> - Мөнгөн усны ялгарал бууруулах хувь - Мөнгөн усгүй технологи нэвтрүүлсэн олборлолтын тоо

Эдгээр олон улсын үзэл баримтлал нь дэлхийн соёл, ховордсон зүйлүүд, байгалийн өвийг хамгаалах, иргэний эрх чөлөө, үндэстэн дамнасан байгаль орчны талаарх маргааныг шийдвэрлэх механизм зэрэг бүс нутгийн байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн байна. Олон улсын өмнө гэрээгээр хүлээсэн үүргийг амжилттай хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын байгаль орчны салбарын хууль тогтоомжийн зохицуулалтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх замаар боловсронгуй болгох шаардлага тулгарч байгааг дараах судалгаагаар илэрхийлэгдэж байна.

Өөрөөр хэлбэл байгаль орчны талаар баримтлах дэлхий нийтийн, бүс нутгийн, үндэсний хэмжээнд байгаль орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд байгаль орчны салбарын үндэсний хууль тогтоомж чухал нөлөө үзүүлэх нь тодорхой.

Зураг 19. Олон Улсын конвенцууд



Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, амлалтад туссан арга хэмжээ нь үндэсний бодлогын баримт бичгүүдэд бүрэн тусгагдаагүй, мөн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлоогүйгээс хэрэгжилтийн явцыг үнэлэх боломжгүй байна.

5. Тогтвортой хөгжил ба санхүүжилт

1. Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs): 2030 он хүртэл тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах.
2. Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга (BIOFIN): Биологийн олон янз байдлыг хамгаалах санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах

Дээрх олон улсын баримт бичигт туссан үзэл баримтлал нь дэлхийн соёл, ховордсон зүйлүүд, байгалийн өвийг хамгаалах, иргэний эрх чөлөө, үндэстэн дамнасан байгаль орчны талаарх маргааныг шийдвэрлэх механизм зэрэг бүс нутгийн байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн байна. Олон улсын өмнө гэрээгээр хүлээсэн үүргийг амжилттай хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын байгаль орчны салбарын хууль тогтоомжийн зохицуулалтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх замаар боловсронгуй болгох шаардлага тулгарч байгааг дараах судалгаагаар илэрхийлэгдэж болно. Өөрөөр хэлбэл байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах дэлхий нийт, бүс нутаг, үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох, амжилттай хэрэгжүүлэхэд байгаль орчны салбарыг зохицуулсан хууль тогтоомж гол нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хэмжээнд нэгдэн орсон дээрх гэрээ, конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой чиг үүргийг дотоодын хууль тогтоомжид хэрхэн туссан байдлын судалгааг салбарын 22 хуулийн зорилго болон эрх олгосон заалт нь хангаж байгаад дүн шинжилгээ хийхэд 30-34 хувийн нийцэлтэй байгааг шинжилгээнээс харж болох юм.

Дүгнэлт:

- Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн амлалт, үүрэгт туссан арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр салбарын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгаж өгөөгүйгээс хэрэгжилтийн явцыг тодорхойлох боломжгүй байна.

- Монгол Улсын хувьд олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн харилцан хамаарлын асуудлыг олон улсын гэрээ нь соёрхон батлагдсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин

төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил ба гэрээнээс үүсэх үүргийг ёсчлон биелүүлэх талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан байдаг ч зарим тохиолдолд хуулиар зохицуулаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой бэрхшээлүүд салбарын хэмжээнд тулгарч байна.

- Шинжилгээнээс олон улсын өмнө гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг зохицуулахыг эрмэлзэж хуульчлагдсан хууль тогтоомж нь харьцангуй сүүлд батлагдсан хуулиуд байна.

2.1.3 Байгаль орчны салбарын хууль, эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ

Хууль тогтоомжоор тодорхойлсон яамны чиг үүргийн талаарх судалгааны үр дүн

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газрын хууль тогтоомжоор олгосон чиг үүрэг нь яам болон агентлагийн нийтлэг чиг үүрэгтэй нийцэж буй эсэхийг харьцуулах байдлаар судаллаа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хууль тогтоомжоор оноосон чиг үүргийг тодорхойлон шинжлэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль болон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хуулиуд болох Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, түүнчлэн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан бусад хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 36 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд судалгааг хийв.

Ойн газарт хууль тогтоомжоор олгосон чиг үүргийг тодорхойлон шинжлэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Ойн тухай хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/418 дугаар тушаалаар баталсан Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд судалгааг хийлээ.

Мөн энэхүү судалгаагаар хууль тогтоомж, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан тухайлсан чиг үүрэг хоорондын нийцэл, зөрчил, уялдааг тодорхойлохыг зориогүй болно.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хууль тогтоомжоор оноосон чиг үүргийн судалгаа

Монгол Улсын яам: Яамны эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд яамыг "...Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж тодорхойлжээ.

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдын эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлэх ерөнхий чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон:

Стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх;

Хэрэгжилтийг нь зохицуулахад мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх;

Хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх.

Дээр дурдсан яамны ерөнхий чиг үүргийн хүрээнд эрхлэх нийтлэг ажлыг Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд эдгээр чиг үүрэг, эрхлэх асуудал нь Монгол Улсын аливаа яамны нийтлэг ажил, чиг үүрэг юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хуулиар оноосон чиг үүрэг

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлыг дараах байдлаар тодорхойлсон:

	ногоон хөгжлийн бодлого;
Монгол Улсын	байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
Засгийн газрын	усны нэгдсэн бодлого;
тухай хуульд	цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх	усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
асуудлыг дараахь	ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;
байдлаар тодорхойлсон:	байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал; биоаюулгүй байдлын бодлогын асуудал; салбарын мэргэжлийн хяналтын асуудал; төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал; агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

Үүнээс үзэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд үндсэн 3 бодлого, 6 асуудал, 1 мэдээллийн сангийн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар "...бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг..." эрхлэхээр байна.

Өмнөх хэсэгт дурдсан яамны нийтлэг чиг үүргийн дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам эрхлэн гүйцэтгэнэ.

Түүнчлэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргийг салбарын нийтлэг асуудлыг зохицуулсан 4 хуулиар тодорхойлсон бөгөөд эдгээр нийтлэг чиг үүргийн хүрээнд нарийвчилсан чиг үүргийг салбарын бусад 18 хуулиар тодорхойлжээ.

Яамны эрхлэх нийтлэг чиг үүрэг болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны одоогийн нөхцөл байдлын харьцуулалт

Яамны эрхлэх нийтлэг чиг үүрэг болон салбарын хууль, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, хөтөлбөрт тусгагдсан чиг үүргийг харьцуулахын тулд чиг үүрэг нэг бүрийг дараахь байдлаар ангилан авч үзлээ:

- Бодлого боловсруулах, тодорхойлох;
- Хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх;
- Зохицуулах /зөвшөөрөл олгох, хориглох, хязгаарлах гэх мэт/;
- Хяналт тавих;
- Захиргааны /зохион байгуулалт, уялдаа холбоог хангах, удирдлагаар хангах гэх мэт/
- Бусад

Яамны эрх зүйн байдлын тухай хуулиар яаманд хуулийн 13 заалтаар 28 нийтлэг чиг үүргийг оноосон байна.

Зураг 20. Яамны нийтлэг чиг үүрэг



Яам нь нийтлэг ямар чиг үүрэг гүйцэтгэхийг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоохдоо нийт үйл ажиллагааныхаа 80 орчим хувийг бодлого боловсруулах, бодлого тодорхойлоход зарцуулахаар тусгасан байна.


Харин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хуулиуд /Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль/-иар нийт 132 чиг үүргийг олгосон байна.

Эдгээр чиг үүргийг дээрх аргачлалтай адилаар тооцож үзэхэд нийт чиг үүргийн 45.7% нь бодлого боловсруулах, батлах, 19.0% хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, 6.7% нь зохицуулах, 10.5% нь хяналт тавих, 17.1% нь захиргааны, 1.0% нь бусад чиг үүрэг байна.

Зураг 21. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын гол 4 хуулиар оноосон чиг үүрэг

Мөн салбарын үндсэн харилцааг зохицуулсан дээрх 4 хуулиас гадна, салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан 18 хууль, нийт 22 хуулиар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд нийт 337 заалтаар 442 чиг үүрэг оноожээ. Эдгээрийг дээрх аргачлалаар ангилбал, 46.4% нь бодлого боловсруулах, батлах, 13.6% нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх, 15.8% нь зохицуулах, 8.1% нь хяналт тавих, 14.7% нь захиргааны, 1.4% нь бусад чиг үүрэг байна.

Зураг 22. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын гол 4 хуулиар оноосон чиг үүрэг



Түүнчлэн, салбарын дараах хуулиудаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд оноосон чиг үүрэг дэх бодлого боловсруулах, батлах чиг үүргийн эзлэх хувь харьцангуй бага

буюу Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон яамны эрхлэх нийтлэг чиг үүргээс зөрүүтэй харьцаагаар тусгагдсан байна. Үүнд:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар яаманд 20 заалтаар нийт 23 чиг үүрэг оноосны 8 буюу 34.8% нь бодлого боловсруулах;
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулиар яаманд 14 заалтаар нийт 15 чиг үүрэг оноосны 3 буюу 20% нь бодлого боловсруулах, 9 буюу 60% нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар яаманд 16 заалтаар 21 чиг үүрэг оноосны 8 буюу 38.1% нь бодлого боловсруулах, 9 буюу 42.9% нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх;
- Байгалийн ургамлын тухай хуулиар яаманд 12 заалтаар 13 чиг үүрэг оноосны 4 буюу 30.8% нь бодлого боловсруулах;
- Амьтны тухай хуулиар яаманд 39 заалтаар 54 чиг үүрэг оноосны 17 буюу 31.5% нь бодлого боловсруулах, 22 буюу 40.7% нь зохицуулах;
- Газрын хэвлийн тухай хуулиар яаманд 7 заалтаар нийт 11 чиг үүрэг оноосны 3 буюу 27.8% нь бодлого боловсруулах;
- Хувиргасан амьд организмын тухай хуулиар яаманд 10 заалтаар 10 чиг үүрэг оноосны 2 буюу 20% нь бодлого боловсруулах чиг үүрэг байгаа бол хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон зохицуулах чиг үүрэг тус бүр 30%-ийг эзэлж байна.
- Генетик нөөцийн тухай хуулиар яаманд 24 заалтаар нийт 38 чиг үүрэг оноосны 7 буюу 18.4% нь бодлого боловсруулах, 17 буюу 44.7% нь захиргааны чиг үүрэг байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан зорилт

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан яамны зорилтыг чиг үүрэг бүрээр мөн дээрхийн адил ангилан ангилан авч үзлээ. /Жич: Хөтөлбөрт хэрэглэсэн “зорилт” гэсэн нэр томъёо нь агуулгын хувьд яамны өдөр тутам хэрэгжүүлэх ажил үүргийг илэрхийлсэн байх тул эдгээр зорилтыг чиг үүрэгт хамааруулж тооцсон болно./

Үүнд:

- судлах, боловсруулах, батлах

- нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах


- хэрэгжүүлэх

- хянах

Шинжилгээгээр хөтөлбөрт 55 зорилтоор 135 чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас 19 буюу 14.1% нь бодлого боловсруулах, 32 буюу 23.7% нь бодлого, хууль хэрэгжүүлэх, 15 буюу 11.1% нь хяналт тавих, 66 буюу 48.9% нь захиргааны, үлдсэн нь бусад чиг үүрэг байна.

Үүнээс үзэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт яам бодлого боловсруулах чиг үүргээс илүүтэй бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүргийг түлхүү хэрэгжүүлэхээр тусгасан нь яаманд хууль тогтоомжоор оноосон нийтлэг чиг үүрэгтэй нийцээгүй гэж дүгнэж болохоор байна.

Зураг 23. Хөтөлбөрт тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зорилт, чиг үүрэг



Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулиар аливаа яам үйл ажиллагаандаа нийтлэгээр бодлого боловсруулах, тодорхойлох чиг үүргийг түлхүү хэрэгжүүлэхээр заасан. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хувьд, салбарын хуулиар тус яаманд оноосон нийт чиг үүргийн тал орчим нь бодлого боловсруулах, тодорхойлох, батлах чиг үүрэг байгаагаас үзэхэд, салбарын нийт эрх зүйн орчны хүрээнд яамны нийтлэг чиг үүргийн харьцааг харьцангуй хадгалсан байх бөгөөд яам өөрийн хариуцсан салбарын бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа төвлөрүүлэн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

Гэвч салбарын тухайлсан харилцааг зохицуулсан доорх хуулиудаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд оноосон чиг үүргийн хувьд яамны эрхлэх чиг үүргийн зохистой харьцаа алдагдаж, бодлого боловсруулах, тодорхойлох чиг үүргээс илүүтэй хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэг түлхүү тусгагдсан байгааг анхаарах нь зүйтэй. Үүнд:


- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль;
- Байгалийн ургамлын тухай хууль;
- Амьтны тухай хууль;
- Газрын хэвлийн тухай хууль;
- Хувиргасан амьд организмын тухай хууль;
- Генетик нөөцийн тухай хууль;

Харин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасан нийт чиг үүргийн ердөө 14.1% нь бодлого боловсруулах, эсрэгээр, 48.9% нь захиргааны чиг үүргийг гүйцэтгэхээр байгаа нь яамны чиг үүргийн 80 орчим хувь нь бодлого тодорхойлох, боловсруулах, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахаар хуульд заасан шаардлагатай нийцэхгүй байна.

Судалгаанд нийт хүчин төгөлдөр хуулиас байгаль орчны салбарын хуулийг ангилах, салбарын хуулиуд болон хүчин төгөлдөр нийт хуульд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбартай холбоотой журам, заавар, бусад эрх зүйн акт батлах талаарх заалтын судалгаа, эдгээр эрх зүйн актууд батлагдсан эсэх, түүнчлэн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомжоос бусад эрх зүйн актууд хуулийн дагуу хүчин төгөлдөр болсон эсэхийг гаргахыг зорилоо.

Мөн тус салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа эрх зүйн орчны ерөнхий хүрээг тогтоон, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудаас тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн актуудыг тодорхойлж, түүнийг зохицуулах харилцааны төрлөөр нь ангиллаа.

Зураг 24. Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын үйл ажиллагаанд нийт 44 хууль, 94 эрх зүйн акт /дүрэм, журам, бусад хэм хэмжээний акт/ мөрдөгдөж байна.

Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх ажлын хүрээнд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хууль тогтоомжид хийсэн судалгааны үр дүнгийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг тодорхойлоход:

1. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020-2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг судалж үзэхэд 2021 онд өргөн мэдүүлэх 5, 2022 онд өргөн мэдүүлэх 2, үүнээс тогтоосон хугацаанд өргөн мэдүүлээгүй 1, батлагдсан 6 хууль байна.
2. Харин Монгол Улсын хууль тогтоомжийг 2024-2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг судалж үзэхэд 2025 онд боловсруулан батлуулах 11 хуулийн төсөл, 2026 онд боловсруулан батлуулах 1 хуулийн төсөл тус тус тусгагдсан бөгөөд бүгд боловсруулалтын шатанд байна.

Хуулиар эрх олгогдон батлагдсан эрх зүйн актын төрөл, зохицуулах харилцааны харьцуулалт:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт мөрдөгдөж байгаа 22 хуульд эрх зүйн акт /дүрэм, журам/-ыг батлахаар эрх олгосон 138 заалт байгаагаас холбогдох 94 эрх зүйн акт /дүрэм, журам/-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Хүснэгт 11. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичиг

Зохицуулах харилцаа	Нийт	Дүрэм	Журам	Заавар	Жагсаалт	Загвар	Аргачлал	Хөтөлбөр	Дэглэм	Бусад хэм хэмжээний акт
НИЙТ	138	3	60	3	9	24	11	0	20	8
Тусгай хамгаалалттай газар нутгийн харилцаа	4		3							1
Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа болон бусад	11	1	5		2		2		1	
Ургамал хамгаалал	2				1					1
Ойн харилцаа	24		9			13				2
Агаартай холбоотой харилцаа	36		18		1				17	
Байгаль орчныг хамгаалах	7		3			2	2			
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	8		5				3			
Усны харилцаа	22	2	9	2	1	4	2		1	1

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Амьтны харилцаа	2	1				1
Хог хаягдлын харилцаа	8	2	1	2	1	2
Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээ	3					3
Генетикийн нөөцтэй холбоотой харилцаа	8	3		1	4	
Салбар дундын харилцаа		2		1		

Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.” гэж заасан, мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр эрх зүйн акт мөн боловч 24 буюу 25.5 % нь хуулиас давсан зохицуулалтыг тусгасан байна.

Хүснэгт 12. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдын батласан эрх зүйн баримт бичиг

Зохицуулах харилцаа	Баталсан субъект	Нийт дүн	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд					Ойн газар	БОУАӨС бусад салбарын сайдтай хамтарсан			
			Дүрэм	Журам	Заавар	Жагсаалт	Бусад хэм хэмжээний акт	Журам	Журам	Жагсаалт	Бусад хэм хэмжээний акт	
НИЙТ		97	2	26	1	4	16	2	12	4	30	
Тусгай хамгаалалттай газар нутгийн харилцаа		4		3			1					
Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа болон бусад		8		1					4	1	2	
Ургамал хамгаалал		3					1		1	1		
Ойн харилцаа		12		5			3	2	2			
Агаартай холбоотой харилцаа		20				1			1		18	
Байгаль орчныг хамгаалах		6	1	2			2			1		
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ		7	1	4			1				1	
Усны харилцаа		16		6		1	3		1		5	
Амьтны харилцаа		1		1								
Хог хаягдлын харилцаа		8		1	1	1	3			1	1	
Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээ		1		1								
Генетикийн нөөцтэй холбоотой харилцаа		4		2		1	1					
Салбар дундын харилцаа		7					1		3		3	

Хүснэгт 13. Бусад эрх зүйн баримт бичиг

	ТХГНХ	ХХБАБ	Ургамал	Ой	Агаар	БОХ	БОНБУ	Ус	Амьтан	Хог хаягдал	УЦУОХШ	Генетик	Салбар дунд
НИЙТ	6	11	2	24	36	7	8	22	2	8	3	8	3
Дүрэм		1						2					
Журам	3	5		9	18	3	5	9	1	2		3	2
Заасар	2							2		1			
Жагсаалт		2	1		1			1		2		1	1
Загвар				13		2		4		1		4	
Аргачлал		2				2	3	2		2			

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

Дэглэм	1	17	1	1
Бусад	1	1	2	3

Хүснэгт 14. Хуулиар эрх олгогдсон боловч батлагдаагүй эрх зүйн актын төрөл, батлах субъектын харьцуулалт:


Батлах субъект	Нийт	Байгаль орчин, уур амьсгарын өөрчлөлтийн сайд	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бусад салбарын сайдтай хамтарсан	Ойн газар
Нийт	44	35	8	1
Дүрэм	3	3		
Журам	13	10	3	
Заавар	1		1	
Жагсаалт	3	3		
Загвар	4	4		
Аргачлал	4	3	1	
Хөтөлбөр	0			
Дэглэм	0			
Бусад хэм хэмжээний акт	16	12	3	1

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаатай холбоотой салбар дундын асуудлыг зохицуулсан 35 эрх зүйн баримт бичиг /дүрэм, журам, заавар гэх мэт/ батлагдаагүй, мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бусад салбарын сайдтай хамтран батлахаар холбогдох хууль, тогтоомжид тусгагдсан 8, Ойн газар 1 эрх зүйн баримт бичиг /дүрэм, журам, заавар, жагсаалт, хөтөлбөр, бусад хэм хэмжээний акт/-ийг батлаагүйгээс байгаль орчны салбарын үйл ажиллагаатай уялдах бусад салбарын хамтын ажиллагаанд хүндрэл учруулах, оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах боломжгүйд хүрэх нөхцөл бүрдсэн байж болзошгүйг харуулж байна.

Зураг 25. Батлагдаагүй эрх зүйн баримт бичгийн зохицуулах харилцаа



Зураг 26. Батлах субъект



Хүснэгт 15. Байгаль орчны багц хуулиар эрх олгогдсон эрх зүйн акт

Баталсан субъект Зохицуулах харилцаа	Нийт дүн	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд					Ойн газар	БОУАЭС бусад салбарын сайдтай хамтарсан		
		Дүрэм	Журам	Заавар	Жагсаалт	Бусад хэм хэмжээний акт	Журам	Журам	Жагсаалт	Бусад хэм хэмжээний акт
Нийт	45	3	9	8	21		1		3	
Агаар	2			1	1					
Амьтан	9			3	5				1	
Ашигт малтмал	1			1						
Байгалийн ургамал	2			1	1					
Газрын хэвлий	1								1	
Байгаль орчныг хамгаалах	3	1	1	1						
Тариалан	1				1					
Хог хаягдал	2				2					
Тусгай хамгаалалттай газар нутаг	4		1		2		1			
Ой	8	1	4		3					
Ус	3				3					
Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх	2				2					
Салбар дундын харилцаа	7	1	3	1	1				1	

Дүгнэлт

Хуулиар эрх олгогдсон харилцааг журамлаагүй, захиргааны хэм, хэмжээний актын бүртгэлд бүртгүүлээгүйгээс тухайн эрх зүйн актаар зохицуулагдах үйл ажиллагаа, эрх зүйн харилцаанд зөрчил үүсгэх, зөрчил үүссэн тохиолдолд холбогдох асуудлыг шийдвэрлэх, зохицуулахад болон төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж, доголдол үүсгэж болзошгүй байна.

Иймд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам болон бусад эрх зүйн хэм, хэмжээний актыг боловсронгуй болгох, мөн хууль, журмаар зохицуулаагүй үйл ажиллагаа, эрх зүйн харилцааг журамлах замаар тус салбарын хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрх зүйн системчлэлийн аргуудаас консолидаци эсхүл кодификацийн аргыг ашиглах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1) Кодификаци бол хуучирсан хэм хэмжээ, зарчмыг халах, хийдлийг арилгах, шинэ хэм хэмжээг тогтоох үндсэн зорилтыг агуулдаг бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээнүүдийг агуулгын хувьд нэгтгэн боловсруулах үндсэн дээр шинэ эрх зүйн актыг бүтээн төрөлжүүлэх ажиллагаа юм. Энэ аргыг сонгосон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан 1) газар, түүний хэвлий; 2) ой; 3) ус; 4) амьтан; 5) ургамал; 6) бусад баялаг; гэсэн дарааллын дагуу төрөлжүүлэн нэгтгэх боломжтой.


2) Консолидаци нь өнгөрсөн хугацаанд бий болсон нэг салбарын харилцааг зохицуулж байгаа олон тооны хуримтлагдсан олон дахин давтагдсан, үл зөвшилцсөн, зөрчилдсөн актуудын олонлогийг арилгах буюу тэдгээрийг нэгтгэн нэг багц хууль болгох нэгтгэн төрөлжүүлэх арга ажиллагаа юм. Энэ тохиолдолд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд бусад хэм хэмжээг нэгтгэх хувилбар байж болох юм²⁰.

Ойн газарт хуулиар оноосон чиг үүрэг

Монгол Улсын хэмжээнд ойн салбартай холбоотой үүсэх харилцааг 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар зохицуулж байна.

Тус хуулиар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газрыг “улсын хэмжээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж тодорхойлсон ба хуулийн 27 заалтаар Ойн газарт нийт 66 чиг үүрэг оноожээ.

Зураг 27. Ойн тухай хуульд заасан чиг үүрэг



Эдгээр чиг үүргийг мөн адил дээр дурдсан аргачлалаар ангилахад, нийт чиг үүргийн 15.2% нь бодлого боловсруулах, 24.2% нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх, 9.1% нь зохицуулах, 7.6% нь хяналт тавих, 33.3% нь захиргааны, 10.6% нь бусад чиг үүрэг байна.

Үүнээс үзэхэд, Ойн тухай хуулиар Ойн газарт оноосон чиг үүргийн харьцаа нь Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон аливаа агентлагийн хэрэгжүүлэх нийтлэг чиг үүргийг харьцаатай нийцэж байх бөгөөд Ойн газрын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэмжээнд бодлого боловсруулах, хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүргүүд харьцангуй зохистой, тэнцвэртэй харьцаагаар тусгагдсан байна.


Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ

Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт хэрэгжүүлэх 23 арга хэмжээний хүрээнд нийт 55 чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Эдгээр чиг үүргийг өмнөх аргачлалаар ангилахад, нийт 55 чиг үүргийн 18.2% нь бодлого боловсруулах, 21.8% нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх, 5.5% нь хяналт тавих, 54.5% нь захиргааны чиг үүрэг байна

²⁰ "Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа" 2023 он

Зураг 28. Хөтөлбөрт тусгагдсан Ойн газрын зорилт, чиг үүрэг



Үүнээс үзэхэд Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүргийн харьцаа нь Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай болон Ойн тухай хуулиар тодорхойлсон чиг үүргийн харьцаатай нийцэж байх бөгөөд бодлого боловсруулах, хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүргүүд харьцангуй зохистой, тэнцвэртэй харьцаагаар тусгагдсан байна.

Дүгнэлт

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар аливаа агентлаг үйл ажиллагаандаа өөрийн хариуцсан салбар, хүрээний хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүргийг түлхүү хэрэгжүүлэхээр заасан.

Засгийн газрын агентлаг-Ойн газрын хувьд, салбарын харилцааг зохицуулсан Ойн тухай хууль болон байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт тусгагдсан тус газрын чиг үүргийн дийлэнх нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэг байх ба бодлого боловсруулах чиг үүргийн харьцаа нь хуулиар тодорхойлсон нь Засгийн газрын агентлаг үйл ажиллагаагаа хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэгт төвлөрүүлэх хуулийн шаардлагад нийцэж байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын нийт 22 хуулиар оноосон чиг үүргийн 50 орчим хувь нь бодлого боловсруулах, тодорхойлох чиг үүрэг байгаагаас үзэхэд, салбарын нийт эрх зүйн орчны чиг үүргийн харьцаа нь Яамны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон шаардлагад нийцэж байх ба яам өөрийн хариуцсан салбарын бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа төвлөрүүлэн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гэвч салбарын тухайлсан харилцааг зохицуулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Газрын хэвлийн тухай, Хувиргасан амьд организмын тухай, Генетик нөөцийн тухай хуулиар тус тус яаманд оноосон чиг үүргийн хүрээнд дээр дурдсан чиг үүргийн зохистой харьцаа алдагдаж, бодлого боловсруулах, тодорхойлох чиг үүрэг харьцангуй бага, эсрэгээр хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэг түлхүү тусгагдсан нь Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангахгүй байна.

Түүнчлэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасан нийт чиг үүргийн ердөө 14.1% нь бодлого боловсруулах, эсрэгээр, 48.9% нь захиргааны чиг үүргийг гүйцэтгэхээр байгаа нь яамны чиг үүргийн 80 орчим хувь нь бодлого тодорхойлох, боловсруулах, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахаар хуульд заасан шаардлагатай нийцэхгүй байна.

Харин Ойн тухай хууль болон Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт тусгагдсан Ойн газрын хэрэгжүүлэх чиг үүргийн дийлэнх нь хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэг байх ба бодлого боловсруулах чиг үүргийн харьцаа нь хуулиар тодорхойлсон шаардлагатай нийцсэн гэж дүгнэж байна.

2.1.4 Байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, түүний уялдаа

Монгол Улсын Засгийн Газраас байгаль орчны салбарын асуудлууд болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах хүрээнд тус салбарын бодлогын арга хэмжээ, зорилтуудыг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг 29. Байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогын баримт бичгүүд



Монгол Улсын хөгжлийн бодлогын дээрх баримт бичгүүдэд салбарын чиг үүргийн асуудлаарх зорилтыг тусган уялдааг хангахыг зорьж байна. Үүнд:

Зураг 30. Урт, дунд, богино бодлогын баримт бичигт туссан салбарын асуудлаарх тоон судалгаа



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн "Алсын хараа 2050"-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын чиг үүрэгтэй холбоотой 4 зорилгын 8 зорилтын 74 үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна. Үүнд:

Монгол Улс нь байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нийт хүн амд хүртээж, хүний амьдрах орчин, амьдралын чанарыг сайжруулахаар дээрх баримт бичгийн гүйцэтгэлийг хянах шалгуур үзүүлэлтийн 74 арга хэмжээний хүрээнд 15 шалгуур үзүүлэлт

тодохойлсон байгаа нь арга хэмжээ бүрийн гарц, үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуур тодорхойлогдоогүй байгааг харуулж байна.

Зураг 31. Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиг үүргийн хэмжээнд туссан зорилго, зорилтын тоон схем




Зураг 32. Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгээр батлагдсан шалгуур үзүүлэлтэд хийсэн шинжилгээний дүгнэлт



Энэхүү баримт бичигт туссан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг уялдуулан баталж, хэрэгжилтийг судал үзэхэд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Алсын хараа 2050” баримт бичигтэй уялдааг хангуулан төлөвлөсөн байдал нь дунджаар 59 хувь байна.

Зураг 33. Урт, дунд бодлогын баримт бичгийн уялдаа



Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдаатай төлөвлөх, урт хугацааны бодлогын зорилгыг хэрэгжилтийг явцдаа бүрэн хангуулах зорилгоор 9 төрлийн баримт бичгээр 363 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 онд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хариуцах чиг үүргийн хүрээнд үнэлгээ хийхэд дараах үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжилтийн үнэлгээ бодлогын баримт бичгийн төрлөөр

№	Баримт бичгийн нэр	Чиглэлийн зохицуулалтын тоо	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ
1	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	40	-	-
2	Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	74	2024	50.27
3	Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	13	2023	44.8
4	Олон улсын гэрээ конвенц	22	-	-
5	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	75	2023	58.7
6	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	27	2023	65.2
7	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	10	2024	41.3
8	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	49	2024	71
9	Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	53	-	-

Салбарын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дунд болон богино хугацаанд төлөвлөн ажиллахдаа уялдаа холбоогүй төлөвлсөн байна. Нөгөөтэйгүүр Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн дагуу хийсэн Алсын хараа-2050 бодлогын арга хэмжээний хэрэгжилтийн явцын дүнг 2024 оны 08 дугаар сарын байдлаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тушаалаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-аар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны чиг үүргийн

хүрээнд хамрах зорилтын биелэлтийг үнэлсэн байна. Зорилтыг үнэлэхдээ холбоотой батлагдсан шалгуур үзүүлэлтийн 2025 онд хүрэх түвшинд гүйцэтгэгдсэн эсэхийг эхэнд тавьсан болно.

Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн Хүний хөгжил-хүнд ээлтэй амьдрах орчин зорилгын “2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана” зорилтын хүрээнд 3 үйл ажиллагаа нь дараах хэрэгжилттэй үнэлэгдсэн байна.

Зураг 34. Алсын хараа-2050 Зорилго 2-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ



Төлөвлөлтийн хувьд дээрх 3 зорилтын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй бөгөөд 2024 ны 08 дугаар сарын байдлаар хэрэгжилт дээрх байдалтай буюу зорилтод бүрэн биш ч тодорхой хэмжээний ажил эхлэлийн шатандаа байна.

Түүнчлэн тус урт хугацааны бодлогын баримт бичгийн 6 дугаар зорилго болох Ногоон хөгжлийн хүрээнд үндсэн 4 зорилт болох а) Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална б) Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ в) Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ г) Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна зэрэг 4 зорилтын 64 үйл ажиллагааны хэрэгжилт дараах байдлаар үнэлэгдсэн байна.

Зураг 35. Алсын хараа-2050 Зорилго 6-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ




Төлөвлөлтийн хувьд мөн үйл ажиллагаа бүрийн үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй буюу 64 үйл ажиллагааны хэмжээнд 11 шалгуур үзүүлэлтийг баталсан байгаа нь зорилгыг бүрэн хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Мөн баримт бичгийн 9 дүгээр буюу Улаанбаатар ба дагуул хот-орчин төвтэй шийдэл зорилгын “9.2 дугаар Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно” хүрээнд хэрэгжүүлэх 16 арга хэмжээ нь дараах хэрэгжилттэй байна.

Зураг 36. Алсын хараа-2050 Зорилго 9-т туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ-ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны чиг үүрэгт хамааралтай эдгээр 3 зорилгын хэрэгжилт 52.6 хувь буюу зорилт бүрээр дараах байдалтай үнэлэгдсэн байна.


Зураг 37. Алсын хараа-2050 туссан яамны чиг үүргийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ



Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тус салбарын болон дэмжих чиг үүргийн байгууллагын уялдаа, хамтын ажиллагаа нэн чухал байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам дээрх баримт бичигт туссан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг дараах 15 агуулгын хүрээнд багцлан харуулбал, Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын чиг үүрэгт хамааруулан 4 багцад буюу а) Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээрх арга хэмжээ 10 хувь б) чадавх бэхжүүлэх чиглэлээрх арга хэмжээ 22 хувь в) удирдлага зохион байгуулалт чиглэлээрх арга хэмжээ 41 хувь г) төсөл хөтөлбөрийн чиглэлээрх арга хэмжээ 17 хувь тус тус төлөвлөгдсөн байгаа нь тус салбарын чиг үүрэгт холбоотой арга хэмжээ нь салбар дундын хамтын ажиллагаа, оролцоо, манлайллын хүрээнд бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийг шаардлагатайг харуулж байна.

Зураг 38. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах баримт бичгүүд



Дээрх 4 ангиллаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах 9 баримт бичиг тус бүрт төлөвлөсөн 363 арга хэмжээг дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

Хүснэгт 17. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах баримт бичгүүд, 4 ангиллаар

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт	Эрх зүйн орчинг боловсрон-гуй болгох	Удирдлага, менежмент	Чадавхи бүрдүүлэх	Төсөл, хөтөлбөр
Нийт	363	36	186	81	60
Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	40	6	29	5	-
Олон улсын гэрээ, конвенц	22	-	-	-	22
Алсын хараа-2050	74	5	39	19	11
Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	13	1	5	1	6
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	27	1	22	3	1
Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	75	10	37	21	7
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	49	6	17	20	6
Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	10	-	7	-	3
Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	53	7	30	12	4

Урт хугацааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дийлэнх буюу 51.2 хувийг чиг үүргийн яамны удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа гэж тодорхойлсон бол 22.3 хувийг тухайн чиглэлийн байгууллагын үйл ажиллагаа явуулах барилга байгууламж болон техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, мэдээллийн системийн шинэчлэлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, ашиглахаар тусгасан байна. Дээрх судалгаагаар салбарын бодлого төлөвлөлт, салбарын чиг хандлагын тодорхойлох асуудлаар шинэчлэл төдийлөн тусгагдаагүйг харж болохоор байна.


Цаашлаад бодлогын баримт бичгүүдэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүд нь агуулгын хувьд салбарын эрхлэх асуудлыг тодорхойлсон боловч нэг агуулгад багтах эсхүл салбарын олон улсын чиг хандлагын өөрчлөлтөөр ялгаатай тодорхойлох шаардлагыг хангаагүй нь зарим зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгомжтой тодорхойлоогүйг харуулж байна. Үүнийг дараах зургаас харж болно.

Зураг 39. Бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний тоо (ангиллаар)



Салбарын чиг үүрэгт хамаарах асуудлыг Олон улсын байгууллага, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн зарим шинэчлэлүүд гарч ирсэн 1990-ээд онд **"Орчны бохирдол"** гэсэн тодорхойлолтыг "Агаар, Ус, Хөрс"-ний бохирдол гэсэн 3 ангиллаар ойлгож байсан бол өнөө үед хүний хүчин зүйлсийн нөлөөллөөс хамааран дараах 9 төрлийн бохирдлыг орчны бохирдол гэж томъёолох болсон байна.

Зураг 40. Орчны бохирдолын тодорхойлолт



Дээрх олон улсын чиг хандлагын хүрээнд “орчны бохирдол” гэдэг нэршил Монгол Улсын байгаль орчин, орчин уур амьсгалын өөрчлөлтийн салбарын эрхлэх асуудалд хамаарахгүй ангилал нэмэгдэж байгаа нь тухайн салбарын эрхлэх асуудал, хамрах хүрээг илүү тодорхой болгох, цогцоор нь авч үзэх хэрэгцээ шаардлага бий болсон гэж үзэж байна.

Энэ салбарт хамаарах бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо болон зорилго, зорилт, арга хэмжээг хэрхэн томъёолсныг харьцуулан доорх хүснэгтэд харуулав.

Зураг 41. Бодлогын уялдаа холбоо-бодлого-хууль-төлөвлөлтийн уялдааг хангах процессын шинжилгээ

Чиглэл	Монгол Улс нэгдэн орсон гэрээ, конвенц	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	Алсын хараа-2050* Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Шинэ сэргэлтийн бодлого	Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны стратеги төлөвлөгөө 2021-2024
Агаарын бохирдол	1	✗	5	✗	3	2	1	3
Амьдрах орчин	✗	2	✗	✗	✗	✗	✗	✗
Байгалийн нөөц	✗	4	2	✗	1	2	✗	✗
Байгаль орчныг хамгаалах	1	2	2	1	✗	5	1	5
Био аюулгүй байдал	10	2	2	✗	✗	1	✗	3
Газар зохион байгуулалт	✗	4	✗	✗	1	✗	✗	2
Газрын доройтол, ашиглалт	✗	2	2	✗	1	4	1	3
Ногоон технологи	✗	✗	9	2	1	9	1	1
Ойн нөөц	✗	1	4	2	3	6	1	3
Орчны бохирдол	✗	3	1	✗	✗	1	✗	2
Тусгай хамгаалалтын газар	✗	✗	4	✗	✗	1	1	✗
Ургамал, амьтны нөөц	3	3	4		3	5	2	3
Усны нөөц	1	9	22	5	7	7	4	13
Хог хаягдал	1	3	8	2	2	4	3	3
Цаг уур	5	5	5	1	7	6	4	9
Цөлжилт	1	✗	1	✗	1	1	1	1
Экосистем	✗	✗	3	✗	1	✗	✗	✗
Нийт	23	40	74	13	31	54	20	51

Тухайлсан асуудлыг авч үзвэл: Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд буюу Засгийн газрын тухай хууль /2024 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/-иар “Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал”-ыг хариуцуулсан байна.

Хүснэгт 18. Яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт хуулиар тусгайлан заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байдал

Яамдын нэрс	Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал
1. Эдийн засаг, хөгжлийн яам	Үгүй
2. Гадаад харилцааны яам	Үгүй
3. Сангийн яам	Үгүй
4. Хууль зүй, дотоод хэргийн яам	Тийм
5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тийм
6. Батлан хамгаалах яам	Тийм
7. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Үгүй
8. Боловсролын яам	Үгүй
9. Зам, тээврийн хөгжлийн яам	Тийм
10. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Үгүй
11. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Тийм
12. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Үгүй
13. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Үгүй
14. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Үгүй

15. Эрчим хүчний яам	Үгүй
16. Эрүүл мэндийн яам	Үгүй

Дээрх хүснэгтэд Засгийн газрын тухай хуулиар эрхлэх асуудалд нь хуульчилан тусгасан “Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал”-ыг яамдууд үйл ажиллагааныхаа стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгасан эсэх асуудлыг харуулав.

Судалж үзэхэд 16 яамнаас 31.25 хувь буюу 5 яам /ХЗДХЯ, БОУАӨЯ, БХЯ, ЗТХЯ, АҮЭБЯ/ нь уг асуудлыг үйл ажиллагааныхаа стратеги, хөтөлбөртөө тусгасан бол 11 яам хуулиар олгосон тухайн асуудлыг орхигдуулсан, нөгөө талаар салбарын яам нь дээрх баримт бичгүүдэд бодлогын зөвлөмж, санал өгсөн эсэх нь тодорхойгүй байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын бодлогын уялдаа (цөлжилт)-г авч үзэхэд:

НҮБ-ын цөлжилттэй тэмцэх суурь конвенц²¹ Тогтвортой хөгжлийн зорилтын 15-р зорилт буюу “Газрын доройтлыг зогсоох, нөхөн сэргээх” зорилттой уялддаг. Монгол улс энэ конвенцод 1996 онд нэгдэн орж, газар ашиглалт, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үндсэн агуулгын хувьд:

Цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах:

- Конвенцын хүрээнд хөдөө аж ахуй болон байгаль орчны тогтвортой менежментийг дэмжих замаар хөрсний доройтол, цөлжилтийн сөрөг нөлөөг бууруулахыг зорьж байна. Энэ нь газар ашиглалт, хөрс хамгааллын арга хэмжээ, нөхөн сэргээлт зэрэг үйл ажиллагааг хамардаг.

Хамтын ажиллагаа:

- Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хоорондын хамтын ажиллагааг чухалчилдаг. Үүнд санхүүжилт, технологийн шилжүүлэг, чадавх бэхжүүлэх дэмжлэгүүд багтана.

Тогтвортой хөгжил:

- Конвенцын зорилго нь зөвхөн байгаль орчныг хамгаалахаас гадна орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад оршино. Иймд цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийг хангах чухал нөхцөл болж байна.

Африкт онцгой анхаарал хандуулах:

- Африк тив нь ган, цөлжилтийн эрсдэлд хамгийн их өртсөн бүс нутгийн нэг тул тус бүс нутагт чиглэсэн тусгай дэмжлэг, арга хэмжээг конвенцын хүрээнд хэрэгжүүлдэг.

Зураг 42. Цөлжилттэй тэмцэх бодлого, төлөвлөлтийн уялдаа

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал батлах тухай	Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Шинэ сэргэлтийн бодлого	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны стратеги төлөвлөгөө 2021-2024
	1		1	1	1	1

- **Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого:**
- 6.2.8.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- **Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл**

²¹ НҮБ-ын цөлжилттэй тэмцэх суурь конвенц буюу англиар United Nations Convention to Combat Desertification (UNCCD) у, 1994 онд батлагдаж, 1996 онд хүчин төгөлдөр болжээ. Монгол улс 1996 онд энэ конвенцод нэгдсэн.

- 6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.
- **Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр**
- Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- **Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр**
- Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газар нутгийг нөхөн сэргээх, элсний нүүлтийг хязгаарлах, баянбүрдийг хамгаалах, сэргээх байгальд ээлтэй, дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх
- **Байгаль орчин, аялал жуулчлалын яамны стратеги төлөвлөгөө 2021-2024**
- Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг зохицуулах Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх"

Дүгнэлт

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Алсын хараа 2050”-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын чиг үүрэгтэй холбоотой 4 зорилго, 8 зорилт, 74 арга хэмжээний хүрээнд 15 шалгуур үзүүлэлтийг тодохойлсон нь эдгээр арга хэмжээ бүрийн гарц, үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуурыг бүрэн, оновчтой үнэлэх боломжгүй байна.

“Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой баталсан дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний уялдаа холбоо дунджаар 59.0 хувь байна.

Байгаль орчны салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц, ургамал, ус, ойн нөөц, биологийн олон янз байдал, орчны бохирдол, агаарын бохирдол, амьдрах орчин гэх зэргээр ойлголт, нэр томъёо, хамрах хүрээг ялгаатай, нэгдсэн байдлаар уялдуулан тодорхойлоогүй байна.

Алсын Хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд салбарын бодлогыг “Ногоон хөгжлийн бодлого”-оор тодорхойлж, зорилт, зорилгууд тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшнийг баталсан ч “Ногоон хөгжил”-ийн бодлого ямар түвшинд хэрэгжиж байгаа нь тодорхой бус байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын Ногоон хөгжлийн бодлогын Эх байгаль анхдагч экосистемтэй холбогдох зорилтыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс бусад баримт бичигт тусгаагүй байна. Энэ зорилт нь байгаль хамгааллын суурь үндэс, цогцоор нь авч үзэх, судлах өргөн агуулга бүхий зорилт тул бодлого, төлөвлөлтөд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Засгийн газрын тухай хуулиар Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд нь хуульчлан тусгасан “Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал”-ыг 11 яам үйл ажиллагааныхаа стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртөө тусгаагүй, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

2.1.5 Салбар дундын уялдаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Монгол Улсын нэгдэн орсон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын олон улсын 17 гэрээ, конвенцоор үүрэг, амлалт авч салбарын хэмжээнд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Эдгээр баримт бичигт нэгдэн орохдоо хүлээсэн үүрэг, амлалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний

нийгмийн байгууллагууд, олон улсын түнш байгууллагууд, эрдэм шинжилгээний болон шинжлэх ухааны байгууллагууд, иргэдийн хамтын оролцоо, уялдаа холбоо, үр дүнтэй хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын бодлогын баримт бичиг, конвенцуудын хэрэгжилтийн зарчим дээр үндэслэн Талуудын хамтын ажиллагааны механизмыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 19. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, оролцоо

Оролцогч тал	Гол үүрэг, оролцоо	Оролцооны хэлбэр
Монгол Улсын Их Хурал (УИХ)	- Байгаль орчны конвенцуудын хэрэгжилтийг дэмжих хууль, тогтоол батлах. - Засгийн газрын бодлогыг хянах, үнэлэх. - Байгаль хамгааллын хөрөнгө оруулалтыг батлах.	Хууль батлах, бодлогын хяналт тавих
Монгол Улсын Засгийн газар	- Олон улсын үүрэг, амлалтуудыг үндэсний бодлоготой уялдуулах. - Байгаль хамгааллын санхүүжилтийн механизмуудыг сайжруулах. - Салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг удирдах.	Улсын хэмжээнд бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)	- Байгаль орчны олон улсын конвенцуудын хэрэгжилтийг удирдах, хяналт тавих. - Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг зохицуулах. - Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs)-ын хэрэгжилтийг хянах, уялдуулах.	Үндэсний бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангуулах Талуудын хамтын ажиллагааг зохицуулах, удирдах
Бусад яамд (ЭЗХЯ, ХХААХҮЯ, ЗТЯ, ЭХЯ, СЯ, ХЗДХЯ, БХБЯ, УУХҮЯ, ЭМЯ, БШУЯ)	- Байгаль орчны асуудлыг салбарын бодлоготой уялдуулах. - Төрийн бодлого, стратегийг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэх.	Салбар хоорондын уялдаа, бодлогын зохицуулалт хийх
Хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд (ГЕГ, ОБЕГ, ОГ, УГ, ЦУОШГ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар гэх мэт)	- Байгаль орчны хууль, бодлогын хэрэгжилтийг хянах, хэрэгжүүлэх.	Үндэсний түвшинд хэрэгжилт, хяналт тавих
Орон нутгийн түвшний төрийн байгууллагууд (Аймаг, сум, дүүргийн захиргаа, Байгаль орчны газар, Гааль, Онцгой байдал гэх мэт)	- Байгаль хамгааллын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх. - Иргэдийн оролцоог хангах, олон нийтэд мэдээлэл түгээх.	Орон нутгийн түвшинд хэрэгжилтийг зохицуулах
Хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд	- Байгальд ээлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх. - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.	Байгальд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа
ТББ, иргэний нийгэм	- Олон нийтийн хяналт тавих, оролцоог нэмэгдүүлэх.	Байгаль хамгааллын үйл ажиллагааг дэмжих
Эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургууль, эрдэмтэд	- Байгаль орчны судалгаа, инноваци хөгжүүлэх.	Шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулах
Олон улсын байгууллагууд (НҮБ, Дэлхийн банк, WWF, GCF, GEF, олон улсын донор байгууллагууд), төсөл хөтөлбөрүүд	- Санхүүжилт, техникийн туслалцаа үзүүлэх.	Олон улсын санхүүжилт, техник туслалцаа

Иргэд, малчид, нөөц ашиглагчдын бүлэг	- Байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах.	Байгалийн нөөцийн менежментэд оролцох
Мэргэжлийн зөвлөл	- Салбарын стандарт, шаардлагыг боловсруулах.	Байгаль орчны удирдлагын сайжруулалт

Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн санал


Энэхүү судалгааны явцад Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлагыг 5 чиглэлийн 18 асуумжаар хийхэд хамгийн олон давтамжтай гарсан саналууд:

- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь зөвхөн БОУАӨЯ-ны хүлээсэн үүрэг бус харин хүн амын амжиргаа, эрүүл мэнд, аюулгүй амьдрах амьдралын чанарыг тогтоон барих, сайжруулах зэрэг шууд болон шууд бус үр нөлөөг үзүүлдэг учраас бусад төрийн захиргааны байгууллагууд нийтээрээ хамтрах шаардлагатай. Нөгөөтэйгүүр бусад байгууллагыг чиг үүргийн хувьд удирдлага аргазүй болон бодлогын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажиллах ерөнхий чиг үүргийн яам байх шаардлагатай байна.
- БОУАӨЯ нь мэргэжилтэнд асуудал очоод шийдвэрлэгдэхгүй цаг алддаг. Бодлого чиглэлээ зөв гаргаагүйн улмаас, төсөл, хөтөлбөрийн мөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл өндөр байна.
- Бодлого тогтвортой, тодорхой биш байна, төсөл, хөтөлбөрүүд олон мэдээллийн сан байгуулсан байдаг ч ашигладаг эсэх, түүнийгээ хөгжүүлж байгаа эсэх нь тодорхой бус.
- Яамнаас нэгдсэн бодлогоор зангидагдахгүй, зохицуулалт нь оновчтой бус учраас, БОУАӨЯ төсөл, хөтөлбөрүүдийг уялдуулж чадахгүй байна.
- Байгаль орчны салбарт олон улсын байгууллага, банк, төсөл, хөтөлбөрүүдээс мөнгө босгож байгаль орчны чиглэлд зарцуулах маш их боломж байна. Иймээс яамнаас бодлогоор зангидах, мэргэжлийн хүнээр яам, агентлагийн албан хаагчдыг бүрдүүлбэл энэ их боломжийг Олон улсын байгууллага, хамтын ажиллагааны хүрээнд ашиглаж чадахаар байна.
- Зарим чиглэлийн төсөл, хөтөлбөр өөрсдөө хамтарч ажилладаг, зарим нэг асуудал дээр үйл ажиллагаа давхцах байдал түгээмэл ажиглагддаг.
- Дата анализ хийх чадамж байхгүй эсвэл хүсэхгүй байгаа тул хөгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.
- Мэдээллийн системийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгох; (- ой гэхэд л 5-6 програм байна.)
- Байгаль маань “үйлчилгээгээ” авч чадахгүй, тэнцвэрт байдал алдагдаж байна, Байгаль өөрөө дохио өгч байгаа, Нэн тэргүүний асуудал болгомоор байна.
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудалд хүнээс үзүүлж буй дарамт, байгалийн гамшигт үзэгдэл ихээр нэмэгдэж байна. Энэ чиглэлд манлайлал үзүүлж ажиллавал Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүд хамтран ажиллахад бэлэн байдаг.
- Байгаль орчны салбарын олон улсын гэрээ, конвенцийг 1 хүн хариуцахаар ажлын ачаалал нэмэгдэж, илүү үр дүнтэй ажиллах боломжийг хязгаарлаж байна.

Салбар дундын бодлого, зохицуулалтаар хангах үндэсний зөвлөл, хороодын талаар

Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны 21 дүгээр тогтоолоор БОУАӨЯ-ны эрхлэх асуудалд хамаарах 2 үндэсний зөвлөл, 2 үндэсний хороог салбар дундын бодлого, зохицуулалтыг хангах зорилгоор байгуулсан байна.

Зураг 43. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамаарах салбар дундын бодлого, зохицуулалтыг хангах Үндэсний зөвлөл, хороо



Усны үндэсний зөвлөл

Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Усны Үндэсний зөвлөл”-ийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй Засгийн газрын 11 гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, ГХЯ, Усны газар, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн төлөөллийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулжээ. Уг Үндэсний зөвлөлийн дэд даргаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд ажиллаж байна.

Зураг 44. Усны үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн



- Усны тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9^{1.1}-д “Усны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын зөвлөмж өгөх, мэдээлэл харилцан солилцох үүрэг бүхий Усны үндэсний зөвлөл байна.”, 9^{1.2}. Усны үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.” гэж хуульчилсан байна.


- Тэгвэл Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Усны Үндэсний зөвлөл”-ийг байгуулахдаа Усны тухай хуулийг зөрчиж, уг зөвлөлийн дэд даргаар байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар шийдвэрлэсэн байна.

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 175 дугаар захирамжаар “Усны үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ыг баталж, зөвлөл нь жилд 2-оос доошгүй удаа хуралдаж, тухайн жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар зохицуулсан ч **бүрэн хэрэгжихгүй байна.**

Уур амьсгалын Үндэсний хороо

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Уур амьсгалын Үндэсний хороо”-г Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан 24 хүний бүрэлдэхүүнтэй УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны дарга, Засгийн газрын 9 гишүүн, ГХЯ, ЗГХХГ, Засгийн газрын 5 агентлаг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зөвлөх, Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай элч, ШУА-ийн ерөнхийлөгч, орон нутгийн байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Уг Үндэсний хорооны дэд даргаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд ажиллаж байна.

Зураг 45. Уур амьсгалын Үндэсний хорооны бүрэлдэхүүн



- Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц /цаашид "Конвенц" гэх/-ийг хэрэгжүүлэх, уур

амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Уур амьсгалын үндэсний хороо байгуулах;"-аар хуульчилсан.

- Харин Засгийн газрын 2023 оны 155 дугаар тогтоолоор баталсан "Уур амьсгалын Үндэсний хорооны ажиллах журам"-ийн 1.1-д уг Үндэсний хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын Парисын хэлэлцээр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцоор хүлээсэн үүрэг болон **"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, цөлжилт, газрын доройтлыг бууруулах** ажлын салбар дундын уялдааг хангах, зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн гэж үйл ажиллагааны хамрах хүрээг өрөгжүүлэн тодорхойлжээ.

- Дээрх журмын 2.1-д "Үндэсний хорооны дарга нь Монгол Улсын Шадар сайд, орлогч дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байна. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны уур амьсгалын асуудал эрхэлсэн нэгжийн дарга байна." гэж заажээ.

- Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор "Уур амьсгалын Үндэсний хороо"-ны бүрэлдэхүүнийг батлахдаа энэ журамд заасан "1 дэд дарга нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байх, нарийн бичгийн дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны уур амьсгалын асуудал эрхэлсэн нэгжийн дарга байна." гэснийг **орхигдуулсан байна.**

- Мөн Үндэсний хорооны үйл ажиллагааг бүтэн жилээр төлөвлөж, хорооны хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж, хууль, журамд тусгайлан заасан асуудлыг хэлэлцэхээр зохицуулсан ч бүрэн **хэрэгжихгүй байна.**

Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын Үндэсний зөвлөл

Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор "Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын Үндэсний зөвлөл"-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ахлуулсан 15 хүний бүрэлдэхүүнтэй Засгийн газрын 2 гишүүн, ЭЗХЯ, АҮЭБЯ, ХХААХҮЯ, Тагнуулын ерөнхий газар, ОБЕГ, ГЕГ, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цөмийн энергийн комисс, ШУА-ын харьяа хүрээлэн, МУИС, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулжээ. Уг Үндэсний зөвлөлийн дэд даргаар Эрүүл мэндийн сайд ажиллаж байна.

Зураг 46. Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн



- Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөл Ерөнхий сайдын дэргэд, салбар зөвлөл холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.” гэж хуульчилсан байна.

- Засгийн газрын 2014 оны 168 дугаар тогтоолоор “Химийн хортой болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг батлуулан ажиллаж байна.


Тус дүрмийн 2.2 дахь хэсэгт Үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байхаар заасан боловч яамны Химийн бодисын нөлөөллийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн уг албан үүргийг давхар хариуцан гүйцэтгэж байна. Мөн дүрмийн 3.11 дэх хэсэгт Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын алба гүйцэтгэхээр зохицуулсан хэдий ч өнөөдрийн байдлаар Ажлын албагүй байна.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсгийг үндэслэн Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих” чиг үүрэг бүхий “Агаарын бохирдолыг бууруулах Үндэсний хороо”-г Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ахлуулсан 23 хүний бүрэлдэхүүнтэй Засгийн газрын 13 гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөл, Ерөнхий сайдын зөвлөл, ОБЕГ, ЦЕГ, Нийслэлийн Засаг даргын асуудал хариуцсан орлогч, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, “Таван толгой

түлш” ХХК-ийн төлөөллийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулжээ. Уг Үндэсний хорооны дэд даргаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч ажиллаж байна.

Зураг 47. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн



Агаарын бохирдолыг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны орон тоог 5 байхаар тогтоож, Үндэсний хорооны ажиллах журмыг батлан ажиллаж байна.

Дүгнэлт:

Бодлогын уялдааны бодит хэрэгжилтэд тулгарч буй гол хүндрэлүүд нь төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхардал, мэдээллийн урсгалын тогтолцооны сул байдал, төлөвлөлтийн уялдаагүй байдал, нэгдсэн үнэлгээнд хариуцлага хандлагын дутагдал зэрэг бүтэц, зохион байгуулалтын шинжтэй дараах сорилтууд байна.

Нэгдүгээрт, БОУАӨЯ, Эдийн Засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), мөн олон улсын болон дотоодын төслийн нэгжүүд бүгд бодлогын уялдаа, үнэлгээ, хяналт шинжилгээтэй холбоотой үүрэг гүйцэтгэж байгаа ч эдгээр байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагын хуваарилалт тодорхой бус, хөндлөн зохицуулалт сул байгаагаас зорилтод бодлого хэрэгжихгүй байх нөхцөл бүрдэж байна.

Хоёрдугаарт, Тогтвортой хөгжлийн зорилт, “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого, салбарын дунд хугацааны төлөвлөлт, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн

мэдээлэл нь нэгдсэн мэдээллийн тогтолцоонд холбогдоогүй, тус тусдаа платформ, мэдээллийн сан ашиглаж байгаа нь мэдээллийн урсгалыг хязгаарлаж, уялдаа, хяналт алдагдахад хүргэж байна.

Гуравдугаарт, Төслийн хэрэгжилт, ахиц дэвшлийг үнэлэхэд ашиглагддаг үзүүлэлтүүд болон шалгуур стандартууд салбар бүрт өөр өөр, олон улсын болон үндэсний түвшинд ч ялгаатай тул нийтлэг үнэлгээний аргачлал, индикаторын тогтолцоо бүрдээгүй байна. Үүний улмаас төсөл, хөтөлбөрүүдийн бодит үр нөлөөг харьцуулах, нэгтгэх, нөлөөллийн дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагддаг.

Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхийн тулд институц хоорондын хариуцлага, мэдээлэл солилцоо, төлөвлөлтийн мөчлөг, үнэлгээний системийг цогцоор нь уялдуулах шаардлага тулгарч байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа байгууллагууд Усны Үндэсний зөвлөл, Уур амьсгалын Үндэсний хороог байгуулсан үндсэн зорилго болох Үндэсний хэмжээний болон салбар дундын зохицуулалт шаардсан бодлогын асуудал болон зөвлөл, хорооны ажиллах журамд заасны дагуу тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, жилд 2-оос доошгүй удаа хуралдах, хагас жил дутамд ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь танилцуулж, шийдвэрлүүлэх хөшүүргийг бүрэн ашиглахгүй байна.

Дээрх үндэсний зөвлөл, хорооны үйл ажиллагаа тухайнсалбарын яам, агентлагтай чиг үүргийн давхардал байгаа эсэхийг дахин нягталж, шаардлагагүй үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах эсхүл өөрчилж салбарын сайд, Засгийн газрын гишүүнээр ахлуулан бодлогын нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй байна.

2.1.6 Туршлага, сургамж

Байгаль орчны хяналтын улсын хорооны дарга, Байгаль орчны сайд асан З.Батжаргал /1990-1996 он/:

Сайд нарын зөвлөлийн харьяанд байсан Цаг уурын алба байгаль орчны чиглэлийн дүрэм, журам, стандарт боловсруулдаг мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Байгаль орчны хяналтын хэлтэс, Экспертизийн хэлтсийг байгуулан ажиллаж байх үед Засгийн газарт Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллага байх ёстой гэдэг саналыг салбарын хэсэг нөхдийн хамт тавьж, 1987 оны 12 дугаар сард Байгаль орчныг хамгаалах яам анх байгуулагдаж байсан.

1990 онд яамыг Байгаль орчны хяналтын улсын хороо болгож Ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлдэг маш их эрх мэдэлтэй хэдий ч суурь, харьяа байгууллага байхгүй байсан. Хороонд шинжлэх ухаан, эдийн засгийн суурь мэдээлэл, арга хэрэгсэл хэрэгтэй байсан тул Хөдөө аж ахуйн яамны харьяа Ой, Газар, Ус болон Цаг уурын хүрээлэнгүүд зэрэг үйлдвэрлэл, шинжилгээний байгууллагуудыг хорооны харьяанд шилжүүлсэн байдаг.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж, харьяа үйлдвэр, шинжилгээний хүрээлэнгүүдийн эрдэмтдийн ачаар өмнө гаргасан журам, дүрмүүдээ өөрчилж, 1995 он хүртэл 3 багц 15 хуулийг УИХ-аар батлуулснаар анх Байгаль орчны эрх зүйн тогтолцоо бүрдүүлсэн.

Бидний анх батлуулсан 3 багц 15 хуулийн гол агуулга нь ганц захиргааны арга хэмжээ бус шинжлэх ухаан, эдийн засгийн аргын үндэсийг бий болгосон. Мөн хуульд Монгол Улс байгаль орчны мэдээллийн сантай байхаар хуульчилж, 50 гаруй мэдээллийн дэд сантай Байгаль орчны мэдээллийн төвийг байгуулсан хэдий ч өнөөдөр тус төвийг татан буулгаж Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгийн нэг хэлтэст харьяалуулсан хариуцлаггүй зүйл болсон гэж боддог.

Мэдээллийн сан байхгүй, шинжлэх ухаанч бусаар байгаль орчныг бодлого боловсруулна гэж байхгүй. Мөн эдийн засгийн хөшүүрэг гэдэг зүйлийг одоо Байгаль орчныг ашигласны нөхөн төлбөрөөр ойлгож байгаа юм. Нөхөн төлбөрийг төвлөрүүлдэг ч эргээд байгаль орчныг хамгаалах чиглэлд зарцуулагдах нь хангалтгүй байна.

Орчин үед экосистемийн үйлчилгээний төлбөр гэдэг зүйлийг ярих цаг болсон. Энэ нь Монгол улсаас гадагш урсаж буй гол, мөрөн ОХУ-ын Байгаль нуурын 30-40%-ийг бүрдүүлдэг учир усан цахилгаан станц барьж чадахгүй байна. Бид тэгвэл ОХУ-тай гадагш урсаж буй усандаа төлбөр ногдуулах бодлого барих хэрэгтэй. Ингэж байж бид эдийн засгийн хөшүүргийг шинэчилж, хувийн хэвшлийг байгаль орчны чиглэлээр татан оролцуулж, идэвхжүүлнэ.

Ерөнхий чиг үүргийн яам болно гэдгийг эрх мэдэлтэй болно гэж ойлгож болохгүй. Шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн хөшүүрэгтэй, бусад яамдыг үүрэгжүүлсэн, хувийн хэвшлийг татан оролцуулсан салбар дундын зохицуулалтыг хариуцсан байдлаар ойлгох шаардлагатай юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болоход аялал жуулчлалдаа илүү анхаарч, байгаль орчныг орхигдуулсан. Одоо Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болоход уур амьсгалын өөрчлөлтдөө илүү анхаарах бус үндсэн зарчим буюу байгалийн нөөц, орчны бохирдолд буюу байгаль орчны чиглэлд бүхэлд нь анхаарах ёстой.

Монгол улсын байгаль орчны хувьд байгалийн нөхцөл байдал, хөрш орон, дэлхий нийтийн байгаль орчны асуудлыг анхаарч, нийцүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулахдаа гадаад улсын хөрөнгө, төсвийн гуйлга гуйна гэж ойлгож болохгүй. Харин ч дэлхий нийтэд, бусад улсад тулгамдаж буй байгаль орчин, уур амьсгалын чиглэлээр хамтарч ажиллах чиглэлд анхаарах шаардлагатай.

1992 онд гаргасан санаачилга буюу Монгол улсын газар нутгийн 30 хүртэл хувийг 2030 он хүртэл тусгай хамгаалалтад авах шийдвэр. Тухайн үед манай төр засаг ч үүнийг дэмжиж, одоо манай улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 20 гаруй хувьтай байна. Гэтэл 3-4 жилийн өмнө дэлхий нийтээр 2030 он хүртэл газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалтад авах талаар ярьж эхэлсэн. Бидний аль эрт ярьж, эхлүүлсэн зүйлийг дэлхий нийтээр саяхан ярьж эхэлсэн. Анх Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг боловсруулахдаа олон улсын байгууллагаас гаргасан дүрмийг баримтлаагүй. Тус дүрэмд тусгай хамгаалалтыг ойролцоогоор 10 ангилсан байхад Монгол улсын хувьд энэ нь нийцэхгүй тул үндсэн 4 ангиллыг л тусгасан.

Одоогоос 3-4 жилийн өмнө Даян дэлхийн байгаль хамгаалах сангаас /WWF/ улсын тусгай хамгаалалтын шилжилт нь уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар 130 гаруй оронд судалгаа хийгдэхэд Монгол Улс хамгийн өндөр оноог авсан байсан. Ингээд бидний анх гаргаж байсан Монгол улсын газар нутгийн 30 хүртэл хувийг 2030 он хүртэл тусгай хамгаалалтад авах шийдвэр бол зөв шийдвэр байсан гэж боддог.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх /2008-2012 он/:

Байгаль орчны салбар нь эдийн засаг, эрчим хүч, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг олон асуудлуудыг хөнддөг учир тэр олон хуулиудын давхцлыг арилгаж, хоорондын уялдааг нэгтгэх байр суурьтай ажиллаж, яамд, агентлагуудаас холбогдох албан хаагчдыг татан оролцуулж, хууль эрх зүйн шинэчлэл, реформыг хийж 10 гаруй хууль болгож нэгтгэсэн.

Байгаль орчны салбар нь зөвхөн төрийн байгууллагын хүрээнд хийх ажил биш л дээ. Яагаад гэвэл Монгол улс маш том газар нутагтай, байгаль, цаг уурын олон бүсчлэлтэй байдаг. Олон нийтийг татан оролцуулах шаардлагатай гэдэг агуулгаараа Байгаль орчны чиглэлээр 600 орчим төрийн бус байгууллага байсныг нэгтгэж Монголын Байгаль орчны иргэний зөвлөл /МБОИЗ/ гэж байгуулах санаачлагыг гаргаж байсан.

Тус зөвлөлийн зардлыг нь төрөөс гаргаж дүрэм, журамтай, амьтан, ургамал, ус зэрэг салбар бүрийн төлөөллийг оролцуулж, дэргэдээ эрдэмтдийн зөвлөлтэй анхны МБОИЗ-ийг байгуулж байсан. Иргэний зөвлөл даргаа сонгож, салбар бүрийн төлөөллийг хамруулсан

эрдэмтэдийн зөвлөлтэй, мөн Ногоон парламентийг иргэний зөвлөлийн дэргэд 30 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хуулиуд дээр байгаль орчны чиглэлээр ямар бодлого барих талаар хэлэлцдэг байсан.

Байгаль орчны яам бол ерөнхий чиг үүргийн яам байж аж үйлдвэр, эрдэс баялаг, эдийн засгийн хөгжлийн асуудал дээр нэг номерт бодлогыг зангидаж, эдийн засгийг солонгоруулах төсөл хөтөлбөр болон хариуцлагатай уул уурхай ажиллах боломжийг дэмжих учиртай.

Тухайн үед шинэ Засгийн газар байгуулагдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам өөрийн байргүй байсан бөгөөд нэгдүгээрт үндсэн чиглэлийн яам болгох, хоёрдугаарт Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг өөрийн байртай болгох байсан. Гэтэл 2022-2024 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүн яармаг руу нүүлгэж, маш том бодлогын алдаа гаргасан гэж үздэг.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд байх хугацаанд нэлээн мөнгө байгаль орчны чиглэлээр төсөвт төвлөрүүлж чадсан. Жишээ нь: нүүрс экспортлож буй тонн тутмаас 1000 төгрөгийн татвар авах зохицуулалтыг хийсэн. Салбарын төсвийг нэмэх ёстой гэдгийг 100% дэмжиж байгаа. Манай улс ДНБ-ийхээ ойролцоогоор 60%-ийг уул уурхайн салбараас бүрдүүлдэг. Тиймээс 1.0-4.0% руу ч очсон болно. Гэхдээ тэрийг цуглуулаад шууд үр гэсэн үг биш. Тэр 4.0%-иас нэг хувийг нь тухайн жилд ашиглаж, үлдэх 3.0%-ийг өсгөж, арвижуулаад том усан сан байгуулах, гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх зэрэгт ашиглаж болно.

Байгаль орчны салбарт нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай зүйл бол стандартуудыг л маш сайн гаргаж ашиглалт, хориглолт, хариуцлага зөв тооцдог байх ёстой гэж боддог. Байгаль орчныг бохирдуулна гэдэг нь байгалийн баялгийг буруу ашиглах, бохирдуулж байгаа тохиолдолд хяналт тавьж, торгууль төлбөрийн хувьд өндөр байх шаардлагатай.

Стандартаа зөв гаргачихвал хүмүүсийн сэтгэхүй ч гэсэн өөрчлөгдөнө. 10-аад жилийн өмнө хөдөө явах замд цэнхэр уут хөглөрч байдаг байсан. Одоо цэнхэр уут байхгүй болсон. Энэ чинь хүмүүсийн сэтгэхүй болохоос төсөв, хууль гарч энийг янзлаагүй шүү дээ... хүмүүс өөрчлөгдөж байна. Тэгэхээр стандартаа тавиад байгаль орчныг зөв ашиглах боломжийг нь бас нээж өгөх ёстой.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд асан С.Оюун /2012-2015/

2012 онд Засгийн газар байгуулагдаж, Н.Алтанхуяг ерөнхий сайд байх үед Иргэний зориг, ногоон нам /ИЗНН/ Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө ногоон хөгжлийн бодлогыг тусгасан байсан. Монгол улсад төдийгүй дэлхий даяар байгаль орчны бодлого, тогтвортой хөгжлийн бодлого чухалаар яригдаж байлаа. Тухайн үед хамтарсан Засгийн газар байгуулагдах яриа, хэлэлцээр явагдаж, хэрэв ИЗНН Засагт хамтрах тохиолдолд Байгаль орчны яамыг хариуцах, тэгэхдээ тус яамыг хөгжлийн яам байх ёстой гэдэг үзэл баримтлалыг манай намын гаргаж тавьсан. Нөгөө талаар байгаль орчны салбар нь нэг салбар, нэг улсаас үл хамаарах дэлхийн хэмжээний асуудлыг хариуцдагаараа онцлогтой байсан тул Байгаль орчны яамыг Ерөнхий чиг үүргийн яам болгох, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогыг хариуцах гэсэн нөхцөлийг тавьж, тохиролцоонд хүрч Байгаль орчин, ногоон хөгжлийн яам /БОНХЯ/ Засгийн газарт Ерөнхий чиг үүргийн яам болж байсан.

БОНХЯ болсны дараа Ногоон хөгжлийн бодлогыг боловсруулж 2014 онд Улсын Их Хурлаар батлуулсан. Ямар нэгэн хөгжлийн бодлого боловсруулж батлуулахад Засгийн газрын гишүүдийн дэмжлэгийг авахаас гадна Улсын Их Хурлын гишүүдийн дэмжлэг, ойлголт чухал байдаг. Тэр агуулгаараа БНСУ-ын Ногоон хөгжлийн бодлогоо тухайн үед батлсан байсан тул 10 гаруй гишүүнийг Ногоон хөгжлийн бодлого, Олон улсын ногоон хөгжлийн бодлогын талаар туршилга судлуулж, мөн Казахстан улсын Байгаль орчны сайд “Ногоон гүүр” нэртэй Ногоон хөгжлийн бодлогын зарим сайн туршилгаас судалж, яамны маань албан хаагчид гол зүйлийг боловсруулж гаргасан.

НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийг байгууллага, агентлаг болгох асуудал яригдаж байсан ч чадаагүй тул НҮБ-ийн байгаль орчны ассемблей болж байсан үед 30-40 улс, орнууд 2 жилдээ нэг удаа уулзаж, байгаль орчны хөтөлбөр, төсөв, дараагийн чиг хандлагыг тодорхойлдог байсан бол дэлхийн бүх 180 гаруй улс, орны байгаль орчны сайд нар 2 жил тутам цуглардаг Ассемблейтэй болсон. Энэ байгууллага нь дан ганц сайд биш төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллага зэрэг маш олон хүмүүс цуглаж, байгаль орчны чиглэлээр том асуудлуудыг хэрхэн шийдэх талаар шийдэл гаргадаг.

2014 оны 06 дугаар сард Ассемблейн хурал болж Засгийн газраас сайд нарыг жилд 2-оос дээш удаа гадаад томилолтоор явахыг хязгаарласан байсан тул энэ хуралд Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд явж, маш сайн ажилласан. Ер нь эндээс харахад дэд сайд гэдэг маш чухал үүрэг гүйцэтгэдэг, байх ёстой албан тушаал гэж хардаг.

2013 онд Дэлхийн байгаль орчны өдрийг Монгол улсад зохион байгуулахаар болж, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Гадаад хэргийн яамны албан хаагчид зохион байгуулалтыг хийж, улс төрийн дэмжлэгийг Засгийн газраас авч, Монгол Улс байгаль орчны чиглэлээр олон улсад дуу хоолойгоо сайн хүргэж, идэвхитэй ажилласны үр дүнд 2014 онд НҮБ-ийн Байгаль орчны ассемблейн анхны ерөнхийлөгч болсон байх гэж боддог.

Энэ ажил нь ганц улс улсын байгаль орчны сайд нарын хурлыг даргалах бус 2 жилийн хугацаанд хурлыг удирдаж, оруулах төсөл, хөтөлбөр, улс хооронд гэрээ, хэлэлцээрийг шийдэх, ассемблейг төлөөлж олон улсын хуралд үгээ хэлэх зэрэг нэг талдаа асар их нэр хүндтэй ч нөгөө талдаа асар их ажил, хариуцлагатай ажил байдаг.

Засгийн газрын бүтцэд Ерөнхий чиг үүргийн яам байхын давуу тал нь улс төрийн асуудал, бодлогод илүү хүчтэй нөлөөлөх боломжтой болно. Дэлхий дахинд одоо ч байгаль орчны асуудал, тогтвортой хөгжлийн асуудал, дэлхийн дулаарлын асуудал ногоон хөгжлийн шилжилтийн асуудал чухал хэвээр байгаа. Одоо 2, 3 жилдээ АНУ-ын улс төрөөс шалтгаалан ухарч магадгүй ч гэсэн дэлхийн дулаарал, орчны бохирдол зэрэг асуудлууд алга болохгүй учраас чухал хэвээр байх болно. Ер нь **Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг ерөнхий чиг үүргийн яам болгох нь дан ганц яам, салбарын хувьд чухал ач холбогдолтой зүйл биш, энэ бол Монгол улсын хувьд чухал зүйл бөгөөд зөв хөгжихийн үндэс суурь юм.**

Байгаль орчин бохирдуулагчийн төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөрөөс тодорхой хэмжээнд орлого бий болгож, орон нутагт эсвэл энэ чиглэлийн асуудлуудыг шийдэх шийдлүүдийг өөрсдөө боловсруулах нь чухал.

Улс дотоодын хөрөнгө босголтыг хийхийн тулд үйлдвэрлэлийн чиглэлийн усны төлбөрийг нэмсэн. Энэ нь чухал ач холбогдолтой бөгөөд анх удаа Оюутолгой ХХК-аас Өмнөговь аймгийн төсөвт 10 гаруй тэрбум төгрөг орж байсан санагдаж байна. Мөн Цэвэр агаар санг татан буулгасныг буруу гэж боддог. Цэвэр агаар сан 2011 онд батлагдсан хуулиар гадаад улсад гаргаж байгаа нүүрснээс 1 тонн тутамд 1000 төгрөг Цэвэр агаар санд орно гэсэн зохицуулалттай байсан. Тухайн үед 20 гаруй сая тонн экспортлож, 20 гаруй тэрбум төгрөгийг тэр санд төвлөрүүлсэн. Одоо гэхэд 80 гаруй сая тонн нүүрс экспортлож байгаа гэвэл 80 гаруй тэрбум төгрөг төвлөрнө, тэгээд зарцуулалтыг зөв хийгээд явах чухал юм. Агаарын бохирдлын үндэсний хороог Ерөнхий сайдын харьяанд байлгавал илүү үр дүнтэй байдаг.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ерөнхий чиг үүргийн яам болж чадвал одоо илүү хүчтэй дугарч, нөлөөлж, чанга байр суурьтай байх хэрэгтэй. Аль нам, аль сайд байхаас үл хамааран төрийн бодлого, хууль тогтоомжийн залгамж чанар, улс төрийн манлайлал маш чухал байдаг. Нэг жишээг дурдахад,

2012 оны Байгаль орчны эрх зүйн шинэчлэлийн ажлыг Л.Гансүх сайд эхлүүлж, хуулийн төслүүдийг боловсруулж, Д.Цогтбаатар сайд УИХ-аар батлуулж, миний хувьд хуульд туссан гол үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, суурь зохицуулалтад тулгуурлан Байгаль орчны яамыг Ерөнхий чиг үүргийн яам болгох, олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх, бодлоготой уялдуулах, байр суурийг нэмэгдүүлэх ажлуудыг гүйцэтгэж байсан нь бүгд л хоорондоо уялдаа холбоо, залгамж байдлаар явж байсан.

Байгаль орчны тулгамдсан асуудлын талаарх эрдэмтэн, судлаачдын хэлэлцүүлгийн дүн шинжилгээ

БОУАӨЯ болон түүний харьяа Ойн газарт процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийж байгаатай холбогдуулан “Монгол Улсын байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал” сэдвээр салбарын эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэдийг оролцуулсан уулзалтыг 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж ажиллав.

Уг уулзалтад төрийн захиргааны төв байгууллага, дээд боловсролын байгууллагуудын харьяа хүрээлэн, судалгааны төв болон шинжлэх ухааны академи зэрэг хүрээлэнгээс нийт 18 эрдэмтэн судлаач оролцсон бол Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын удирдлага албан хаагчдын нийт 34 төлөөлөл оролцов.

Энэхүү уулзалт ярилцлагын зорилго нь шинжлэх ухаанд суурилсан, ойн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын гаргасан үр дүнг ойн менежментийг хэрэгжүүлэхдээ ашиглаж чадаж байгаа эсэхийг тандахад оршиж байв.


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 10-р сарын 13-ны өдрийн А/418 дугаар тушаалаар батлагдсан “Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” шийдвэр нь ойн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүйн үндэс болдог ажээ. Уг бодлогоор ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, шинжлэх ухаанд суурилсан менежментээр хангах зорилтыг дэвшүүлсэн.

БОУАӨЯ-ны үндсэн чиг үүргийн нэг буюу уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэл нь Ойн менежменттэй шууд холбогддог. Ойн тогтвортой менежмент нь байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай нүүрс төрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэн, ялгарлыг багасгах, усны нөөцийг хадгалан хамгаалах замаар ирээдүй хойч үедээ нөөцийг үлдээх, нийгмийн хэрэгцээг хангах экосистемийн тогтолцоог бэхжүүлдэг.

Ой нь зөвхөн мод тарих, арчлах төдийгүй, экосистемийн үйлчилгээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нүүрс шингээлтийг нэмэгдүүлэх зэрэг олон талт үр ашиг, нөлөө үзүүлдэг. Энэ бүхэн нь ойн бодлогыг шинжлэх ухааны судалгаа, инновац дээр тулгуурлах шаардлагатайг харуулж байгаа юм.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хуурай газрын экосистемийг хамгаалах нь ойн менежментийн зорилго болж байна. Иймээс Ойн газар нь судалгааны байгууллагатай хамтран ажиллаж, үр дүнг үйл ажиллагаандаа тусгах нь амин чухал юм.

Зураг 48. Судалгаа ба ойн менежментийн мэдээллийн урсгал



Дээрх зурагт ойр менежмент болон судалгааны байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг зураглан үзүүлэв.

Ойн салбарын судалгаа нь тодорхой үр дүнд чиглэсэн, хэрэгцээт мэдээлэлд тулгуурласан байх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймээс судалгааны ажлын захиалга боловсруулах, үнэн зөв мэдээлэл цуглуулах, өгөгдлийн санг баяжуулж олон нийтэд нээлттэй болгох ажлуудыг уялдаа холбоотой, үр дүнтэй зохион байгуулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Судалгааны хүрээлэнгүүдийн өнөөгийн нөхцөл байдал

ЗГХХГ судалгааны байгууллагуудыг урьж, тэдний үйл ажиллагаа, судалгаатай танилцав.

1. ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэн

ОМССХ нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дараах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн ургуулах хөрс, үрийн аж ахуйн технологи боловсруулах.
- Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажлыг механикжуулах машин, тоног төхөөрөмжийн туршилт, нутагшуулах.
- Мэргэжлийн сургалт, зөвлөх үйлчилгээ, стандартчилал, мониторингийн жишиг талбай байгуулах.

2. Шинжлэх ухааны академи - Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн

БЦХ-ийн судлаачид шилмүүст ой, ялангуяа шинэс модны үрийн чанар, үржлийн хүчин зүйлийн талаарх суурь судалгаануудыг хийсэн байна. Үүнд:

- Үрийн чанарт нөлөөлөх тоосны хэлбэр, морфологи, хортон шавжийн нөлөөллийн судалгаа.
- Үрийн байнгын талбай байгуулах үндэслэл, генетик нөөцийн хамгааллын судалгаа.

3. Газарзүй, Геоэкологийн хүрээлэн (ГГЭХ)

ГГЭХ нь ойн үрийн аж ахуйтай холбоотой судалгаануудыг түлхүү хийсэн байна. 2024 онд тус хүрээлэн дараах аргачлал, стандартуудыг боловсруулсан нь:

- Ойн үрийн плантаци байгуулах аргачлал.
 - Ойн үрийн байнгын талбай тусгаарлах, арчлах аргазүйн сургалтын хөтөлбөр.
- Эгэл нарсны боргоцойн чанарын MNS стандартын төсөл боловсруулсан зэрэг үр дүнг тус тус танилцуулав.

Байгаль орчны салбарт тулгамдаж буй шинжлэх ухааны асуудлууд:

Шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа, мэргэжилтнүүдийн дүгнэлтэд үндэслэн байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил үр дүн багатай байгааг тогтмол судлах, амьдралын хувь тооцох мониторингийн тогтолцоо сул байна.
- Үрийн бэлтгэлийн ажил хангалтгүй, үрийн аж ахуйн селекцийн судалгаа бүрэн хийгдээгүй, модны үрийг ой-ургамалжлын бүс хооронд шилжүүлэн тариалах ажил төлөвшөөгүй байна.
- Генетикийн хувьд тохиромжгүй тарьц, суулгац тарьж буй нь тухайн бүс нутагт тохирохгүй ургамлын тархалтыг бий болгож, байгалийн эко-үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Байгалийн унаган төрх бүхий улиасны арчилгаа. мөчрийн тайралт хийгдэхгүй байгаа нь нөхөн сэргээгдэх чадавхыг алдагдуулж байна.
- Ойн нөхөн сэргээлтийн ажил хууль, стандартын хүрээнд хийгдэхгүй байгаа тул гүйцэтгэлийн чанар, хяналт хангалтгүй.
- Ойн хөнөөлт шавжийн эсрэг тэмцэлд хэрэглэж буй бодис, арга нь экосистем, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Үүний суурь судалгаа дутмаг байна.
- Үндсэн зорилгод нөлөөлөх нүүрстөрөгчийн шингээлттэй холбоотой судалгаа, ойтой холбосон гидрогеологийн судалгаа дутмаг байна

Ойн судалгаа ба менежментийн уялдаа: Мэдээлэл солилцоо, ухаалаг шийдвэр гаргалт

Ойн судалгаа нь ойн төрөл зүйл, өсөлт хөгжил, нүүрс шингээлтийн чадавх, гидрологийн зохицуулалт зэрэг экосистемийн олон талт үзүүлэлтийг судалдаг. Энэхүү шинжлэх ухааны

үндэслэлтэй судалгааны үр дүнг ойн менежментийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дараах гурван үндсэн чиглэлд менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Үүнд:

1. Нөхөн сэргээлт

- Судалгааны байгууллагуудын боловсруулсан үрийн чанарын стандарт, генетик нөөцийн судалгаа нь нөхөн сэргээлтийн ургамал сонголт, тарьц суулгацын чанарыг сайжруулахад шууд тусална.
- Нүүрс шингээлт, хөрсний усны зохицуулалтын судалгаа нь байгальд ээлтэй нөхөн сэргээлтийн технологийг сонгоход чухал мэдээлэл өгнө. Техник, технологийг нэвтрүүлэх.
- Тарьц, суулгац ургуулах, мод тарих, ойжуулах ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.


2. Ойн ашиглалт

- Судалгааны үр дүн дээр үндэслэн мод, модон түүхий эдийн тогтвортой ашиглалт, ойн дагалдах баялгийн ухаалаг менежментийг хэрэгжүүлэх боломжтой.
- Тухайлбал, ашиглалтын дараах сэргээлт, унаган төрх сэргээх төлөвлөлтөд судалгаа чухал нөлөөтэй.
- Бэлтгэсэн модны нөөцийг хяагдалгүй иж бүрэн ашиглах технологийг сонгох.

3. Ойн хамгаалал

- Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний үнэлгээ, хортон шавжийн биологи зэрэг судалгаа нь хамгаалалтын арга хэмжээг оновчтой болгоно.
- Гидрологийн болон нүүрс шингээлтийн мэдээлэл нь хамгаалалд хөрөнгө оруулалт татах үндэслэл болдог.

Зураг 49. Судалгааны байгууллагын судалгааны ажлын үр дүн ашиглах нь



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа судалгааны байгууллагуудын чадавхыг дараах байдлаар ашиглах бүрэн боломжтой байна. Иймээс Ойн газар болон судалгааны байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцооны байнгын урсгалыг дэмжих хэрэгтэй байна.

ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн судалгаануудыг ойн менежментэд ашиглах боломжууд:

- Үр, суулгацын чанарын хяналт, ойжуулалтын механикжуулалтыг бодлогын түвшинд нэвтрүүлэх.
- Ойн газрын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах.
- Олон улсын төсөлд хамтран ажиллах, инновацыг нутагшуулах.

Ойн менежментэд ашиглах боломжууд:

- Шинэс зэрэг модлог ургамлын байгалийн нөхөн сэргээлт, үр үржүүлгийн ажлын үр нөлөөг сайжруулах.
- Генетик хувилбар, тохиромжтой үрийн сонголтод тулгуурласан бодлого хэрэгжүүлэх.
- Үрийн чанарын хяналтын тогтолцоог шинжлэх ухаанд суурилсан хэлбэрээр хөгжүүлэх.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн (ГГЭХ) Ойн менежментэд ашиглах боломжууд:

- Үрийн чанар, үрийн аж ахуйн аргагүйг стандартжуулах, практикт нэвтрүүлэх.
- Үрийн шинжилгээний лаборатори болон мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх.
- Үрийн чанарт суурилсан ойн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж ашиглах.

Дүгнэлт

Монгол Улсын ойн тогтвортой менежмент нь зөвхөн хэрэгжилтийн ажлаар бус, шинжлэх ухаанд суурилсан, үндэслэлтэй бодлогын шийдвэрээр хангагдах шаардлагатай. Судалгааны байгууллагуудын оролцоог системтэй, стратеги түвшинд хангаж чадвал Ойн газар нь илүү үр дүнтэй, уур амьсгалд тэсвэртэй, хариуцлагатай ойн менежментийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

- Ойн газрын судалгааны хэрэгцээ, судалгааны байгууллагуудын санал болгож буй чиглэлүүдийг уялдуулан судалгааны захиалгын тогтолцоог бий болгох.
- Ойн судалгаа, менежмент хоорондын мэдээллийн урсгалыг идэвхжүүлэх, хамтран зохион байгуулсан сургалт, хурал, туршилтын талбайн тоог нэмэгдүүлэх.
- Ойн судалгаа, менежментийн уялдаатай ажиллагаанд зориулсан олон талт санхүүжилтийн эх үүсвэр (төр-хувийн хэвшил-хандивлагчид)-ийг тогтвортой болгох.
- Олон газарт, жижиг нэгжүүд судалгааны ажил явуулах нь үр ашиг муутай, хүн хүч тарамдсан байдал байгаад дүгнэлт хийж, эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажил гүйцэтгэх хязгаарлагдмал хүн хүчний нөөцийг нэгтгэн төвлөрүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2.2 САНХҮҮЖИЛТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын санхүүжилт нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэж байна.

- Улсын болон орон нутгийн төсөв
- Олон улсын төсөл хөтөлбөр

2.2.1 Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, үр дүн

Байгаль орчны салбарт үйл ажиллагаа явуулдаг төсөвт байгууллагууд улсын болон орон нутгийн хоёр үндсэн эх үүсвэрээс санхүүждэг. Улсын төсвийн санхүүжилт нь тус салбарын сайдын багцад орон нутгийн төсвийн санхүүжилт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хүрээнд батлагддаг.

2015–2023 оны хооронд салбарын нэгдсэн төсвийн зардлын дунджаар 68 хувийг (93 тэрбум төгрөг) улсын төсвөөс, үлдсэн 32 хувийг (45 тэрбум төгрөг) орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Байгаль орчны төсвийн бүтэц нь хэт төвлөрсөн шинжтэй байгаа нь цаашдын санхүүжилтийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Тодруулбал, салбарын нэгдсэн төсвийн 80 орчим хувь нь ердөө дөрвөн хөтөлбөрт (агаарын бохирдол ба уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бодлого, ус цаг уур, ойжуулалт) төвлөрч байгаа нь бусад чухал чиглэлүүд санхүүжилт дутмаг байх нөхцлийг бүрдүүлж байна. Хог хаягдлын хөтөлбөр, газрын доройтлын эсрэг үйл ажиллагаа, нөхөн сэргээлт зэрэг хөтөлбөрүүдийн санхүүжилт бодит хэрэгцээг хангахгүй байгаа төдийгүй зарцуулалт нь бусад хөтөлбөрийн хүрээнд бүртгэгддэг тул бодит зардлыг үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн хувьд, сүүлийн хоёр жилд салбарын гүйцэтгэл өмнөх жилүүдийн дунджаас буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сулруулж байна. Улсын төсвийн гүйцэтгэлд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байснаас орон нутгийн төсвийн гүйцэтгэлд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, байгаль хамгаалал, хөрөнгийн зардлын хэрэгжилт сул байснаас голлон шалтгаалжээ.

Салбарын зардлын бүтцэд урсгал зардал давамгайлж байгаа нь анхаарал хандуулах асуудлын нэг юм. 2015–2023 оны дунджаар нийт зардлын 86.1 хувь нь урсгал, зөвхөн 10.4 хувь нь хөрөнгийн зардалд зарцуулагдсан бөгөөд эдгээрийн гүйцэтгэл ч хангалтгүй буюу тус тус 89.9 хувь, 86.6 хувьтай байна. Урсгал зардлын дийлэнх хувийг цөөн төрлийн зардал (цалин хөлс, үйл ажиллагааны зардал гэх мэт) эзэлж байгаагаас үзэхэд салбарын хөрөнгө оруулалт, дэд бүтэц сайжруулах чиглэлийн санхүүжилт хангалтгүй хэвээр байна.

Хөтөлбөрүүдийн гүйцэтгэл, зарцуулалтын үр өгөөжийн хувьд ялгаатай байна. Ус, цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөр нь зардлынхаа 92.4 хувийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж, харьцангуй өндөр үр өгөөжтэй байгаа бол агаарын бохирдол, нөхөн сэргээлт, хог хаягдлын хөтөлбөрүүдийн гүйцэтгэл дунджаас доогуур буюу хангалтгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэхийг үүрэг болгосон ч "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2022 онд ДНБ-ний 0.28 хувь, 2023 онд ДНБ-ний 0.29 хувь, 2024 онд ДНБ-ний 0.35 хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.²²

Нөгөөтэйгүүр, байгаль орчны салбарын нэгдсэн төсөв өсөлттэй байгаа ба 2015–2023 онд батлагдсан улсын төсвийн зардал жилд дунджаар 19.3 хувиар, орон нутгийн төсвийн зардал 25.1 хувиар тус тус өссөн бол нэгдсэн төсвийн нийт зардал дунджаар 20.8 хувиар өссөн байна. Үүнтэй адилаар, зарцуулалтын түвшин ч өсөлттэй байж, улсын төсвийн зарцуулалт жилд дунджаар 20.6 хувь, орон нутгийнх 23.3 хувь, нэгдсэн төсвийн нийт зарцуулалт 20.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн хоёр жилд байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл өмнөх онуудын дунджаас доогуур түвшинд хадгалагдаж байна. 2015–2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай байсан бол улсын төсвийн гүйцэтгэл 94.9 хувь, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 85.4 хувьтай байв. Харин 2022 онд улсын төсвийн гүйцэтгэл 84.0 хувь, 2023 онд 86.6 хувь байсан бол орон нутгийн төсвийн гүйцэтгэл тус бүр 86.7 болон 84.3 хувьтай гарсан нь дундаж түвшнээс бага үзүүлэлт болжээ.

Улсын төсвийн гүйцэтгэлийн бууралтад агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх тусгайлсан арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байсан нь голлох шалтгаан болсон байна. Харин орон нутгийн төсвийн гүйцэтгэлд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт,

²² ЗГХА, Ойн газрын 2024 оны тайлан


агаарын бохирдол, байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн арга хэмжээ болон хөрөнгийн зардлын гүйцэтгэл хангалтгүй байдал голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн төсвийн зардлын 36.2 хувийг Нийслэлийн Агаарын чанарын алба, 35.2 хувийг аймаг, нийслэлийн байгаль орчны бодлогыг хариуцсан төсөвт байгууллагууд эзэлж байна.

Салбарын төсвийн зарлагын бүтцийн хувьд урсгал зардал давамгайлж байгаа бөгөөд 2015–2023 оны дунджаар нийт зардлын 86.1 хувийг урсгал, 10.4 хувийг хөрөнгийн зардал эзэлжээ. Мөн урсгал зардлын гүйцэтгэл дунджаар 89.9 хувь, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 86.6 хувьтай байна.

Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, салбарын нэгдсэн төсвийн урсгал зардлын 70–80 хувийг цөөн хэдэн төрлийн зардал эзэлдэг байна. 2015–2023 оны дунджаар:

Зураг 50. Салбарын урсгал зардлын бүтэц, 2015–2023 оны дунджаар



Байгаль орчны салбарын зардлыг тодорхойлоход хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөр, зориулалт арга хэмжээний ангиллыг үндэслэн тооцдог. Энэ хүрээнд Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар нийт 13 хөтөлбөр, 12 зориулалт арга хэмжээ батлагдсан боловч, тэдгээрийн хэрэгжилт нь улсын болон орон нутгийн төсөвт ялгаатай байсаар ирсэн.

2015–2023 оны хугацаанд:

- Улсын төсөв: 8 хөтөлбөр, 5 зориулалт арга хэмжээ тогтмол хэрэгжсэн.
- Орон нутгийн төсөв: 7 хөтөлбөр, 4 зориулалт арга хэмжээ хэрэгжсэн байна.

Түүнчлэн, салбарын нэгдсэн төсвийн зардлын 80 орчим хувь нь ердөө дөрвөн хөтөлбөрт төвлөрсөн байдалтай байна. 2015–2023 оны дундаж үзүүлэлтээр:

Хүснэгт 20. Байгаль орчны салбарын зардлын бүтэц

Хөтөлбөрийн чиглэл	Зардлын хувь (%)	Зардлын хэмжээ (тб.₮)
Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт	31.0%	43.0
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	23.0%	31.0
Ус, цаг уур, орчны шинжилгээ	21.0%	29.0
Ойжуулалт	6.3%	8.7

Эдгээр тоо баримт нь байгаль орчны төсвийн зардал хэт төвлөрсөн бүтэцтэй байгааг харуулж байгаа бөгөөд цаашид хөтөлбөрүүдийн төрөлжүүлэлт, санхүүжилтийн тэнцвэрт байдалд анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөр

Байгаль орчны салбарын нийт төсвийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг “Ус, цаг уур, орчны шинжилгээ” хөтөлбөрийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газар, 21 аймаг, нийслэлийн шинжилгээний төвүүд, төв лаборатори, судалгаа мэдээллийн хүрээлэн, нислэгийн цаг уурын төв зэрэг байгууллагууд үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт

хөтөлбөрийн зардлын 92.4 хувийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж байгаа нь уг хөтөлбөрийн зардал оновчтой, чиглэсэн байгааг харуулж байна.

Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт болон нөхөн сэргээлтийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэл

Хүрээлэн буй орчны хүрээнд хэрэгждэг хэд хэдэн чухал хөтөлбөрүүдийн гүйцэтгэл дунджаас (91.2%) доогуур, хангалтгүй байгааг онцлох хэрэгтэй. Үүнд:

- Агаарын бохирдлыг бууруулах
- Уур амьсгалын өөрчлөлт
- Газрын доройтол, цөлжилт
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрүүд багтана.

Түүнчлэн, агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилт сүүлийн хоёр жилд 26.6 хувиар буурсан нь гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

Хог хаягдлын хөтөлбөр

Хог хаягдлын хөтөлбөрийн санхүүжилт салбарын бодит хэрэгцээтэй харьцуулахад хангалтгүй байна.

•2015–2023 онд жилд дунджаар хог хаягдлын үйлчилгээний хураамжаар 20 тэрбум төгрөг төвлөрч байсан ч хөтөлбөрт 3.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

•2023 онд нийт хураамжийн 22.8% буюу 6.5 тэрбум төгрөг-ийг л хог хаягдлын хөтөлбөрт зарцуулсан байна.

Гэсэн хэдий ч хог хаягдлын зардлууд ихэнхдээ бусад хөтөлбөрт бүртгэгдэж байгаа тул салбарын нийт зардлыг бодитоор үнэлэхэд хүндрэл учирч байна.

Ойжуулалтын хөтөлбөр

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-аар хэрэгжсэн арга хэмжээний зардлын үр өгөөж харьцангуй сайн байгаа ч, орон нутгийн ТЭЗ-үүдийн хувьд нэгдсэн үр дүн, шалгуур үзүүлэлтийн ялгаа нь үр өгөөжийг хэмжихэд хүндрэл учруулж байна.

Уг хөтөлбөрт:

- Улсын төсвөөс “Ойн газар”,
- Орон нутгийн төсвөөс ойн ангиуд тус тус санхүүждэг.

Аймаг бүрт өөр өөр шалгуур үзүүлэлт ашигладаг тул орон даяар нэгтгэсэн үр дүн гаргах, зардлын өгөөжийг үнэлэхэд хүндрэлтэй байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарцуулалт:

- 2015–2023 онд энэ орлогын дунджаар 47% нь ойжуулалт хөтөлбөрт зарцуулагдсан.
- 2023 оны байдлаар энэхүү хувь 80% болж нэмэгджээ.

Хүснэгт 21. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт ба хэрэгжилт (2015–2023)

Арга хэмжээ	Хамрагдсан талбай	Шалгуур үзүүлэлтийн биелэлт
Ойжуулалт, нөхөн сэргээлт	62.8 мян.га	57.2%
Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх	1,357.1 мян.га	104.2%
Ойн доройтлоос хамгаалах арчилгаа, цэвэрлэгээ	226.8 мян.га	121.9%

Эдгээр үзүүлэлтүүд нь Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь 2022 онд 8.2%-д хүрсэн буюу “Ногоон хөгжлийн бодлого”-ын зорилтот түвшинг хангаж байгааг илтгэж байна. Энэ нь ойжуулалт хөтөлбөрийн зарцуулалт үр дүнтэй байгааг харуулж байгаа боловч:

- Нэгдсэн төсвийн хүрээнд гарсан үр дүн, гарцыг бүрэн тодорхойлоогүй

- Шалгуур үзүүлэлтийн нэгдсэн аргачлал, хэмжүүр дутагдалтай байгаагаас үр өгөөжийг үнэлэхэд хүндрэлтэй хэвээр байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөр:

Байгаль орчны салбарын хамгийн том дотоод санхүүгийн эх үүсвэр нь БНАТ-ийн орлого юм. БНАТ-ийн хувь хэмжээ нь тухайн ашиглаж буй нөөцийн төрөл болон хэмжээнээс хамаарч өөр өөр байдаг бөгөөд Монгол Улсын “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан байдаг. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу тус орлогын тодорхой хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ёстой.

Энэ нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор төрөөс авдаг нэг төрлийн төлбөр бөгөөд дараах төрлийн нөөц ашигласны төлбөрийг хамардаг:

- Ойн нөөц ашигласны төлбөр
- Усны нөөц ашигласны төлбөр
- Амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөр
- Ашигт малтмал (зарим тохиолдолд)
- Газрын гадаргын болон гүний ус ашигласны төлбөр гэх мэт

Өнгөрсөн оны төсвийн жилд БНАТ-ийн орлого 283,994.0 сая төгрөг болж 2023 оны орлогоос 30,663.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогыг тодруулбал, газрын төлбөр 162,295.7 сая, усны нөөцийн төлбөр 86,939.4 сая, ойн нөөцийн төлбөр 20,044.9 сая, амьтны нөөцийн төлбөр 14,350.3 сая, ургамлын нөөцийн төлбөрт 363.7 сая төгрөг бүрдүүлсэн байна.


БНАТ-ийн орлого нь тус салбарын дотоодын хамгийн том эх үүсвэр бөгөөд энэ орлогын тодорхой хувийг хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ёстой. Гэвч 2015–2023 оны хугацаанд уг орлогыг хуульд заасан хэмжээнд хүргэж, бүрэн зарцуулаагүй бөгөөд жилд дунджаар 40 орчим тэрбум төгрөг зарцуулах шаардлагатай байснаас дунджаар 35 орчим тэрбум төгрөгийг зарцуулсан байна.²³

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ой, ан амьтан, ургамал, ойн нөөц ашигласны болон газрын төлбөрийн орлогыг хуулийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд хуваарилан зарцуулах хуулийн заалт бий. Энэ дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, ИТХ-ын 2024 оны шийдвэрээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах төсвийг 72,581.6 сая төгрөг баталсан нь 2021 оны дүнтэй харьцуулахад 4 дахин нэмэгджээ.

Энэхүү орлогын зарцуулалт тодорхой байгалийн нөөцөд чиглээгүй, ямар төрлийн нөөцийг нөхөн сэргээсэн нь бүрэн тодорхойгүй байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна.


²³ НҮБХХ-ийн хэрэгжүүлсэн Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд хийгдсэн “Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээ”

Зураг 51. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/²⁴



Өнгөрсөн оны жилийн эцсийн санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээгээр 47,382.2 сая төгрөгийг зарцуулсан буюу журмын хэрэгжилт 64.3 хувьтай байна.

Зураг 52. БНАТ-ийн орлогын гүйцэтгэл, хэрэгжүүлсэн БОХНСАХ-ний тоо болон зардлын гүйцэтгэлийн харьцуулсан үзүүлэлт²⁵, тэрбум төгрөг



БОУАС (Байгаль орчин, уур амьсгалын сан)-нд төвлөрүүлсэн ус, агаар бохирдуулсны төлбөрийн дийлэнх хэсгийг агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт зарцуулж байна.

- 2015–2023 оны дундаж: нийт зардлын 82.6% буюу 30.9 тэрбум төгрөг
- 2020–2022 он: Орлогоос 1.8 дахин их төсөв зарцуулсан
- 2023 он: Орлогоос 2.8 дахин бага төсөв зарцуулсан

Сүүлийн жилүүдэд орлого болон зарцуулалтын харьцаа алдагдаж, агаар бохирдуулсны төлбөрийн орлого нь хөтөлбөрийн санхүүжилтэд хангалттай ашиглагдахгүй байгаа нь харагдаж байна.

- 2015–2023 оны дунджаар: Жилд хамгийн багадаа 40 тэрбум төгрөг зарцуулах шаардлагатай байснаас дунджаар 35 тэрбум төгрөг л зарцуулагджээ.
- Төсвийн зарцуулалт нь тодорхой байгалийн нөөцөд чиглээгүй, ямар төрлийн нөөц нөхөн сэргээгдсэн нь тодорхой бус байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна.

Байгаль орчны салбарын төсөв сүүлийн жилүүдэд өсөлттэй байсан ч олон улсын дунджаас доогуур түвшинд байна. Төсвийн дийлэнх нь цөөн хэдэн хөтөлбөрт төвлөрч, зарим хөтөлбөрийн гүйцэтгэл, санхүүжилт хангалтгүй байна. Санхүүжилтийн томоохон эх үүсвэр

²⁴ МУ-ын нэгдсэн төсвийн 2021-2024 оны мэдээ

²⁵ <https://finance.eic.mn/implement?v=2023&a=>

болох байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлогыг бүрэн зориулалтын дагуу зарцуулах, төсвийн бүртгэл, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

МУЗЗНДНТУТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10 “байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт;” чиг үүргийг орон нутгийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр тусгасан ч энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хууль /16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1/ ИТХ дахин баталж хуваарилах : Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төсөв баталж, биелэлтэд хяналт тавихаар заасан.

Тулгамдаж буй асуудал:

- Орон нутгийн ЗД, ИТХ-аас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бууруулж төлөвлөх
- Төсвийг өөр зориулалтаар зарцуулах
- Аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны уялдаа холбоо байхгүй

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулснаар Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан үйл ажиллагаа бүрэн хэрэгжих боломж бүрдэнэ.

Монгол Улсын байгаль орчны татвар:

Монгол Улсын байгаль орчны татварын хэмжээ 2022 онд 1008.9 тэрбум төгрөг болж, 2015 оноос 81.5 хувиар өссөн бол 2021 онд 8.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 22. Байгаль орчны татвар, татварын орлогын төрлөөр

	2015	2019	2021	2022	Өөрчлөлт 2022/21	
	тэрбум төг				Дүн	Хувь
Байгаль орчны татвар – бүгд	555.9	1,009.8	1,097.4	1,009.0	(88.4)	(8.1)
Эрчим хүчний татвар	352.0	409.5	414.0	282.9	(131.1)	(31.7)
Тээврийн татвар	83.0	380.2	409.4	412.4	3.0	0.7
Бохирдлын татвар	12.2	47.3	46.9	26.2	(20.7)	(44.1)
Байгалийн нөөцийн татвар	108.7	172.8	227.1	287.5	60.4	26.6
Нийт татварт байгаль орчны татварын эзлэх хувь	10.9	10.4	9.7	6.5		
ДНБ-д байгаль орчны татварын эзлэх хувь	2.4	2.7	2.5	1.9		

Байгаль орчны татвар 2022 онд татварын нийт орлогын 6.5 хувийг бүрдүүлжээ. Үүнд тээврийн татвар 2.7 хувь, байгалийн нөөцийн татвар 1.9 хувь, эрчим хүчний татвар 1.8 хувь, байгаль орчны бохирдлын татвар 0.2 хувийг эзэлж байна. Байгаль орчны татварын ихэнх хувийг эрчим хүчний татвар болон тээврийн татвар эзэлж байна.

Тээврийн татвар 2022 онд 412.4 тэрбум төгрөгт хүрч, 2015 оноос 5.0 дахин, 2021 оноос 0.7 хувиар нэмэгджээ. Түлшний импортын 2022 оны хэмжээг 2015 онтой харьцуулахад онгоцны түлшний импорт 2.7 дахин, авто бензиний импорт 57.0 хувь, дизелийн түлшний импорт 49.9 хувиар тус тус өссөн байна. Байгаль орчны бохирдлын татвар 2022 онд 26.2 тэрбум төгрөгт хүрч, 2019 оноос 44.6 хувь, 2021 оноос 44.1 хувиар буурсан. Байгалийн нөөцийн татвар 2022 онд 287.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 60.3 тэрбум төгрөг буюу 26.6 хувиар өссөн байна.

Монгол Улсад байгаль орчны татварын бодлогыг хөгжүүлснээр төсвийн орлогод “ногоон” татварын эзлэх хувийг тодорхойлох боломж бий болно. ДНБ-д татварын орлогын эзлэх хувь нь татварын ачаалал хэр байгааг харуулах үзүүлэлт юм.

Зураг 53. ДНБ-д нийт татвар, Байгаль орчны татварын эзлэх хувь²⁶



ДНБ-д нийт татварын орлогын эзлэх хувь 2022 онд 28.7 хувь болж, 2021 оноос 2.8 нэгжээр хувиар өссөн байна. ДНБ-д байгаль орчны татварын эзлэх хувь 2021 онд 2.5 хувь байсан бол 2022 онд 1.9 хувь болж, 2021 онтой харьцуулахад 0.6 нэгжээр хувиар буурсан байна. Байгаль орчны татварын 56.3 хувийг ААНБ ууд, 43.7 хувийг иргэд төлж байна.

Зураг 54. Татварын бодлогын дэмжлэг-Ойн салбарт²⁷



Дүгнэлт:

Салбарын төсвийг батлахдаа улсын болон орон нутгийн Төсвийн ерөнхийлан захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг “шалтгаан-үр дагаврын цогц шинжилгээ”-нд үндэслэн гарц/бүтээгдэхүүн, үр дагавар, үр нөлөөг оновчтой тодорхойлж баталснаар салбарт олгож буй төсвийн зарлагын үр ашгийг оновчтой тооцоолох нөхцөл бүрдэх бөгөөд зардал илүү үр өгөөжтэй зарцуулагдана.

БОУАӨЯ нь бодлогын хүрээнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу БНАТ-ын төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаар болох 85 хувийг орон нутгийн төсвөөс “Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувиар тооцон төлөвлөхөр заасан байдаг ч орон нутгийн ЗД, ИТХ-аас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бууруулж төлөвлөх, төсвийг өөр зориулалтаар зарцуулах,

²⁶ МУ-ын нийгэм, эдийн засгийн танилцуулга (2019-2023), 2024 он

²⁷ Сангийн яам, Ойн салбарын төсөв-2024 илтгэл, 2024 он

аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны уялдаа холбоо байхгүй зэрэг асуудлууд байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг мөрдөж байна.

Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүнд, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилсан төсөвлөлтөд үндэслэн тодорхойлж улсын болон орон нутгийн төсөвт хөтөлбөрийн хүрэх үр дүнд ижил хэмжигдэхүүнээр хэмжиж салбарын нэгдсэн төсвийн хүрэн дэх үр дүнгүүдийг оновчтой тодорхойлдоггүйгээс төсвийн үр өгөөжийг хэмжих боломжгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэхийг үүрэг болгосон ч “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2022 онд ДНБ-ний 0.28 хувь, 2023 онд ДНБ-ний 0.29 хувь, 2024 онд ДНБ-ний 0.35 хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.²⁸

Монгол орны ойн хүлэмжийн хийн шингээлт, ялгаруулалтын суурь үзүүлэлтийг тогтоожт ойн доройтол, хомсдлыг бууруулах, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсаас санхүүгийн дэмжлэг авах, нүүрстөрөгчийн худалдааны зах зээлд оролцох боломж нээгдэж байна. Өөрөөр хэлбэл экосистемийн динамик тэнцвэрт байдлыг хадгалсан ойн тогтвортой менежмент нь ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ойн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ганц биш олон эх үүсвэрээс санхүүжих боломжтой “ногоон бизнес” хөгжих боломж бүрдэх юм.

2.2.2 Олон улсын төсөл хөтөлбөр, түүний үр дүн

2021-2024 оны хугацаанд гадаадын зээл тусламжаар тус салбарт нийтдээ 166.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. /төслийн дэлгэрэнгүй хүснэгтийг хавсаргав/

Зураг 55. Гадны зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээлэл²⁹

Хэрэгжиж байгаа 4 арга хэмжээ-234.6 тэрбум төг	Хэрэгжиж дууссан 5 арга хэмжээ-55.7 тэрбум төг	Хэлэлцээрт 3 арга хэмжээ, 32.0 тэрбум төг	Судалж байгаа 2 арга хэмжээ, 92.0 тэрбум төг
<input type="checkbox"/> БОУАӨЯ - Байгаль орчны төв лабораторийн чадавхийг сайжруулах төсөл (2023-2027) /БНСУ/	<input type="checkbox"/> БОУАӨЯ - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл (2015-2022) /ХБНГУ/	<input type="checkbox"/> Бага оврын тоног, төхөөрөмж үйлдвэрлэл /НҮБ, ХААХОУС/	<input type="checkbox"/> "Биокомбинат" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх /ОХУ/
<input type="checkbox"/> БОУАӨЯ - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл II, III шат (2019-2027) /ХБНГУ/	<input type="checkbox"/> НЗДТГ - Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл (Ядуурлыг бууруулах Японы сан) (2020-2024) /АХБ/	<input type="checkbox"/> 50га хүлэмжийн цогцолбор байгуулах /Унгар/	<input type="checkbox"/> Вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох /ОХУ/
<input type="checkbox"/> НЗДТГ - Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл (2018-2025) /ЕСБХБ/	<input type="checkbox"/> НЗДТГ - Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл II (2019-2024) /ДБ/	<input type="checkbox"/> Өрхийн борлуулалтын дэмжлэг /АХБ/	
<input type="checkbox"/> ОАЗДТГ - Эрдэнэт хотын хатуу хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл (2019-2025) /Польш/	<input type="checkbox"/> НЗДТГ - Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл (2017-2021) /АХБ/		
	<input type="checkbox"/> БОУАӨЯ - Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцлийг сайжруулах төсөл (2018-2021) /БНХАУ/		

²⁸ ЗГХА, Ойн газрын 2024 оны тайлан

²⁹ Сангийн яам, Ойн салбарын төсөв-2024 илтгэл, 2024 он

Хүснэгт 23. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслүүд /сая төгрөг/³⁰

№	Хөгжлийн түнш, эх үүсвэр	Хэрэгжүүлэгч, төслийн нэр, хугацаа	Хэлэлцээрийн дүн / Төсөвт өртөг	Ашиглаагүй үлдэгдэл
1	БНСУ, Зээл	БОУАӨЯ - Байгаль орчны төв лабораторийн чадавхийг сайжруулах төсөл (2023-2027)	50,703.90	49,571.60
2	ХБНГУ, Тусламж	БОУАӨЯ - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл II, III шат (2019-2027)	100,664.85	68,656.80
		БОУАӨЯ - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл (2015-2022)	42,096.21	-
3	ЕСБХБ, Зээл, тусламж	НЗДТГ - Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл (2018-2025)	50,280.76	4,207.16
4	Польш, Зээл	ОАЗДТГ - Эрдэнэт хотын хатуу хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл (2019-2025)	32,944.86	3,294.49
5	АХБ, Тусламж	НЗДТГ - Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл (Ядуурлыг бууруулах Японы сан) (2020-2024)	10,142.82	-
		НЗДТГ - Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл (2017-2021)	9,466.63	-
6	ДБ, Зээл	НЗДТГ - Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл II (2019-2024)	39,082.62	-
7	БНХАУ, Тусламж	БОУАӨЯ - Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцлийг сайжруулах төсөл (2018-2021)	5,404.69	-
НИЙТ			340,787.3	125,730.0

2024 оны байдлаар Дэлхийн банк, БНСУ, ХБНГУ, АХБ, БНХАУ, Польш, ЕСБХБ зэрэг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр 2021-2024 онуудад 9 төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 5 төсөл, хөтөлбөр хэрэгжиж дууссан байна.³¹ Эдгээр төслүүдийг зорилгоор нь ангилан харвал Уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох, Биологийн олон янз байдал, экосистемийн хамгаалах, ойн менежмент, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд чиглэж байна.

Эдгээр Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээрх төслүүдээс дараах ажлууд хэрэгжиж дууссан байна.

- ХБНГУ, Тусламж-42,1 сая төг: Дэд төслийн 11 хамгаалалтын захиргаадад 1 Хамгаалалтын захиргааны байр, 6 сургалт мэдээллийн төв, 53 байгаль хамгаалагчийн байр, 16 бартаат замын авто машин, 16 гал түймрийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон автомашин, 64 бартаат замын мотоцикл, мэргэжилтнүүдийн ажлын өвөл зуны дүрэмт 600 ш иж бүрэн хувцас, хээрийн болон судалгааны тоног төхөөрөмж, Орчны бүсийн судалгаа, мэдээллийн төвд тавилга, IT тоног төхөөрөмж, УТХГ-ын орчны бүс, аялал жуулчлал болон менежментийн нийт 24 төлөвлөгөө, БОЯБ-ын судалгаа, Эко кабинетыг сургалт сурталчилгааны багаж хэрэгслээр хангах, Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, Дэд төслийн хүрээнд Хамгаалалтыг захиргаадыг УАЗ, трактор, соруулдаг машин зөөврийн чингэлэг зэрэг бусад тээврийн хэрэгслээр хангах ажлууд хийгдсэн.
- АХБ, Тусламж- 19,6 тэрбум төгрөг, Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах хувилбаруудыг тодорхой болгох ажлын хүрээнд хүнсний хаягдлыг дахин боловсруулах судалгаа хийгдэж, хэвлэгдсэн. 2 дүүргийн 50 айл өрхөд туршилтын төсөл хэрэгжсэн. 1,100 кг хүнсний хаягдлыг дахин боловсруулсан. Сургууль, цэцэрлэг, байгууллагын түвшинд буюу 10 байршилд туршилтын төсөл хэрэгжиж байна. 1,200 кг

³⁰ Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04-р сарын 17-ны өдрийн 02/2982 тоот албан бичиг

³¹ Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04-р сарын 17-ны өдрийн 02/2982 тоот албан бичиг

- хүнсний хаягдлыг дахин боловсруулсан. Аж ахуй нэгжтэй хамтран туршилтын төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдсэн.
- ДБ, Зээл- 39.1 тэрбум төг: Төвлөрсөн дулаанд холбогдох боломжгүй байршил дахь 2 сургууль цэцэрлэгийн халаалтыг "газрын гүний дулаанаар шийдэх" туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Мөн Улаанбаатар хотын төвийн болон гэр хорооллын бүсэд байрлалтай 9 сургууль, цэцэрлэгийг дулаалсан. Төрийн болон нийслэлийн өмчит 7 халаалтын зуухыг буулган, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбосон. Улаанбаатар хот дахь 15 угсармал орон сууцны блок дулаалж 2 ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэн байгуулна. Түүнчлэн гэр хороолол дахь 340 айл өрхийн халаалтыг хуримтлуурт халаагуураар шийдэж, орон байрны дулаан алдагдлыг бууруулах "Халаалт, дулаалгын цогц шийдэл" бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
 - БНХАУ, Тусламж-5,4 тэрбум төг: Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах төслийн хэрэгжүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 53% нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд чиглэж байгаа нь байгаль хамгаалал, биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаа тавигдаж байгааг харуулж байна.

Бусад чухал чиглэлүүд болох уур амьсгалын өөрчлөлт (16%), цөлжилт, ойн салбар (8%), химийн хорт бодисын менежмент (6%) зэрэгт харьцангуй бага боловч тогтвортой хөрөнгө оруулалт хийгдэж байна.

Дээрхээс дүгнэхэд, байгаль орчны салбарын 2021–2024 оны төсвийн шинжилгээнээс тус салбарын санхүүжилтийн бүтэц, зарцуулалтын үр өгөөж, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд бодлогын түвшний зохицуулалт, санхүүгийн ил тод байдлыг сайжруулах шаардлага нэн тулгамдаж байна.

Олон улсын төсөл, хөтөлбөрүүд нь байгаль орчны салбарт чухал хувь нэмэр оруулж байгаа ч нийт санхүүжилт дотоод эх үүсвэртэй харьцуулахад хязгаарлагдмал байна.

Монгол Улсад хэрэгжиж буй олон улсын байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, болон хүлэмжийн хийн бууруулах төсөл хөтөлбөрүүд нь экосистемийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн иргэдийн амьжиргааг сайжруулах, төрийн бодлогыг байгальд ээлтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Төслийн үр дүн, нөлөөг авч үзвэл, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Монгол Улсад хэрэгжиж буй байгаль хамгаалал болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл, хөтөлбөрүүд нь тодорхой ахиц, үр дүнг бий болгосон байна. Байгаль хамгааллын бүтээмжийг нэмэгдүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх, түүний удирдлага, хамгаалалтын чанарыг сайжруулах чиглэлд бодитой ахиц гарсан бөгөөд зарим бүс нутагт хамгаалалтын бүсчлэл, орон нутгийн оролцоонд суурилсан менежмент үр дүнтэй хэрэгжиж эхэлжээ.

Мөн малчид болон орон нутгийн иргэдийн уур амьсгалын эрсдэлийг даван туулах чадварыг сайжруулахад төслүүдийн гүйцэтгэсэн үүрэг ихээхэн байв. Усны хангамжийг сайжруулах жижиг хэмжээний дэд бүтэц байгуулж, ургацын төрөлжилтийг нэмэгдүүлэн газар тариалан, хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжсэн нь орон нутгийн иргэдийн орлогын шинэ эх үүсвэр болж, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлсэн байна. Үүнээс гадна, байгаль орчин, уур амьсгалын асуудлуудыг салбар хоорондын бодлого төлөвлөлтөд тусгах, уур амьсгалын эрсдэлийг үнэлж төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх үйл явц эхэлсэн нь системийн өөрчлөлтөд хүргэх чухал алхам болж байна.

Дүгнэлт:

Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн эерэг үр дүнг төслүүд хоорондын уялдаа холбоо, нэгдсэн удирдлага, бодлого тодорхойлдог байгууллагуудын дотоод зохион байгуулалт, уялдаагүй байдал сулруулж байна.

Яам хоорондын мэдээллийн урсгал, харилцаа холбоо, үнэлгээний арга зүй, туршлага солилцох асуудал сул хэвээр байгааг ярилцлагад оролцсон байгууллагууд онцлон тэмдэглэсэн. Үүнтэй холбоотойгоор зарим төслийн чиглэл давхцаж, нөөцийн үр ашиггүй

хуваарилалт, олон улсын төсөл, хөтөлбөр, тусламжийн бодлогын нэгдмэл байдал оновчтой бус байгаа нь бодлогын түвшинд цаашид анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Төсөл хөтөлбөрүүдийг нэгдсэн стратеги, ил тод мэдээллийн систем, олон талт оролцоонд тулгуурлан уялдуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

2.3. ХҮНИЙ НӨӨЦ

2.3.1. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт

БОАЖЯ /хуучнаар/-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/185 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг үндэслэн “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр баталжээ.

Дээрх хөтөлбөрийг яамны 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайлыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.” зорилтын хүрээнд жил бүр 6 багц арга хэмжээнд хамруулан ерөнхийлөн төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллажээ.

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4.5-д яам нь “төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ...”, 2.5.5.2-т “салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг хийж, хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог дээшлүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, ...”, 3.3.5-д “Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь “төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхыг бэхжүүлэх, ажлын байрны эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах, цалин хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх”-ээр тусгасан байна.

2.3.2. Байгаль орчны салбарын хүчний нөөцийн өнөөгийн байдал

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ирүүлсэн мэдээллээр энэ салбарт 94 байгууллагад 3300 гаруй албан хаагч ажиллаж байна³².

Байгаль орчныг хамгаалах тухай хууль 35 дугаар зүйл /Мэдээллийн сангийн бүрдэл/-ийн 35.1-ийн 18 дахь хэсэгт “Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц”-ийн мэдээллийн сантай байхаар хуульчилсан. Мэдээллийн санд³³ салбарын хүний нөөцийн мэдээллийг харьяалагдах байгууллагаар нь төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг нийт 7 бүлэгт ангилан хөтлөхөөр байгуулжээ.

Зураг 56. Байгаль орчны байгууллага, хүний нөөцийн мэдээллийн сангийн бүтэц

The screenshot displays the web interface for the 'BO-ny байгууллага, хүний нөөцийн мэдээллийн сан' (BO-ny organizations, human resources information system). The header includes the logo and name of the 'Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам' (Ministry of Environment, Uur Amьсгалын Өөрчлөлтийн Яам). The main content area features a search form for 'Төрийн байгууллага' (State organizations). The search criteria include 'Аймаг, нийслэлийн нэр' (Province, capital name) with a dropdown menu currently set to 'Бүх аймаг' (All provinces) and 'Байгууллагын нэр' (Organization name) with a text input field. A search button labeled 'Хайх' (Search) is located at the bottom right of the search area. The page also has navigation links for 'Нүүр хуудас' (Home) and 'Мэдээ оруулах' (Add news).

³² Эх сурвалж

³³ www.eic.mn

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөцийн мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлж байхаар заасан боловч өнөөдрийн байдлаар мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй байна.

Яамны нийт орон тоо 122, үүнээс сул орон тоо 8, одоо ажиллаж байгаа 116 албан хаагч байна. 31 албан хаагч түр орлон гүйцэтгэж байгаагийн 13 нь удирдах албан тушаалтан буюу газар, хэлтсийн дарга нар байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төрийн захиргааны удирдах албан тушаалын 3, гүйцэтгэх албан тушаалын 19 сул орон тоонд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зарыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг дуустал байгууллагын вэб сайт болон Төрийн албаны зөвлөлийн вэб сайтаар олон нийтэд мэдээлсэн байна. Зарлагдсан гүйцэтгэх албан тушаалын 3 сул орон тоонд төрийн бусад байгууллагад ажиллаж буй 4 албан хаагч саналаа ирүүлсэн бөгөөд тэдгээр нь албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаагүй, бусад албан тушаалд албан хаагч бүртгүүлээгүй тул сул орон тоог нөхөөгүй байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалт зохион байгуулахаар Төрийн албаны зөвлөлд 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 02/1333, мөн удирдах албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 02/1332 дугаартай албан бичгээр хүргүүлжээ.

Монгол Улсын Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-ийн шинэ хөгжүүлэлтийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 66, 67, 68, 69 дүгээр тогтоолоор батлагдсан БОУАӨЯ-ны төрийн захиргааны 98 албан тушаалын тодорхойлолтыг ХНУМТ-ын цахим системд бүртгүүлж, сул орон тооны нээлттэй сонгон шалгаруулалт явуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 24. БОУАӨЯ-ны чиг үүргийн шинжилгээнд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл (2025 оны 04 дүгээр сарын 17-ны байдлаар)³⁴

Д/д	Албан тушаал	Ажил-лавал зохих	Ажил-лаж байгаа	Тайлбар
Нэг.Удирдлага (2)				
1.	Сайд	1	1	-
2.	Төрийн нарийн бичгийн дарга	1	1	-
Хоёр.Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар (Орон тоо-10)				
1.	Газрын дарга	1	1	Түр орлон-5 - Газрын дарга - Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн дарга - Ногоон технологи, инновацын хэлтсийн дарга - Байгаль орчны салбарын стандартчиллын асуудал хариуцсан ахлах шинжээч - Технологи, инновац хариуцсан мэргэжилтэн
2.	Хэлтсийн дарга	2	2	
3.	НБТГ-ын ахлах шинжээч	3	3	
4.	Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн шинжээч, мэргэжилтэн	2	2	
5.	Ногоон технологи, инновацын хэлтсийн мэргэжилтэн	2	2	
Гурав.Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар (Орон тоо-16)				
1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-1 - Ойн бодлого хариуцсан ахлах шинжээч Түр орлон-2 - Мэдээллийн сан, кадастрын хэлтсийн дарга - Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга
2.	Хэлтсийн дарга	2	2	
3.	БНБХГ-ын ахлах шинжээч, мэргэжилтэн	9	8	
4.	Мэдээллийн сан, кадастрын хэлтсийн мэргэжилтэн	3	3	
5.	Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн мэргэжилтэн	2	2	
Дөрөв.Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар (Орон тоо-18)				

³⁴ БОУАӨЯ

1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-1 - Байгаль орчны аудит хариуцсан шинжээч Түр орон-6 - Орчны бохирдлын хэлтсийн дарга - Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга - Химийн бодисын нөлөөллийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн - Агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн - Уул уурхайн төсөл хариуцсан ахлах шинжээч - Хүнд үйлдвэрийн төсөл хариуцсан ахлах шинжээч
2.	Хэлтсийн дарга	2	2	
3.	ХБОБХГ-ын ахлах шинжээч, мэргэжилтэн	3	3	
4.	Орчны бохирдлын хэлтсийн ахлах шинжээч, шинжээч, мэргэжилтэн	4	4	
5.	Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах шинжээч, шинжээч, мэргэжилтэн	8	7	
Тав.Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар (Орон тоо-7)				
1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-1 - Өргөдөл, гомдол, хамгаалалтын захиргаад хариуцсан мэргэжилтэн Түр орон-2 - Газрын дарга - Төлөвлөлт, бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч
2.	Ахлах шинжээч	2	2	
3.	Мэргэжилтэн	4	3	
Зургаа.Төрийн захиргааны удирдлагын газар (Орон тоо-33)				
1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-2 - Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, дүн шинжилгээ хариуцсан ахлах шинжээч - Захиргааны акт, төлөвлөгөө, тайлан хариуцсан шинжээч Түр орон-5 - Хуулийн хэлтсийн дарга - Бүтээмж, мэдээллийн технологийн хэлтсийн дарга - Хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч - Төрийн нарийн бичгийн даргын туслах бөгөөд яамны дотоод үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн - Өргөдөл, гомдол, жендер, гамшиг, дайчилгаа хариуцсан ахлах зохион байгуулагч
2.	Хэлтсийн дарга	2	2	
3.	ТЗУГ-ын ахлах шинжээч, шинжээч, мэргэжилтэн, бусад	18	17	
4.	Хуулийн хэлтсийн мэргэжилтэн	5	4	
5.	Бүтээмж, мэдээллийн технологийн хэлтсийн ажилтан	2	2	
6.	Сайдын ажлын албаны зөвлөх, хэвлэлийн төлөөлөгч, ажилтан, туслах	4	4	
Долоо.Гадаад хамтын ажиллагааны газар (Орон тоо-6)				
1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-2 - Олон улсын гэрээ, конвенц хариуцсан шинжээч - Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Түр орон-2 - Газрын дарга - Олон улсын байгууллага хариуцсан ахлах шинжээч
2.	Ахлах шинжээч	1	1	
3.	Шинжээч	1	1	
4.	Мэргэжилтэн	3	1	
Найм.Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Орон тоо-10)				
1.	Газрын дарга	1	1	Түр орон-3 - Газрын дарга - Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн - Тайлангийн нэгтгэл, хөрөнгийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
2.	Хэлтсийн дарга	1	1	
3.	СХОГ-ын ахлах шинжээч, мэргэжилтэн	3	3	
4.	Санхүүгийн хэлтсийн ерөнхий нягтлан, нягтлан бодогч, мэргэжилтэн	5	4	
Ес.Хяналт, үнэлгээ, аудитын газар (Орон тоо-5)				
1.	Газрын дарга	1	1	Түр орон-3 - Яам, харьяа байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн - Төсөл хөтөлбөр, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн - Статистик, мэдээлэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
2.	Ахлах шинжээч	1	1	
3.	Шинжээч	1	1	
4.	Мэргэжилтэн	2	1	
Арав.Салбарын хяналтын газар (Орон тоо-15)				
1.	Газрын дарга	1	1	Сул орон тоо-1 - Агаарын чанарын хяналт хариуцсан шинжээч Түр орон-3 - Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга - Тусгай хамгаалалтын газар нутгийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн - Эрсдэлийн бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч
2.	Хэлтсийн дарга	1	1	
3.	СХГ-ын ахлах шинжээч, шинжээч, мэргэжилтэн	10	9	
4.	Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч, мэргэжилтэн	3	3	

Нийт дүн	122	116	Сул орон тоо-8 Түр орон-31
----------	-----	-----	-------------------------------

Эх сурвалж: Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам(2025 он)

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” батлагдсан байна. Үүнтэй холбогдуулан яамны төрийн захиргааны албан тушаалын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталсан байна.

БОУАӨЯ-ны чиг үүргийн RACI шинжилгээ

Процесст оролцогчдын оролцоог тодорхойлж буй тэмдэглэгээг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- **R** - Хариуцан хийж, гүйцэтгэх;
- **A** - Тухайн үйл явцад хариуцлага хүлээх, батлах;
- **C** - Тухайн үйл явцын талаар харилцан зөвлөлдөх, оролцох;
- **I** - Үйл явцын талаар мэдээлсэн байх зэрэг болно

Хүснэгт 25. БОУАӨЯ-ны газар, хэлтсүүдийн чиг үүргийн уялдаа, оролцооны RACI

Д/д	Газар, хэлтэс	Үндсэн чиг үүрэг	R	A	C	I
1	Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар	Бодлого, хууль тогтоомж, судалгаа	✓	✓	2, 3, 6	8, 9
2	Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар	Нөөцийн үнэлгээ, нөхөн сэргээлт	✓	✓	1, 3, 4	8, 9
3	Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар	Нөлөөллийн үнэлгээ, экосистемийн тэнцвэр хадгалах	✓	✓	1, 2, 4	8, 9
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар	Хамгаалалт, судалгаа	✓	✓	1, 2, 3	8
5	Төрийн захиргааны удирдлагын газар	Хүний нөөц, хууль зүйн зөвлөмж	✓	✓	1, 7	6, 8
6	Гадаад хамтын ажиллагааны газар	Гэрээ, конвенц, олон улсын төсөл	✓	✓	1, 5	3, 7
7	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Төсөв, хөрөнгө оруулалт	✓	✓	1, 6	8
8	Хяналт, үнэлгээ, аудитын газар	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	✓	✓	1, 2, 3	9
9	Салбарын хяналтын газар	Хууль тогтоомжийн хяналт	✓	✓	8	1, 2, 3

RACI нь байгууллагын чиг үүргийн хэрэгжилт, хариуцлага, уялдаа холбоо, мэдээлэл солилцоог тодорхойлоход чухал хэрэгсэл юм. Энэхүү шинжилгээгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 9 газар, хэлтсийн чиг үүрэг Responsible – R (хариуцан хийж гүйцэтгэх), Accountable – A (Тухайн үйл явцад хариуцлага хүлээх, батлах), Consulted – C (Тухайн үйл явцын талаар харилцан зөвлөлдөх, оролцох), Informed – I (Үйл явцын талаар мэдээлсэн байх)-ийн дүн шинжилгээг хийв.

R: Бүх газар, хэлтэс өөрсдийн чиг үүргийн хэрэгжилтэд бүрэн 100% оролцдог.

A: газар бүр өөрийн гол чиг үүрэгт хариуцлага хүлээж, шийдвэр гаргалтад оролцдог.

C: Дундаж оролцоо ~55%, уялдаа холбоо сайтай хэдий ч зарим тохиолдолд хэт төвөгтэй зөвлөлдөх бүтэц нь шийдвэр гаргалт, хариуцлагыг сулруулах эрсдэлтэй.

I: Дундаж оролцоо ~45%, мэдээллийн урсгал системтэй боловч давхцал үүсэх хандлагатай.


Хүснэгт 26. RACI шинжилгээний дүгнэлт, зөвлөмж

Үүрэг	Давуу тал	Боломжит эрсдэл	Сайжруулах санал
R / A (Гүйцэтгэх, Хариуцах)	Чиг үүрэг, хариуцлага тодорхой, давхардалгүй ажиллах нөхцөл бүрдсэн	-	Оролцооны бүтэц харьцангуй оновчтой, үр ашигтай хэвээр хадгалах
C (Зөвлөлдөх)	Газар, нэгжүүдийн уялдаа, хамтын ажиллагаа сайжирсан	Хэт олон зөвлөлдөх оролцоо нь шийдвэр гаргалтыг удаашруулж, хариуцлагыг сулруулах эрсдэлтэй	Зөвлөлдөх бүтэц, сэдвийг тодорхой болгож, зөвхөн холбогдох нэгжүүдийг хамарсан системтэй зохион байгуулах
I (Мэдээлэх)	Ил тод, нээлттэй мэдээллийн урсгал бий болсон	Давхар мэдээлэл дамжуулах, мэдээлэл хоцроох, хэт төвөгтэй сүлжээ бий болох	Нэгдсэн, цахимжсан мэдээллийн систем хөгжүүлж, мэдээллийн давхцал, хоцрогдлыг арилгах

Батлагдсан албан тушаалын тодорхойлолтод шинжилгээг хийхэд:

- Төрийн захиргааны албан тушаалд ажиллах албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулахдаа байгаль орчны чиглэлийн мэргэжлийг шууд заасан 41, байгаль орчин болон бусад мэргэжлийг хавсарсан байдлаар заасан 37, бусад мэргэжлийн чиглэл заасан 20 албан хаагч ажиллуулахаар тусгажээ.
- “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т хуулийн асуудал хариуцсан бүтцийн нэгжтэй байхаар зохион байгуулагдсан хэдий ч яамны төрийн захиргааны 98 албан хаагчийн 51 албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагад “Эрх зүй”-ч мэргэжлийг оруулсан нь салбарын онцлог, хүний нөөцийн бодлоготой уялдахгүй байна.
- Албан тушаалын тодорхойлолтод байгаль орчны салбарт шууд хамааралтай бус “Уул уурхайн олборлолт”, “Газар тариалан, мал аж ахуй”, “Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар дундын чиглэл”, “Био-ангаах ухаан” гэсэн мэргэжлүүдийг оруулсан нь Байгаль орчны салбарын онцлог болох шинжлэх ухаанд суурилсан, олон улсын хамтын ажиллагаа, салбар дундын онцлогийг харгалзан байгаль орчны чиглэлийн нарийн мэргэжил, туршлагад тулгуурлан бодлого боловсруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харьяа болон төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах боломжийг хязгаарлаж байна.

Зураг 57. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүний нөөцийн хөдөлгөөн /2018-2025 он/



Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 2025 он.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2018-2024 оны хүний нөөцийн хөдөлгөөнөөс харахад тухайн яаманд ажиллаж буй албан хаагчид өөрийн хүсэлтээр болон захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлөгдөх байдал сүүлийн 5 жилд анхаарал татахуйц өндөр буюу 24.1-56.4 хувь байна. Тухайлбал: 2022 онд 110 албан хаагч ажилласны 39 буюу 35.5 хувь нь өөрийн хүсэлтээр, 23 буюу 20.9 хувь нь захиргааны санаачлагаар нэгтгэж үзвэл 62 албан хаагч буюу 56.4 хувь нь өөрчлөгдсөн, мөн 2023 онд 133 албан хаагч ажилласны 29 буюу 21.8 хувь нь өөрийн хүсэлтээр, 32 буюу 24.1 хувь нь захиргааны санаачлагаар нийтдээ 61 албан хаагч буюу 45.9 хувь нь өөрчлөгджээ.

Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулах зохицуулалтыг бий болгосон ч 2013 онд төрийн албан хаагчийн 11.5 хувь нь, 2017 онд 15.5 хувь нь 2019 онд 22.3 хувь, 2022 онд 23.8 хувь нь солигдсон байна. */Үндэсний аудитын газраас 2024 онд хийсэн “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” аудитын тайлангаас/*

Байгууллагын нийт албан хаагчийн жилд 5-10 хувь нь халагдаж, солигдож байхыг хэвийн буюу тогтвортой гэж үзэхэд 20 орчим хувь буюу төрийн захиргааны таван албан хаагч тутмын нэг нь ажлаас халагдаж эсвэл чөлөөлөгдөж байгаа нь төрийн албаны ой санамж алдагдах, мэдлэг туршлагын дутагдал үүсгэх эрсдэлийг дагуулж байна. */Үндэсний аудитын газраас 2024 онд хийсэн “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” аудитын тайлангаас/*

Дээрх судалгаанд дурдсан байгууллагын нийт албан хаагчдын 5-10 хувь нь халагдаж солигдож байхыг хэвийн тогтвортой гэж үздэгтэй Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүний нөөцийн хөдөлгөөн буюу ажлаас халагдах эсвэл чөлөөлөгдөх байдлыг харьцуулж үзвэл 24.1-56.4 хувь буюу 2-оос 5 дахин өндөр байна. Энэ нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баримталж буй төрийн албаны тогтвортой байдал, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны залгамж чанарыг хангах, салбарын хүний нөөц, ойн санамжийг хадгалах, мэргэжлийн байх бодлого, зорилттой нийцэхгүй байна.

Дүгнэлт:

Засгийн газрын тогтворгүй байдал, улс төрийн хүчин зүйлсээс шалтгаалан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэр, бүтэц зохион байгуулалт 2012 оноос хойш 6 удаа өөрчлөгдөж, 9 дэх Засгийн газрын гишүүн ажиллаж байна. Эдгээр өөрчлөлт бүрт удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг өөрчилснөөс хүний нөөцийн бодлого алдагдаж, салбарын албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах боломжийг хязгаарласан байна.

Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах хамгийн гол нөхцөлийн нэг ажлын байрны орчин, тав тухтай байдал, байршил байдаг. 2022 оны төгсгөл, 2023 оны эхэнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ыг тодорхой судалгаагүй, албан хаагчдын хүсэл сонирхол, саналыг үл харгалзан өвлийн улиралд яармаг руу нүүлгэсэн байна. Тухайн жилд яамны албан хаагчид хамгийн олноор өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Эндээс үзвэл төрийн захиргааны төв байгууллагыг нүүлгэн шилжүүлэх асуудал нь бодит судалгаа, албан хаагчдын санал хүсэлтийг харгалзан шийдвэрлээгүйгээс салбар хүний нөөцийн дутагдалд орох, төрийн бодлогын залгамж чанар, ой санамж алдагдах нөхцөлийг үүсгэж байна.

RACI шинжилгээгээр яамны чиг үүргийн хэрэгжилт, хариуцлага, уялдаа холбоо, мэдээлэл солилцоог тодорхойлоход бүх газар, хэлтэс өөрсдийн чиг үүргийн хэрэгжилтэд бүрэн оролцож, гүйцэтгэгчийн үүрэгтэй ажиллахын зэрэгцээ өөр өөрийн үндсэн чиг үүрэгт хариуцлага хүлээж, шийдвэр гаргалтад оролцдог. Хэдий тийм боловч зарим тохиолдолд хэт олон зөвлөлдөх оролцоотой байгаа нь шийдвэр гаргалтыг удаашруулж, хариуцлагыг сулруулах эрсдэлтэй байна. Мөн давхар мэдээлэл дамжуулах, мэдээлэл хоцроох, хэт төвөгтэй сүлжээ бий болох хандлага ажиглагдаж байна.

Байгаль орчны салбарын болон БОУАӨЯ, Ойн газрын албан хаагчдаас авсан судалгаагаар байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэгжийн чиг үүргийн хувиарлалт, удирдлагын ур чадвар, арга барил, ажиллах орчин, ажлын жигд бус хувиарлалт зэрэг асуудлуудад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын сэтгэл ханамж дунджаас доогуур байна. Энэ нь албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах, ажилдаа үнэнч хандах, бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Ойн салбарын хүний нөөцийн мэдээлэл:³⁵

Ойн мэргэжлээр дээд боловсрол эзэмшихээр 2023-2024 оны хичээлийн жилд 289 оюутан суралцаж байгаагаас бакалаврт 178, магистрт 96, докторт 15 суралцагч суралцаж байна. Улсын хэмжээнд 2024 онд шинээр 52 суралцагч элсэн орсон. Энэ хичээлийн жилд мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын байгууллагад ойн арчилгаа, ашиглалтын ажилтнаар 35, ойжуулагчаар 462, ойн аж ахуйн ажилтнаар 45, техникчээр 17 суралцаж оюутан суралцаж байгаагаас шинээр мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд ойжуулагч 448, ойн аж ахуйн ажилтнаар 54, ойн нөхөрлөлөөр 45 суралцаж элсэн орж суралцаж байна.³⁶

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүний нөөцийг бэлдэх, мэргэшүүлэх, чадавхжуулах зорилгоор хоёрдогч бакалаврын зэрэг олгох, мод тарьж ургуулах цахим, танхим, практик хослуулсан сургалтад 47.4 мянган хүнийг хамруулжээ. Үүнд:

- Боловсрол шинжлэх ухааны болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалыг үндэслэн 21 аймгийн 329 сумд, Улаанбаатар хотын 9 дүүрэг тус бүрээс 3 биологи, байгаль орчны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн төрийн албан хаагчид, мод бут тарьж ургуулах сонирхолтой хувийн хэвшилд ажиллаж буй иргэдийг оролцуулсан 24 багц цагийн багтаамж бүхий сургалтыг 2 үе шаттай МУИС, ШУТИС, ХААИС болон Биологийн хүрээлэн, Газарзүй геоэкологийн хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулсан. Сургалт нь 8 модультай, онлайн болон хээрийн гэсэн үе шатуудтай зохион байгуулагдсан. Онлайн сургалтад орон нутгийн төлөөлөл болсон 1036 хүн хамрагдсан байна.
- Монгол Улсын Их Сургуульд хоёрдогч бакалаврын зэрэг олгох “Ойн аж ахуй” хөтөлбөрийг шинээр нээж, 2022-2023 оны хичээлийн жилд нийт 52 оюутан элсэн суралцаж байна. Хөдөө аж ахуйн их сургууль, Батлан хамгаалах яамтай хамтран давхардсан тоогоор 23,600 хүнд мод тарьж, ургуулах 40 цагийн сургалт, 120 хүнд сургагч багшийн сургалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 54 хүнд сертификаттай, 51 хүнд сургагч багшийн сертификаттай сургалт, Хан-Уул дүүргийн 51 хүнд сертификаттай сургалт, нийт 23,876 хүнд сургалтыг цахим, танхим, практик хослуулж явуулжээ.
- Ойн салбарын хүний нөөцийг бэлдэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, салбарын хөгжлийг эрчимжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх, дэмжих чиглэлд төр болон эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг төлөөлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монгол Улсын их сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Талуудын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын их сургуулийн Ойн аж ахуй хөтөлбөрт 2022-2023 оны хичээлийн жилд тус сургуулийн хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимд ойн аж ахуй, хүрээлэн буй орчин, инженерчлэлийн мэргэжлээр бакалаврын зэрэгт элсэн суралцаж буй оюутнуудаас ойн чиглэлээр суралцаж, цаашид мэргэших сонирхолтой, шилдэг оюутнуудыг сонгон шалгаруулж, Бүгд Найрамдах Унгар Улсад суралцуулахаар шийдвэрлэсэн байна.
- Өмнөговь аймаг болон Оюу Толгой ХХК, тус аймгийн Ханбогд сумын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-аас 2022-2023 оны хичээлийн жилд тэтгэлэг олгох хөтөлбөр зарласан. 2022-2023 оны хичээлийн жилд Өмнөговь аймгийн ЗДТГ-аас санал болгосны дагуу тус аймагт шаардлагатай байгаа мэргэжлүүдээр магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа Өмнөговь аймгийн оюутнуудаас сонгон шалгаруулалт хийж шалгарсан оюутнуудад “Говийн оюу– Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгож байна. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах мэргэжлийн чиглэлд ойн аж ахуйн инженер мэргэжил багтсан болно.
- Оюу толгой ХХК нь 2011 оноос өнөөг хүртэл дотоодын тэтгэлэгт хөтөлбөртөө 376 оюутан хамруулаад байна. 2022-2023 оны хичээлийн жилд 25 оюутан шалгаруулсан. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах мэргэжлийн чиглэлд ойн аж ахуйн инженер мэргэжил багтсан болно. Тэтгэлэгт сургалтын болон оюутны байрны төлбөр, сар бүрийн тэтгэмж, залуусын хөгжлийн хөтөлбөрт суралцах боломж багтаж байна.

³⁵ ЗГХА, Ойн газрын тайлан, 2024 он

³⁶ ЗГХА, Ойн газрын тайлан, 2024 он

Хүснэгт 27. Ойн газрын чиг үүргийн шинжилгээнд хамрагдсан албан хаагчдын мэдээлэл (2025 оны 04 дүгээр сарын 17-ны байдлаар)

Д/д	Албан тушаал	Ажиллавал зохих	Ажиллаж байгаа	Тайлбар
Нэг.	Удирдлага (1)			
1.	Дарга	1	1	-
Хоёр.	Захиргаа, удирдлагын хэлтэс (Орон тоо-13)			
1.	Хэлтсийн дарга	1	1	Түр орлон- 1 Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
2.	Ахлах мэргэжилтэн	4	4	
4.	Бусад	8	8	
Гурав.	Ойн нөөцийн хэлтэс (Орон тоо -11)			
1.	Хэлтсийн дарга	1	1	Түр орлон-1 Ойн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн
2.	Ахлах мэргэжилтэн	6	6	
3.	Мэргэжилтэн	4	4	
Дөрөв.	Ойн нөхөн сэргээлтийн хэлтэс (Орон тоо- 10)			
1.	Хэлтсийн дарга	1	1	Сул орон тоо-1 Таримал ой, байгалийн сэргэн ургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
2.	Ахлах мэргэжилтэн	5	5	
3.	Мэргэжилтэн	4	3	Түр орлон- 1 Говь хээрийн бүсийн ойжуулалт,цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Тав.	Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээлэл технологийн хэлтэс (Орон тоо-3)			
1.	Хэлтсийн дарга	1	1	-
2.	Ахлах мэргэжилтэн	2	2	
Нийт дүн		38	37	Сул орон тоо-1 Түр орлон-3

Эх сурвалж: Ойн газар

Ойн газрын хувьд удирдах албан тушаалтан 5, төрийн захиргааны албан тушаалтан 30, бусад албан хаагчид 8 ажиллаж байна. Судалгаагаар албан үүргийг түр орлон гүйцэтгэж буй 3, сул орон тоо 1 байна.

Ойн газрын чиг үүргийн RACI шинжилгээ

Процесст оролцогчдын чиг үүрэгт RACI шинжилгээг хийж оролцооны давхцалыг тодорхойлохыг зорилгоо. RACI чиг үүргийн давхцалыг Ойн газрын 4 стратеги, 13 үйл ажиллагаанд үндэслэж дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 28. Ойн газрын хэлтсүүдийн чиг үүргийн уялдаа, оролцооны RACI

Стратегийн зорилт	Захиргаа, удирдлагын хэлтэс	Ойн нөөцийн хэлтэс	Ойн нөхөн сэргээлтийн хэлтэс	ХШҮ, Мэдээллийн технологийн хэлтэс
1. Ойн нөөцийн судалгаа хийх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох менежмент, чадавхыг бий болгон, хомсдол, доройтлоос сэргийлэх;	C	R/A	I	C/I
	I	R/A	I	C
	I	R	I	A/C
2. Ойн тогтвортой менежмент, биологийн олон янз байдал экосистемийг хадгалах, хамгаалах, экологийн болон эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх	I	R/A	C	I
	C	R/A	I	C
	I	R/A	C	I
	I	C	R/A	I
	I	C	R/A	C

3. Ойжуулалт, нөхөн сэргээлт, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх	I	I	R/A	C
4. Ойн сайн засаглал, эрх зүй, санхүү, салбарын шинжлэх ухаан, сургалт, боловсролын тогтолцоог сайжруулах, хүний нөөц	R/A	C	C	I
	R/A	C	I	C
	R/A	I	I	C
	I	C	I	R/A

Хүснэгт 29. RACI чиг үүргийн давхцал (хувиар)

Хэлтэс	R	A	C	I	Нийт	Давхцалын хувь
Захиргаа, удирдлага	3	3	2	2	10	77%
Ойн нөөц	5	3	3	2	13	100%
Ойн нөхөн сэргээлт	3	3	3	3	12	92%
ХШҮ, Мэдээлэл	2	1	4	3	10	77%

Ойн нөөцийн хэлтэс нь бүх стратегийн чиг үүрэгт хамгийн их 100 % оролцоотой буюу давхцал өндөртэй, Ойн нөхөн сэргээлтийн хэлтэс нь стратегийн чиг үүргүүдийн ихэнх 92%-д, харин Захиргаа, удирдлагын хэлтэс болон Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн технологийн хэлтэс нь стратегийн чиг үүргийн 77%-д оролцож байна.

Ойн газарт ажлын хэт төвлөрөл, ажлын ачаалал тэнцвэргүй хувиарлагдсан байна. Ойн нөөцийн хэлтсийн хувьд стратегийн бүх чиг үүрэгт оролцож байгаа нь ажилчдад хэт ачаалал үүсгэх эрсдэлтэй бөгөөд ажлын бүтээмж, чанарыг бууруулах зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн хэрэгжүүлж буй чиг үүрэг давхцаж, хариуцлага тодорхойгүй болох, шийдвэр гаргалт удаашрах зэрэг үр дагавар гарахаар байна.

Захиргаа, удирдлагын хэлтэс болон Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн технологийн хэлтэс стратегийн чиг үүргүүдэд зөвхөн зөвлөлдсөн, мэдээлэл өгсөн хэлбэрээр оролцож байгаа нь тэдгээр хэлтсийн нөлөө, оролцоо, үнэ цэнийг стратегийн түвшинд үнэлэхгүй байх, шийдвэр гаргалтад оролцохгүй болох, мэдээлэл дутмаг, хоцрогдолтой байх эрсдэлтэй байна. Түүнчлэн ажлын ачаалал, чиг үүргийн тодорхойгүй байдлаас хүний нөөцийн эргэлт, тогтвортой байдал алдагдах, зарим хэлтэст үйл ажиллагааны ачаалал төвлөрсөн нөхцөлд тухайн хэлтсийн удирдлага солигдох, ажилтан ажлаас гарсан тохиолдолд байгууллагын бүх үйл ажиллагаа доголдох эрсдэл түгээмэл байна.

Дүгнэлт:

Байгаль орчны салбар нь өргөн цар хүрээг хамарсан шинжлэх ухаанч мэдлэг, нарийн мэргэжил, олон улсын болон салбар дундын бодлогыг боловсруулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр төв, орон нутгийн байгууллагыг хангах хүний нөөцийн нарийн бодлого, төлөвлөлт шаардсан салбар боловч өнөөдрийн байдлаар хүний нөөцийн бодлогын баримт бичиг, нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй байна.

Байгаль орчны салбарт ажиллаж буй төр, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн байгууллага, Их, дээд сургууль, хувийн хэвшил, нөхөрлөл болон ирээдүйд ажиллах мэргэжилтнүүдийн тоо, чадвар, мэргэшил, хуваарилалт зэрэгт тулгуурлан салбарын хүний нөөцийн бодлого, зохицуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг яаралтай хийх шаардлагатай байна.

“Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т Хуулийн асуудал хариуцсан бүтцийн нэгжтэй байхад нийт 98 албан хаагчийн 51 албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагад “Эрх зүй”-ч

мэргэжлийг болон байгаль орчны салбарт шууд хамааралтай бус “Уул уурхайн олборлолт”, “Газар тариалан, мал аж ахуй”, “Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар дундын чиглэл”, Био-ангаах ухаан” гэсэн мэргэжлүүдийг оруулсныг залруулж, байгаль орчны чиглэлээр мэргэжил эзэмшисэн боловсон хүчин ажиллах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Ойн газрын нэгжүүд хоорондын ажил үүргийн хуваарь оновчтой тодорхойлогдоогүйгээс зарим хэлтэст үйл ажиллагааны ачаалал төвлөрсөн нөхцөлд тухайн хэлтсийн удирдлага солигдох, ажилтан ажлаас гарсан тохиолдолд байгууллагын тухайн асуудалтай холбогдох үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна.

2.3.3. Байгаль орчны салбарын албан хаагчдын бүтээмжийн судалгаа

Байгаль орчны салбарын 1094 албан хаагчаас хөдөлмөрийн бүтээмж, сэтгэл ханамжтай холбоотой судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын мэдээллийг цэвэрлэн 930 албан хаагчдын мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Тус судалгаанд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газар, Усны газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Усны сав газрын захиргаа, Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ, аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, Цаг уур, орчны шинжилгээний төвийн төлөөллүүдийг хамруулсан.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 11.3 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 1.1 хувь нь Ойн газар, 2.7 хувь нь Усны газар, 16.8 хувь нь аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, 17.4 хувь нь улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, 7.5 хувь нь Усны сав газрын захиргаанаас хамрагдсан байна. Цаг уур, орчны шинжилгээний төв болон аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчид идэвхтэй хамрагдсан байна.


Зураг 58. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, байгууллагын төрлөөр, эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 42.8 хувь нь эрэгтэйчүүд, 57.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдыг насны бүлгээр авч үзвэл 3.0 хувь нь 18-25 насныхан, 34.9 хувь нь 26-35 насныхан, 35.4 хувь нь 36-45 насныхан, 21.6 хувь нь 46-55 насныхан, 5.1 хувь нь 56, түүнээс дээш насныхан байна.


Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 3.0 хувь нь 18-25 насныхан, 36.4 хувь нь 26-35 насныхан, 31.2 хувь нь 36-45 насныхан, 20.4 хувь нь 46-55 насныхан, 9.0 хувь нь 56, түүнээс дээш насныхан байна. Харин эмэгтэйчүүдийн 3.0 хувь нь 18-25 насныхан, 33.8 хувь нь 26-35 насныхан, 38.5 хувь нь 36-45 насныхан, 22.6 хувь нь 46-55 насныхан, 2.1 хувь нь 56, түүнээс дээш насныхан байна.

Зураг 59. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, хүйс, насны бүлэг, хувиар




Судалгаанд хамрагдсан албан хаагчдыг улсад ажилласан жилээр нь авч үзвэл 12.2 хувь нь 1 жил хүртэлх, 23.4 хувь нь 1-4 жил хүртэлх, 25.4 хувь нь 5-10 жил хүртэлх, 15.5 хувь нь 11-15 жил хүртэлх, 11.3 хувь нь 16-20 жил хүртэлх, 12.3 хувь нь 20, түүнээс дээш жил байна. Судалгаанд хамрагдсан 5 хүн тутмын гурав (61.0 хувь) нь 10 хүртэл жил улсад ажилласан туршлагатай. Албан хаагчид дунджаар улсад 9 жил 9 сар ажилласан байна.

Зураг 60. Судалгаанд хамрагдсан албан хаагчид, хүйс, ажилласан жил, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 6.0 хувь нь удирдах албан хаагч, 69.9 хувь нь гүйцэтгэх, 16.0 хувь нь туслах, 8.1 хувь бусад албан хаагч байна. Удирдах албан тушаалтны 33.9 хувь нь, гүйцэтгэх албан тушаалтны 34.6 хувь нь, туслах албан тушаалтны 34.9 хувь нь, бусад албан тушаалтны 46.7 хувь нь 5 хүртэлх жил ажилласан туршлагатай байна.

Зураг 61. 5 хүртэлх жил ажилласан хамрагдсан албан хаагчид, албан тушаалын ангилал, хувиар




Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 55.5 хувь нь Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас судалгаанд хамрагдсан албан хаагчдын 63.8 хувь нь, Ойн газрын 50.0 хувь нь Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байна.

Зураг 62. Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид, албан хаагчдад эзлэх хувь



Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдыг албан тушаалын ангиллаар нь авч үзвэл 7.2 хувь нь удирдах, 69.8 хувь нь гүйцэтгэх, 14.9 хувь нь туслах, 8.1 хувь нь бусад чиглэлийн албан тушаалтан байна. Өөрөөр хэлбэл Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа 10 албан хаагч тутмын 7 (69.8 хувь) нь гүйцэтгэх албан тушаалтан байна.

Зураг 63. Олон улсын гэрээ, конвенцоор Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид, албан тушаалын ангиллаар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас ажлын үр дүнгийн үр шим хүртэгчийг нь асуухад 47.0 хувь нь иргэд, 18.4 хувь нь би өөрөө, 11.7 хувь нь аж ахуй нэгж, байгууллага, 7.6 хувь нь удирдлага, 6.8 хувь нь яам, үлдсэн 8.5 хувь нь бусад гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 58.7 хувь нь иргэн, аж ахуй нэгж, байгууллага ажлын үр дүнгийн үр шим хүртэгч гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 88.5 хувь нь үр дүнгээ тодорхойлж хариулт өгсөн бөгөөд 55.2 хувь нь хангалттай сайн ажиллаж байгаа, 5.9 хувь нь байгаль дэлхийгээ хамгаалахад хувь нэмэрээ оруулж байгаа, 4.6 хувь нь дундаж ажиллаж байгаа, 4.4 хувь нь үр дүнг чухалчилж ажиллаж байгаа, 3.4 хувь нь иргэд, ААНБ-уудад тустай ажил эрхэлж байгаа, 2.7 хувь нь маш хариуцлагатай ажиллаж байгаа, 2.3 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа гэж хариулсан байна. Албан хаагчдаас удирдлагын ур чадвар муугаас болж үр дүн муу, хангалттай сайн ажиллахгүй байгаа гэсэн хариултауд ирсэн байна.

Зураг 64. Ажлын үр дүнгээ тодорхойлсон байдал, хувиар



Цахим
судалгаанд
хамрагдсан
иргэн:

Анх ажилд ороод хэн ч миний ажлын чиг үүргийг тодорхой тайлбарлаж өгөөгүй, ажлын байрны тодорхойлолттой танилцуулаагүй. Шууд удирдлагаасаа юу хийх үү гэж асуухад хариу өгөхгүй байсаар байгаад бүтэн нэг жилээ үр ашиггүй өнгөрөөсөндөө маш их харамсдаг. Энэ үед л байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн ямар чухал байр суурьтай байдгийг ойлгосон.

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгаанд хамрагдсан албан хаагчдаар удирдлагын ур чадвар, манлайлал, тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын зохион байгуулалт, хуваарилалт, ашиглаж буй материал, багаж хэрэгсэл, ажиллах хүч, аюулгүй байдал, ажилтны идэвхжилт, гадаад орчин, бусад хүчин зүйлстэй холбоотой 7 бүлгийн 34 үзүүлэлтээр сэтгэл ханамжийн үнэлгээ хийлгэж, ач холбогдлын харьцангуй индекс тооцсон.

Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 84.6 хувь нь 7 бүлгийн 34 үзүүлэлтэд үнэлгээ өгч хөдөлмөрийн бүтээмжид ямар нэгэн байдлаар нөлөөтэй гэж үзсэн бол 15.4 хувь нь нөлөөгүй гэж хариулсан. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 100 хүн тутмын 84 хүн нь хөдөлмөрийн бүтээмжид ямар нэгэн байдлаар нөлөөтэй гэж үзсэн байна.


Судалгаанд хамрагдсан албан хаагчид программ хангамжийн уялдаа (91.4 хувь), интернэтийн хурд (91.2 хувь), материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал (90.6 хувь), материал, техник хэрэгслийн шинэлэг байдал (90.3 хувь), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг (90.3 хувь) хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй гэж хамгийн их үнэлгээ өгсөн байна.

Зураг 65. Хөдөлмөрийн бүтээмжийн үнэлгээ, 34 үзүүлэлтээр



Ач холбогдлын харьцангуй индексийг 7 бүлгээр авч үзэхэд Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой ($R=0.6011$), Материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой ($R=0.5984$), Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой ($R=0.5815$) эхний 3 байранд эрэмбэлэгдсэн байна. Байгаль орчины салбарын албан хаагчдын Албан хаагчдыг идэвхжүүлэх, материал, техник хэрэгсэлийн хуучрал, эвдрэл, программ хангамжийн уялдаагүй байдал, албан хаагчдын харилцаа хандлага нь хөдөлмөрийн бүтээмжид голлох сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

Зураг 66. Ач холбогдлын харьцангуй индекс, бүлгээр



Ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр авч үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.6186$), интернэтийн хурд ($R=0.6149$), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг ($R=0.6121$), ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал ($R=0.6053$), программ хангамжийн уялдаагүй байдал ($R=0.6049$), илүү цагаар ажиллах ($R=0.6000$), шагнал урамшууллын системийн дутагдалтай байдал ($R=0.5959$), материал, техник хэрэгслийн

элэгдэл, хуучрал ($R=0.5955$), удирдлагын ур чадварын дутмаг байдал ($R=0.5936$), ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шударга бус байдал ($R=0.5917$) нь эхний аравт эрэмбэлэгдсэн байгаа бөгөөд салбарын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна.

Хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 5 үзүүлэлт нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай, 1 нь ажлын зохион байгуулалт, хуваарилалттай, 1 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Зураг 67. Ач холбогдлын харьцангуй индекс, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт



Хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлсийг байгууллагаар авч үзвэл:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд ажлын жигд бус хуваарилалт ($R=0.6354$), амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.6326$), илүү цагаар ажиллах ($R=0.6263$), ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал ($R=0.6253$), ажилтнууд хоорондын үл ойлголцол ($R=0.6229$), чиг үүргийн бус ажил эрхлэлт ($R=0.6168$), материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал ($R=0.6137$), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг ($R=0.6120$), ажилтны сэтгэл санааны тогтворгүй байдал ($R=0.6104$), ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал ($R=0.6102$) нь эхний 10-т эрэмбэлэгдсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 3 үзүүлэлт нь ажлын зохион байгуулалт, хуваарилалттай, 3 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь албан хаагчдын харилцаа хандлагатай, 1 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Ойн газрын албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.7778$), ажлын жигд бус хуваарилалт ($R=0.7556$), ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал ($R=0.6889$), хэт ачаалалтай ажиллах ($R=0.6800$), материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/ ($R=0.6750$), программ хангамжийн уялдаа ($R=0.6667$), ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал ($R=0.6600$), удирдлагын ур чадварын дутмаг байдал ($R=0.6571$), агааржуулалтын систем ($R=0.6444$), чиг үүргийн бус ажил эрхлэлт ($R=0.6222$) нь эхний аравт эрэмбэлэгдсэн байна.

Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 3 үзүүлэлт нь ажлын зохион байгуулалт, хуваарилалттай, 2 нь албан хаагчдын харилцаа хандлагатай, 2 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Усны газрын албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.7294$), ажилтнуудыг

чадавхжуулах сургалтын дутмаг байдал ($R=0.6444$), агааржуулалтын систем ($R=0.5889$) нь эхний гуравт эрэмбэлэгдсэн байна.

Усны газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 4 үзүүлэлт нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 2 нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай, 2 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Зураг 68. Ач холбогдлын харьцангуй индекс-1, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт, байгууллагаар



Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд программ хангамжийн уялдаа ($R=0.5863$), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг ($R=0.5862$), цалин олголтын хоцролт/хүлээлт үүсгэдэг байдал ($R=0.5824$) нь эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 4 үзүүлэлт нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 2 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай, 2 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Усны сав газрын захиргааны албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд интернэтийн хурд ($R=0.7406$), материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал ($R=0.7406$), Программ хангамжийн уялдаа ($R=0.7015$) нь эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Усны сав газрын захиргааны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 5 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ-ын албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд удирдлагын ур чадварын дутмаг байдал ($R=0.8444$), удирдлагын шийдвэр гаргалтын тодорхойгүй байдал ($R=0.8000$), интернэтийн хурд ($R=0.7778$) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ-ын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 5 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд илүү цагаар ажиллах ($R=0.6074$), ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал ($R=0.6044$), ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал ($R=0.5970$) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Хамгаалалтын захиргааны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 4 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой үзүүлэлтүүд байна.

Аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал (R=0.6662), материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/ (R=0.6629), амрах хооллох байрны ая тухгүй байдал (R=0.6569) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 4 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 4 нь Материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал (R=0.6609), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг (R=0.6591), Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/ (R=0.6564) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 5 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой үзүүлэлтүүд байна.

Зураг 69. Ач холбогдлын харьцангуй индекс-2, хамгийн өндөр үнэлгээтэй 10 үзүүлэлт, байгууллагаар

Цаг уур, орчны шинжилгээний газар



Усны сав газрын захиргаа



Байгаль орчны судалгаа шинжилгээний төв



Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа



Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар



Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв



Албан тушаалын ангиллаар

Удирдах албан тушаалтай албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд удирдлагын ур чадварын дутмаг байдал (R=0.6537),

ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал ($R=0.6280$), ажилтнууд хоорондын үл ойлголцол ($R=0.6245$) нь эхний 3-т эрэмбэлэгдсэн.

Удирдах албан тушаалтай албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 3 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Гүйцэтгэх албан тушаалтай албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд интернетийн хурд ($R=0.6389$), программ хангамжийн уялдаа ($R=0.6285$), шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг ($R=0.6274$) нь эхний 3-т эрэмбэлэгдсэн.

Гүйцэтгэх албан тушаалтай албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 4 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 4 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Зураг 70. Ач холбогдлын харьцангуй индекс-1, албан тушаалаар



Туслах албан тушаалтай албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.6132$), удирдлагын ур чадварын дутмаг байдал ($R=0.6036$), удирдлагын харилцаа, хандлагын доголдол ($R=0.5942$) нь эхний 3-т эрэмбэлэгдсэн.

Туслах албан тушаалтай албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 3 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 4 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Бусад албан тушаалтай албан хаагчдын өгсөн үнэлгээнээс ач холбогдлын харьцангуй индексийг 34 үзүүлэлтээр тооцож үзэхэд цалин олголтын хоцролт/хүлээлт үүсгэдэг байдал ($R=0.6222$), ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шударга бус байдал ($R=0.5933$), материал, техник хэрэгслийн шинэлэг байдал ($R=0.6245$) нь эхний 3-т эрэмбэлэгдсэн.

Удирдах албан тушаалтай албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг бүлгээр авч үзэхэд 5 нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Зураг 71. Ач холбогдлын харьцангуй индекс-2, албан тушаалаар




Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой бүлэг

Удирдлагын ур чадвар, манлайлал бүлэгт ур чадварын дутмаг байдал, удирдлагын хяналтын сул байдал, ажилтан, удирдлагын харилцаа, хандлагын доголдол, удирдлагын шийдвэр гаргалтын тодорхойгүй байдал гэсэн 5 хүчин зүйлийг авч үзсэн.

Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 76.9 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бөгөөд 23.1 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 24.3 хувь нь маш бага, 18.3 хувь нь бага, 21.5 хувь нь дунд, 16.2 хувь нь их, 19.9 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна. Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд үнэлгээ өгсөн 3 хүн тутмын нэг (36.0 хувь) нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөтэй гэж үнэлжээ.

Зураг 72. Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар




Хүснэгт 30. Удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Удирдлагын ур чадварын дутмаг байдал	100.0%	23.3%	16.0%	23.0%	16.1%	21.6%
Удирдлагын хяналтын сул байдал	100.0%	24.4%	18.0%	23.4%	16.6%	17.5%
Ажилтан, удирдлагын хоорондын үл ойлголцол	100.0%	25.5%	18.5%	20.6%	15.7%	19.7%
Удирдлагын харилцаа, хандлагын доголдол	100.0%	25.7%	18.1%	19.7%	16.6%	19.9%
Удирдлагын шийдвэр гаргалтын тодорхойгүй байдал	100.0%	22.8%	20.0%	20.7%	15.9%	20.6%

Удирдлагын ур чадвар, манлайлал бүлэгт Удирдлагын ур чадварын дутмаг байдал (R=0.5936) 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 9-рт эрэмбэлэгдэж байна.

Зураг 73. Удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ (R=0.7956), Усны сав газрын захиргаа (R=0.6185), Аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төв (R=0.6118) эхний 3-т эрэмбэлэгдсэн нь тухайн байгууллагуудад удирдлагын түвшинд шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.

Зураг 74. Удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд удирдлагын ур чадварын дутмаг байдал (R=0.5640) 1-рт бүлэгт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 25-рт эрэмбэлэгдэж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн үзүүлэлтүүд сөргөөр нөлөөлөх нөлөөлөл бага байна.

Ойн газрын албан хаагчдын удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд удирдлагын ур чадварын дутмаг байдал (R=0.6571) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 8-рт

эрэмбэлэгдэж байна. Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид удирдлагын ур чадварын дутмаг байдал сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 31. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын удирдлагын ур чадвар, манлайлал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Удирдлагын ур чадварын дутмаг байдал	0.5640	25	0.6571	8
Удирдлагын шийдвэр гаргалтын тодорхойгүй байдал	0.5506	28	0.6000	16
Удирдлагын харилцаа, хандлагын доголдол	0.5190	31	0.6000	17
Удирдлагын хяналтын сул байдал	0.5163	33	0.5556	27
Ажилтан, удирдлагын хоорондын үл ойлголцол	0.5412	30	0.4800	31

Материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой бүлэг

Материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой бүлэгт Материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал, Материал, техник хэрэгслийн шинэлэг байдал, Интернэтийн хурд, Материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/, Программ хангамжийн уялдаагүй байдал гэсэн 5 хүчин зүйлийг авч үзсэн.

Материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой хүчин зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 90.7 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 9.3 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 20.4 хувь нь маш бага, 21.7 хувь нь бага, 19.5 хувь нь дунд, 15.1 хувь нь их, 23.3 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 75. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар



Хүснэгт 32. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар


Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал	100.0%	21.7%	21.0%	18.9%	14.7%	23.7%
Материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/	100.0%	22.1%	22.6%	18.1%	14.6%	22.7%
Материал, техник хэрэгслийн шинэлэг байдал	100.0%	20.6%	22.7%	19.5%	15.2%	21.9%
Интернэтийн хурд	100.0%	19.6%	20.9%	18.4%	14.9%	26.3%
Программ хангамжийн уялдаа	100.0%	18.1%	21.3%	22.6%	16.0%	22.0%

Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжтай бүлэгт интернэтийн хурд (R=0.6149) 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 2-рт эрэмбэлэгдэж, Программ хангамжийн уялдаагүй байдал (R=0.6049) бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 5-рт эрэмбэлэгдэж байна.

Интернэтийн хурд, программ хангамжийн уялдаагүй байдал нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх чухал хүчин зүйл болохыг илэрхийлж байгаа бөгөөд интернэтийн хурдыг


сайжруулах, программ хангамжуудын уялдааг сайжруулж нэгдсэн нэг мэдээллийн сантай болох шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Зураг 76. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Ашиглаж буй техник тоног төхөөрөмж, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Усны сав газрын захиргаа ($R=0.7133$), Ойн газар ($R=0.6744$), Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар ($R=0.6373$) эхний 3-т эрэмбэлэгдсэн байна. Тухайн байгууллагуудад ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамжийн шинэчлэл хийх, программ хангамжийн уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Зураг 77. Ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал ($R=0.6137$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 7-рт эрэмбэлэгдэж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал сөргөөр нөлөөлж байна.

Ойн газрын албан хаагчдын ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/ ($R=0.6750$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 5-рт эрэмбэлэгдэж байна. Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/, программ хангамжийн уялдаагүй байдал сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 33. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ашиглаж буй материал, техник хэрэгсэл, программ хангамж бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Материал, техник хэрэгслийн хомсдол /хүртээмж/	0.5822	21	0.6750	5
Программ хангамжийн уялдаа	0.6081	11	0.6667	6
Интернэтийн хурд	0.6062	12	0.6444	12
Материал, техник хэрэгслийн элэгдэл, хуучрал	0.6137	7	0.6000	13
Материал, техник хэрэгслийн шинэлэг байдал	0.5898	16	0.5750	21

Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой бүлэг

Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлэгт Илүү цагаар ажиллах, Ажлын жигд бус хуваарилалт, Чиг үүргийн бус ажил эрхлэлт, Хэт ачаалалтай ажиллах, Ажлын төлөвлөгөө муу байх, Ажлын цагийг үр ашиггүй өнгөрөөх, Ажлын арга барил тодорхойгүй байх гэсэн 7 хүчин зүйлийг авч үзсэн.

Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой хүчин зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 85.2 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 14.8 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 20.4 хувь нь маш бага, 21.7 хувь нь бага, 19.5 хувь нь дунд, 15.1 хувь нь их, 23.3 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 78. Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар




Хүснэгт 34. Ажлын зохион байгуулалт, хуваарилалттай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Хэт ачаалалтай ажиллах	100.0%	21.3%	20.9%	25.0%	15.8%	17.0%
Ажлын төлөвлөгөө муу байх	100.0%	23.1%	22.0%	24.5%	16.0%	14.4%
Ажлын цагийг үр ашиггүй өнгөрөөх	100.0%	24.3%	22.2%	21.7%	16.0%	15.7%
Ажлын арга барил тодорхойгүй байх	100.0%	23.9%	21.3%	23.7%	17.1%	14.0%
Илүү цагаар ажиллах	100.0%	19.0%	21.7%	20.9%	17.0%	21.4%
Ажлын жигд бус хуваарилалт	100.0%	20.6%	21.4%	22.6%	15.8%	19.6%
Чиг үүргийн бус ажил эрхлэлт	100.0%	21.5%	21.4%	21.8%	16.6%	18.7%

Илүү цагаар ажиллах ($R=0.600$) нь бүлэгт 1-рт, 34 үзүүлэлтийн 6-рт эрэмбэлэгдэж байна. Мөн ажлын жигд бус хуваарилалт ($R=0.5848$) нь бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 15-рт эрэмбэлэгдэж, чиг үүргийн бус ажил эрхлэлт ($R=0.5793$) нь бүлэгт 3-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 19-рт эрэмбэлэгдэж байна.


Илүү цагаар ажиллах, ажлын жигд бус хуваарилалт, чиг үүргийн бус ажил эрхлэлт нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх чухал хүчин зүйлүүдийн нэг болж байгааг судалгааны дүнгээс харж болохоор байна. Ажил амьдралын тэнцвэрийг хангаж, албан хаагчдын ажлыг жигд хуваарилах шаардлагатайг илэрхийлж байна.

Зураг 79. Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Ойн газар ($R=0.6152$), Усны сав газрын захиргаа ($R=0.6014$), Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ($R=0.5982$) эхний 3-т эрэмбэлэгдсэн байна. Тухайн байгууллагуудын албан хаагчид чиг үүргийн бус ажил эрхлэлтээс шалтгаалж илүү цагаар ажиллах, ажлын жигд бус хуваарилалтаас шалтгаалж зарим албан хаагчид хэт ачаалалтай ажиллах нөхцөл байдал үүссэн байх магадлалтай байна. Иймд байгууллагуудад ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийн дахин хуваарилалт хийх хэрэгцээ шаардлага байна.

Зураг 80. Ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд ажлын жигд бус хуваарилалт (R=0.6354) бүлэгт болон 34 үзүүлэлтийн 1-рт эрэмбэлэгдэж, илүү цагаар ажиллах (R=0.6263) бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 3-рт эрэмбэлэгдэж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид ажлын жигд бус хуваарилалт, илүү цагаар ажиллах, чиг үүргийн бус ажил эрхлэлт сөргөөр нөлөөлж байна.

Ойн газрын албан хаагчдын ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд Ажлын жигд бус хуваарилалт (R=0.7556) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 2-рт эрэмбэлэгдэж байна. Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид ажлын жигд бус хуваарилалт, хэт ачаалалтай ажиллах сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 35. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ажлын зохион байгуулалт, хуваарилалт бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Ажлын жигд бус хуваарилалт	0.6354	1	0.7556	2
Илүү цагаар ажиллах	0.6263	3	0.4667	32
Чиг үүргийн бус ажил эрхлэлт	0.6168	6	0.6222	10
Хэт ачаалалтай ажиллах	0.5918	15	0.6800	4
Ажлын арга барил тодорхойгүй байх	0.5800	22	0.6000	14
Ажлын төлөвлөгөө муу байх	0.5667	24	0.6000	15
Ажлын цагийг үр ашиггүй өнгөрөөх	0.5640	26	0.5778	20

Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлэг

Ажилтны идэвхжилттэй холбоотой бүлэгт Ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал, Ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал, Ажилтнууд хоорондын үл ойлголцол, Ажилтны сэтгэл санааны тогтворгүй байдал гэсэн 7 хүчин зүйлийг авч үзсэн.

Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 86.0 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 14.0 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 20.8 хувь нь маш бага, 20.9 хувь нь бага, 23.7 хувь нь дунд, 15.7 хувь нь их, 18.8 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 81. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар



Хүснэгт 36. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар


Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал	100.0%	20.5%	20.9%	23.1%	15.5%	20.0%
Ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал	100.0%	20.1%	21.7%	22.8%	17.4%	18.0%

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

Ажилтны сэтгэл санааны тогтворгүй байдал	100.0%	21.1%	21.4%	24.6%	15.3%	17.5%
Ажилтнууд хоорондын үл ойлголцол	100.0%	21.5%	19.7%	24.5%	14.8%	19.6%


Ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал ($R=0.5871$) нь бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 12-рт эрэмбэлэгдэж, ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал ($R=0.5830$) нь бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 16-рт эрэмбэлэгдэж байна.

Зураг 82. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Ажилтны идэвхжилттэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Ойн газар ($R=0.6270$), Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ($R=0.6146$), Усны сав газрын захиргаа ($R=0.6042$) эхний 3-т эрэмбэлэгдсэн байна. Байгууллагын соёлыг сайжруулах (хамт олны уур амьсгал), мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах хэрэгцээ байна.

Зураг 83. Албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдлын харьцангуй индексийг авч үзэхэд ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал ($R=0.6253$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34

үзүүлэлтийн 4-рт эрэмбэлэгдэж, ажилтнууд хоорондын үл ойлголцол (R=0.6229) бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 5-рт эрэмбэлэгдэж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал, ажилтнууд хоорондын үл ойлголцол, ажилтны сэтгэл санааны тогтворгүй байдал сөргөөр нөлөөлж байна.

Ойн газрын албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал (R=0.6889) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 3-рт эрэмбэлэгдэж, ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал (R=0.6600) бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 7-рт эрэмбэлэгдэж байна. Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал, ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 37. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Ажилтнуудын ажилдаа үнэнч бус байдал	0.6253	4	0.6889	3
Ажилтнууд хоорондын үл ойлголцол	0.6229	5	0.5778	18
Ажилтны сэтгэл санааны тогтворгүй байдал	0.6104	9	0.5778	19
Ажилтнуудын мэдлэг ур чадварын дутмаг байдал	0.6000	13	0.6600	7

Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлэг

Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлэгт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт, Үйлдвэрлэлийн осол гэмтэл, хордлого, Агааржуулалтын систем, Аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх байдалгэсэн 4 хүчин зүйлийг авч үзсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 82.1 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 17.9 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 24.7 хувь нь маш бага, 20.5 хувь нь бага, 23.8 хувь нь дунд, 14.6 хувь нь их, 16.4 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 84. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар




Хүснэгт 38. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт	100.0%	22.0%	21.4%	23.2%	15.7%	17.8%
Үйлдвэрлэлийн осол гэмтэл, хордлого	100.0%	27.8%	20.4%	24.6%	13.1%	14.2%
Агааржуулалтын систем	100.0%	24.4%	19.1%	24.9%	14.3%	17.4%
Аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх байдал	100.0%	25.0%	21.1%	22.6%	15.4%	16.0%


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт ($R=0.5717$) нь бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 24-рт эрэмбэлэгдэж, Агааржуулалтын систем ($R=0.5623$) нь бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 27-рт эрэмбэлэгдэж байна. Салбарын албан хаагчдын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүчин зүйлсүүд хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлөх нөлөө нь бага байна.

Зураг 85. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ ($R=0.6357$), Ойн газар ($R=0.6000$), Аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төв ($R=0.5804$) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна. Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ-ын ажлын байрны агааржуулалтын системийн сайжруулах шаардлагатай байна.

Зураг 86. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хөдөлмөрийн аюулгүй байдал бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт ($R=0.5898$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 17-рт эрэмбэлэгдэж байна.

Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт ($R=0.6250$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 11-рт эрэмбэлэгдэж байна.

Хүснэгт 39. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын хэрэгжилт	0.5898	17	0.6250	11
Аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх байдал	0.5896	18	0.5600	24
Агааржуулалтын систем	0.5756	23	0.6444	9
Үйлдвэрлэлийн осол гэмтэл, хордлого	0.5080	34	0.5750	22

Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлэг

Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлэгт Шагнал урамшууллын системийн дутагдалтай байдал, Амрах хооллох байрны ая тухгүй байдал, Шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг, Ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал, Цалин олголтын хоцролт/хүлээлт үүсгэдэг байдал, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шударга бус байдал гэсэн 6 хүчин зүйлийг авч үзсэн.

Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой хүчин зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 84.3 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 15.7 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 20.8 хувь нь маш бага, 19.3 хувь нь бага, 21.5 хувь нь дунд, 15.6 хувь нь их, 22.8 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 87. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой хүчин зүйлсэд өгсөн ерөнхий үнэлгээ, хувиар



Хүснэгт 40. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар


Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Шагнал урамшууллын системийн дутагдалтай байдал	100.0%	21.6%	18.4%	22.3%	15.9%	21.8%
Амрах хооллох байрны ая тухгүй байдал	100.0%	19.2%	18.4%	21.7%	15.2%	25.4%
Шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг	100.0%	18.3%	19.4%	22.3%	17.9%	22.1%
Ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал	100.0%	19.4%	19.5%	22.9%	15.4%	22.8%
Цалин олголтын хоцролт/хүлээлт үүсгэдэг байдал	100.0%	24.1%	19.2%	21.4%	13.9%	21.5%
Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шударга бус байдал	100.0%	22.7%	20.6%	18.4%	15.1%	23.3%

Амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.6186$) нь бүлэгт болон 34 үзүүлэлтийн 1-рт эрэмбэлэгдэж, шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг ($R=0.6121$) нь бүлэгт 2-рт, 34 үзүүлэлтийн 3-рт эрэмбэлэгдэж, ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал ($R=0.6121$) нь бүлэгт 3-рт, 34 үзүүлэлтийн 4-рт эрэмбэлэгдэж, шагнал урамшууллын

системийн дутагдалтай байдал ($R=0.5939$) нь бүлэгт 4-рт, 34 үзүүлэлтийн 7-рт эрэмбэлэгдэж байна.

Ажлын байрны ая тухгүй байдал, албан хаагчдын шинэ санаа, санаачлага, бүтээлч байдлыг дэмждэггүй, ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулдаггүй, шагнал урамшууллын дутагдалтай байдал нь салбарын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлсүүд байна. Иймд ажлын байрны амрах, хооллох ая тухтай байдлыг сайжруулж, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол явуулах, шинийг санаачилж бүтээлч ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Зураг 88. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл



Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ ($R=0.6538$), Аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төв ($R=0.6357$), Усны сав газрын захиргаа ($R=0.6182$) эхний гуравт эрэмбэлэгдсэн байна.

Зураг 89. Албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.6326$) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 2-рт эрэмбэлэгдэж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид амрах хооллох байрны ая тухгүй байдал, шинэ санаа бүтээлч байдлын дэмжихгүй байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

Ойн газрын албан хаагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд амрах хооллох байрны ая тухгүй байдал ($R=0.7778$) бүлэг болон 34-р үзүүлэлтийн 1-рт эрэмбэлэгдэж байна.

Хүснэгт 41. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын ажилтанг идэвхжүүлэхтэй холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс


Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Амрах хооллох байрны ая тухгүй байдал	0.6326	2	0.7778	1
Шинэ санаа бүтээлч байдлын дэмжлэг	0.6120	8	0.5200	29
Ажилтнуудыг чадавхжуулах сургалтын дутмаг байдал	0.6102	10	0.5556	26
Шагнал урамшууллын системийн дутагдалтай байдал	0.5935	14	0.5600	23
Цалин олголтын хоцролт/хүлээлт үүсгэдэг байдал	0.5873	19	0.4667	33
Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шударга бус байдал	0.5870	20	0.5111	30

Гадаад орчинтой холбоотой бүлэг

Гадаад орчинтой холбоотой бүлэгт Засгийн газрын шийдвэрийн нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/, үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал, бусдын нөлөө /шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлөх/ гэсэн 3 хүчин зүйлийг авч үзсэн.

Гадаад орчинтой холбоотой зүйлсэд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 87.7 хувь нь үнэлгээ өгсөн (хөдөлмөрийн бүтээмжид нөлөөтэй) бол 12.3 хувь нь хөдөлмөрийн бүтээмжид нөлөөгүй гэж үзсэн байна. Үнэлгээ өгсөн албан хаагчдын 21.8 хувь нь маш бага, 23.5 хувь нь бага, 24.0 хувь нь дунд, 15.4 хувь нь их, 16.3 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлсэн байна.

Зураг 90. Гадаад орчинтой холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар



Хүснэгт 42. Гадаад орчинтой холбоотой хүчин зүйлсэд өгсөн үнэлгээ, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/	100.0%	18.8%	23.3%	24.2%	14.0%	19.8%
Үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал	100.0%	21.5%	23.2%	24.0%	15.0%	16.2%
Шийдвэрт нөлөөлөх нөлөөлөл их	100.0%	25.1%	23.9%	23.8%	14.1%	13.0%

Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/ ($R=0.5833$) нь бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 14-рт эрэмбэлэгдэж, үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал ($R=0.5622$) нь бүлэгт 2-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 28-рт эрэмбэлэгдэж байна.

Хүснэгт 43. Гадаад орчинтой холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, эрэмбэлэл

Хүчин зүйлс	АХХИ (RII)	Эрэмбэ
Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/	0.5853	14
Үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал	0.5622	28
Шийдвэрт нөлөөлөх нөлөөлөл их	0.5323	33

Гадаад орчинтой холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индексийг байгууллагаар авч үзэхэд Байгаль орчны судалгаа шинжилгээний төв УТҮГ (R=0.6190), аймаг, нийслэлийн Байгаль орчны газар (R=0.5938), аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний төв (R=0.5981) эхний 3-т эрэмбэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар болон Цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид хууль, дүрэм, журмын өөрчлөлт нь сөрөг нөлөө үзүүлж байна.

Зураг 91. Гадаад орчинтой холбоотой бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс, байгууллагаар



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчдын гадаад орчин бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээний ач холбогдолын харьцангуй индексийг авч үзэхэд Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/ (R=0.5511) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 27-рт эрэмбэлэгдэж байна. Харин **Ойн газрын** албан хаагчдын гадаад орчин бүлгийн үзүүлэлтүүдэд өгсөн ач холбогдолын харьцангуй индексийн үнэлгээг авч үзэхэд үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал (R=0.5600) бүлэгт 1-рт эрэмбэлэгдэж, 34 үзүүлэлтийн 25-рт эрэмбэлэгдэж байна.

Хүснэгт 44. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын албан хаагчдын гадаад орчин бүлгийн ач холбогдлын харьцангуй индекс

Үзүүлэлт	БОУАӨЯам		Ойн газар	
	АХХИ (RII)	Эрэмбэ	АХХИ (RII)	Эрэмбэ
Засгийн газрын нөлөө /дүрэм, журмын өөрчлөлт их байх/	0.5511	27	0.5400	28
Үйлчлүүлэгч, иргэний мэдлэг, мэдээллийн дутмаг байдал	0.5505	29	0.5600	25
Шийдвэрт нөлөөлөх нөлөөлөл их	0.5188	32	0.4400	34

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны үнэлгээнд байгууллагын бүтцийн оновчтой зохион байгуулалт, чиг үүргийн оновчтой зохион байгуулалт, нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал, дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа, уялдаатай байдал, ажлын байран дах сэтгэл ханамжийн талаар асууж тодруулсан.

Судалгаанд хамрагдсан 4 албан хаагч тутмын 1 нь өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байна.

Зураг 92. Өөрийн хийж буй ажилдаа сэтгэл ханамжтай байдал, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас байгууллагын бүтэц хэр зэрэг оновчтой зохион байгуулагдсан талаар асуухад 18.5 хувь нь маш сайн, 37.7 хувь сайн, 31.5 хувь нь дунд, 8.9 хувь муу, 3.3 хувь нь маш муу гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 10 албан хаагч тутмын дөрөв (43.8 хувь) нь байгууллагын бүтэц оновчгүй гэж үнэлсэн байна.


Зураг 93. Байгууллагын бүтэц оновчтой зохион байгуулагдсан эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас байгууллагын нэгжийн чиг үүрэг хэр зэрэг оновчтой зохион байгуулагдсан талаар асуухад 18.4 хувь нь маш сайн, 41.5 хувь сайн, 30.1 хувь нь дунд, 7.5 хувь муу, 2.5 хувь нь маш муу гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд

хамрагдсан 10 албан хаагч тутмын дөрөв (40.1 хувь) нь байгууллагын нэгжийн чиг үүрэг оновчгүй гэж үнэлсэн байна.

Зураг 94. Байгууллагын чиг үүрэг оновчтой эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 48.3 хувь нь нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал байгаа гэж үнэлсэн байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардлын талаар асуухад 14.3 хувь нь маш сайн, 34.4 хувь сайн, 36.1 хувь нь дунд, 8.7 хувь муу, 3.4 хувь нь маш муу гэж хариулсан байна.

Зураг 95. Байгууллагын албан хаагчдын ажил үүрэг давхардалтай эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 48.0 хувь нь дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааг муу гэж үнэлсэн байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааг асуухад 16.3 хувь нь маш сайн, 35.7 хувь сайн, 33.3 хувь нь дунд, 9.8 хувь муу, 4.8 хувь нь маш муу гэж хариулсан байна.

Зураг 96. Дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааны үнэлгээ, хувиар




Олон улсын судалгааны GALLUP компаний судалгаанд 4 албан хаагч тутмын нэг нь сэтгэл ханамжгүй байвал тухайн албан хаагч ажлаас гарах түвшин 59.0 хувиар өндөр байдаг, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 16.0 хувиар, хөдөлмөрийн бүтээмж 18.0 хувиар, ашигт ажиллагаа 15.0 хувиар бага байдаг байна.

HARVARD BUSINESS REVIEW-д нийтлэгдсэн судалгаанд 4 албан хаагч тутмын нэг нь сэтгэл ханамжгүй байвал багийн хамтын ажиллагаа 24.0 хувиар, шийдвэр гаргалтын үр дүн 17.0 хувиар буурдаг байна.

Мөн SOCIETY FOR HUMAN RESOURCE MANAGEMENT (SHRM)-ийн судалгаанд 1 сэтгэл ханамжгүй ажилтан дор хаяж 3 бусад ажилтны бүтээмжид сөргөөр нөлөөлдөг, багийн гишүүдийн хооронд харилцааны асуудал 32% өсдөг, байгууллагын соёлд сөрөг нөлөө үзүүлж, ажилчдын ерөнхий сэтгэл ханамжийг 28%-иар бууруулдаг байна.

Зураг 97. Сэтгэл ханамжгүй нэг албан хаагчын үзүүлэх нөлөө



Дүгнэлт

Салбарын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг харахад 5 үзүүлэлт нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай, 1 нь ажлын зохион байгуулалт, хуваарилалттай, 1 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

Судалгаанд хамрагдсан 4 албан хаагч тутмын нэг нь өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байгаа нь ажлын зохион байгуулалт, ажиллах орчин, нөхцөл байдалтай холбоотой юм. Сэтгэл ханамжгүй нэг албан хаагч бусдад сөргөөр нөлөөлөх нөлөө өндөр тул ажиллах орчин, нөхцөл байдлыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

Судалгаанд хамрагдсан 10 албан хаагч тутмын дөрөв (43.8 хувь) нь байгууллагын бүтэц оновчгүй, 10 албан хаагч тутмын дөрөв (40.1 хувь) нь байгууллагын нэгжийн чиг үүрэг оновчгүй, 10 албан хаагч тутмын дөрөв (48.3 хувь) нь нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал байгаа гэж хариулсан бөгөөд тухайн салбарт дахин инженерчлэлийг хийх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байсныг илэрхийлж байна.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын мэдээллээс харахад байгууллагын оновчгүй зохион байгуулалт, нэгжийн чиг үүргийн оновчгүй байдлаас болж нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал үүссэн байх магадлалтай юм. Иймд бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, чиг үүргийг тодорхой болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Мөн Байгаль орчны салбарын дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцоо маш муу байгаа судалгаанд хамрагдсан албан хаагчид онцолсон. Иймд тухайн салбарт нэгдсэн мэдээллийн тогтолцоо бий болгох, сайжруулах, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх шаардлагатай байна.

2.4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2.4.1. Төрийн үйлчилгээний эрх зүйн орчны шинжилгээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хэрэгжүүлэх эрх, чиг үүрэг:

Энэ судалгаагаар нутгийн өөрийн удирдлагын байгууллагад хуулиар олгогдсон эрх хэмжээ байгаль орчны салбарт хэрхэн тусгагдаж, тухайн хуулиар орон нутгийн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулахыг зорилгоо.

Хүснэгт 45. Эрх зүйн баримт бичгүүдийн нийцэл

Нийцэл	НИЙТ	Болов-сруулах	Бодлого хэрэгжүүлэх	Зохицуулах	Хяналт тавих	Захиргааны чиг үүрэг	Бусад
НИЙТ	503	111	59	31	65	224	13
Яамны эрх зүйн байдлын тухай хууль	0						
Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль	3				1	2	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	9			2	4	3	
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	113	23	5	6	9	70	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	6				2	4	
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	15	9			2	4	
Усны тухай хууль	35	7	3	3	6	11	5
Ойн тухай хууль	108	21	13	8	18	48	
Амьтны тухай хууль	33	8	6	4	3	8	4
Байгалийн ургамлын тухай хууль	15	3	1	2	2	6	1
Агаарын тухай хууль	10	2	2	3	1	2	
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	7	4	2		1		
Хог хаягдлын тухай хууль	59	12	8	2	11	25	1
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	3	1				2	
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	16	2	3	1	3	7	
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	11	6				5	
Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль	15	2	5			8	
Газрын тухай хууль	0						
Газрын хэвлийн тухай хууль	0						
Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулхр тухай хууль	3		3				
Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль	29	11	8		3	5	2
Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль	0						

Судалгаагаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 22 хуулиас хэрэгжүүлж буй бүрэн эрх, чиг үүргийг ангилсан бөгөөд давтамжтай байдлаар орон нутгийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагад нийт 503 бүрэн эрх олгогдсон байна. Тухайлбал,

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар хяналт тавих 1, захиргааны чиг үүрэг буюу зохион байгуулах, уялдаа холбоог хангах, хангамж, хүний нөөцийн асуудлыг зохицуулах зэрэг 2 чиглэлээр бүрэн эрх олгогдсон байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар зохицуулах мөн зөвшөөрөл олгох, хязгаарлах зэрэг 2, хяналт тавих 4, захиргааны чиг үүрэг буюу зохион байгуулах, уялдаа

холбоог хангах, хангамж, хүний нөөцийн асуудлыг зохицуулах зэрэг 3 төрлийн чиглэлээр тус тус бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ.

Харин Ойн тухай хуульд бодлого боловсруулах, батлахаар 21, бодлого, хууль хэрэгжүүлэхээр 13, зохицуулах мөн зөвшөөрөл олгох, хязгаарлах зэрэг 8, хяналт тавих 18, захиргааны чиг үүрэг буюу зохион байгуулах, уялдаа холбоог хангах, хангамж, хүний нөөцийн асуудлыг зохицуулах 48 бүрэн эрх тус тус олгогдсон байна. Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд бодлого боловсруулах, батлахаар 23, бодлого, хууль хэрэгжүүлэхээр 5, зохицуулах мөн зөвшөөрөл олгох, хязгаарлах зэрэг 6, хяналт тавих 9, захиргааны чиг үүрэг буюу зохион байгуулах, уялдаа холбоог хангах, хангамж, хүний нөөцийн асуудлыг зохицуулах 70 бүрэн эрхийг хуулиар олгосон байна.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд, 22 хуульд 111 буюу 22% нь бодлого боловсруулах, батлах бүрэн эрх бол, 59 буюу 11% нь бодлого, хууль хэрэгжүүлэх, 31 буюу 6% хувь нь зохицуулах, зөвшөөрөл олгох, хязгаарлах зэрэг бүрэн эрх байна. Мөн хяналт тавихаар 65 бүрэн эрх олгогдсон нь хуулиар нийт олгогдсон бүрэн эрхийн 12%-ийг эзэлж байна. Харин 224 захиргааны бүрэн эрх олгогдсон байгаа нь хамгийн өндөр хувийг буюу 44%-ийг эзэлж, 13 буюу хамгийн бага болох 2% нь бусад хэлбэрээр бүрэн эрхээ хэрэгжүүлж байгааг харуулж байна.

Байгаль орчин, уур амьсгалын салбарын голлох хуулиуд болох Байгаль орчныг хамгаалах тухай болон Ойн тухай хуулиудад нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ хамгийн ихээр тусгагджээ.


Тодруулбал, Ойн тухай хуулиар нийт 108 бүрэн эрх олгогдож, нутгийн өөрийн удирдлагын байгууллага ойн чиглэлээр нийт олгогдсон бүрэн эрхийн 19%-ийг бодлого боловсруулахад, 12%-ийг бодлого, хууль хэрэгжүүлэхэд, 7%-ийг зохицуулах, зөвшөөрөл олгох, хязгаарлахад, 16%-ийг хяналт тавихад, 44%-ийг захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд тус тус зарцуулж байна.

Чанарын ярилцлагаар бүртгэсэн асуудлууд нь хууль тогтоомжийн хэрэгжилт, уялдаа холбоо, хүний нөөцийн бодлогын талаар байх бөгөөд эдгээр асуудлууд нь хуулийг өөрөөр хэрэглэх, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, журмын зохицуулалт нь практикт нийцэхгүйгээс улбаалж иргэн аж ахуйн нэгжид хүндрэл учруулах, салбарын хүний нөөцөд нөлөөлөх, тухайн салбарт төрөөс баримтлах бодлого хэрэгжихгүй байх эрсдлийг дагуулж байна. Нөгөөтэйгүүр эдгээр асуудал, эрсдлүүд нь төрийн албан хаагч, иргэдийн сэтгэл ханамжид нөлөөлж, төрийн бүтээмж болоод бодлого, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц сөрөг нөхцөл байдлыг үүсгэж байна.

Тусгай зөвшөөрлийн талаарх судалгааны үр дүн:

Байгаль орчны чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 31 тусгай зөвшөөрлөөс Засгийн газар-1, Байгаль орчин, уур, амьсгалын өөрчлөлтийн яам 18, Ойн газар-1, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага-1, Удирдах зөвлөл-1, Засаг дарга-8, Сав газрын захиргаа-1, Ойн анги-1, мөн хуулийн 8.2 дугаар зүйлд заасан 16 энгийн зөвшөөрлөөс Байгаль орчин, уур, амьсгалын өөрчлөлтийн яам 8, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага-1, Засаг дарга-6, Сав газрын захиргаа-1 тусгай болон энгийн зөвшөөрлийг тус тус олгохоор эрх олгосон байна.

Зураг 98. Тусгай болон энгийн зөвшөөрөл



Үүнээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож буй 18 тусгай, 8 энгийн зөвшөөрлийг олгож буй явц, дараалал, хэрэгжилтийг тус зөвшөөрлүүдийг хариуцан ажилладаг холбогдох албан тушаалтнуудын өгсөн мэдээлэл, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын 11 хууль, зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг зохицуулсан Засгийн газрын тогтоолоор батлагдсан 2, Байгаль орчны асуудал [эрхэлсэн](#) сайдын тушаалаар батлагдсан 2 хэм хэмжээний актын хүрээнд хянаж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдло.

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож буй тусгай болон энгийн зөвшөөрлийг харьцуулсан байдлаар доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 46. Тусгай зөвшөөрлийн жагсаалт, эрх бүхий байгууллагаас олгож буй тооны харьцуулалт

Д/д	Зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн тоо	Зөвшөөрөл олгож буй байгууллага					Бусад
			Засгийн газар	Төрийн захиргааны төв /яам/	Төрийн захиргааны /агентлаг/	Нутгийн захиргаа/сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ЭД, агентлаг	УИХ-ын СЗХ, МБ	
1	Байгаль орчны чиглэлээр	31	1	18	1	10	-	1
2	Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр	38	-	-	-	-	38	-
3	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр	22	-	6	2	-	-	14
4	Батлан хамгаалахын чиглэлээр	-	-	-	-	-	-	-
5	Зам, тээврийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	11	1	7	3	-	-	-
6	Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр	12	-	6	6	-	-	-
7	Соёл, боловсролын чиглэлээр	12	-	СоЯ-1 БоЯ-7	-	3	-	1
8	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр	30	3	АҮЭБЯ-9 БоЯ-4	7	3	-	4
9	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр	15	-	1	-	-	-	14
10	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр	1	-	1	-	-	-	-
11	Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	13	-	6	5	1	-	1

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр	14	3	8	1	2	-	-
13	Эрүүл мэндийн чиглэлээр	17	-	12	3	2	-	-
14	Эрчим хүчний чиглэлээр	34	-	22	-	-	-	12

Хүснэгт 47. Энгийн зөвшөөрлийн жагсаалт, эрх бүхий байгууллагаас олгож буй тооны харьцуулалт

Д/д	Зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн тоо	Зөвшөөрөл олгож буй байгууллага					
			Засгийн газар	Төрийн захиргааны төв /яам/	Төрийн захиргааны байгууллага /агентлаг/	Нутгийн захиргаа /сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ЗД, агентлаг/	УИХ-ын СЗХ, МБ	Бусад
1	Байгаль орчны чиглэлээр	16	-	8	-	8	-	-
2	Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр	51	-	-	-	-	51	-
3	Барилга, хот байгуулалтын чиглэлээр	3	1	1	-	1	-	-
4	Зам, тээврийн хөгжлийн чиглэлээр	5	-	2	3	-	-	-
5	Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр	3	-	1	1	-	-	1
6	Соёл, боловсролын чиглэлээр	14	1	СоЯ-7 БоЯ-5	-	-	-	1
7	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр	1	-	-	1	-	-	-
8	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр	3	-	2	-	-	-	1
9	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр	2	-	-	2	-	-	-
10	Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	14	2	1	9	2	-	-
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр	8	-	3	4	1	-	-
12	Эрүүл мэндийн чиглэлээр	1	-	-	1	-	-	-

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож буй тусгай болон энгийн зөвшөөрлийн тоог бусад төрийн захиргааны төв байгууллагуудтай харьцуулж үзэхэд хамгийн өндөр буюу 26 тусгай зөвшөөрлийг олгож байна. Үүн дээр байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас саналыг боловсруулж, Засгийн газар болон Удирдан зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн олгох 2 зөвшөөрлийг нэмж тооцвол 28 зөвшөөрөл болно.

Эдгээр 28 зөвшөөрлийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар 19, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар 7, Тусгай хамгаалалтын нутгийн бодлогын хэрэгжилтийн газар 2-ыг тус тус олгож байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуульд тусгайлан заагаагүй боловч зөвшөөрөл агуулсан гэж үзэх боломжтой төрийн үйлчилгээ буюу байгаль орчны Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан батлах, төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах, тайланг баталгаажуулах асуудал нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, уг хуулийн хавсралтаар батлагдсан төслийн ангиллын дагуу яам болон орон нутгийн захиргааны байгууллагад хамаарагдаж байна.

Дээр дурдсан 18 тусгай зөвшөөрлийн 8 тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл агуулсан гэж үзэх 4 төрийн үйлчилгээний дагуу 2023 онд 3231 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрх, зөвшөөрөл, үйлчилгээ авсан байна.

БОУАӨЯ-наас тусгай зөвшөөрөлтэй холбоотой ирүүлсэн мэдээлэл бүрэн бус байсан, нөгөө талаар тусгай зөвшөөрлийн мэдээлэл нэгдсэн байдлаар бүртгэгдэг эсэх, тухайн байгууллагын шуурхай байдал зэргийг тандах зорилгоор 2024 оны жилийн эцсийн тоон мэдээллийг нэгдсэн байдлаар нарийвчлан гаргуулахаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр БОУАӨЯ-нд хандсан боловч 21 хоногийн хугацаанд асуудал хариуцсан албан хаагчид тодорхой бус шалтгаанаар мэдээллийг нэгтгэж ирүүлээгүй болно.

Энэ нь мэдээллийг нэгдсэн байдлаар ангилж бүртгэгдэггүй, тусгай зөвшөөрлийг бүртгэлийн хөтлөлт сул, албан хаагчдын ажлын ачаалал ихтэй холбоотой гэж үзэж болох ч нөгөө талаар эрх бүхий байгууллагаас мэдээллийг гаргуулахаар хандахад ирүүлэхгүй байгаа нь энгийн иргэд болон бусад байгууллагаас мэдээлэл авах боломж туйлын хязгаарлагдмал болохыг илэрхийлж байна.

Хүснэгт 48. Тусгай зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	ЭЗ-н зохицуулалт		Зөвшөөрөл олгож буй үйл ажиллагааны хэлбэр			Тогтоогдсон нөхцөл байдал	Зөрчигдсэн хууль
		Хууль	ЭХХА	Зөвлөл	дүгнэлт	Х-гүй		
1	1.2.амьтныг сэргээн нутагшуулах	+			+		Цахимжуулаагүй. Амьтны тухай хуульд зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдлийг тусгаагүй, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлдэггүй	Амьтантай холбогдолтой 5 тусгай, 3 энгийн зөвшөөрөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг Амьтны тухай хуулиар зохицуулаагүй, хариуцсан албан тушаалтан нь зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох төрийн байгууллагаас лавлагаа, мэдээлэл авах болон баримт бичгийн эх хувьтай нь тулгалт хийж магадлан шалгадаггүй, харьяалах зөвлөлөөр хэлэлцүүлэхгүйгээр аж ахуйн нэгж, байгууллагаас зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл бүрэн байгаа эсэхийг шалган, харьяалах нэгжийн даргадаа танилцуулан, хуулийн хэлтсээр хянуулан зөвшөөрөл олгож байгаа нь Зөвшөөрлийн болон Амьтны тухай хуулийг;
2	1.3.амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох	+				+		
3	1.4.ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	+				+		
4	1.13.харь амьтныг нутагшуулах, өсгөж үржүүлэх	+				+		
5	1.15.ховор амьд амьтны цуглуулга хийх	+				ДХ		
6	1.5.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх	+		+	+	Хуулийн дагуу олгодог		
7	1.6.байгаль орчны аудит хийх	+				+	Цахимжсан	
8	1.7.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх	+				+	Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэггүй	
9	1.8.генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах	+					Дуудлага худалдаагаар зохицуулагддаг Цахимжуулаагүй	Зөвшөөрлийг цахимжуулаагүй нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3-т "зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах" гэж, 2.6-д "зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

10	1.9.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах	+	+	+			Тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлөөр Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэн олгодог	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлөөр олгож байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16-т “Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно” гэж заасныг;
11	1.10.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх, устгах	+	+	+			Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэн олгодог	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулсан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь заалт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно”-ыг;
12	1.12.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	+				+	Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэггүй	
13	1.14. химийн болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах	+		+	+		Хуулийн дагуу олгодог	
14	1.16.ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	+				+		Зөвшөөрлийг цахимжуулаагүй нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3-т “зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах” гэж, 2.6-д “зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
15	1.17.хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх	+		+			Цахимжаагүй	
16	1.19.ургамлыг гадаад улсад гаргах		+			+		
17	1.31.Газрын хэвлий нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	+	+			+	Цахимжаагүй Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэн олгодог	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулсан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь заалт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно”-ыг;

Хүснэгт 49. Энгийн зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	ЭЗ-н зохицуулалт		Зөвшөөрөл олгож буй үйл ажиллагааны хэлбэр			Тогтоогдсон нөхцөл байдал	Зөрчигдсэн хууль
		Хууль	ЗХХА	Зөвлөл	Дүгнэлт	Х-гүй		
1	1.1.Амьтны цуглуулгыг гадаадад гаргах	+					+	Амьтантай холбогдолтой 5 тусгай, 3 энгийн зөвшөөрөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг Амьтны тухай хуулиар зохицуулаагүй, хариуцсан албан тушаалтан нь зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох төрийн байгууллагаас лавлагаа, мэдээлэл авах болон баримт бичгийн эх хувьтай нь тулгалт хийж магадлан шалгадаггүй, харьяалах зөвлөлөөр хэлэлцүүлэхгүйгээр
2	1.5.нэн ховор амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнах, барих	+					+	
3	1.7.эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг	+					+	

	эрүүлжүүлэх зорилгоор амьтныг агнах, барих						аж ахуйн нэгж, байгууллагаас зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдэл бүрэн байгаа эсэхийг шалган, харьяалах нэгжийн даргадаа танилцуулан, хуулийн хэлтсээр хянуулан зөвшөөрөл олгож байгаа нь Зөвшөөрлийн болон Амьтны тухай хуулийг;
4	1.2.гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ судалгаа явуулах	+				+	Зөвшөөрлийг цахимжуулаагүй нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3-т "зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах" гэж, 2.6-д "зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.
5	1.3.харь ургамлыг байгальд тарималжуулах	+				+	
6	1.4.нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах	+				+	
7	1.6.тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах	+				+	
8	1.16.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх	+	+			+	

Дүгнэлт:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож буй 17 тусгай зөвшөөрлийн 9 буюу 52.9%, энгийн 8 зөвшөөрлийн 8 буюу 100% нь цахимжуулаагүй, 10 буюу 58.8% нь зохих зөвлөлөөр хэлэлцүүлдэггүй, тусгай 3, энгийн 1, нийт 4 зөвшөөрөл буюу 16% нь Захиргааны хэмжээний актыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон, 1 тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлөөр олгож байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад тус яам нь байгаль орчны чиглэлээр олгож буй тусгай болон энгийн зөвшөөрлийг задлах, хуваах, зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг бүрдлийн хянан магадлааг бүрэн гүйцэт хийхгүй, албан бичиг хэлбэрээр олгох үйл ажиллагааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн гүйцэт цахимжуулаагүйгээс зөвшөөрөл олгох үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж, доголдол үүсгэх нөхцөл, шалтгаан болох боломжтой.

Иймд Зөвшөөрлийн тухай хууль болон байгаль орчны салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам болон бусад эрх зүйн хэм, хэмжээний актыг боловсронгуй болгох, мөн хуулиар хориглосон, давсан зохицуулалттай захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, зөвшөөрөлтэй холбогдох салбарын хуулиар зохицуулаагүй үйл ажиллагаа, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.4.2. Зөвшөөрөл олгох процесс зураглалын шинжилгээ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны процессын судалгаа

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газрын олгож буй тусгай зөвшөөрлийн үйл явцыг нарийвчлан судалж, 39 процессын зураглалыг BPMN 2.0 стандартын дагуу боловсруулсан. Энэхүү судалгаанд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөө, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохын тулд холбогдох албан хаагчид, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй ярилцлага хийж, баримт бичгийн болон статистик мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн байна.

Яамны хэмжээнд нийт 35 төрлийн зөвшөөрөл олгодог бол Ойн газар 7 төрлийн зөвшөөрлийг хариуцан олгож байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хаагчид, үйлчилгээ авч буй аж ахуй нэгжийн төлөөлөлтэй уулзаж ярилцлагын хэлбэрээр мөн байгууллагын баримт бичиг болон статистик дүн шинжилгээнд суурилж нийт зөвшөөрөл олгох 39 процесст шинжилгээ хийж үзэхэд 54.4% нь цаасан хэлбэртэй, 20.7% нь цаасан болон цахим хослуулсан хэлбэрээр, 24.3% нь цахимаар хийж байгаа нь тусгай

зөвшөөрөл олгох процесс бүрэн цахимжаагүй байгааг баталж байна. Мөн нийт үйл ажиллагааны 20.7% нь цаас болон цахим хослуулсан хэлбэрээр давхардуулан хийж байгаа нь ажлын бүтээмж алдагдах, давхардсан үйлдэлүүдийг хийж байна.

Хүснэгт 50. Процессын зураглалын ерөнхий мэдээлэл

Байгууллага	Дүн	БОУАӨЯ	Ойн газар
Зурагдсан процессын тоо	39	32	7
Процессын алхмын тоо	691	544	147
Хурал	4	4	0
Хяналт	267	218	49
Цаас, хувь	54.4%	55%	52.4%
Цахим, хувь	24.3%	23.2%	28.6%
Цаас болон цахим, хувь	20.7%	21.1%	19%
Цаасны хэрэглээ, хувь	54.4%	55%	52.4%
Цахимын хэрэглээ, хувь	75.1%	76.1%	71.4%
Оролцогч тал	253	316	63
Хурал, хувь	0.6%	0.7%	0%

Процессын шинжилгээ, нийтлэг тулгамдсан асуудлууд

Процессын дахин инженерчлэлийн хүрээнд бүх оролцогч талуудын оролцоог харгалзан, “Асуудлын мод” болон “Таван яагаад” аргачлалыг хослуулан ашиглаж, дараах нийтлэг асуудлуудыг тодорхойлсон:

- Мэдээллийн үнэн зөвийг шалгах тогтолцооны дутагдал: Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа цахимжсан боловч ирүүлсэн мэдээллийг бусад төрийн байгууллагын мэдээллийн сантай тулгах систем байхгүй тул албан хаагчид гар аргаар нягтлах шаардлагатай байна. Энэ нь баримт бичгийн бүрдлийг хангасан гэх хуурамч нөхцлийг бүрдүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байна.
- Баримт бичгийн боловсруулалтын хүндрэл: Хүсэлтүүдийг цахимаар хүлээн авч байгаа хэдий ч олон хуудастай тайлан, үнэлгээний баримтуудыг албан хаагчид гар аргаар уншиж танилцах шаардлагатай байна. Үүний улмаас албан хаагчдын ажлын бүтээмж буурч, цаг хугацааны хувьд ихээхэн ачаалал үүсгэж байна.
- Хүний нөөцийн хэт ачаалал: Албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс илүүтэйгээр тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажилд ихээхэн цаг зарцуулж байна.
- Шийдвэр гаргах үйл явцын тодорхойгүй байдал: Хуралдааны хугацаа тодорхойгүй, процессын шат дамжлага ойлгомжгүй байгаа нь шийдвэр гаргах хурдыг удаашруулж байна.
- Баримт бичгийн шаардлагын уялдаа холбоогүй байдал: Төрийн байгууллагууд иргэд, аж ахуйн нэгжүүдээс шаардлагатай мэдээллээ давхардуулан авч байгаа нь процессын үр ашиггүй байдлыг нэмэгдүүлж байна.
- Санхүү болон цаг хугацааны бэрхшээл: Тухайн зөвшөөрлийг авахын тулд аж ахуйн нэгжүүд олон төрлийн нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай болдог нь санхүүгийн болон цаг хугацааны хувьд ихээхэн хүндрэл учруулж байна.
- Тухайн зөвшөөрлийг авахын тулд аж ахуйн нэгжүүд олон төрлийн нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай болдог нь санхүүгийн болон цаг хугацааны хувьд ихээхэн хүндрэл учруулж байна.
- Давхардсан хяналтын шатлал: Процесс тус бүр дунджаар 7 хяналтын шат дамжлагатай байгаа нь хэт их хяналттай байгааг харуулж байна. Ихэнх хяналтын шатууд зөвхөн гарын үсэг зурах хэлбэртэй бөгөөд бодитой шийдвэр гаргахад нөлөөлдөггүй.
- Хууль, эрх зүйн журмалсан байдал: Тусгай зөвшөөрөл бүрийг нэг бүрчлэн задалж журамлаагүй тул цар хүрээ, давтамжаас үл хамааран нэг ижил шаардлага тавьдаг нь хүндрэл учруулдаг.

RACI матрицын үнэлгээ

Тусгай зөвшөөрөл олгох үйл явцад оролцогч талуудын чиг үүргийн хуваарилалтыг тодорхойлохын тулд RACI матрицын аргыг ашиглаж үнэлгээ хийсэн.

Үр дүнд:

- Тухайн процессыг хариуцсан албан хаагч нь боловсруулалт, хяналт, хариуцлага хүлээх, мэдээлэх зэрэг олон чиг үүрэгтэй, ажлын ачаалал ихтэй байна.
- Хэт олон хяналтын шатлалын улмаас процесс удааширч, албан хаагчдын ачааллыг нэмэгдүүлж байна.


Дүгнэлт

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын процессын дахин инженерчлэлийн хүрээнд дараах үндсэн асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

1. Мэдээллийн үнэн зөвийг шалгах цахим систем нэвтрүүлэх;
2. Процессын шат дамжлагыг оновчтой болгох, давхардлыг арилгах;
3. Хяналт тавих шатлалыг цөөрүүлж, шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлэх;
4. Баримт бичгийн шаардлагыг оновчтой болгон уялдааг хангах;
5. Албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах зохицуулалт хийх.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож байгаа зөвшөөрлийн процессын мэдээлэл

Зураг 99. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл



Зургийн тайлбар:

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хууль (2022 он), Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он)-аар зохицуулж байна.

Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу БОУАӨЯ нь улсын хэмжээнд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгодог.

Мөн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журам"-ын дагуу хэрэгжүүлдэг.

Үйл явц, оролцогч талууд: Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд дараах байгууллага, албан тушаалтнууд оролцдог.

- Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)
- Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар
- Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга
- Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга бөгөөд Ерөнхий шинжээч
- БОУАӨЯ болон холбогдох мэргэжилтнүүд
- Төрийн захиргаа, удирдлагын газар (ТЗУГ)

Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нийт 39 үе шаттай явагддаг бөгөөд үүний 83% нь цаасан болон цахим хосолсон, 17% нь бүрэн цахим хэлбэрээр явагдаж байна. Гэвч уг үйл явцад тулгарч буй дараах асуудлууд оролцогч талуудад хүндрэл учруулж байна.

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд тулгарч буй асуудлууд:

1. Программ хангамж, техник тоног төхөөрөмжийн асуудал

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлд les.e-business.mn платформ ашигладаг бөгөөд системийн доголдол, гацалт ихээр гарч, зөвшөөрөл олгох үйл явц удааширч байна.
- Системд зөвшөөрөл хариуцсан албан хаагч шинээр нэвтрэхэд хүндрэлтэй, өмнөх албан хаагчийн үлдээсэн мэдээлэлтэй холилдон ойлгомжгүй байдал үүсэх нь элбэг.
- Цахимаар ирүүлсэн баримт бичгийг буцаах, нэмэлт мэдээлэл шаардах хэсгүүд бүрэн ажилладаггүйгээс болж "татгалзан шийдвэрлэх" товчийг дарах шаардлага үүсдэг. Үүнээс болж аж ахуйн нэгж, байгууллага татгалзсан шалтгаанаа тодорхой мэдэх боломжгүй, шаардлагатай нэмэлт мэдээллээ бүрдүүлэхэд хүндрэлтэй.
- Цахимаар илгээсэн баримт бичгийн үнэн зөвийг нягтлан шалгах боломжгүй, PDF форматтай баримтуудыг мэргэжилтнүүд уншихад хүндрэлтэй.
- Eic.mn мэдээллийн сангийн баяжуулалт бүрэн хийгдээгүй, хяналт тавих субъект тодорхойгүй.
- Зөвшөөрөл олгох тушаалын төслийг хянан баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан томилолтоор ажиллах тохиолдолд гарын үсэг орлох боломжгүй тул шийдвэрлэх хугацаа удааширдаг.

2. Хууль, эрх зүйн зохицуулалтын хүндрэлүүд

- Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор гэрчилгээний хуулбар эсвэл түрээсийн гэрээ шаардах эрх зүйн зохицуулалт тодорхой бус.
- Аж ахуйн нэгжийн захирлын танилцуулга болон бусад баримт бичигт тавигдах шаардлага тодорхойгүй. Үүнээс сүүлийн 2-3 жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлага тавьж байгаа нь хууль эрх зүйн үндэслэлгүй.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн сунгалт нь БОУАӨ-ийн сайдын тушаалаар батлагдаж, сунгалтын гэрчилгээ нь ХБОБХГ-ын даргын гарын үсгээр баталгааждаг. Гэвч энэ үйл явц нь эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байна.

3. Салбар хоорондын уялдаа холбооны асуудал

Монгол Улсад Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгахад Зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Хог хаягдлын тухай хуулиар зохицуулдаг.

БОУАӨЯ нь улсын хэмжээнд аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа бүхий аж ахуйн нэгж байгууллагад тусгай зөвшөөрөл олгодог.

Аж ахуйн нэгж байгууллагууд Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”, БОНХ-ийн сайдын 2014 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Үйл явц, оролцогч талууд:

- Аж ахуй нэгж байгууллага (ААНБ)
- БОУАӨЯ-ны харьяа “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” УТҮГ
- Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл
- Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар
- БОУАӨЯ-ны холбогдох албан хаагчид

Тусгай зөвшөөрлийг олгох үйл явц нийт 39 процесс буюу алхамтай явагддагаас 79% нь цаас болон цахим хосолсон, 21% нь цахим суурьтай явагдаж байна.

Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал:

1. Программ хангамж, техник тоног төхөөрөмжийн асуудал

- Цахим мэдээллийн сан ажиллахгүй, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа бүгд цаасаар явагддаг. Энэ нь цаг хугацаа алдах, бүтээмж буурах, үйлчилгээний чанар буурах, алдаа гаргах, хүний нөөцийн хувьд давхардал үүсгэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.
- Мэргэжлийн зөвлөлийн материал хүлээн авах үйл явц цахимжаагүй.
- БОУАӨЯ-ны вэбсайтаас шаардлагатай мэдээллийг бүрэн авах боломжгүй, мэдээлэл тодорхой бус байна.

2. Хууль, эрх зүйн зохицуулалтын хүндрэлүүд

- Тусгай зөвшөөрөл 1, 5, 10 жилийн хугацаатай олгогддог боловч тухайн хугацааг тогтоох нарийн шаардлага, шалгуур байхгүй, нэгэн ижил баримт бичгийн бүрдүүлэлт шаарддаг.
- Нэг жилийн хугацаатай түр зөвшөөрөл нь Хог хаягдлын тухай хуулийн 37.1.1-д заасанчлан барилгын ажил эхлүүлэхээс үйл ажиллагаа эрхлэх хүртэл хэрэгжих ёстой боловч бодит байдал дээр Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах зэрэг шаардлага тавьж байгаа нь хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна гэсэн асуудлыг ААНБ-ууд тавьдаг. Тусгай зөвшөөрлийг олгосон хугацаанд ААНБ нь үйл ажиллагааны тайлан ирүүлдэггүй бөгөөд зөвшөөрөл авах, сунгуулахад тайлан шаарддаггүй.
- Таван жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийг олгохдоо нэг жилийн хугацаанд явуулсан үйл ажиллагаа, технологийн горим, хяналт-шинжилгээний дүнг үндэслэх шаардлага тавьдаг боловч эдгээр шалгуур тодорхойгүй, тоног төхөөрөмж, хөрс, усны бохирдлын шинжилгээ гэх мэт баримт бичгийн шаардлага тодорхой бус байна.
- Хог хаягдлын Мэргэжлийн зөвлөл нь Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв дээр төвлөрсөн нь иргэд, аж ахуйн нэгжийн үйлчилгээ авах шат дамжлагыг нэмэгдүүлж, хүндрэл учруулж байна.
- 2023 оны 9 дүгээр сард бүрдүүлэх баримт бичгийн журам хүчингүй болсон тул одоогоор баримт бичгийн шаардлага тодорхойгүй байна.


- Тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц анх удаа зөвшөөрөл авахтай адил бүх баримт бичгийг бүрдүүлэх шаардлага тавьж байгаа нь аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулж байна.

3. Салбар хоорондын уялдаа холбооны асуудал

- Засгийн газрын 2018 оны 116 тогтоолоор “Аюултай хог хаягдлын жагсаалт”-ыг баталсан хэдий ч аюултай хог хаягдлын байгууламж байхгүй байна.

Ойн газраас олгож байгаа зөвшөөрлийн процессын мэдээлэл

Зураг 101. Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл



Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг Ойн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зохицуулдаг.

“Зөвшөөрлийн тухай” хуульд тусгай зөвшөөрөл олголт цогц байхыг заасан боловч БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ сайдын тушаалаар баталсан журмын дагуу нэг тусгай зөвшөөрлийг долоон ангилал болгон хуваасан байна.

Тусгай зөвшөөрөл олгох үйл явц, оролцогч талууд

- ААН, ТББ
- Холбогдох аймаг, нийслэлийн Байгаль орчны газар
- Ой хариуцсан мэргэжилтэн
- Ойн газрын дарга
- Ойн анги, мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийг хариуцсан мэргэжилтэн
- Төлөвлөгөө, төсөл хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хууль хариуцсан ахлах мэргэжилтэн
- Ойн нөөцийн хэлтсийн дарга
- Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
- Хяналт, үнэлгээ, шинжилгээ, мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нийт 21 үе шаттай явагддаг бөгөөд 10 оролцогч талтай байна. Зөвшөөрөл олгох үйл явцын 52.3% нь цаасан, 28.5% нь цахим бол үлдсэн 19.2% нь цаасан болон цахим хэлбэрээр явагдаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зөвшөөрлийг олгох үйл явцын 71.5 % нь цаасан суурьтай байгааг харуулж байна. Дээрх асуудлын улмаас оролцогч талуудад дараах хүндрэл учирч байна.

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд тулгарч буй асуудлууд

1. Программ хангамж, техник тоног төхөөрөмжийн асуудал

- Шаардлага хангаагүй материалыг e-Business систем дээр буцаасан ч ААНБ системийг шалгаагүйгээс болж материалаа засварлан дахин илгээгээгүй тохиолдолд 30 хоногийн нөхөн бүрдүүлэлтийн хугацаа хэтэрч, тусгай зөвшөөрөл авах эрхээ алдаж байна.
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэвлэх техник, тоног төхөөрөмж хангалтгүй байна.

2. Хууль, эрх зүйн зохицуулалтын хүндрэлүүд

- Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тушаал гаргахад таван дарга /Ойн газрын дарга, Ойн нөөцийн хэлтсийн дарга, Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Захиргаа удирдлагын хэлтсийн хэлтсийн дарга, Хяналт, үнэлгээ, шинжилгээ, мэдээллийн технологийн хэлтэс/-аар хянуулдгаас шийдвэр гаргах хугацаа удааширч байна.
- Тусгай зөвшөөрлийг сунгах, цуцлах үйл явцад эрх бүхий магадлан итгэмжлэлийн ажлын хэсэг ажилладаг боловч хяналтын хуудсын тодорхой бус байдал нь эрсдэл үүсгэж байна.
- Нэг тусгай зөвшөөрлийг долоон ангилал болгон хувааснаар аж ахуйн нэгж (ААН), төрийн бус байгууллагууд (ТББ) тус бүрт тавигдах шаардлагыг хангахын тулд нэмэлт хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн шаардлага хангах хэрэгтэй болдог.
- ААН-ээс ирүүлсэн материал дутуу, шаардлага хангахгүй тохиолдолд тухайн орон нутгаас хянан магадлагааны хуудас ирүүлэх, дүгнэлт буруу гаргах асуудал байна.
- Зөвшөөрлийн тухай хуулинд заасанчлан зөвшөөрөл ирүүлснээс хойш хоёр хоногийн дотор хянан магадлагааг эхлүүлэх ёстой боловч хариуцсан мэргэжилтний ажлын ачаалал, дотоод зохион байгуулалтын улмаас энэ хугацаанд амжихгүй байх тохиолдол гарч байна.
- Нэг албан хаагч долоон төрлийн тусгай зөвшөөрлийг хариуцахаас гадна бусад чиг үүргийнхээ ажлыг гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, зөвшөөрөл олгох хугацааг удаашруулж байна.

3. Салбар хоорондын уялдаа холбооны асуудал


- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үзүүлж гэрчилгээг авахад **Татварын** хэлтэс болон ААН тоон гарын үсэг авах процессын талаар хангалттай мэдээлэлгүйгээс болж цаг алдах, ойлгомжгүй байдал үүсэх асуудал гарч байна.

2.4.3. Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Байгаль орчны салбарын үйл ажиллагаан дахь эрсдэлийн үнэлгээ

Судалгаагаар нийт **905** асуудал бүртгэгдсэн. Бүртгэлийг эх сурвалжаар нь ангилж үзвэл 55.4 хувь нь ААН-тэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, 17.9 хувь нь процесс зураглал, 14.6 хувь нь баримт бичиг, 6.1 хувь нь ганцаарчилсан ярилцлага, 4.5 хувь нь Төрийн албан хаагчтай хийсэн фокус бүлгийн ярилцлага, 1.5 хувь нь Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас бүртгэсэн байна.

Зураг 102. Дата эх сурвалж



Асуудлын ангиллын “дотоод” гэдэгт тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авч, шийдвэр гаргаж хэрэгжүүлж болохуйц бол, “гадаад” гэдэгт тухайн байгууллагаас хамааралгүй, шийдвэр, үйл ажиллагааг дээд шатны болон, бусад салбарын, хувийн хэвшлийн байгууллага дангаараа, эсхүл хамтран гаргаж, хэрэгжүүлдэг, тухайн нэгж, албан тушаалтан дангаараа арга хэмжээ авах боломжгүй байх нөхцөлийг ойлгоно. (Хүснэгт 41)

Хүснэгт 51. Асуудлын ангилал

№	Дотоод (Internal) ³⁷	Гадаад (External) ³⁸
1	Байгууллагын дотоод дүрэм, журмаас үүдэлтэй	Хууль тогтоомжоос үүдэлтэй
2	Ажиллах орчин, нөхцөлөөс үүдэлтэй	Салбарын дүрэм, журмаас үүдэлтэй
3	Байгууллага, нэгжийн удирдлагын арга барилтай холбоотой	Ажиллах гадаад орчин, нөхцөлөөс үүдэлтэй
4	Санхүү, иргэн, ААН-д үзүүлсэн үйлчилгээний өглөг, авлагатай холбоотой	Дээд байгууллагууд, түүний удирдлагуудаас үүдэлтэй
5	Байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой	Санхүү, үйл ажиллагааны төсөв хүрэлцээгүйтэй холбоотой
6	Албан хаагчийн мэдлэг, мэдээлэл дутмагаас үүдэлтэй	Иргэн, ААН-ийн мэдлэг, мэдээлэл дутмагаас үүдэлтэй
7	Албан хаагчийн ажлын хариуцлагагүй байдлаас үүдэлтэй	Иргэн, ААН-ийн харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой
8	Албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой	Салбар хоорондын болоод бусад харилцагч байгууллагуудын программ хангамж, тоног төхөөрөмжтэй холбоотой


³⁷ “дотоод” гэдэгт тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авч, шийдвэр гаргаж хэрэгжүүлж болохуйц нөхцөлийг ойлгоно.

³⁸ “гадаад” гэдэгт тухайн байгууллагаас хамааралгүй, шийдвэр, үйл ажиллагааг дээд шатны болон, бусад салбарын, хувийн хэвшлийн байгууллага дангаараа, эсхүл хамтран гаргаж, хэрэгжүүлдэг, тухайн нэгж, албан тушаалтан дангаараа арга хэмжээ авах боломжгүй байх нөхцөлийг ойлгоно

9	Байгууллагын программ хангамж, тоног төхөөрөмжтэй холбоотой	ААН-д тулгамдаж буй хүндрэл бэрхшээл
10	ААН-д тулгамдаж буй хүндрэл бэрхшээл	
11	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой	

Дээрх асуудлын ангиллаас хамаарч бүртгэсэн асуудлыг нийт 29 хэсэгт ангилан бүртгэсэн. Бүртгэсэн 905 асуудлаас хамгийн их давтагдсан 15 асуудлын хамгийн их буюу 18.8 хувь нь байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой (дотоод), 9.2 хувь нь салбарын дүрэм, журмаас үүдэлтэй (гадна), 8.5 хувь нь ААН-д тулгамдаж буй хүндрэл бэрхшээл (гадаад), 8.3 хувь нь хууль тогтоомжоос үүдэлтэй асуудал хамгийн их бүртгэгдсэн байна.

Зураг 103. Бүртгэсэн асуудлын төрөл



Ярилцлагын явцад нийт 611 асуудал бүртгэсэн бөгөөд нийт асуудлын 81.9 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, 9 хувийг ганцаарчилсан ярилцлага, 2.3 хувийг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн төлөөлөлтэй хийсэн ярилцлага, 6.7 хувийг Төрийн албан хаагчийн фокус бүлгийн ярилцлагаас тус тус бүртгэсэн байна.



Ярилцлага судалгаанд хамрагдсан ТАХ:

Ойн зохион байгуулалтын судалгааг 10 жил тутамд хийх ёстой гэж хуульчилсан байдаг ч 12-13 жил болж хийгддэг. Тус судалгаа болон ойн зохион байгуулалтын төлөвлөгөө гараагүйгээс үүдэн мод бэлтгэх санал хуучин судалгаан дээр үндэслэж, бодит бус төлөвлөгөө гарах магадлал өндөр байдаг.

Албан хаагчид хувийн имэйл хаягаараа албаны бичиг баримтаа солилцдог. Нэгдсэн дундын мэдээллийн сан байхгүй. Мэдээлэл алдагдах, нууцлал хамгаалагдаагүй.



Ярилцлага
судалгаанд
хамрагдсан
ТАХ:

Сумын *Засаг даргын Тамгын* газарт ажиллаж байгаа Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч 2 өөр газраас томилогдож байна. Байгаль хамгаалагч байгаль орчны газраас томилогддог. Гэтэл байгаль орчны хяналтын улсын байцаагч сумын засаг даргын тамгын газраасаа томилогддог. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн чиг үүрэг нь хяналт болон байгаль орчны бодлогоо барьдаг. Харин байгаль хамгаалагч бол хэрэгжилтийг хариуцах ёстой гэтэл ажлын байрны тодорхойлолт яг ижилхэн байгаа.



Ярилцлага
судалгаанд
хамрагдсан
ТАХ:

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх- Журам шинэчлэгдээд тавигдах шаардлага өндөр болсон. Зах зээлд давамгайл эрхтэй компаниуд дандаа шалгарч байна. Бусад ААН-үүдийг боож байна. Тендерийг өмнө хэсэгчилж зарладаг байсан бол одоо бүх үйл ажиллагааг багцалж нэг зарлаж байна. Тухайн багцалж зарласан тендерийн шаардлагыг хангах ААН цөөхөн байдаг. Барагтаа тэнцдэггүй.

Ойн зохион байгуулалтын судалгааг 10 жил тутамд хийх ёстой гэж хуульчилсан байдаг ч 12-13 жил болж хийгддэг. Тус судалгаа болон ойн зохион байгуулалтын төлөвлөгөө гараагүйгээс үүдэн мод бэлтгэх санал хуучин судалгаан дээр үндэслэж, бодит бус төлөвлөгөө гарах магадлал өндөр байдаг.

Баримт бичгийн хүрээнд нийт 132 асуудал бүртгэгдсэн бөгөөд 72.7 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 9.1 хувь нь Булган аймгийн Байгаль орчны газар, 18.2 хувь нь Ойн газрын баримт бичгээс тус тус бүртгэсэн байна.

Процесс зураглалаас нийт 162 асуудал бүртгэсний 86.4 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 13.6 хувь нь Ойн газрын процесстой хамааралтай асуудлууд бүртгэгдсэн байна.

Эрсдэлийн ангиллын хувьд үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл 56.2 хувь, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл 19.5 хувь, төсөв санхүүгийн эрсдэл 12.2 хувь, бодлогын буюу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц эрсдэл 9.9 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд Эрсдэлийн дэд ангиллын хувьд төсөв, санхүүжилтийн эрсдэл, байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой, салбарын дүрэм, журмаас үүдэлтэй, салбарын болоод салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохион байгуулалттай холбоотой эрсдэлүүд 24.2-72.8 хувийг эзэлж байна.

Дээрх дүнгээс харахад гүйцэтгэл, зохион байгуулалтын үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж тухайн эрсдэлүүдийн үр нөлөөллийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авах, эдгээр эрсдэлүүдийн нөлөөлөл өөрчлөгдсөн эсэхийг тогтмол хянах шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой болон зөвшөөрөл олгох процесстой холбоотой бүртгэгдсэн эрсдэлийг авч үзвэл **байгууллагын үйл ажиллагаатай холбоотой** эрсдэл хамгийн их буюу нийт эрсдэлийн 22 хувийг эзэлж байна. Иймээс тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, зохион байгуулалтад анхаарлаа хандуулж эрсдэлүүдийн үр нөлөөллийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авах, эдгээр эрсдэлүүдийн нөлөөлөл өөрчлөгдсөн эсэхийг тогтмол хянах шаардлагатай.

Тусгай зөвшөөрлийн хувьд хамгийн олон эрсдэл бүртгэгдсэн нь Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, Озон задалдаг дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох худалдах, ашиглах, Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, Ургамлыг гадаад улсад гаргах, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл байна.


Эрсдэлийн удирдлагын үнэлгээний цахим судалгаа

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдсэн эсэх, салбарын төрийн албан хаагчдад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цаг уур, орчны шинжилгээний газар, Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, мөн Цаг уур, орчны шинжилгээний төв зэрэг байгууллагын 930 албан хаагчдаас эрсдэлийн удирдлагын цахим судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын хүйсийн харьцааг харвал 57.2 хувь нь эрэгтэй, 42.8 хувь нь эмэгтэй байна.

Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын байгууллагын хувьд цаг уур, орчны шинжилгээний газар 25.8 хувь, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 17.4 хувь, Аймаг, нийслэлийн байгаль орчны газар 16.8 хувь, Аймаг, нийслэлийн цаг уур, орчны шинжилгээний төв 13.2 хувь, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 11.3 хувь тус тус хамрагдсан байна.

Та эрсдэлийн удирдлагын талаар ямар хэмжээнд мэдэх вэ? асуултын хүрээнд судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 2.3 хувь нь маш их, 8.5 хувь нь их, 51.6 хувь нь дунд, 20 хувь нь бага, 7.0 хувь нь маш бага, 10.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 104. Албан хаагч эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг




Танай байгууллагаас сүүлийн 4 жилийн хугацаанд эрсдэлийн удирдлагатай холбоотой сургалт зохион байгуулж байсан уу? гэсэн асуултын хүрээнд судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 19.8 хувь нь тийм, 47.4 хувь нь үгүй, 32.8 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 105. Сургалт зохион байгуулж байсан эсэх




Эрсдэлийн удирдлагын талаар мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлоход судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 54.4 хувь нь сургалтын хэрэгцээ их байна гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 106. Сургалтын хэрэгцээ байгаа эсэх




Байгууллагад эрсдэлд хяналт тавих чиг үүрэг бүхий нэгж, албан тушаалтан (Дотоод аудит, Хяналт шалгалтын нэгжийг хамаарахгүй) байгаа эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 33.4 хувь нь байхгүй гэсэн бол 29.7 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 107. Хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтан, хэлтэс байдаг эсэх




Байгууллага эрсдэлээ удирдах дараах үе шатыг ямар шатанд хэрэгжүүлж байна гэдэг асуултад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 19.7 хувь нь эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, 17.2 хувь нь эрсдэлээ тодорхойлох, 17.2 хувь нь мониторинг, сайжруулалт, 11.6 хувь нь эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, 5.8 хувь нь эрсдэлийг хэмжих, 28.5 хувь нь аль нь ч хийгддэггүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 108. Байгууллага нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авдаг эсэх



Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлд өртөг түвшинг судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдаар тодорхойлуулахад 43.0 хувь нь их, 48.4 хувь нь дундаас доош, 7.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 109. Гүйцэтгэж буй чиг үүрэг эрсдэлд өртөх магадлал хэр байдаг эсэх



Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын хэрэгцээг тодорхойлуулахад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 52.0 хувь нь ихээс дээш, 26.7 хувь нь дунд, 4.5 хувь нь бага, 2.0 хувь нь маш бага, 14.7 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 110. Ажиллаж буй байгууллагад эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалт байх шаардлагатай эсэх



Албан хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхэд хамгийн их учирч байсан эрсдэлийг тодорхойлуулахад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 15.5 хувь нь техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой, 12.0 хувь ажиллах орчноос үүдэлтэй, 10.7 хувь хууль тогтоомжоос үүдэлтэй гэсэн хариулт хамгийн их байна.

Зураг 111. Чиг үүргээ хэрэгжүүлэхэд ямар эрсдэл учирч байгаа вэ?



Албан хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл магадлалаар эрэмбэлүүлэхэд судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 14.8 хувь техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой, 13.5 хувь ажиллах орчноос үүдэлтэй, 10.4 хувь удирдлагын арга барилтай холбоотой гэсэн хариулт тус тус хамгийн өндөр байна.

Зураг 112. Учирч болох хамгийн өндөр магадлалтай эрсдэлийг тодруулсан байдал



Албан хаагчдаас өөрийн хийж гүйцэтгэж буй үйл ажиллагаанд учрах эрсдэлийн давтамжийг тодорхойлуулж үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээнээс дүгнэхэд ажиллах орчин болон техник хэрэгсэл программ хангамжтай холбоотой эрсдэл учрах магадлалтай гэсэн хариултыг ирүүлсэн байна.

Эрсдэлийн удирдлагын үнэлгээний цахим судалгааны үр дүнгээс харахад төрийн байгууллагуудын албан хаагчид эрсдэлийн удирдлагын талаар хангалттай ойлголтгүй байгаа нь харагдаж байна. Судалгаанд оролцогчдын ердөө 2.3% нь эрсдэлийн удирдлагын талаар "маш их" мэдлэгтэй гэж хариулсан нь уг чиглэлээр байгууллагуудад мэдлэг олгох, сургалт зохион байгуулах шаардлагатайг илтгэж байна.

Хүснэгт 52. Учрах эрсдэлийн давтамж

№	Эрсдэлийн төрөл	Өдөр тутам	Сар тутам	Улирал тутам	Хагас жил тутам	Жил тутам болон түүнээс дээш	Байхгүй
1	Хууль тогтоомжоос үүдэлтэй	16.1%	12.3%	18.5%	9.9%	17.7%	25.5%
2	Удирдлагын арга барилтай холбоотой	17.5%	14.7%	14.9%	8.8%	12.0%	31.9%
3	Ажиллах орчноос үүдэлтэй	26.9%	12.0%	15.4%	9.0%	12.2%	24.5%
4	Техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой	25.9%	16.1%	15.6%	9.6%	14.6%	18.2%
5	Хамтран ажиллагчаас үүдэлтэй	20.6%	13.5%	17.3%	9.0%	11.2%	28.3%
6	Үйл ажиллагааны зохион байгуулалт буюу процесстой холбоотой	16.3%	16.1%	17.6%	11.0%	13.1%	25.8%
7	Санхүүтэй холбоотой	12.4%	19.2%	18.5%	11.3%	13.7%	24.9%
8	Иргэн, ААН-ийн мэдлэг, мэдээлэл дутмагаас үүдэлтэй	19.0%	16.8%	17.4%	10.8%	12.0%	24.0%
9	Дадлага, туршлагаас үүдэлтэй	17.1%	12.3%	19.1%	10.1%	13.5%	27.8%

Албан хаагчдаас өөрийн хийж гүйцэтгэж буй үйл ажиллагаанд учрах эрсдэлийн нөлөөллийг тодорхойлуулж үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээнээс дүгнэхэд техник хэрэгсэл программ хангамжтай холбоотой эрсдэл учрах магадлалтай гэсэн хариултыг хамгийн их ирүүлсэн байна.


Хүснэгт 53. Учрах эрсдэлийн нөлөөлөл

№	Эрсдэлийн төрөл	Нөлөөгүй	1	2	3	4	5
1	Хууль тогтоомжоос үүдэлтэй	20.3%	22.0%	15.8%	18.4%	10.6%	12.8%
2	Удирдлагын арга барилтай холбоотой	21.6%	22.2%	15.4%	16.7%	11.0%	13.2%
3	Ажиллах орчноос үүдэлтэй	17.4%	21.0%	16.6%	19.7%	11.1%	14.3%
4	Техник хэрэгсэл, программ хангамжтай холбоотой	14.0%	18.4%	18.6%	19.2%	13.3%	16.5%
5	Хамтран ажиллагчаас үүдэлтэй	19.0%	21.0%	19.8%	20.1%	10.0%	10.1%
6	Үйл ажиллагааны зохион байгуулалт буюу процесстой холбоотой	17.5%	21.3%	18.9%	19.7%	12.2%	10.4%
7	Санхүүтэй холбоотой	19.9%	17.5%	18.7%	19.1%	12.4%	12.4%
8	Иргэн, ААН-ийн мэдлэг, мэдээлэл дутмагаас үүдэлтэй	18.8%	19.0%	21.0%	18.9%	11.8%	10.4%
9	Дадлага, туршлагаас үүдэлтэй	22.8%	21.0%	20.0%	17.3%	10.1%	8.8%

Эрсдэлийн ангиллыг гадаад, дотоод гэсэн 2 үндсэн хэсэг болон хүний нөөцтэй холбоотой, тусгай зөвшөөрөл авах, сунгуулах процесстой холбоотойгоор бүртгэгдсэн эрсдэлүүдэд тулгуурлан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын онцлогийг харгалзан дараах ангиллуудыг тодорхойлсон болно.

Эрсдэлийн ангиллын хувьд үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл 56.2 хувь буюу хамгийн өндөр бүртгэгдсэн байгаагаас үзэхэд тусгай зөвшөөрлийн процесс иргэн, ААН болон албан хаагчдад хүндрэлтэй байгаа ч үүнээс илүүтэйгээр тухайн байгууллага үйл ажиллагаа, зохион байгуулалтаас хамаарсан эрсдэл өндөр байна.

Зураг 113. Эрсдэлийн ангилал



Эрсдэлийн дэд ангиллын хувьд төсөв, санхүүжилтийн эрсдэл, байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой, салбарын дүрэм, журмаас үүдэлтэй, Салбарын болоод салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохион байгуулалттай холбоотой болон байгаль орчны эрсдэлүүд бусад ангилалтай харьцуулахад өндөр бүртгэгдсэн байна.


Хүснэгт 54. Эрсдэлийн дэд ангилал

Ангилал	Дэд ангилал	Нийт эрсдэл	Эзлэх хувь
Төсөв санхүүгийн эрсдэл	Төсөв, санхүүжилтийн эрсдэл	41	5.0%
	Нягтлан бодох бүртгэл, тайлагналын эрсдэл	34	4.2%
	Төсөв хөрөнгийн ашиглалт, шамшигдуулалд	25	3.1%
Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой (дотоод)	111	13.6%
	Төлөвлөгөөт ажлууд тасалдах эрсдэл	91	11.1%
	Байгууллагын нэр хүнд унах эрсдэл	57	7.0%
	Ашиглалт, шамшигдуулах болон авлигын эрсдэл	43	5.3%

	Мэдээллийн технологийн эрсдэл (Программ хангамж сайжруулах, бусад)	41	5.0%
	Хүний нөөцийн эрсдэл	37	4.5%
	Байгууллага, нэгжийн удирдлагын арга барилтай холбоотой (дотоод)	17	2.1%
	Албан хаагчийн мэдлэг, мэдээлэл дутмагаас үүдэлтэй (дотоод)	16	2.0%
	Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэнд, ажиллах орчны эрсдэл	13	1.6%
	Албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой (дотоод)	13	1.6%
	Цахим мэдээллийн сангийн аюулгүй байдалд учрах эрсдэл	9	1.1%
	Баримт бичиг, судалгаа, тооцоо, төслийн нууцлал алдагдах эрсдэл	7	0.9%
	Дэд бүтэц, холбоо, харилцаа, цахим сүлжээ, шуудан, хангалтын эрсдэл	4	0.5%
Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Салбарын дүрэм, журмаас үүдэлтэй (гадна)	79	9.7%
	Хууль тогтоомжоос үүдэлтэй (гадна)	71	8.7%
	Байгууллагын дотоод дүрэм, журмаас үүдэлтэй (дотоод)	9	1.1%
Бодлогын буюу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц эрсдэл	Салбарын болоод салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохион байгуулалттай холбоотой	59	7.2%
	Байгаль орчны бодлого, зорилтуудад учрах эрсдэл.	19	2.3%
	Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын бодлого, зорилтуудад учрах эрсдэл	2	0.2%
	Төсөл, Зээл, тусламжийн бодлого, зорилтуудад учрах эрсдэл.	1	0.1%
Бусад	Байгаль орчин	17	2.1%
	Авлига ашиг сонирхлын эрсдэл	1	0.1%

Тодорхойлсон нийт эрсдэлийг давтамж болон нөлөөллийн хамаарлаар үнэлэхэд эрсдэлийн түвшин бага 35.1 хувь, дунд 56.7 хувь, өндөр 7.1 хувь, аюултай 1.1 хувь тус тус байна. Үүнээс үзэхэд байгаль орчны салбарын эрсдэлийн удирдлага дунд түвшинд байна.

Зураг 114. Эрсдэлийн түвшин



БОУАӨЯ болон Ойн газрын процесс/тусгай зөвшөөрөлд бүртгэгдсэн эрсдэлийг түвшнээр авч үзвэл байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой процессууд дээр хамгийн их эрсдэл бүртгэгдсэн бөгөөд түвшний хувьд аюултай 2, бага 65, дунд 108, өндөр 11 тус тус байна.

Хүснэгт 55. Процесс/тусгай зөвшөөрөлд бүртгэгдсэн эрсдэлийн түвшин

№	Процесс/тусгай зөвшөөрөл	Нийт	Аюултай	Бага	Дунд	Өндөр
НИЙТ		817	9	287	463	58
1	Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой	186	2	65	108	11
2	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх	88	-	15	69	4
3	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх	82	-	3	72	7

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

4	Озон задалдаг дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох худалдах, ашиглах.	50	1	18	28	3
5	Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	42	-	17	24	1
6	Ургамлыг гадаад улсад гаргах	38	-	16	18	4
7	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах	37	-	9	28	-
8	Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	37	3	25	9	-
9	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл	30	-	10	16	4
10	Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээ ажил явуулах	30	1	13	11	5
11	Мод бэлтгэх эрхийн бичиг	24	1	15	6	2
12	ҮАЧ- Ойн дагалт баялгийг ашиглах	24	-	15	9	-
13	Амьтантай холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч	23	-	10	12	1
14	ҮАЧ-Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх	23	-	16	7	-
15	А.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	18	1	4	7	6
16	Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	16	-	6	10	-
17	Ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	11	-	3	5	3
18	Б.Агнуурын амьтныг ахуйн зориулалтаар агнах барих	8	-	3	4	1
19	ҮАЧ-Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх	8	-	8	-	-
20	ҮАЧ-Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх	7	-	2	5	-
21	Иргэн спорт агнуур болон олдворын ангийн чиглэлээр	6	-	5	1	-
22	В.Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	5	-	-	2	3
23	Нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах	4	-	1	3	-
24	Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх	4	-	1	1	2
25	Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох	3	-	1	1	1
26	Дотоод хяналт шалгалт	3	-	3	-	-
27	Судалгааны сорьц дээж бүрдүүлэлтийн гэрчилгээ олгох	3	-	1	2	-
28	Ургамлыг гадаад улсад гаргах (Самар)	2	-	-	2	-
29	Б.Агнуурын амьтныг ахуйн зориулалтаар агнах барих	2	-	1	1	-
30	Амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох	1	-	-	1	-
31	ҮАЧ- Ойн дагалт баялгийг хамгаалах	1	-	-	1	-
32	ҮАЧ- Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх	1	-	1	-	-

Эрсдэлийн матриц нь төсөл, үйл ажиллагаанд тохиолдох боломжит эрсдэлийг тодорхойлох, ангилах боломжийг олгодог бөгөөд нийт бүртгэгдсэн 905 асуудлаас нийт 817 эрсдэл тодорхойлж, үнэлгээ хийсэн. Үүнээс 70.9 хувийг дундаж түвшний эрсдэл эзэлж байна. Дулааны матрицын тархалтаас харахад бага 20 хувь, өндөр 8.6 хувь, аюултай 0.4 хувийг тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн эрсдэлийг магадлал, нөлөөллөөр нарийвчилбал нөлөөлөл дунд зэрэг, ховор тохиолдох магадлалтай эрсдэлүүд хамгийн их бүртгэгдсэн байна.

Хүснэгт 56. Байгаль орчны салбарын эрсдэлийн дулааны матриц

Сөрөг эрсдэлийн матриц		Нөлөөлөл					
		1	2	3	4	5	
		Ач холбогдолгүй	Бага	Дунд зэрэг	Их хэмжээний	Аюултай	
Магадлал	5	Өндөр магадлалтай	0.6%	0.9%	1.0%	0.2%	0.2%
	4	Тодорхой	1.0%	1.8%	2.1%	0.7%	0%
	3	Магадлалтай	2.1%	13.8%	16.4%	3.2%	0.7%
	2	Ховор	0.9%	12.1%	18.2%	3.1%	0.4%

1	Маш ховор	2.2%	5.5%	9.3%	2.3%	1.2%
---	-----------	------	------	------	------	------

Дээрх судалгааны аргачлалыг ашиглан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа байгууллага Ойн газар, Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар, Сумын болон сум дундын ойн анги, Булган аймгийн Байгаль орчны газар, Ойн анги иргэн, аж ахуйн нэгжид олгож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой болон иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, албан хаагчдын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй эрсдэлүүдийг шинжилж үнэлэхэд чиглэсэн. Салбарын онцлогоос хамаарч зорилго, зорилтоо хангаж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, албан хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг тодорхойлох, бүртгэх, үнэлэх зорилгоор дараах зохион байгуулалттайгаар ажилласан. Үүнд:

- Судалгаанд хамрагдаж байгаа ААН байгууллага, албан хаагчдын асуудлыг бүртгэн шинжлэх;
- Бүртгэгдсэн асуудал буюу шалтгаан эх үүсвэрийг тодорхойлж эрсдэлийг хариуцагч нэгж болон хамаатах субъектээр гарган, төрлөөр ангилах;
- Эрсдэлийн магадлал нөлөөллийг тодорхойлон үнэлгээ хийх;
- Эрсдэлийн үнэлгээнд суурилж процессын дахин инженерчлэл хийх шаардлагатай буюу эрсдэлтэй процесс, төрийн үйлчилгээний мэдээллийг дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх санал хүргүүлэх.

Дээрх үр дүнд хүрэхийн тулд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газар, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн болон дэд процесс, Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаанд нөхцөл байдлын шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, үйл ажиллагааны эрсдэлийг болон тулгарч байгаа асуудал, үүсэх магадлалтай эрсдэлийг тодорхойлсон.

Дүгнэлт:

Бүртгэгдсэн 905 асуудлаас 817 эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийхэд эрсдэлийн түвшний хувьд аюултай түвшний эрсдэл 1.1 хувийг, өндөр түвшний эрсдэл 7.1 хувийг, дунд түвшний эрсдэл 56.7 хувийг, бага түвшний эрсдэл 35.1 хувийг тус тус эзэлж байна. Хэдийгээр нийт тодорхойлогдсон эрсдэлийн 56.7 хувь нь дундаж түвшний буюу тэсэж болохуйц эрсдэлүүд боловч тухайн эрсдэлүүдийн үр нөлөөллийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авах, эдгээр эрсдэлүүдийн нөлөөлөл өөрчлөгдсөн эсэхийг тогтмол хянах шаардлагатай байна.

Байгууллагын эрсдэлийн менежментийн тогтолцоо, үр нөлөөний байдалд хийсэн судалгааны дүнгээс харахад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна. Иймээс тухайн эрсдэл учрахаас урьдчилан сэргийлж, зайлсхийх стратеги боловсруулах, үүсгэж буй асуудлыг яаралтай шийдвэрлэх, эрсдэлээс зайлсхийх төлөвлөгөө боловсруулах, тохиолдсон даруйд бууруулах арга хэмжээг авах, үр нөлөөллийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авах. хуваарийн дагуу хяналт хийх. урт хугацаандаа нөлөөллийг хянах зэрэг үйл ажиллагаа хийгддэггүй байна.


2.4.4. Иргэн, ААНБ-ын судалгаа

Иргэн, ААНБ-ын сэтгэл ханамжийн судалгаа

Байгаль орчны салбарын үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааны QR code-ыг цахим хуудсанд байршуулж судалгаа авсан. Тус сэтгэл ханамжийн судалгаанд 34 иргэн, ААНБ хамрагдсан байна.

Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 17.6 хувь нь иргэн, 82.4 хувь нь аж ахуй нэгж байгууллага байна. Байгаль орчны чиглэлээр хамгийн сүүлд ямар байгууллагаас үйлчилгээ авсан эсэхийг нь тодруулахад 82.4 хувь нь төрийн байгууллага, 11.8 хувь нь мэргэжлийн байгууллага, 5.9 хувь нь бусад байгууллагаас үйлчилгээ авсан байна.

Зураг 115. Хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллага, төрөл, хувиар



Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 47.1 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 29.4 хувь нь Ойн газар, 11.8 хувь нь Усны газар, 35.3 хувь нь аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, 17.6 хувь нь Сум болон сум дундын ойн ангиас давхардсан тоогоор үйлчилгээ авсан байна.

Зураг 116. Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ын байгаль орчны чиглэлээр хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллага, хувиар



Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 41.2 хувь нь тусгай зөвшөөрөл авах, сунгуулах, 17.6 хувь нь энгийн зөвшөөрөл авах, сунгуулах, 11.8 хувь нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан батлуулах, 11.8 хувь нь тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах үйлчилгээ авсан байна. Өөрөөр хэлбэл үйлчилгээ авсан 5 иргэн, ААНБ-ын дөрөв (41.2 хувь) нь тусгай зөвшөөрөл авах, сунгуулах үйлчилгээ авсан байна.

Зураг 117. Хамгийн сүүлд үйлчилгээ авсан байгууллагаас авсан үйлчилгээ, хувиар



Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 41.2 хувь нь ямар нэгэн хүндрэл учирсан, 58.8 хувь нь хүндрэл гараагүй гэж хариулсан байна. Хүндрэл учирсан гэж хариулсан иргэн, ААНБ-уудын ихэнх нь хугацаандаа үйлчилгээ авч чаддаггүй, салбарын байгууллагуудын хоорондын харилцан уялдаа байхгүй, нэг бичиг баримтыг цаасаар, цахимаар, олон давтамжтай авдаг, хянан шалгах үйл ажиллагааны гомдол гаргаад түүний араас олон удаагийн шат дараалсан албан бичиг өгч гомдол санал шийдэгдэхгүй байна гэж хариулсан байна.



Цахим судалгаанд хамрагдсан иргэн:

Салбарын байгууллагуудын хоорондын харилцан уялдаа байхгүй, нэг бичиг баримтыг цаасаар, цахимаар, олон давтамжтай авдаг хэдий ч хоорондоо мэдээллээ хуваалцдаггүй. Шийдвэр гаргах хугацаа удаан байсан.

Бүрдүүлэх материал дутуу гээд буцаагдсан. Цахим дээрээ материалууд нь хадгалгадаггүй учир дахин материалаа бүрдүүлэх гэхээр хугацаатай албан тоотуудын хугацаа нь дуусчхаад дахин авах хэрэгцээ шаардлага үүсээд байгаа нь асуудал үүсгэж байна.



Цахим судалгаанд хамрагдсан иргэн:

Мод үржүүлгийн чиглэлээр зөвшөөрөл авсан. Бүрдүүлэх материал нь үнэхээр том ААНБ-уудад байдаг юмнууд шаардаад байгаа нь харамсалтай байна. Бид чинь сонирхлоороо мод үржүүлээд тэрбум модонд хувь нэмрээ оруулах гээд бас л хичээж явна шүү дээ. Хийсэн хөдөлмөрөө үнэлэх гээд зарж борлуулж ашиг олох бодолтой байдаг ч. Энэ зөвшөөрөл гэдэг нэртэй юм л саад болоод байна даа. Газрын асуудал хариуцсан хүн, БОГ-тай хамтран ажиллаж аль болох үржүүлэх талбайн хэмжээг их сайн өгөх хэрэгтэй байна. Бас газрын дуудлагын үнэ үнэхээр өндөр байна шүү. Хүнсний ногоо тарих газар 70 мянга, мод үржүүлэг 4.8 сая гэхээр юу гэсэн үг вэ? Мод ногооноос үр ашиг багатай урт хугацаанд үр өгөөж өгдөг шүү тэгтэл үнийг зөрүү ийм өндөр байгааг арилгах хэрэгтэй байна.



Цахим судалгаанд хамрагдсан иргэн:

Асуудал гарч байгаагүй. Төлөвлөгөөнөөс багасгаж ирэх тохиолдол их гардаг. Улс төрийн нөлөөлөл хөдөө орон нутагт их байна. Мод бэлтгэх дээр бол намынхаа хүмүүст их хэмжээ өгөөд байдаг. Уг нь хүчин чадлыг нь тооцож байгаад хуваарилалт хиймээр байдаг.

Хянан шалгах үйл ажиллагааны гомдол гаргаад түүний араас олон удаагийн шат дараалсан албан бичиг өгч гомдол санал шийдэгдэхгүй явсаар л байна.

Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудаас тухайн үйлчилгээг хуульд заасан хугацаандаа авч чадсан уу гэж тодруулахад 52.9 хувь нь хугацаандаа авч чадсан, 47.1 хувь нь хугацаандаа авч чадаагүй гэж хариулсан байна. Хугацаандаа авч чадаагүй иргэн, ААНБ дунджаар 69


хоногийн дотор үйлчилгээ (тухайн үйлчилгээнүүдийг ангилж харахад ихэнх нь тусгай зөвшөөрлийн үйлчилгээ байна) авсан байна.

Зураг 118. Хамгийн сүүлд авсан үйлчилгээг хуулийн хугацаанд авсан эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 21.4 хувь нь цахим хэлбэрээр, 35.7 хувь нь цаасан хэлбэрээр, 42.9 хувь нь хосолсон хэлбэрээр тухайн үйлчилгээг авсан байна. Цахим хэлбэрээр үйлчилгээ авсан иргэн, ААНБ-уудын 66.7 хувь нь, цаасан хэлбэрээр үйлчилгээ авсан иргэн, ААНБ-уудын 60.0 хувь нь, хосолсон хэлбэр үйлчилгээ авсан иргэн, ААНБ-уудын 66.7 хувь нь хугацаандаа үйлчилгээ авсан байна. Дээрх мэдээллээс харахад цаасан хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээнүүд удаашралтай байна.

Зураг 119. Төрийн байгууллагаас авсан үйлчилгээ, үйлчилгээ авсан хэлбэр, хувиар



Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-аас үйлчилгээ үзүүлсэн албан хаагчтай, тухайн авсан үйлчилгээтэй, үйлчилгээ үзүүлсэн байгууллагатай холбоотой 14 үзүүлэлтээр сэтгэл ханамжийн үнэлгээг тодорхойлсон.

Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд үйлчилгээ үзүүлсэн албан хаагчдад 35.7 хувь нь маш сайн, 25.0 хувь нь сайн, 25.0 хувь нь дунд, 8.9 хувь нь муу, 5.4 хувь нь маш муу гэж үнэлсэн байна. Үйлчилгээ авсан 10 иргэн, ААНБ тутмын зургаа (60.7 хувь) нь үйлчилгээ үзүүлсэн албан хаагчдыг сайн үнэлсэн байна.


Албан хаагчийн мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 57.1 хувь нь сайн, 28.6 хувь нь дунд, 14.3 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйтэй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 64.3 хувь нь сайн, 28.6 хувь нь дунд, 7.1 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Албан хаагч танд ойлгомжтой, тодорхой мэдээлэл өгч чадсан эсэхэд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 57.1 хувь нь сайн, 21.4 хувь нь дунд, 21.4 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Албан хаагч танд бүрэн үйлчилгээ үзүүлсэн эсэхэд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд 64.3 хувь нь сайн, 21.4 хувь нь дунд, 14.3 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Зураг 120. Үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээ, хувиар



Хүснэгт 57. Үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээ, төрөл, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Албан хаагчийн мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдал	100.0%	0.0%	14.3%	28.6%	28.6%	28.6%
Албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйтэй байдал	100.0%	7.1%	0.0%	28.6%	35.7%	28.6%

Албан хаагч танд ойлгомжтой, тодорхой мэдээлэл өгч чадсан эсэх	100.0%	7.1%	14.3%	21.4%	14.3%	42.9%
Албан хаагч танд бүрэн үйлчилгээ үзүүлсэн эсэх	100.0%	7.1%	7.1%	21.4%	21.4%	42.9%

Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд үйлчилгээтэй холбоотой ерөнхий үнэлгээнд 14.3 хувь нь маш сайн, 22.6 хувь нь сайн, 31.0 хувь нь дунд, 17.9 хувь нь муу, 14.3 хувь нь маш муу гэж үнэлсэн байна.

Бүрдүүлэх бичиг баримтын шаардлага өнөөгийн нөхцөл байдалтай уялдаж буй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 42.9 хувь нь сайн, 21.4 хувь нь дунд, 35.7 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Шат дамжлага, процесс үйл ажиллагааны талаарх мэдээллийн нээлттэй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 42.9 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 21.4 хувь нь муу гэж үнэлсэн байна.


Үйлчилгээ үзүүлэх цаг хугацааны талаарх мэдээллийн нээлттэй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 42.9 хувь нь сайн, 42.9 хувь нь дунд, 14.3 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Асуудал гарсан тохиолдолд үнэн зөв, мэдээлэл өгөх байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд 42.9 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 21.4 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Төрийн байгууллагаас шалтгаалсан асуудал гарсан үед хаана, хэнд хандах талаар мэдээллийн нээлттэй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 28.6 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 35.7 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Үйлчилгээг шуурхай авахын тулд танил талаа ашигласан байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд 28.6 хувь нь сайн, 14.3 хувь нь дунд, 57.1 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Зураг 121. Үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой үнэлгээ, хувиар



Хүснэгт 58. Үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой үнэлгээ, төрөл, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Бүрдүүлэх бичиг баримтын шаардлага өнөөгийн нөхцөл байдалтай уялдаж буй байдал	100.0%	7.1%	35.7%	21.4%	21.4%	14.3%
Шат дамжлага, процесс үйл ажиллагааны талаарх мэдээллийн нээлттэй байдал	100.0%	7.1%	14.3%	35.7%	28.6%	14.3%
Үйлчилгээ үзүүлэх цаг хугацааны талаарх мэдээллийн нээлттэй байдал	100.0%	14.3%	0.0%	42.9%	21.4%	21.4%
Асуудал гарсан тохиолдолд үнэн зөв, мэдээлэл өгөх байдал	100.0%	0.0%	21.4%	35.7%	28.6%	14.3%
Төрийн байгууллагаас шалтгаалсан асуудал гарсан үед хаана, хэнд хандах талаар мэдээллийн нээлттэй байдал	100.0%	7.1%	28.6%	35.7%	14.3%	14.3%
Үйлчилгээг шуурхай авахын тулд танил талаа ашигласан байдал	100.0%	50.0%	7.1%	14.3%	21.4%	7.1%

Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд үйлчилгээтэй холбоотой ерөнхий үнэлгээнд 14.3 хувь нь маш сайн, 22.6 хувь нь сайн, 31.0 хувь нь дунд, 17.9 хувь нь муу, 14.3 хувь нь маш муу гэж үнэлсэн байна.


Одоогийн мөрдөж буй хууль, дүрэм, журам практикт нийцэж буй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 28.6 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 35.7 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Төрийн үйлчилгээний цахимжуулалтын үр дүн, ач холбогдолтой байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 21.4 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 42.9 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Байгаль орчны салбарын төрийн байгууллагуудын уялдаатай ажиллаж буй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 28.6 хувь нь сайн, 28.6 хувь нь дунд, 42.9 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Байгууллага, албан хаагчийн асуудал шийдвэрлэж буй байдалд судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-ууд 28.6 хувь нь сайн, 28.6 хувь нь дунд, 42.9 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Зураг 122. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагатай холбоотой үнэлгээ, хувиар



Хүснэгт 59. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагад өгсөн үнэлгээ, төрөл, хувиар

Үзүүлэлт	Нийт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Одоогийн мөрдөж буй хууль, дүрэм, журам практикт нийцэж буй байдал	100.0%	7.1%	28.6%	35.7%	21.4%	7.1%
Төрийн үйлчилгээний цахимжуулалтын үр дүн, ач холбогдолтой байдал	100.0%	14.3%	28.6%	35.7%	14.3%	7.1%
Байгаль орчны салбарын төрийн байгууллагуудын уялдаатай ажиллаж буй байдал	100.0%	42.9%	0.0%	28.6%	21.4%	7.1%
Байгууллага, албан хаагчийн асуудал шийдвэрлэж буй байдал	100.0%	14.3%	28.6%	28.6%	21.4%	7.1%

Үйлчилгээ авсан ААНБ-ын чанарын судалгааны дүгнэлт

Байгаль орчны салбарт хийгдэж буй Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд тус салбараас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 2000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагаас санамсаргүй түүврийн аргаар 300 орчим аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдон судалгааны ажлын зорилгыг танилцуулж, мэдээлэл өгснөөс фокус бүлгийн ярилцлагад 82 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон байна. Фокус бүлгийн ярилцлагыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газраас 13 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд Улаанбаатар хот, Сэлэнгэ, Булган аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын дунд зохион байгууллаа.

Мөн Байгаль орчны салбарын үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааны QR code-ыг цахим хуудсанд байршуулж үйлчилгээ авсан 34 иргэн, ААНБ-аас судалгааг авсан.

Хүснэгт 60. Тусгай зөвшөөрлийн төрөл, хамрагдсан аж ахуйн нэгж

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо
1.	Амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох	10
2.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага	8
3.	Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах	6
4.	Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	3
5.	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах	9
6.	Ургамлыг гадаад улсад гаргах	1

7.	Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	4
8.	Үнэлгээний үйлчилгээ авсан байгууллага	2
9.	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах	5
10.	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх	5
11.	Мод үржүүлэг, ойжуулалт, нөхөн сэргээлт	
12.	Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа	29
13.	Ойн дагалт баялгийг ашиглах	
НИЙТ		82

Ойтой холбоотой тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага

Ойн газраас ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны дараах чиглэлийн хүрээнд тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагаас фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- ✓ Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх;
- ✓ Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх;
- ✓ Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;
- ✓ Ойн дагалт баялгийг хамгаалах;
- ✓ Ойн дагалт баялгийг ашиглах;
- ✓ Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх;
- ✓ Ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах.

Фокус бүлгийн ярилцлагын хүрээг тусгай зөвшөөрөл авахтай холбоотой мэдээ, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдэл, цахимжилт, түүний үр нөлөө, үйл ажиллагааны шат дамжлага, үйлчилгээ авахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирол, хяналт шалгалтын үйл ажиллагаа, төрийн байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдал, гарч буй хүндрэл бэрхшээл болон түүнийг сайжруулах санал зэргийг тодорхойлсон.

Мөн Ойн газраас ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хамгийн их нь 5 болон түүнээс бага тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага бүлгийн ярилцлагад оролцсон байна.

Судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд бүлгийн ярилцлагаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний үйл ажиллагаа, хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар аж ахуйн нэгж, байгууллагаас тодруулга авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд нэг тэрбум мод тарьж, арчлан хамгаалж, ургуулж, ойн санг 9 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, хүлэмжийн хийн шингээлт болон усны нөөцийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэхийг зорьж байна. Мөн мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын тоо мэдэгдэхүйц өсөлттэй байна. Энэхүү хөдөлгөөн нь Монгол орны байгаль орчны нөхцөлийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа юм.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Бүлгийн ярилцлагад оролцсон аж ахуйн нэгж, байгууллагууд тусгай зөвшөөрөл авах, сунгуулахтай холбоотой мэдээ, мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын сайтаас авдаг байна. Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, сунгуулах асуудлаар лавлах зүйл гарсан тохиолдолд аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтэнтэй холбогдон нэмэлт тодруулга авдаг байна. Бүлгийн ярилцлагад оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь үйл ажиллагаа

жигдэрсэн тул сунгуулах хүсэлтээ цахимаар гаргаж шийдвэрлүүлсэн, хүндрэл учраагүй гэсэн байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ойн чиглэлийн үржиж, төлжих бүхий л үйл ажиллагаа ордог. Ой зохион байгуулалт, хортон шавжаас бусад тусгай зөвшөөрөлтэй буюу 5 төрлийн тусгай зөвшөөрөлтэй. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн мэдээллийг ойн гарын авлага, ойн газрын цахим хуудас болон ойн газрын холбогдох мэргэжилтнүүдээс мэдээлэл авсан. Тусгай зөвшөөрлийн гол эх үүсвэр нь нийслэлээс гардаг. Нийслэлд батлагдсан тусгай зөвшөөрөл Ойн газарт очдог. Ойлгомжтой байсан.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээ, мэдээлэл нь яам, агентлагийн сайтад нээлттэй байдаг тул аж ахуйн нэгжид хүндрэл учирдаггүй мөн процесс үйл ажиллагаа нь ижил байдаг гэсэн бол бүрдүүлэх бичиг баримтын нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотойгоор ажилчдад хүндрэл учирдаг гэж бүлгийн ярилцлагад оролцогчид дурдсан байна. Энэ нь улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотойгоор тогтмол орлогогүй нь нөлөөлдөг гэсэн байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Мод бэлтгэл, ойд арчилгаа, цэвэрлэгээ, ойн огтлол, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр тусгай зөвшөөрлийг авсан. Ойн нөхөн сэргээх гэсэн 2 тусгай зөвшөөрөлтэй. Анх 10 жилийн хугацаагаар авсан ч дууссан. Сүүлд 2024 онд сунгуулж 5 жилээр авсан. Ойлгомжтой байдаг. Хянан магадалгааны хуудасны дагуу бүрдүүлбэрийг бүрдүүлж өгдөг. Нийгмийн даатгалын шимтгэл дээр асуудал гардаг. Туслах ажилтнууд нийгмийн даатгал төлөх хүсэлгүй байдаг. Тогтмол ажил биш улирлын чанартай тул



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойн арчилгаа цэвэрлэгээний чиглэлээр тусгай зөвшөөрлийг 2016 онд анх авсан. Бүрдүүлэх баримт бичгийг сумын засаг дарга, аймгийн байгаль орчны газар, аймгийн засаг дарга, БОУАӨЯ-д уламжлаад цаасаар тусгай зөвшөөрлийг хурдан авсан. Үйлдвэрлэлийн огтлолыг 2019 онд хүссэн боловч эргэн хариу хэлээгүй. Тэгээд саяхан очиж асуусан чинь архивт орсон гэх шалтгаанаар дахин бүрдүүлэх шаардлагатай болсон тул орхисон.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойн ангиас мэдээлэл аваад материалаа бүрдүүлээд өгдөг. Үндсэн ашиглалт, ойжуулалтын чиглэлээр тусгай зөвшөөрөл авах гээд Ойн газарт цахимаар хүргүүлсэн. /Ойн анги, БОГ-аас бол баримт бичиг авдаг/ Зун 7-р сард материалаа явуулсан. Тэгээд нэлээд хэд материал бүрдүүлэх дутуу байгаад сая 9 сард хэлээд дахин бүрдүүлж өгсөн. Хяналтын шатанд гэсэн төлөвтэй байгаа. 2019 онд арчилгаа цэвэрлэгээг бол авсан байгаа. Анх авахдаа Ойн ангиас бичиг баримтын бүрдэл дээр зөвлөгөө авдаг.

Мөн тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой бүрдүүлж буй материалууд нь ижил байдаг тул нэг удаа материалаа өгөөд цаашид нэмэлт болон өөрчлөлт орсон тохиолдолд мэдээллээ шинэчилж өгдөг байх нь зүйтэй талаар оролцогчид үзэж байсан.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлтийг 2021 оноос эхлэн цахимаар буюу e-mongolia, e-business.mn, ies.mn зэрэг сайтаар дамжуулан гаргадаг болсноор аж ахуй эрхлэгчдийн цаг хугацааг ихээхэн хэмнэж байгааг дурдсан бөгөөд нийт ярилцлагад оролцогчдын дийлэнх нь сэтгэл хангалуун байсан. Харин цахимаар хүсэлтээ өгөхөөс гадна цаасаар давхар өгч байгаа нь хүндрэл учруулдаг гэсэн байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг ойн газарт цахим хэлбэрээр, нийслэлд цаасан хэлбэрээр өгсөн.

2021 онд холбогдох материалаа бүрдүүлээд албан бичгээ бүрдүүлээд ойн ангид өгсөн. Мод үржүүлгийн гэрчилгээний хугацаагаар сунгуулахаар одоо өгөх гэж байна. Энд эхлээд албан бичиг бэлдэнэ. Одоо бол аймгаас албан бичиг аваад цахимаар илгээж болох юм байна, бас хаягаар нь цаасаар ч аваачиж өгч болно гэсэн.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Цахимжсан гээд байгаа гэхдээ бид нараас цаасаар нэхдэг бүрдүүлбэрүүд байсаар л байгаа. Бараг цахимжуулалт гэдэг нь илүү ажил болсон санагдаж байгаа. Гэхдээ сайжрах байх аа гэж найдаж байна. Төрийн захиргааны төв байгууллага, нийслэл дээр цахимаар гэдэг ч аймаг, сум дээр очихоор цаасаар л материал нэхдэг. Төрийн байгууллагууд хоорондоо уялдаа холбоотой ажиллаж, төрд байгаа иргэний мэдээллийг ахин дахин иргэнээс нэхмээргүй байна. Үүнээс шалтгаалж эдийн засаг, цаг хугацааны хувьд маш их асуудал гардаг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойн газар дээр очиж бүрдүүлэх материалаа аваад Байгаль орчны газарт бүх материалаа бүрдүүлж өгөөд, Байгаль орчны газраас Байгаль орчны яам руу хүргүүлдэг. Түүнийхээ дараа нь зөвшөөрлөө яамнаас өөрийн биеэр очиж авч байсан. Анх цахим биш байхад арай хялбар байсан. Бүрдүүлбэрийг цаасаар бүрдүүлээд явахад асуудал арай бага байдаг.

Бүрдүүлэх материал дунд ААН-д камер байгааг нотлох бичиг баримтыг цагдаагийн газраас авахыг шаарддаг. Хүсэлт явуулдаг ч ЦЕГ-аас энэ бичиг цахимаар ирдэггүй.

Цахимаар хүсэлтээ гаргахад материалын бүрдэл бүрэн тохиолдолд ямар нэгэн хүндрэлгүйгээр шийдэгддэг гэсэн бол материал дутуу тохиолдолд хуулийн хүрээнд хүлээлгийн хугацаа дахин сунгагдаж, хяналтын шатанд гэсэн төлөвт шилжсэнээр дахин хуулийн хугацаагаар шийдэгдэж байгаа нь хүндрэл учруулдаг байна. Энэ нь зөвхөн шинээр нэмэлт материал нягталж буй тохиолдолд заавал хуулийн хугацаагаар удаан хүлээлгэлгүйгээр шийдвэрлэж байх нь зүйтэйг дурдаж байсан.

Цахимжилт үр дүнгээ өгч, шат дамжлага багассан ч цахим системийн хөгжүүлэлт хийхтэй холбоотойгоор гэнэтийн шинэчлэлт, өөрчлөлтийг урьдчилан мэдэгддэггүй, мөн тайлан, тодорхойлолт зэрэг нь цахимд ороогүйгээс үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг гэсэн байна. Учир нь цахимжуулалт хэлбэрээр цаасан баримтыг скайнердаж оруулдаг, мөн давхар цаасаар материалаа хүргэж өгдөг зэрэг асуудлууд нь байсаар байгааг дурджээ.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Цахим болсноос илүү биеэрээ материалаа аваачиж өгөх нь зүйтэй байна. Цахимд бас бүрэн итгэхгүй байгаа, гараараа бичиж, тамга дарсан албан бичиг л хүчинтэй байна гэж боддог. Иргэн, ААН-үүдээс өөрсдөөс нь шалтгаалан хугацаа хоцроох асуудал байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Үйл ажиллагааны шат дамжлагын хувьд Ойн газар байгуулагдахаас өмнө Байгаль орчны яамаар дамждаг, сайдын тушаал хүлээдэг, цаасаар аваачиж өгдөг, орон нутгийн Засаг дарга, Байгаль орчны газраас бичиг авдаг зэрэг хүндрэлүүд байсан. Харин Ойн газар байгуулагдсанаар олон шат дамжлага цөөрсөн гэж үзэж байсан. Мөн 2021 оноос цахимаар хүсэлт авдаг болсонтой холбоотойгоор олон байгууллагад материал өгдөг шат дамжлага цөөрсөн байна.

Цахимаар хүсэлтээ өгч цаг хугацааг хэмнэж байгаа ч тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад шаардлагатай материалыг бүрдүүлэхэд олон төрийн байгууллагаас тодорхойлолт авдаг, мөн тодорхойлолт авахтай холбоотой цаг хугацаа, зардал гардаг асуудал хэвээр байгааг дурдсан.

Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авч байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцахгүйгээр зөвхөн цаасан материалын бүрдлээр тусгай зөвшөөрөл олгож байгаа нь учир дутагдалтай. Шалгуур дээр мэргэжлийн хүн байх ёстой гээд заасан байдаг. Жишээ нь: ажилд томилсон тушаал гаргасан байх, нийгмийн даатгалын шимтгэлийг 3 сар төлсөн байх зэрэг шалгуур байдаг. Тэр нь гэхдээ зөвхөн цаасан дээрх бүрдлээр хангах боломжтой. Харин тусгай зөвшөөрөл олгож байгаа

зөвлөл, шийдвэр гаргагч нь аж ахуйн нэгжүүд мэргэжлийн хүний нөөцөө хэрхэн яаж ажлын байраар хангаж ажиллуулж байна, газар дээр нь очиж үзэж, аж ахуйн нэгжүүдийн боломж, чадамжийг тодорхойлдог байх ёстой гэсэн байна.

Мөн сүүлийн жилүүдэд БОУАӨЯ болон Ойн газраас адистатчилал, шалгалтыг зохион байгуулж, тусгай зөвшөөрлийг сунгах боломжтой, шаардлага хангасан аж ахуйн нэгжийг газар дээр нь сунгасан нь хялбар байсан талаар дурдсан байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Их хүндрэлтэй, явах асуудал ихтэй. Шууд сунгах газартайгаа харьцаж чаддаггүй. Сумаас дэмжих тодорхойлолт авна. Засаг дарга тодорхойлолт өгөхийн тулд Ойн ангиас мэдээлэл авдаг. Аймгаас дараа нь очиж тодорхойлолт авдаг.

Тусгай зөвшөөрөл сунгуулахтай холбоотой хугацаа нь таван жил байгаа нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид бага байдаг тул хугацааг нь уртасгах шаардлагатай гэж үзэж байсан.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Манайх 5 дахь удаагаа зөвшөөрлөө сунгуулж байгаа бөгөөд сүүлийн үеийн баримт бичгийн бүрдүүлбэр маш олон шат дамжлагатай байна. Одоогоор хийх ёстой ажил, цахим тоон гарын үсэг нь гацах гэх мэтчилэн асуудлуудтай. Аймгийн Байгаль орчны газраараа ороод материалын бүрдүүлбэрүүдээ өгдөг. Материал бүрдүүлэлт 2023 оноос эхлэн цахимаар авч эхэлж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирлын тухайд авч үзвэл:

Бүлгийн ярилцлагад оролцогчдын хувьд тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад хамгийн багадаа 7 хоног, хамгийн ихдээ 6 сарын хугацааг зарцуулсан талаар дурдсан. Энэ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж цаг хугацаанаас үүдэлтэй эдийн бус хохирол учруулсан гэсэн байна. Тусгай зөвшөөрөл авах болон сунгуулах асуудалд дийлэнх нь хуулийн хугацаандаа шийдэгддэг гэсэн байна.

Мөн Ойн газраас тэмдэгтийн хураамжид 10,000-28,000 төгрөг, шинээр тусгай зөвшөөрөл авах үед 300,000, сунгуулах үед 150,000 төгрөгийг тус тус тушааж байсан гэсэн байна. Энэ нь үйл ажиллагааг эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл болдоггүй гэсэн байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Сүүлийн байдлаар хэлэхэд шөнө оройн цагаар сууж 3-5 хоног суусан. Сүүлд цахимаар өгсөн бөгөөд PDF болгож явуулсан ч буцаасан байсан. Буцаасан шалтгааныг тайлбарлаж өгөөгүй. Сайн лавлаж асуусан ч мэргэжлийн биш байна гэдэг шалтгаанаар буцаасан гэсэн. Акт, гэрээ, ойжуулалтын тайланг тусад нь хийсэн боловч нэг болгож явуулах шаардлагатай байсан. Учир нь эхнийх нь л мэргэжилтэн рүү татагдсан цахимаар гэдэг шалтгаантай байсан. Тоон гарын үсэг 65000, бичгийн цаас, принтерийн хор зэрэг ойр зуур зардлууд байдаг. Хянан магадалгааг анх бэлдэхэд 14 хоногийн хугацаа зарцуулж байсан. Сунгалт хийхдээ анх бэлдсэн хуучин файл дээр засварладаг тул цаг хугацаанд асуудал үүсэхгүй байгаа.

Төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс эдийн засгийн хохирол учирч байсан ч тодорхой тооцож мөнгөн дүнг дурдаагүй байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Тооцоологдоогүй цаг хугацаанаас шалтгаалсан асуудал гардаг. Жишээ нь: Экологийн цагдаагийн албаны мэдээллээр гэж шалгаж, хуулийн хугацаа 14 хоног машин журамладаг. Үүнээс шалтгаалан бид тооцоолж чадахгүй эдийн засгийн хохиролд ордог. Дараа нь ямар нэгэн асуудал байхгүй байна гэж тайлбаргүй явуулдаг.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл:

Аж ахуй эрхэлж буй байгууллагад БОУАӨЯ, аймгийн Байгаль орчны газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, Экологийн цагдаагийн алба, мөн хөндлөнгийн хяналт шалгалтыг төрийн болон төрийн бус байгууллагууд зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой зөвлөмж чиглэл өгдөг гэсэн байна. Мөн жил бүр ямар нэг байдлаар хяналт шалгалтууд ирдэг бөгөөд зарим тохиолдолд хугацааны хувьд ойрхон давхардаж ирэх тохиолдол гардаг гэсэн байна.



Бүлгийн ярилцлагын оролцогч:

Аль хэдийн нутгийн хүмүүс түүгээд явсан байдаг. Гэтэл зөвшөөрөл өгсөн тухайн газар нутгийн иргэд байгалийг сүйтгээд, хог тариад явдаг. Дараа нь тэрхүү асуудлаас шалтгаалж сум дундын ойн анги аж ахуй нэгжүүдэд торгууль ногдуулдаг утгагүй асуудал байсаар байна. Үүнээс шалтгаалж эрхээ цуцлуулсан.



Бүлгийн ярилцлагын оролцогч:

Хяналт шалгалтын асуудал сум болон аймгаас тогтмол ирдэг. 2024 онд 3-4 удаа ирсэн. Сүүлийн жилүүдэд ихэссэн. хяналтаар ирэхээ урьдчилан мэдэгддэг. 1-100 оноогоор үнэлдэг. Бригадын асуудал болон НДШ байнга ярьдаг. Ойн газраас ирээгүй байхаа хэлж мэдэхгүй байна.

Яам, агентлагаас жил бүр, тус тусдаа асуумж бэлтгэсэн цаастай, газар дээрх нөхцөл байдлыг шалгах байдлаар хяналт хийгддэг. Төрийн байгууллагуудын зүгээс хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа төрийн албан хаагчид хууль, дүрэм, журамд заагдаагүй материал, техник хэрэгсэл шаардах, асуудалд хувийн үзэмжээр хандах, нэгдсэн удирдамж чиглэлгүй байх, мэргэжлийн бус байх зэрэг асуудлууд гардаг талаар дурдсан.

Аймгийн Байгаль орчны газар, Сумын болон сум дундын ойн анги заавар, зөвлөгөө, болон хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон үед шаардлагатай мэдээллээр хангадаг гэсэн байна.

Хяналт шалгалтын үр дүнд зөвлөмж өгөх байдал нэг ижил хэлбэр, агуулгатай байдаг талаар дурдаж байсан, харин зөвлөмжийг мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн, аж ахуйн нэгжийн



Бүлгийн ярилцлагын оролцогч:

2019 оноос өмнө ойн мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах сургалт хийгддэг байсан. Одоо тийм зүйл байхгүй, хангалтгүй.

Хууль дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдолд нийтлэг мэдээ, мэдээллээр байнга хангадаг. Гурван сум хариуцсан ойн ангийн мэргэжилтэн байдаг тухай бүрд мэдээллээр хангадаг.

үйл ажиллагааг дэмжсэн, бүтээлч байдал, инноваци, шинэ санаачилгыг бусад байгууллагад танилцуулсан зэрэг мэргэшсэн, шинэлэг ажлуудыг зохион байгуулбал дагаад аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжрах юм.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийн тухайд авч үзвэл:

Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах болон сунгуулахад ойн чиглэлийн мэргэжил эзэмшсэн, төгсөгчид багассан, улирлын чанартай үйл ажиллагаанаас хамаарч тогтмол орлогогүйгээс тогтвортой ажиллах мэргэшсэн хүний нөөцийн дутагдалд орсон, улирлын чанартай үйл ажиллагаа явагддаг тул орон нутагт ажиллах туслах ажилтнууд нийгмийн даатгал төлөх хүсэлгүй байдаг. Үйлчилгээ явуулахтай холбоотой ойлгомжгүй арга зүй шаарддаг, үйл ажиллагаа явуулахтай холбоогүй мэргэжилтний шаардлага тавигддаг, төрийн байгууллагуудын албан хаагчдын мэргэжлийн ур чадвар муу, давхардсан олон хяналт шалгалт хийгддэг, мэргэжил арга зүйгээр дэмжих байдал муу зэрэг хүндрэлүүдийг дурдсан байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Арчилгаа цэвэрлэгээ чиглэлээр учраас хүндрэл учирч байгаагүй. Гэхдээ шаардлагад байгаа дараах асуудлууд жаахан хэцүү байдаг. Трактор арчилгаа цэвэрлэгээнд нээх хэрэггүй байдаг. Бид мориор л зөөдөг. Трактор өргөн зам гаргаж явдаг. НДШ төл, хүний нөөц заачихсан учраас улирлын ажил учраас ихээхэн хүндрэлтэй байдаг. Бусдаар гайгүй, 6 сар ажиллаад 6 сар сул зогсдог учраас компани дампуурчих гээд байна.

Мөн төрийн байгууллагын үйл ажиллагаа, шат дамжлагаас шалтгаалан аж ахуйн нэгж, байгууллагын хийж буй ажлууд үр дүнгүй болох тохиолдол их гардаг гэсэн байна. Учир нь байгаль орчныг хамгаалах, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэг хийх, хортон шавжаас хамгаалах, ойд арчилгаа цэвэрлэгээ хийх зэрэг үйл ажиллагаа нь манай орны байгаль, цаг уурын өвөрмөц онцлог шинж байдлаас шалтгаалан байгалийн нөөцийн менежментийг зөв тооцох, тодорхойлох, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Шавжтай холбоотой юм хэлье. Өндөгнөөсөө хорхой гарах үед анхны шилмүүс идэх үед хор цацах ёстой юм. Гэтэл одоо хорхой навчаа идээд дууссан хойно нь цацаад байх юм. Одоогийн хор нь тийм сайн болсон юм уу мэдэхгүй байна. Дээр үед Хөвсгөл аймагт Үйлдвэр сургалтын коллеж маш олон мэргэжлийн ойжуулагч бэлдэж өгсөн, тэрний хүчээр л одоогийн хүмүүс явж байна. Монгол Улс мод л тарьж байж цөлжилтөөс сэргийлнэ.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Монголд ойн инженерийн чиглэлээр хүний нөөц маш дутмаг байдаг. Гэвч ойн мэргэжлийн байгууллагад ойн инженер байна гэж заасан байдаг. Мөн үүнийг шалгадаг Ойн ангид мэргэжлийн хүн байдаггүй. Төрийн байгууллагаас хяналт шалгалт гэж маш их дарамт ирдэг. Үүнд: ойн анги, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, аймгийн БОГ, экологийн цагдаагийн алба, БОУАӨЯ зэрэг байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой арга замын тухайд авч үзвэл:

УИХ, Засгийн газар, яам, агентлаг зэрэг төрийн байгууллагаас гаргаж буй салбарын хууль, дүрэм, журам, сайдын тушаал болон бусад захиргааны хэм хэмжээний актууд нь салбарын үйл ажиллагаа, бодит нөхцөл байдалтай нийцээгүй, хэт нэг талыг барьсан байдлаар батлагдаж байсан. Мөн батлагдсан эрх зүйн баримт бичигтэй холбоотой шийдлийг яам, агентлаг зөвхөн холбоодоор дамжуулан шийдэх гэдэг гэтэл холбоод нь хоорондоо асуудлаа хэлэлцэж ярьдаггүй, холбоодод ороогүй аж ахуйн нэгжүүд олон байдаг тул мэдээлэл тэр бүр хүрдэггүй талаар дурдаж байсан.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Бэлдмэл бодис үйлчлэхгүй байх тохиолдол гарч байсан. Өмнө нь бид газар дээрээ өөрсдөө очиж судалгаа, шинжилгээний ажлаа хийгээд явдаг байсан. Хортон шавьж нэр төрлөө тодорхойлоод, зүйлээсээ шалтгаалаад ямар хугацаанд хэрхэн ямар байдлаар устгалын ажил явуулахаа шийдээд явдаг байсан. Одоо бол тендерээр өөр аж ахуйн нэгжүүд шалгараад тэр бэлдмэлийг нь ашиглахаар шавьж устахгүй байх зэрэг асуудал үүсдэг. Урьдчилсан байдлаар 4-5 сард судалгааны баг судалгаа, шинжилгээ хийдэг. Яг тэмцэл явуулах хугацаа болохоор бид нар өөрсдөө дахиж очиж хийдэг. Шууд очоод тэмцэл явуулж болдоггүй. Хор цацаад ямар үр дүн гарав, хэр үр дүнд хүрэв гэдгийг нарийн судалдаг. Урьдчилсан судалгаа хийсэн байгууллага дахиад цуг явахгүй, бид нар бас хамт явахгүй харин тухайн газар нутгийн байгаль хамгаалагч, орон нутгийнхан хяналтаа тавиад явдаг. 4-5 сард судалгаа, шинжилгээ хийгээд явж байтал байгаль цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан яг устгалын ажил эхлэх болоход өөрчлөгдөж болно. Тэр тохиолдолд солбилцол, газрыг өөрчилдөг. Сумаараа өөрчлөгддөггүй. Солбилцол, тэмцэл хийх газар нутаг их, бага гэх зэргээр өөрчлөгдөхөд хооронд нь солих, шилжүүлэх гэх мэт шилжилт, өөрчлөлтүүд хийдэг. Шилжилт, өөрчлөлт, солбилцол солих гэх мэт зүйлсийг аймаг, орон нутгийн БОГ өөрсдөө хийдэг, ААН өөрсдөө дур мэдэж хийдэггүй. Өөр газар шилжүүлэх тохиолдолд тухайн орон нутгийн БОГ, хариуцсан мэргэжилтэн, орон нутгийн хариуцсан байцаагч зэрэг тухайн ЭДТГ-аас томилогдож, шийдвэр дүгнэлтийг тал талаасаа байлцаж гаргадаг. Итгэмжлэгдсэн лабораториудаар хороо хэмжүүлдэг. Гаднаас орж ирж байгаа тохиолдолд гаалийн лаборатори хэмждэг. Шинжлүүлсэн бичигтэй бодисыг л бид нар авч ашигладаг. Бодисыг яг ашиглалтын хугацаанд нь ашигладаг.

Иймд яам, агентлаг шийдвэр гаргахдаа мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй бүх аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас санал авдаг тогтолцоонд шилжих шаардлагатай. Мөн эрх зүйн баримт бичгийн шинэчлэл болон цахимжилттай холбоотой шинэчлэлийг хийхдээ хугацаа тулгаж мэдээлэл хүргэдэг гэсэн байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Тайланг татвар, НД, Ойн ангид жилд 2 удаа гаргаж өгдөг, Засаг даргатай гэрээ байгуулдаг, дутуу бол ИТХ-аар орж шийдэгддэг. Эрхийн бичиг /гоожин/ авч байна. Энд ямар нэг хүндрэл байхгүй. Бичүүлээд л аваад явдаг. Мод бэлтгэх арчилгаа цэвэрлэгээтэй холбоотой Менежмент төлөвлөгөөг 5 жилээр баталдаг, тэнд тавигдсан тоог л яг илүү, дутуугүй өгдөг. Энэ жагсаалтад ороход хүндрэлтэй асуудал байхгүй. Засаг даргатай хийсэн гэрээг дүгнүүлээд л асуудал байдаггүй. Арчилгаа хийж байгаа компанид ойжуулалт хийх нь дарамттай байдаг. Энийг хяналтаар ирсэн хүмүүст бол саналаа байнга хэлдэг. Сүүлийн батлагдсан журамд ойжуулалтын м2 нь багассан байсан. Энд баярлаад байгаа. Арчилгаа, ойжуулалт хийх 2 нь тусдаа байлгах саналтай байна. Гал түймэртэй тэмцэх сургалтад хамрагдсан байх гэсэн шаардлага байна: бүх ажилчид хамрагдсан байх ёстой гэдэг энэ бол чухал шаардлага, энийг дагаад ой хээрийн түймэр эрс багассан. Борлуулалт дээр алдаа гардаг, худалдан авалт байхгүй.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Мод үржүүлэг хийе гэхээр мод үржүүлгийн талбайтай бай гэнэ. Талбай авья гэхээр тусгай зөвшөөрөлтэй бай гэнэ. Сэлэнгэ аймагт хуш мод үржүүлэг 3 компани нийлээд хийсэн. Өмнө нь бид самраа 70, 30 гэж гаргадаг байсан. Өнгөрсөн жил сайд 60, 40 гэж гаргах шийдвэр гаргаснаар 70, 30-аараа гаргасан хүмүүс түүхий эд нь илүүдэлтэй, зөвшөөрөл нь хомсдолтой болчихоод байна. Иймээс бид өнгөрсөн жил бэлтгэсэн самраа одоог хүртэл экспортод гаргаж чадаагүй байна. Бизнес эхлээд бүх юм дуусах шатандаа явж байхад гэнэт шийдвэр гаргасан. Энэ асуудлаар яаман дээр бид нар зөндөө зүйл ярьсан. Яам шийдвэр гаргаж болно оо, гэхдээ тэрийгээ цагийг тулгаж биш өмнө нь хэлмээр байна. Хоорондоо уялдаа холбоогүй, гэнэтийн шийдвэрээс шалтгаалж бизнес эрхлэгч бид нар хохирол амсахаа болимоор байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Шүүмжлэлтэй талаас нь харж байна. Өмнөх журам боломжийн журам байсан чинь өнгөрсөн жил Бат-эрдэнэ сайдын гаргасан тушаалаар гарсан журам нь амьдралд нийцээгүй журам гарсан. Манайх 15 жил үйл ажиллагаа явуулж байгаа газар бид нар шаардлагатай үед шаардлагатай ажилчдаа гэрээгээр аваад ажиллуулдаг. Таван ойн инженерийн ажлын байрыг тогтмол хангах нь хэцүү байдаг ба зарим үед ажил олдоно харин зарим үед ажил олдохгүй. Тэгтэл тогтмол ажиллаж байх боломжгүй байдаг.

Ойн салбарт мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байгаа үед мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг ажлын байраар хангах, одоо байгаа мэргэжилтнүүдийг тогтмол чадавхжуулах сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Үйл ажиллагаа нь тогтмолжсон аж ахуйн нэгжээс цаашид олон баримт материал шаардахгүйгээр сунгах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Тусгай зөвшөөрөлд техник, тоног төхөөрөмж, нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн, инженерүүдийн шаардлага тавьдаг гэтэл зарим тохиолдолд эдгээр нь байгаль, цаг уур болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хүндрэлтэй байдаг. Эдгээр асуудлуудыг уян хатан, бодит нөхцөл байдалд ойртсон шаардлага тавьж байх нь зүйтэй гэж дурдсан байна.

Төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагууд хоорондоо уялдаатай ажиллах шаардлагатай мөн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллагуудад олон эрдэм шинжилгээний ажилтнууд давхардсан ижил ажил эрхэлдэг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудал л байдаг. 2024 онд манай байгууллага 12 га газарт мод тарьсан. Тарьц суулгацыг бид бий болгоод байдаг ойжуулалт хийх талбай хомс байгаад байна. Мөн талбайг сонгон ойжуулах гээд очих гэхээр мал, бэлчээр бүхий айл өрх байгаад байдаг нь зөрчилдөөд байдаг.

Үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа бол цаашид олон баримт материалын бүрдэлгүйгээр сунгагдах процесстой болмоор байна. Тусгай зөвшөөрөл шаардагдах зүйлд шууд техник байх ёстой гэх мэтчилэн маш олон бүрдүүлбэрийг шаарддаг. Бид нар трактороо улирлаар түрээсэлж газраа хагалуулдаг. Тэр тал дээр уян хатан байлгадаг болгох шаардлагатай байна.

Төр хийж гүйцэтгэх боломжгүй ажлаа хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай ч тусгай зөвшөөрөл олгох ажлуудыг төрийн байгууллагууд хийх нь зүйтэйг онцолсон байна. Учир нь мэргэжлийн холбоод гэдэг нэртэй ч чадвартай, төлөвшсөн ашиг сонирхлоос ангид аваад явах мэргэжлийн холбоод бий болоогүй байна. Гадны улсын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын чадавх ажиллаж буй байдал нь өөр байдаг харин манай улсын хувьд төрийн хийх ажлыг төрийн бус байгууллага нь авч явах хүртлээ чадавхжаагүй, төлөвшөөгүй байгааг дурдаж байсан.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх шаардлагатай ажил гэж байна. Жишээлбэл: Ойн газар хүний нөөц багатай, дутмаг байдаг. Тэгээд давхар хээрийн хяналтыг давхар хийх нь ачаалал нэмэгдүүлж байгаа. Зарим нь жишээлбэл завсаргүй хөдөө яваад ачаалалтай ажиллаад нийслэл дэх ажил нь орхигддог юм шиг санагддаг. Хяналт, шалгалт, хөндлөнгийн хяналт зэргийг зарим төрийн бус байгууллагад шилжүүлэх нь зүйтэй байх.

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгааг хийж, тэмцлийн ажлаа хийх гээд очиход хортон шавьж байхгүй зэрэг асуудал гардаг. Тэмцлийн ажилд шаардлагатай бэлдмэлийг зарим тохиолдолд 20-30 тн машинаар ачиж, зөөх гэх мэт асуудал гарснаар зардлын хэмжээг өсгөдөг байна. Мөн орон нутагт агуулах саваа өөрсдөө олж бэлдмэлээ хийдэг. Орон нутаг, суманд зориулалтын бэлдмэл хадгалах сав, агуулах гэж байдаггүй зэрэг хүндрэл байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Шалгуурууд тавигддаг, жишээ нь 1 га талбайд тарих модны хэмжээ заадаг. Өнгөрсөн 2023 онд ямар үндэслэлээр өсгөсөн нь мэдэгдэхгүй, 1 га-д тарих модны хэмжээг 1300 болгон нэмэгдүүлсэн. Өмнө нь 800-1000 мод тарьдаг байсан бол одоо 1300 болгосон. Тооны араас л хөөцөлдөөд байгаа юм шиг санагдаж байна. 1 га-д ноогдох зардлын хэмжээ нь яг хэвээрээ өөрчлөгдөөгүй. Гэтэл ААН-ээс гарах зардал нэмэгдэж байна. Тендер зарласан ААН хяналтаа тавиад 3 жилийн усалгаа, ургах үйл ажиллагаанд хяналтаа тавиад явах байх. Жишээлбэл, энэ га-д тарьсан модыг ойн санд хүлээж авах ажлыг БОЯ, тухайн орон нутгийн ойн газар хариуцдаг. Улс хүлээж аваагүй тохиолдолд ойн санд хүлээж авахгүй ойжуулсан талбай гэдгээрээ л явах ёстой. Бид үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг ААН-үүдээ сайн мэдэх учраас тэд нараасаа үржүүлгийн модоо авчихдаг харин мэдэхгүй хүмүүс хувь хүн, шинэ ААН-ээс аваад асуудал гардаг байх.

Бодисын хувьд зориулалтын орчинд нь хадгалахгүй бол болохгүй. Хөдөө орон нутагт уурын зууханд хийж хадгалдаг. Бэлдмэлийн чанар, стандартыг хүрээлэнгээс хэмждэг.

Бүлгийн ярилцлагад оролцогчдын хувьд мод үржүүлэг болон ойжуулалтыг хийж байгаа тус тусдаа аж ахуйн нэгжүүд байдаг, гэвч ой мод болж байгаад хяналт тавьж байгаа тогтолцоо, үйл ажиллагаа байхгүй, тендерээр худалдан авалт хийсэн тохиолдолд тендер зарласан байгууллага 3 жилийн хугацаанд хяналт тавьж ургуулна гэдэг ч энэ хугацаа бол мод ургах процессын хувьд хангалттай биш гэдгийг онцолж байсан. Мөн мод үржүүлгийн ажил хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд тарьц суулгацаа худалдан борлуулах механизм байдаггүй тул төрөөс манай улсын хөрсөнд тарьж нутагшуулсан, дотоодынхоо тарьц суулгацыг борлуулах боломжоор хангаж өгөх нь зүйтэйг онцолж байв.

Мөн тендерт оролцоход хор цацах онгоцтой байх шаардлага тавьдаг, хүний нөөцийн хувьд ойн инженер гэж ганц инженер заадаг нь өрөөсгөл орчин үед ойн инженер гэх мэргэжлээр боловсон хүчин төгсөхөө больсон. Мөн хортон шавж устгах гэж байгаа байгууллагад биологич мэргэжилтэй хүн хэрэгтэй байдаг гэтэл 3 ойн инженер байх ёстой гэдэг нь хүндрэлтэй гэдгийг онцолж байв.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойн холбоо гэж холбоо бүх боломжийг авдаг, тэр холбоонд элсэх эсвэл удирдах зөвлөлийн гишүүдэд онгоцны эрх зөвшөөрөл олддог. Би материалаа өгөхөөр шалгаж байна гээд шийдэж өгдөггүй. Ойжуулалт тэрбум модны хүрээнд санхүүжилт өндөр болсон. Ойжуулалтын тендерт аж ахуйн нэгжүүд багтахдаа больсон. Хортон шавьжны тусгай зөвшөөрөл авахаар 3 хоногийн өмнө Ойн газарт очиж уулзсан. Хортны тусгай зөвшөөрөл авах журам өнгөрсөн жил шинэчлэгдсэн. Тэгсэн нөгөө л хэдэн олигархи компаниуд Ойн газрын таньдаг хүмүүстэй хамтраад журмаа өөрсдийн эрх ашигт тасруулж өөрчилсөн. Туршлагагүй компаниудыг боосон үйлдэл болсон. 2024-2025 онд ойжуулалтын тусгай зөвшөөрөл, хортон шавьжны тусгай зөвшөөрлийг харьцуулахад тэс өөр тоо гарна. Хортон дээр зөвшөөрөл авч чадахгүй байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Санхүүжилт дээр тендер суурилдаг учир олигархи компаниуд өөрсдөдөө тааруулж зарладаг. Хамтраад, өрсөлдөөд орьё гэхээр миний зөвшөөрөл гарахгүй. Бусад зөвшөөрлүүд хурдан гардаг. Даанч хортон шавьжны тусгай зөвшөөрөл гардаггүй. Холбоонд элсэж байж хортон шавьжны тендерт орно. Тендерт ороход холбоонд ор гэдэг. Шинэ боловсон хүчнүүд тэр хүмүүсийн өөдөөс юу ч ярьж чаддаггүй. Ойжуулалт, ой зохион байгуулалт, хортны холбоо зэрэг байгаа. Хортны холбоонд орж байж тендерт орно гэдэг. Сарын хураамж нь тендерийн нэг хувь. Ойжуулалтад ямар ч өөрчлөлт хийгээгүй байж, хортны тусгай зөвшөөрөл дээр өөрчлөлт хийсэн байсан. Яагаад ийм юмыг баталж байгаа гэхээр мэргэжилтэн дарга хий гэсэн гэдэг. Үнэхээр олигархи компаниуд журамд заасан багаж хэрэгсэлтэй бол шалгуулмаар байна. Тэд нарт байхгүй. Зоорины шаардлага хэрэгтэй гэсэн шаардлага тавьдаг бөгөөд ямар хэрэгтэй юм гэхээр, багцалсан тендерүүд бодисоо зоорилох хэрэгтэй гэж хэлдэг. Гэрээт зоорьтой байж болно гэсэн мөртлөө, эрхийн бичигтэй зоорь хэрэгтэй гэдэг. Бусад аж ахуй нэгжид нэг ч зоорь байхгүй. Эдгээрээс болоод хортонгийн зөвшөөрлийг авч чадахгүй байна. Дарга руу нь ороход ойн газрын журамд тэнцэх байгууллага байхгүй, гэрээтээр ороочээ гэж хэлсэн. Зоорьтой компанитай гэрээ хийж байж орно гээд байгаа. Тийм зоорь маш ховор. Хэдэн тэрбумын тендерт орж чадахгүй, компанид чадвар байхгүй бол хүнийх нь чадавх надад байгаа. Итгэмжлэлээр ороход 60, 40 өөр авдаг.

Төрийн байгууллагууд ойн дагалдах баялаг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд өөрсдөө очиж самар түүдэг гэсэн ойлголттой байдаг. Гэтэл аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаандаа оролцох бичиг баримтаа бүрдүүлэх, самрын болц гүйцсэн зэргийг хүлээж байтал нутгийн иргэд самар түүсэн байдаг.

Иймд аж ахуйн нэгжүүд нутгийн иргэдээс самрыг худалдан авч, нөгөө талаас ченжийн ажил хийж байгаа гэдгийг төрийн байгууллага бүгд мэддэг. Гэвч бодит байдал дээр цаасан дээр байгаа шаардлага, бодит нөхцөл байдал хоорондоо асар их зөрүүтэй. Энэ асуудлыг Ойн газар мэдэж байгаа ч өөрсдөө яаж ч чадахгүй байгаа талаар байр суурь илэрхийлдэг. Аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавьж байгаа бол орон нутаг өөрсдөө тухайн газар нутгаа хамгаалах хэрэгтэйг онцолж байв.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Бид гарал үүслийн бичгээ бичээд ойн ангиас авахад НӨАТ-ын баримтыг давхар Ойн анги нэхдэг. Энэ бол хамаарал байхгүй л гэж бодож байна. Тусгай зөвшөөрөл авахад их хүндрэлтэй, мэдээлэл дутмаг, дагалт баялаг авах ёстой зөвшөөрлүүдээ аваад явбал ганцхан хуваарьтай зууралдахгүй. 7 чиглэлийн гэрчилгээ тус тусдаа байх нь зөв үү эсвэл бүгд цогц байх нь зөв үү, байвал амар, стандартаа мөрдөөд дотор нь компани ажлаа төлөвлөөд хийгээд явж болно. Манай сумын хувьд дээд тал нь тусгай зөвшөөрөл л байгаа байх, зарим тусгай зөвшөөрлийн нэрийг анх удаа сонсож байна. /хамгаалах, хөнөөлт шавж/ Материал бүрдүүлэхэд яг суухад 3 хоног нааш цааш яваад дунджаар 7 хоног зарцуулж байна. Тусгай зөвшөөрөл сунгахад сүүлийн 3 жилийн тайланг нэхдэг. Бид жилд 2 удаа тайлангаа Ойн ангидаа өгдөг. Тэндээс л тодруулга авчихдаг баймаар байна. Маш олон цаас бэлддэг өмнө нь энэ тэнд өгсөн тайлангаа дахиад л эхнээс нь шивдэг. Тогтвортой ажлын байргүй учраас хүний нөөц тогтлоггүй.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Төрийн үйл ажиллагаа өмнөх үеэ бодвол харьцангуй сайжирч байна. Манай суманд нэг асуудал бий. Нийт нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ гучин хувийг нь орон нутагтаа хөнгөлөлттэй үнээр зар гэдэг журам бий. Сумаас үнэ тогтоогоод манай компанийг дампууруулсан. Мод нь цаанаасаа өндөр үнэтэй ирээд байдаг. Гэтэл аймгийн Засаг даргаас ямар ч ашиггүй бэлтгэсэн модоо зарах үүрэг хүлээлгэсэн. Дээр нь татвар, орон нутгийн хяналт, шалгалт гээд л олон олон дарамтууд бий. Энэ нь компанийн үйл ажиллагаанд эрс сөргөөр нөлөөлж байна.

ОЗОН ЗАДАЛДАГ БОДИС БОЛОН БУСАД ОРЛУУЛАХ БОДИС, ТЭДГЭЭРИЙГ АГУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ, АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийг анх удаа хүсч буй иргэн, аж ахуй нэгжид бүрдүүлэх баримт бичгийн талаар цахим болон цаасаар хангалттай мэдээлэл байдаггүй. Озоны үндэсний албатай холбогдож тусгай зөвшөөрлийн талаар мэдээлэл авдаг бол БОУАӨЯ-аас тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг хангалттай хэмжээнд авч чаддаггүй байна. Шаардлагагүй баримт бичиг нэхдэг нь хүндрэлтэй байдаг байна. Тусгай зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлбэрийг хянаж, гэрчилгээг гаргасны дараа “танай материал бүрдүүлэлт дутуу байна” гэдэг шалтгаанаар компанийн үйл ажиллагааг зогсоож байсан тохиолдол гарч байсан.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрлийн хүсэлт нь цаасаар авдаг зүйлээ л цахимаар илгээх процесс байгаа тул цахимжуулалтыг сайжруулах, эргэх холбоотой, уялдаатай болгох шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд дээр бүх асуудал төвлөрдөг, шийдвэр гаргах, гарын үсэг зурах, тамга дарах процесс маш удаашралтай байдаг байна. Хариуцсан алба хаагчид нь маш хариуцлагагүй ханддаг. Гаднаас оруулж ирж байгаа бүтээгдэхүүний нэр, марк, орж ирэх гааль, боомтын мэдээлэл зэргийг гэрчилгээн дээр буруу бичих тохиолдол гардаг.



Бүлгийн ярилцлагын оролцогч:

Озон хариуцсан яамны мэргэжилтэн сайд гарын үсэг зураагүй байна гэнэ, тамгагүй байна гэсэн хариулт өгсөн. Үүний улмаас торгууль гээд манай дээр татвараас 60 гаруй сая төгрөг гарчихсан. Тусгай зөвшөөрөл дээр гаднаас оруулж ирж байгаа бүтээгдэхүүний нэр, марк зэргийг буруу бичилттэй гаргадаг, мөн орж ирэх гаалийн мэдээллийг буруу бичсэн байдаг. Дахиад л тусгай зөвшөөрлийн бичиг баримтаа яаман дээр шинээр бүрдүүлээд гааль руугаа явуулдаг.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Озоны үндэсний алба нь хоорондоо уялдаа холбоогүй ажилладгаас шалтгаалан иргэн, ААНБ-ыг орой хүртэл хүлээлгэх, ажил алдагдуулах тохиолдол гардаг байна. Хүний нөөцийн хувьд маш дутагдалтай, ганцхан хүн маш олон хүний мэдээлэл дээр ажилладаг гэсэн байна.



Бүлгийн ярилцлагын оролцогч:

Тусгай зөвшөөрлөө 3 жилээр өгдөг байвал хүндрэлгүй. Гэтэл жилд ганцхан удаа аваад маш их хугацаа алддаг. Иргэн, ААН-үүдэд эрсдэл учруулах магадлал маш өндөр байна. 12 сарын дундуур квотын хүсэлтээ аваад хугацаандаа амжаад тусгай зөвшөөрлөө аваад он гарахаас өмнө шийддэг бол бидэнд ямар нэг хохирол байхгүй. Харамсалтай нь тэгдэггүй юм.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам шинээр батлагдах, эсвэл батлагдсан тохиолдолд албан ёсны сайтаараа дамжуулан шуурхай мэдээллийг түгээдэггүй, сурталчлах, таниулах, үйл ажиллагаа маш сул. Төрд байгаа мэдээллийг бичиг баримтын бүрдүүлбэрт

шаардаж байгаа нь хүндрэлтэй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжтэй түрэмгий харьцдаг тул иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд гуйж, загнуулж, байнга хянуулдаг байдал үүсдэг байна.



Булгийн
ярилцлагын
оролцогч:

Төрийн захиргааны төв байгууллага бодлогоо л баримтлах болохоос биш зөвшөөрөл олгодог баймааргүй байна. Бусад зүйл дээр хэрэгжилт, хяналтаа тавиад явах шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл олгоход ямар баримт бичиг бүрдүүлэх болон ямар шат дарааллаар явах нь иргэн, аж ахуйн нэгжид тодорхойгүй байдаг. Энэ тодорхойгүй байдлын улмаас зарим тохиолдолд шаардлагатай өөр мэдээлэл гэж шаардах, дараа нь бичиг баримтын бүрдэл дутуу гэх мэтчилэн хүндрэл гардаг. Цахим систем нь цаасан материалыг PDF болгон цахимаар явуулдаг, шийдвэрлэлтийн процесс ямар шатандаа явж байгаа нь тодорхойгүй зэрэг цахимжуулалтын байдал хангалтгүй, тусгай зөвшөөрлийг E-business.mn цахим системээр авдаг бөгөөд бичиг баримтын бүрдэлд төрд байгаа мэдээлэл буюу ДАН системээс авах боломжтой мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг нь хүндрэлтэй байдаг байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хугацаандаа шийдвэрлэж буй байдлын тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл олгох процесс нь хараат бус байж чаддаггүй. Хуулийн хугацаандаа шийдвэрлэгддэггүй, хуулийн хугацаанаас 2-3 дахин илүү удаашралтай байдаг тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд таньдаг хүнийг эрж хайж, хурдлуулах арга хэмжээ авдаг байна. Зарим байгууллагуудын хувьд тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ эрт өгсөн хэдий ч, хугацаандаа сунгагдахгүй байдал гардаг байна.

БОУАӨЯ бодлогын асуудалдаа анхаардаггүй, үнэлгээ хариуцсан албан хаагчид тайлан унших, үнэлгээ батлах, хэлэлцэх ажлаасаа өндийдөггүй. Зөвшөөрөл олгодог тусдаа орон тооны хүн гэж байдаггүй бөгөөд дандаа ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд үнэлгээний хуралд нарийн бичиг, хурлын протоколыг хөтлөх гэх зэрэг ажлын ачаалал их байдаг. Хариуцлагагүй албан хаагчаас болж тусгай зөвшөөрөл хүсч, хүргүүлсэн бичиг баримтын бүрдүүлбэр, хавсралт, тайлан зэрэг бичиг баримтууд алга болдог байна. БОУАӨЯ-ны албан хаагчид эмх замбараагүй ажил гүйцэтгэдэг байдал ажиглагддаг. Сайд, дарга нар өөрчлөгдөх үед мэргэжилтэн бас өөрчлөгддөг байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын хувьд үйл ажиллагааг ямар ч асуудалгүй хийж, үнэлэгдээд явж байхад олон дахин шалгалт ирдэг байдал хүндрэлтэй байдаг гэсэн байна.

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ АШИГЛАХ, ХУДАЛДАХ, ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ҮЙЛДВЭРЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлбэрийг бүрдүүлэхээр 2-3 газар оочерлодог ба Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (БОННУ) батлуулахад маш их хүндрэлтэй, дор хаяж 6-8 сар шаарддаг, 10-30 сая орчим төгрөг зарцуулдаг. 1 бодис л нэмэх шаардлагатай болсон үед БОННУ-д нэмэлт тодотгол хийх шаардлага тавьдаг. БОННУ тайлан бэлэн болсон үед Байгаль орчин, уур

амьсгалын өөрчлөлтийн яамны дарга байхгүй, томилолтой зэрэг тамга, тэмдгийн асуудал гардаг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Манайх гоо сайхны бараа оруулдаг, 5 жилийн хугацаатай сунгадаг, сунгалтын шаардлагыг багасгах саналтай байна, ААНБ бүрд нэг ижил шаардлага тавьж байгаа нь хүндрэлтэй байна. Бодисоо судлаад ангилгаад шаардлагуудаа тавих хэрэгтэй гэж бодож байна. Импортоор оруулах, хэрэглэх үед тус тусад нь шаардлага тавьж байна. Судалгааны газартай мөртлөө хангалттай ангилсан судалгаа хийдэггүй, Импортлох зөвшөөрөл, ашиглах зөвшөөрлийн шаардлага адил байдаг.

Баримт бичиг бүрдүүлэлтийн зарим агуулга нь ямар байгууллагаас авах нь тодорхой биш, химийн бодис импортлох, үйлдвэрлэх, экспортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрлүүдийн бүрдүүлбэрийн ялгаа тодорхойгүй, зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүйн улмаас импортлогч аж ахуйн нэгж, байгууллагын хувьд барааг гааль дээр хонуулж төлбөр төлөх, бодисоо устгуулах зэрэг хүндрэл гардаг.

Төрийн байгууллагуудын хувьд төсөв, хөрөнгө хязгаарлагдмал тул химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөл авахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.2-т заасан Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг хамаарахгүй болгох хүсэлтэй гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл олгох процесс болон баримт бичгийн бүрдүүлбэрийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны цахим хаяг болон E-business цахим системээс авдаг. Цахим системд зарим баримт бичгийг оруулахад 2 файл зэрэг оруулсан ч цаанаа аль нэг нь харагдахгүй, тэмдэгтийн хураамжийн төлбөрийг цахимаар зарим тохиолдолд төлж болдоггүй зэрэг ойлгомжгүй асуудал үүсч хүндрэл үүсдэг. Мөн цахим систем гацсан тохиолдолд холбогдох албан хаагчийн мэдээлэл байх шаардлагатай гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас химийн бодисын тусгай зөвшөөрөлтэй холбоотой сургалт, заавар, зөвлөгөө тогтмол өгөх хэрэгцээ шаардлага аж ахуйн нэгжид байдаг байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ойролцоогоор нэг үйл ажиллагаа явуулахад 3 тусгай зөвшөөрөл авах хэрэгтэй болдог, төрийн байгууллагууд ашиглах зөвшөөрлөө өөрсдөө авдаггүй ч манайд нийлүүл гэж хэлдэг. Үүнээс нийлүүлсэн байгууллага хохирох тохиолдол байдаг. Мөн адил төрлийн өөр нэршил бүхий бодис нэмүүлэх үед дахин бичиг баримт бүрдүүлж дахин авах болдог, халдваргүйжүүлэлтийн бодисыг монголд оруулж ирэх үед 3 яамны тушаалаар мөн нарийвчилсан үнэлгээ зэрэг хийлгэх болдог, 70 хувиас доош хувьтай халдваргүйжүүлэх бодисыг шинэ журмаар бичиг шаардахгүй гэсэн нь шударга бус байна, гар ариутгалын бодис хүртэл 90 хувиас дээш байдаг, энэ нь чанаргүй бодис орж ирэхэд хүргэж байна. Бодисуудаа ангилж зөвшөөрлийн шаардлагаа өөрчлөх шаардлагатай.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, судалгаа, шинжилгээний байгууллага, салбарын хяналт нь хоорондоо уялдаа холбоогүй ажиллаж, тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, байгууллагыг нааш цааш явуулдаг байна. Хариуцсан албан хаагчид нь тогтвор суурьшилгүй, байнга солигддог ба химийн чиглэлээр мэдлэг дутмаг.

Химийн бодистой холбоотой хууль, эрх зүйн орчин, нэр томъёоллыг шинэчлэх шаардлагатай. Төрийн байгууллага, салбар хоорондын уялдаа муу, зарим ахуйн зориулалттай, өргөн хэрэглээтэй бараа, бүтээгдэхүүнүүдийг **тусгай зөвшөөрлөөс хасах** шаардлагатай. Нэр томъёо, төрөл, ангиллаа сайжруулахгүй бол үгэнд нь тааруулах шаардлага гарч, хууль нь байдаг ч мөрдөх журам байдаггүй зэрэг олон хүндрэлүүд байдаг гэж дурдсан байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Давхардсан тусгай зөвшөөрөл шаарддаг асуудал байгаа, ЭМЯ болон БОУАӨЯ аль аль нь тусгай зөвшөөрөл шаардаж нэг нэг рүүгээ явуулж байна. Ариутгалын бодис дээр энэ асуудал гаргасан. Хугацаа их алдсан. Жишээ нь: жавилон гэх бодисыг монгол улсад зөвшөөрсөн ч бүртгэлийн гэрчилгээ 3 жилээр авах шаардлагатай болдог сунгуулах нь мөн хүндрэлтэй, баримт бичгийн бүрдүүлэлт, шаардлага, төлөвлөгөөг яг анх авч байгаатай адил гаргадаг. 3 яамны зөвшөөрлийг квот олгож авдаг, гэтэл энэ квот нь маш удаж гардаг. Судалгаа, шинжилгээний төв ямар үүрэгтэйг ойлгодоггүй, нарийвчилсан үнэлгээг хийлгэхэд ИТХ хурлын бичиг авдаг, хуралдах үеийг хүлээх болдог гэх мэт.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаал жил бүрийн 3-р сарын үед батлагддаг нь улирлын чанартай хэрэглэгддэг бодисын хувьд хэт оройтож аж ахуйн нэгж, байгууллагууд хугацаа, санхүүгээр хохирдог талаар дурдсан байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл:

Хяналт шалгалтыг маш олон байгууллагаас хийдэг Тагнуулын байгууллага, байгаль орчны хяналтын улсын байцаагч, онцгой байдлын байгууллага зэрэг. Хяналт шалгалт хийх үед байгаль орчны хяналтын улсын байцаагч нар химийн бодисын мэдлэггүй, торгохоо л боддог. Химийн бодисын чиглэлээр тендер зарлагдсан үед ч хяналт тавих шаардлагатай байна.

АМЬТАН ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны цахим хаягаас баримт бичгийн бүрдүүлбэрийн мэдээллийг авдаг. Тусгай зөвшөөрлийн хүсэлтэд цахим гэсэн зүйл байхгүй, мэйлээр илгээж, дараа нь цаасаар эх хувиар нь шаарддаг. Цахимжуулалтыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газрууд дундаа нэгдсэн системтэй байх хэрэгтэй гэж үзэж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Ан, амьтны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгодог нь сайн. Ан агнуурын тусгай зөвшөөрлийг 1 жилээр олгодог бөгөөд 3 жил эсвэл 5 жилийн хугацаагаар олгодог байх хүсэлтэй байна. Ан амьтны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүрдүүлбэрийг аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт эхлээд өгдөг. Аймгийн Байгаль орчны газар аймаг, нийслэлийн Засаг дарга руу явуулдаг. Аймаг, нийслэлийн Засаг дарга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу явуулдаг. Энэ их шат дамжлагыг багасгах хэрэгтэй гэж үзэж байна. Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж ан, амьтантай холбоотой үйл ажиллагаа эрхлэхэд өөр болсон. Байгууллагууд уг нь өрсөлдөөний журмаар явах хүсэлтэй байдаг. Ан, амьтны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл бол шаардлагагүй гэж үздэг талаар ярьж байв.

Аж ахуйн нэгж, байгууллагуудад ангийн дуудлага худалдаа хүндрэлтэй байдаг. Аймаг болгон аймгийн Засаг даргын захирамжийн дагуу өөр өөр шаардлага тавьдаг тул нэгдсэн журам, зохицуулалттай байдаггүй. Хуучин агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрлийг яам олгодог байсан. Хугацааны хувьд одоо аймаг руу шилжүүлсэн нь сайшаалтай хэдий ч зарим тохиолдолд Засаг дарга нь өөрөө байдаггүй. Энэхүү зөвшөөрөл нь 14 хоногоор олгогддог бөгөөд процессын хувьд ангийн тусгай зөвшөөрлийг эхлээд орон нутгаас авч, дараа нь ан хийх бууны зөвшөөрлийг Улаанбаатар хотоос авдаг нь хугацаа алддаг.

Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгодог. Үүнийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гол нь цахимаар олгох ёстой гэж үзэж байна.

Ангийн явцад Экологийн цагдаагийн алба, байгаль хамгаалагч нар тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор тогтмол шалгалт, хяналт хийгддэг байна. Зарим сумдад хяналт шалгалт хийгддэггүй бөгөөд тогтмол хийх шаардлагатай байна. Ан агнах тусгай зөвшөөрлийг 14 хоногоор олгож байгааг 30 хоног болгож сунгах, Засгийн газраас ангийн тоо толгойг батлах тогтоолыг 12 дугаар сард багтаан гаргаж, дуудлага худалдааг жил бүр 1-р сард багтаан явуулах хэрэгцээ байдаг. Тусгай зөвшөөрөл хүсэхэд цахимаар буюу мэйлээр авсан материалуудыг дахиж цаасаар авдаг нь олон ажил болдог хүндрэлтэй. Ер нь цахимжилт гэдэг зүйлийг маш сайн нэвтрүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Ан, агнуурын мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй байж ан агнах тусгай зөвшөөрлийг авна гэсэн төрөөс шаарддаг. Дуудлага худалдаанд болохоор мэргэжлийн бус байгууллагыг оруулчхаад байдаг. Ингээд ойлгомжгүй байдал үүсээд байдаг. Ангийн улирлын хугацаа их бага байдаг болсон. Энийг сунгах шаардлагатай. 06 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл болгох. Төр хувийн хэвшлийн хоорондын харилцааг сайжруулах. Цахим системд төр, хувийн хэвшлүүд нэг сүлжээнд орох хэрэгтэй. Цахимыг боловсронгуй болгох нь тулгамдсан асуудал.

Дуудлага худалдааг болиулах эсвэл маш сайн хууль, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна. Учир нь нэн ховор амьтныг арилжааны хэрэгсэл болгож, хамгаалалт багасах, төр олсон орлогоо хэрхэн зарцуулдаг нь тодорхой бус байна.

УСНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Мэдээлэл нээлттэй биш, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдөө судлаад олж авдаг. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оны байдлаар цаасаар авдаг байсан бөгөөд сүүлийн үед E-mongolia цахим системээр илгээж байна. Хүсэлтийг хүлээж авсан тохиолдолд “хүлээж авлаа” гэсэн баталгаажуулалтын мэйл ирдэг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Улирлын шинж чанартай учраас зун худаг ухах зөвшөөрөл авахын тулд 1 айлын 155,000₮ хураамж төлдөг. Зөвшөөрөл авахаар сар хүлээж байх хооронд айл нь өөр газраар худгаа хуулсан байх жишээтэй. Ийм байдлаар 40 айл худаг ухах алдсан боломжийн өртгөөс гадна 6 сая гаруй төгрөгөөр хохирч байна.

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагаа хараат бус, бие даасан байх зарчмын хувьд хариуцсан албан хаагч үзэмжээр болон ашиг харсан ханшаар шийддэг гэж үзсэн байна. Олон бичиг баримт нэхэх нь зүйтэй боловч удаан хугацаагаар буюу боломжтой бол 7 жилээр олгох хэрэгтэй. Олон жил ажилласан хариуцсан мэргэжилтэнг сольж, тодорхой хугацаанд сэлгэн ажиллуулдаг, Төрийн албан хаагчийн хүнд суртлыг арилгах, ёс зүйг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна гэж үзэж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл: Хяналт шалгалтын хувьд тус чиглэлээр ямар ч хяналт шалгалт хийгддэггүй байна. Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгасан нь буруу гэж үзсэн байна.

ГАЗРЫН ХЭВЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрлийг авахад шаардлагатай баримт бичиг болон мэдээллийг БОУАӨЯ-ны цахим хуудаснаас авсан бөгөөд уг мэдээлэл нь ойлгомжтой байсан.

Тусгай зөвшөөрлийн шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн талаарх мэдээлэл нь тодорхой байсан тул ямар нэгэн хүндрэл үүсээгүй.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Яамны ажилчид тусгай зөвшөөрөл авах үед Бат-Эрдэнэ гэдэг хүний сонгуулийн ажилд явсан байсан. Говь-Алтай аймгийн Дорви суманд хууль бусаар тусгай зөвшөөрөл олгодог, эсвэл энгийн хүмүүс олгодоггүй бизнес болсон байсан санагдсан.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ цахимаар болон цаасан хэлбэрээр өгсөн. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)-т тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ цаасан хэлбэрээр гаргасан. Бүрэн цахимжаагүй аль алианаар нь өгч байгаа.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа нь процессын хувьд удаан бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмжийн бүрдүүлэлт их байсан нь цаг хугацаа их зарцуулахад нөлөөлсөн.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирлын тухайд авч үзвэл:

Баримт бичиг бүрдүүлэлтэд их хугацаа зарцуулсан бөгөөд нэмэх шаардлагатай баримт бичгийн мэдээллийг яамнаас холбогдож хэлдэггүй, харин өөрийн биеэр лавладаг. Сунгалт хийлгэхэд шинээр авахтай адил баримт бүрдүүлэлт шаардлагатай байдаг. 6 сар гаруй хугацааг сунгалт хийлгэхэд зарцуулсан бөгөөд 5 сар гаруй хугацааг гэрээ байгуулахад зарцуулсан. Бусад зөвшөөрөл авах үед газрын тусгай зөвшөөрлийн хугацааг баримталдаг бөгөөд сунгуулах үед хоёр зөвшөөрлийг хамт сунгуулах шаардлагатай болдог. 3 жилийн хугацааг гуравласан гэрээ болон бусад бүрдүүлэлтэд зарцуулдаг. 5 жилийн хугацаатай олгох үед үйл ажиллагаа эрхэлж амжих боломжгүй болдог. Бүрдүүлэлтийн процесс нь их хугацаа шаарддаг бөгөөд хугацаа дууссан, зөвшөөрөл цуцалсан үед яамнаас мэдэгддэггүй байдал нь хүндрэл учруулдаг. Тусгай зөвшөөрөл авахад 3 жилийн хугацааг бүрдүүлэлтэд зарцуулсан.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Хугацааны тал дээр хүнд суртал гаргадаг. Тендерт тусгай зөвшөөрөл хуулийн хугацаандаа гараагүйгээс оролцож чадалгүй хоцорсон.

Тусгай зөвшөөрөл хуулийн хугацаанд шийдэгддэггүй гэж үзэж байна. Тусгай зөвшөөрөл хуулийн хугацаанд гараагүйгээс үүссэн асуудлаас болж зарлагдсан тендерт оролцож чадаагүй тохиолдол гарч байсан. Тусгай зөвшөөрөл авах журамд хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалт хийх хүсэлтийг гаргах ёстой гэж заасан байдаг. Гэвч энэ хугацааг уртасгавал ААНБ нь өөрийн ажлыг зохицуулж, сунгалтын хүсэлтээ гаргахад хэрэгтэй болно гэж үзэж байна.

Төрийн албаны хүнд суртал, албан хаагчдын мэргэшлийн ур чадваргүй байдлаас шалтгаалж, цаг их алдаж байна. Үнэлгээ хийж байгаа компаниудын хувьд, аудитын зөвшөөрөл болон нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байх ёсгүй ч тусгай зөвшөөрлийг төрийн албан хаагчид үзэмжээрээ өгдөг асуудал үүсч байна. Энэ нь тусгай зөвшөөрөл олгох үйл явцад тодорхойгүй байдал, шударга бус шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийн тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах үед бусад байгууллагуудын материалыг нэгтгэж, хурлаар шийдвэрлэдэг нь цаг алдах гол шалтгаан болдог. Түүнчлэн, техник, тоног төхөөрөмжийн шаардлага өндөр байдаг нь бичиг баримтын бүрдүүлэлтийг хийхэд хүндрэлтэй асуудал болдог. Төрийн захиргааны төв байгууллагаас илүү Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас (НЗДТГ) тусгай зөвшөөрөл авахад их хэмжээний цаг хугацаа зарцуулдаг. Нэг баримт бичгийг хоёр байгууллагад өгч байсан нь төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоогүй байдлыг илтгэдэг. Мөн тусгай зөвшөөрөл авсан ч ажлаа бүрэн дуусгаагүй байхад, эсвэл ажил эхэлж байх үед зөвшөөрлийн хугацаа дуусах тохиолдол гардаг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Хүнд сурталтай санагддаг учраас цаг л их алдаж байна. Үнэлгээний эрхтэй компанид нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл өгөхгүй гэдэг ч МУИС болон хүрээлэнгүүдэд бүх эрхээ өгч байдаг. Тендерт оролцох хугацаа алддаг эсвэл таньдаг байгууллагадаа тендер олгодог.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Тусгай зөвшөөрөл авах үед ихэнх цагийг тодорхойлолт авахад зарцуулсан, дараагаар нь ажлаа хийж дуусаагүй байхад, эсвэл эхэлж байхад зөвшөөрөл нь дуусчихдаг. Мэргэжлийн байгууллагаа дэмждэггүй.

Тусгай зөвшөөрлийг яамнаас авсан хэдий ч, компаниуд бие даасан байдлаа хангаж чадахгүй байгаа нь хараат бус байдлын алдагдалд хүргэдэг. Газрын хэвлийн нөхөн сэргээлтийн эрхтэй компаниуд, тухайн эрхийг ашиглан бизнес хийж, тусгай зөвшөөрлийг зарж буй тохиолдол гарч байна. Тусгай зөвшөөрлийн үнэ нь 20 сая төгрөгөөс эхлэх бөгөөд энэ нь хараат бус зарчмыг хангахгүй байгааг илтгэнэ. Газрын хэвлийн болон техник, биологийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд мөн хог хаягдлын тусгай зөвшөөрлийг давхар авч, энэ байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь зохицуулалт, хяналтын арга хэмжээний дутагдалтай холбоотой байх магадлалтай.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой арга замын тухайд авч үзвэл:

ААНБ-ууд ПДИ-ийн ажилд оролцох хүсэлтэй байгаа бөгөөд бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ч төрийн байгууллагаас хамааралтай асуудлууд үүсч байна. Төрийн байгууллагууд нь мэргэжлийн байгууллагуудаар хийлгэх үйлчилгээг өөрсдөө хийх тохиолдол гарч, энэ нь мэргэжлийн байгууллагыг үнэгүйдэлд хүргэж, өрсөлдөөнийг хязгаарлах асуудал үүсгэж байна. Үүнийг засах, мэргэжлийн байгууллагуудыг дэмжихийн тулд тусгай зөвшөөрлийн шаардлагыг сайжруулах хэрэгтэй.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Бие даасан байдлаа хангаж чадахгүй байгаа. Яам дээрээс өгдөг тусгай зөвшөөрөл авчхаад, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн эрхтэй компанийг бас зарж бизнес хийж байна, үнэ нь 20 саяас эхэлдэг.

Тасралтгүй 2-3 жил дамнан хөдөлмөрлөж, хичээж байхад, өөр нэг байгууллага зөвхөн 1 жил үйл ажиллагаа явуулаад л адилхан үнэлэгдэж байгаа нь стандартын шаардлага дутагдалтай байгааг харуулж байна. Тусгай зөвшөөрлийг олгох үйл явц нь зөвхөн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэх ёстой цогц нөхөн сэргээлт хийхэд ч хамаарна. Гэхдээ мэргэжлийн байгууллагын үнэ цэнийг бууруулж, мэдлэггүй, мэргэшээгүй хүмүүс ажилд орж байгааг эсэргүүцэж байна.

Мэргэжлийн байгууллагуудыг дэмжих, тэдний үнэ цэнийг хадгалах, мэргэшсэн хүмүүст цол зэрэг олгох асуудлыг шийдэх шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар, яамнаас энэ тал

дээр ямар ч бодлого хэрэгжүүлж байгаагүй, төрийн байгууллагууд нь мэргэжлийн байгууллагуудтай өрсөлдөх шаардлага гарч байна.

Мөн тусгай зөвшөөрөл авсан байгууллагын мэдээллийг нээлттэй байлгах, давхардаж байгаа хүний нөөцийг шалгах шаардлагатай. Аймгуудын уул уурхайн байгууллагууд техникийн нөхөн сэргээлийг өөрсдөө хийж байгаа нь мэргэжлийн байгууллагуудын үнэ цэнийг унагаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд санхүүгийн эх үүсвэр гаргаж, нөхөн сэргээлт хийх шаардлагатай.

Тусгай зөвшөөрлийг олгохдоо мэргэжлийн хүний нөөц, хийсэн ажлыг харж олгох хэрэгтэй. Үүнээс гадна, үнэлгээ хийх үйл явц болон тусгай зөвшөөрлийн шаардлага, хууль, эрх зүйг сайжруулах шаардлагатай байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Горхи-Тэрэлжийн тусгай хамгаалалттай газарт биеэр очиж мэдээлэл авсан. Баримт бичгийн бүрдүүлэлт нь ойлгомжгүй байснаас 2-3 удаа биеэр очиж мэдээлэл авах шаардлагатай болсон. Цахим хуудсаас материал бүрдүүлэлтийн зааврыг харж, шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлсэн ч, бүрдүүлэлтэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болсноор дахин биеэр очих шаардлага үүссэн.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах процесс бүрэн цахимжаагүй байгаа учир цаасаар давхар гаргаж, байгууллага бүрт адил материал бүрдүүлж дахин өгөх шаардлага үүсдэг. Энэ нь процессыг урт, бүрдүүлэлт ихтэй болгодог. Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай төлөв байдлын тайлан, Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээ хийлгэж, үүнийхээ тайланг гаргадаг бөгөөд ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэхэд 6 сарын хугацаа зарцуулдаг. Үүний дараа бусад бүрдүүлбэрийг хангахад их хэмжээний хугацаа шаарддаг. Шинээр авах болон хугацаа сунгуулах процесс нь адил бөгөөд хаана тусгай зөвшөөрөл ашиглахаас шалтгаалаад 2-3 төрийн байгууллагаас дэмжих бичиг, тодорхойлолт авахад хугацаа урт зарцуулагддаг. Энэ нь тусгай зөвшөөрөл авах процессыг урт болгодог. Бүрэн цахимжаагүй аль алианаар нь өгч байгаа.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг цөөн компаниуд хийдэг бөгөөд энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаа гэсэн хардлагыг төрүүлдэг. Яамны хүний нөөцийн хувьд мэдээ, мэдээлэл дутмаг байдаг бөгөөд хүсэлт гаргасан баримт материалыг дахин өгөх шаардлага гарч байсан. Нэг баримт бичгийн бүрдүүлбэрийг дахин өгөх шаардлагатай болдог бөгөөд төрийн байгууллагын эргэх холбоо байхгүй. Цахим болгох үйл явцад жишиг загвар үзүүлэх шаардлагатай гэж бодож байна, учир нь энэ нь 2 удаа биеэр очих шаардлагыг үүсгэсэн. Тусгай зөвшөөрөл авахад нийт 17 баримт бичиг бүрдүүлдэг бөгөөд тус бүрт нь сар гаруй хугацаа зарцуулдаг. Тайланг жилд 2 удаа гаргадаг бөгөөд 5 жилийн хугацаатай сунгуулдаг. Сунгуулахад өмнө нь бүрдүүлсэн баримт бичигтэй адил бүрдүүлэлт хийх шаардлагатай болдог.

Түүнчлэн, хүсэлтийг цаасан хэлбэрээр гаргадаг бөгөөд зөвшөөрлийг цуцлах үед ямар учраас эсвэл цуцалсан талаарх мэдээлэл өгдөггүй. Сунгуулах болон шинээр авахад адил бүрдүүлбэрийг шаарддаг.

Ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ шаарддаг бөгөөд тус үнэлгээнүүд нь хийж гүйцэтгэхэд цаг хугацаа их шаарддаг. Тус үнэлгээнүүдийн хийж дуусгах хугацааг хурлын хугацаатай уялдуулж хийдэг нь цаг хугацаа алдах шалтгаан болж байна. Нарийвчилсан болон ерөнхий үнэлгээг ихэвчлэн бизнес гэж хардаг бөгөөд ихэнхдээ яаманд ажиллаж байсан хүмүүс авсан санагддаг.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирлын тухайд авч үзвэл:

Баримт бичиг бүрдүүлэлтэд их хугацаа зарцуулсан бөгөөд нэмэх шаардлагатай баримт бичгийн мэдээллийг яамнаас холбогдож хэлдэггүй, харин өөрийн биеэр лавлаж авч байсан. Сунгалт хийлгэхэд шинээр авах тусгай зөвшөөрлийн адил баримт бүрдүүлэлт шаардлагатай болдог. Сунгалт хийлгэхэд 6 сар гаруй хугацаа зарцуулсан бол гэрээ байгуулахад 5 сар гаруй хугацаа зарцуулсан. Бусад зөвшөөрөл авах үед газрын тусгай зөвшөөрлийн хугацааг барьдаг бөгөөд сунгалт хийх үед хоёр зөвшөөрлийг хамт сунгуулах шаардлагатай болдог. 3 жилийн хугацааг гуравласан гэрээ болон бусад бүрдүүлэлтэд зарцуулдаг. 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгох үед үйл ажиллагаа эрхэлж амжих боломжгүй болдог. Тусгай зөвшөөрлийн бүрдүүлэлт нь хугацаа их шаарддаг бөгөөд үйл ажиллагаа эхлэхэд саад учруулдаг.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Бүрдүүлбэрт их хугацаа зарцуулсан. Хугацаа дууссан, зөвшөөрөл цуцалсан үед яамнаас мэдэгдэлгүй хүндрэл учруулдаг. 3 жилийн хугацааг зөвшөөрөлд зарцуулсан.

Яамны мэдээлэлгүй байдал, хүний нөөцийн чадах дутмагаас хугацаа, санхүүгээр хохирдог.

Нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах хугацаа болон санхүүгийн зардал нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж, хохирол учруулдаг. Мөн яамны мэдээлэл дутмаг байдал болон хүний нөөцийн чадавхгүй байдлаас шалтгаалан хугацаа болон санхүүгээр хохирох тохиолдлууд гардаг. Энэ нь процессыг хурдасгах, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авахад саад болж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл:

Хяналт шалгалт ирж байсан ч ямар шалгуураар шалгадаг нь тодорхойгүй бөгөөд бусад газрыг алгасаж шалгаж байсан тохиолдол гарч байсан. Богд уулын хамгаалалтын захиргаанаас асууж, өөрийн биеэр барилгын ажил, хог хаягдлын ажилд хяналт тавьдаг. Мөн хяналт шалгалт чиг үүргээсээ гадна бусад асуудлыг шалгаж байгааг мэдэрсэн. Нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллага хийсэн эсэх талаар хяналт тавигддаггүй бөгөөд 2014 онд хийсэн нөхөн сэргээлтээс хойш ямар нэгэн нөхөн сэргээлт хийгдээгүй байна. Арга зүйн зөвлөгөө авах тохиолдол огт байгаагүй. Өмнө нь үүссэн асуудалтай холбоотойгоор Хөдөө, аж ахуйн их сургуулиас зөвлөмж асууж байсан боловч ямар нэг заавар, зөвлөмж авч байгаагүй.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Хяналт шалгалт ирж байсан, гэвч ямар шалгуураар шалгадгийг ойлгодоггүй, бусад газрыг алгасаж шалгаж байсан.

Яамнаас заавар, зөвлөмж авахыг хүсэх үед уулздаггүй. Яамны эргэх холбоо бага.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийн тухайд авч үзвэл:

Нарийвчилсан үнэлгээг цөөн компаниуд хийдэг бөгөөд энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсч байна гэсэн хардлагыг төрүүлдэг. Яамны хүний нөөцийн хувьд мэдээ, мэдээлэл дутмаг байгаа нь хүсэлт гаргасан баримт материалыг дахин өгөх шаардлага гаргахад хүргэдэг. Зарим тохиолдолд нэг баримт бичгийн бүрдүүлбэрийг дахин өгөх шаардлагатай болдог бөгөөд төрийн байгууллагууд хоорондын эргэх холбоо байхгүй нь төвөгтэй байдлыг үүсгэдэг. Тусгай зөвшөөрөл авахад нийт 17 баримт бичиг бүрдүүлдэг бөгөөд тус бүрт нь ойролцоогоор сар гаруй хугацаа зарцуулдаг. Тайланг жилд 2 удаа гаргадаг бөгөөд 5 жилийн хугацаатай сунгуулдаг. Сунгуулахад өмнөх баримт бичгийг мөн адил бүрдүүлдэг. Цаасан хэлбэрээр хүсэлт гаргахад зөвшөөрлийг цуцлах үед ямар учраас, эсвэл цуцалсан талаарх мэдээлэл өгдөггүй. Нарийвчилсан болон ерөнхий үнэлгээг ихэнхдээ бизнесийн талаас хийгддэг бөгөөд ихэнх тохиолдолд яаманд ажиллаж байсан хүмүүс энэ үйл явцад оролцдог.



Бүлгийн
ярилцлагын
оролцогч:

Тусгай зөвшөөрөл авахад 3 жилийн хугацаа зарцуулсан. Ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ шаарддаг, хугацаа ордог, хурлын хугацааг хүлээх шаардлагатай болдог. Нарийвчилсан болон ерөнхий үнэлгээг бизнес гэж хардаг, ихэнхдээ яаманд ажиллаж байсан хүмүүс авсан санагддаг.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой арга замын тухайд авч үзвэл:

ПДИ-ийн ажлын үр дүнтэй танилцах хүсэлтэй байна. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай бөгөөд энэ нь төрийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, ажил үүргийн үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй.

Хугацааны хувь 5 жил богино хугацаа мэт санагддаг боловч үүний 2-3 жилийн хугацааг гуравласан гэрээ, А даалгаварт зарцуулж байгаа нь дахин сунгалт хийхэд хүндрэл үүсгэдэг. Төрийн байгууллагуудын залгамж халаа тасарснаас үүдэн дарамттай, шийдвэр гаргалт нь ойлгомжгүй болж байна. Шийдвэр гаргалт нь энгийн, цахим байх хэрэгтэй бөгөөд хугацаа болон үйл явц нь ойлгомжтой, хялбар байх шаардлагатай.

Нэг тусгай зөвшөөрөл авах үед дараагийн бусад тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай болдог. Тайланг олон удаа нэхэхээс илүүтэйгээр, даатгалын мэдээллийг нэг удаа шалгаж, хяналт тавихад хангалттай байвал илүү тохиромжтой байна. Жил бүр олон удаа тайлан нэхэх нь хүндрэл учруулж байна. Мөн 5 жилийн хугацаа үйл ажиллагаа эрхлэхэд хангалтгүй бөгөөд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул байдаг.

Төрийн байгууллагууд газар олгохдоо шаардлага хангаагүй газрыг олгоод, дараа нь буцааж цуцлах тохиолдлууд гардаг. Иймээс бүрэн цахимжуулалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд энэ нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, цаашдын шалтгааныг бууруулахад туслах болно.

Мөн төрийн байгууллагад чиглүүлэх сургалтыг явуулж, албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай. Энэ нь төрийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ, ЭКСПОРТЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

БОУАӨЯ-ны мэргэжилтнүүдээс холбогдох мэдээллийг тогтмол лавлаж авдаг. Эмнэлгийн хог хаягдалтай холбоотой баримт бичиг бүрдүүлэх талаар хуульд тодорхой заасан байхад, журмын Б хэсгийн материалын жагсаалт нь нуршуу бөгөөд ойлгомжгүй байна. Тусгай

зөвшөөрөл авах тухай мэдээлэл БОУАӨЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа шинжилгээний төвийн цахим хуудаст байдаг бөгөөд хууль болон журамд тусгай зөвшөөрлийн талаарх тодорхой заавар бий ч, уг мэдээлэл нь хангалтгүй байдаг. Иймээс яамны мэргэжилтнээс нэмэлт мэдээлэл авдаг. Мөн цаг хугацаа шаардсан олон баримт бичгийг бүрдүүлсэн ч зарим тохиолдолд эдгээр баримт бичгүүд нь шаардлагагүй материал байх тохиолдол гарч байсан.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай 400-500 хуудас материал цаасаар бүрдүүлж өгдөг. Мөн E-Business болон E-Mongolia платформууд ашиглан цахимаар хүсэлтээ гаргадаг. Ерөнхий бичиг баримтыг цахимжуулах нь цаг хугацаа хэмнэх боломжийг олгох бөгөөд энэ нь процессыг хурдасгах арга зам байж болох юм. Гэвч цахим хуудас дахь мэдээлэл нь байнга шинэчлэгддэггүй, энэ нь судалгааны материал алдагдах шалтгаан болж байна гэж үзэж байна.

Судалгааны материал алдагдах нь мэргэжилтнүүдийн хариуцлагагүй байдалтай холбоотой. Цаашид цахимжуулалтын процессыг сайжруулахад мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь чухал ач холбогдолтой. Мөн E-Mongolia, E-business платформ дээр хүсэлт, материал бүрдүүлсний дараа ямар нэг шалтгааны улмаас материал буцаагдвал, эхнээс нь бүх материалыг хавсарган шинээр бүртгүүлж, хүсэлт гаргах шаардлагатай болдог нь цаг хугацаа алдах, процессыг удаашруулах нэг шалтгаан болж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Шат дамжлагын хувьд, баримт бичгээ бүрдүүлээд өгснөөр тусгай зөвшөөрөл авдаг. Гэвч шат дамжлагын процесс нь яамны дотоод зохион байгуулалтаас шалтгаалан ААНБ-д тодорхойгүй байдлыг үүсгэдэг. Тусгай зөвшөөрөл олгож буй байгууллагын албан хаагч баримт бичгийн бүрдлийг нэг бүрчлэн үздэггүй, бүрэн уншиж танилцдаггүй. Тусгай зөвшөөрөл авахад юун түрүүнд тоног төхөөрөмж, барилга байгууламж, үйл ажиллагаа зэргийг бэлэн болсны дараа тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг. Гэтэл туршилтын галлагаа хийх, хашаа, жорлон ухах гэх мэт үйл ажиллагаа явуулахад нийслэл тусгай зөвшөөрөлгүй гэдэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн хариуг албаны зүгээс өгдөг.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирлын тухайд авч үзвэл:

ТЭЗҮ боловсруулахад 20 сая төгрөг шаарддаг боловч өөрсдөө боловсруулж, тэд тамга л дарж өгдөг. Баримт бичиг бүрдүүлээд тусгай зөвшөөрөл авах гэж 1 жил зарцуулсан. 3 жилийн хугацаанд 20 гаруй сая төгрөг зарцуулсан бөгөөд цагдаа, эмнэлгийн байгууллагатай гуравласан гэрээ байгуулах гэж төрийн байгууллага болгоны хаалгыг тогшиж, гуйж явдаг. Зөвхөн ерөнхий үнэлгээ хийлгэхэд 14 хоног болдог бөгөөд барилгын зураг зэрэг 15 сая төгрөг болдог.

Тусгай зөвшөөрөл авах үйл явцад 14 хоногийн дотор хариу өгнө гэж заасан байдаг. Гэвч хэдэн зуун материалыг нэг мэргэжилтэн уншиж судлах боломжгүй байдаг тул тодорхой хугацааны дараа материалуудыг буцааж өгөх шаардлага гардаг.

ЭМЯ-нд хариуцсан мэргэжилтэн нь үргэлж солигддог нь процессыг удаашруулдаг. Нийслэлийн Захирагчийн алба хяналт тавьдаг бөгөөд БОУАӨЯ-аас тусгай зөвшөөрөл олгодог. Тусгай зөвшөөрөл авахад цагдаа, эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулах шаардлагатай байдаг боловч энэ талаар мэдээлэл дутмаг, гэрээний загвар ч байхгүй. Зөвхөн ОБЕГ-т гэрээний загвар байдаг.

Түүнчлэн, эмнэлгийн үйлчилгээний зардал төлөх, онцгой байдлын зайлшгүй багцыг авах шаардлагатай болдог. Байгууллага хооронд уялдаа холбоо байхгүй бөгөөд хоорондоо зөрчилдөөнтэй шаардлага тавьдаг. Жишээ нь, БОУАӨЯ хашаагаа ногоон байгууламжаар бүрдүүлэхийг шаарддаг бол ОБЕГ нь шатах материал угсрах газар ногоон байгууламж байж болохгүй гэж үздэг. Хооронд нь уулзуулсан ч шийдэлд хүрдэггүй. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг 2023 оны 7 дугаар сард мэргэжлийн зөвлөл гаргаж, 18 сарын хугацаа өнгөрсөн ч үйл ажиллагааг эхлүүлж чадаагүй, энэ нь бизнес эрхлэгчид хохирол учруулж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл:

Хуучин МХЕГ-аас хяналт тавьж хормогч зүүгээгүй эсвэл зүү нэвтэрдэггүй бээлий өмсөөгүй гэх шалтгаанаар 3 сая төгрөгөөр торгож байсан. Харин цар тахлаас хойш Нийслэлийн Захирагчийн албанаас хяналт шалгалт хийгээгүй. Хяналт шалгалт мэдээж хийх нь зүйтэй. Гэхдээ сайжруулах зорилготой болохоос дарамтлаад байж болохгүй.

Хятадын компанитай хуйвалдсан байж магадгүй. Хятадын хамааралтай компанид хяналт шалгалт ирдэггүйгээс гадна хурлаар шуурхай ороод зөвшөөрөл авдаг. Үйлдвэрээ барьсны дараа нэг удаа хөндлөнгийн хяналт шалгалт ирж байсан.

Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хурал болох тухай мэдээлэл өгдөг ч бүрдүүлэх баримт бичигтэй холбоотой нэмэлт мэдээлэл авах зорилгоор БОУАӨЯ-ны мэргэжилтнээс лавлахад харилцааны болон хандлагын хувьд асуудалтай байдаг бөгөөд зарим компанид ялгавартай хандах үзэгдэл ажиглагддаг. Тусгай зөвшөөрлийг үзэмжээр олгох хандлага гарч, мэргэжилтнүүд нь мэргэшээгүй байгаагаас нэмэлт материал шаардах, буцаах тохиолдол их байдаг. Баримт бичгийн бүрдүүлэлтээс илүү тайлан мэдээлэл хүсэх байдлаар хавчиж шахах асуудал мөн гарч байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийн тухайд авч үзвэл:

Хөрөнгө оруулалт хийгээд түүхий эд олдохгүй олон компани дампуурсан. Төрийн байгууллагууд хооронд уялдаа холбоо байхгүй учраас хугацаа алдаж, үйл ажиллагаа хүндэрсэн. Олон баримт бичиг бүрдүүлсний дараа зөвхөн "дахин боловсруулах" тусгай зөвшөөрөл олгогдсон. Харин тээвэрлэх, цуглуулах, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхлэхийн тулд тусгай зөвшөөрлөө солиулах гэж оролдсон ч үүнийг хуулийн шаардлага хангахгүй байна. Гуравласан гэрээ байгуулах, төрийн байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй гэдгийг хуульд заасан байдаг ч тухайн төрийн байгууллагуудад гэрээний загвар ч байдаггүй. 2023 оны 7-р сарын 21-нд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар орж тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн ч одоог хүртэл тусгай зөвшөөрөл аваагүй байна. БОУАӨЯ-ны цахим хуудаст тусгай зөвшөөрөл авсан ААНБ-ын жагсаалтад тусгасан боловч, сайд болон дарга нь өөрчлөгдсөнтэй холбогдуулан зөвшөөрлийг авах боломжгүй болсон. Мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл үзүүлсэн ч энэ нь ямар ч нэмэргүй байсаар байна.

Эхний тусгай зөвшөөрлийг авсан байгууллага 5 жилийн дараа тусгай зөвшөөрлөө сунгуулахад, анх бүрдүүлсэн материалуудыг дахин бүрдүүлэх шаардлага үүсдэг. Тухайлбал, компанийн гэрчилгээ, галын хор зэрэг баримт бичгийг өмнө нь өгсөн байхад дахин өгөх шаардлага гардаг. Хоёр удаа хурлын оролцогчоор орсон ч олон баримт бичиг бүрдүүлсний эцэст хуралд 10 минут танилцуулга хийдэг бөгөөд хурлын тов тодорхойгүй, жилд зөвхөн нэг удаа л хуралддаг. Мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргахгүй, зохион байгуулалттайгаар формаль хурал хийж, зөвхөн тамга дардаг байдлаар явуулдаг. Мэргэжлийн зөвлөлд орж 3 удаа хуралд орсон ч хурлын ирц бүрэн биш, мэргэжлийн ямар ч ойлголт, мэдээлэл дутагдалтай байдаг. Ерөнхийдөө мэргэжлийн зөвлөлийн идэвх сул бөгөөд шаардлагатай мэдээллүүдийг өгч чадахгүй байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой арга замын тухайд авч үзвэл:

Удаан хугацааны турш үйл ажиллагаа явуулсан байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах процесс нь анх тусгай зөвшөөрөл авахтай адил байдаг. Энэ нь цаг хугацаа, хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлж байгаа төдийгүй байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иймд, тусгай зөвшөөрлийн сунгалтын үед давхардлыг арилгах, илүү хялбаршуулах шаардлагатай.

Мэргэжлийн зөвлөлд мэргэшсэн эрдэмтэн, судлаачдыг хамруулах нь чухал бөгөөд цаашид мэргэшүүлэх талаас анхаарч, мэргэжлийн мэдлэгтэй, туршлагатай хүмүүсийг оролцуулах шаардлагатай байна. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа сайжирснаар шийдвэр гаргалтын чанарыг сайжруулж, хариуцлагатай мэргэжлийн хяналтыг бий болгоход тусална.

Хог хаягдалтай холбоотой татварын хөнгөлөлт, төрийн бодлогоор дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй. Тухайлбал, хог хаягдлыг дахин боловсруулах үйл явцад төр бодлогоор дэмжих буюу дахин татвар авахгүй болгох хэрэгтэй. Өнөөдөр хог хаягдлыг боловсруулахад нэмэлт мөнгө, татвар төлөх шаардлагатай болж байгаа нь байгууллагуудын хувьд хүндрэл үүсгэж байна. Энэ асуудлыг төрийн бодлогоор шийдэх шаардлагатай.

E-Business, E-Mongolia системээр тухайн байгууллагын захирал эсвэл хувьцаа эзэмшигч орж, баримт бичиг бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг. Иймд, захирлын хүсэлтээр нэмэлт эрх үүсгэж ашиглах саналтай байна. Мөн албан бичиг болон нийтлэг баримт бичгийг цахимаар автоматаар үүсгэх, дахин бүртгүүлэхгүйгээр “нэмэлт материал” өгөх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

БОУАӨЯ-ны мэргэжилтнийг сэлгэж ажиллуулах болон дахин мэргэжилтэн нэмэх нь чухал бөгөөд энэ нь үйл явцын хурд болон чанарыг сайжруулахад туслах болно. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах процессыг илүү хялбар, үр дүнтэй болгохын тулд дээр дурдсан зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Байгаль орчны салбарт хийгдэж буй процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд тус салбараас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж буй 2000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагаас санамсаргүй түүврийн аргаар 300 орчим аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдон судалгааны ажлын зорилгыг танилцуулж, мэдээлэл өгснөөс фокус бүлгийн ярилцлагад 79 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцов.

Фокус бүлгийн ярилцлагын хүрээг тусгай зөвшөөрөл авахтай холбоотой мэдээ, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдэл, цахимжилт, түүний үр нөлөө, үйл ажиллагааны шат дамжлага, үйлчилгээ авахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирол, хяналт шалгалтын үйл ажиллагаа, төрийн байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдал, гарч буй хүндрэл бэрхшээл болон түүнийг сайжруулах санал зэргийг тодорхойлов.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдал, бичиг баримтын бүрдлийн тухайд авч үзвэл:

Бүлгийн ярилцлагад оролцсон аж ахуйн нэгж, байгууллагууд тусгай зөвшөөрөл авах, сунгуулахтай холбоотой мэдээ, мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын сайтаас авдаг байна. Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлт гаргахтай холбоотой нэмэлт шаардлагатай лавлах зүйл гарах тохиолдолд аймаг, нийслэлийн байгаль орчны газрын мэргэжилтэнтэй холбогдож авдаг байна. Бүлгийн ярилцлагад оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь үйл ажиллагаа нь жигдэрсэн сунгуулах хүсэлтээ цахимаар гаргаж шийдвэрлүүлсэн, хүндрэл учраагүй гэсэн байна.

Цахим хуудаст шаардлагатай, бүрдүүлэх материал байдаг бөгөөд хууль болон журамд тусгай зөвшөөрлийн талаарх тодорхой заавар бий ч, уг мэдээлэл нь хангалтгүй байдаг. Мөн цаг

хугацаа шаардсан олон баримт бичгийг бүрдүүлсэн ч зарим тохиолдолд эдгээр баримт бичгүүд нь шаардлагагүй материал байх тохиолдол гарч байсан.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам шинээр батлагдах, эсвэл батлагдсан тохиолдолд албан ёсны сайтаараа дамжуулан шуурхай мэдээллийг түгээдэггүй, сурталчлах, таниулах, үйл ажиллагаа маш сул. Төрд байгаа мэдээллийг бичиг баримтын бүрдүүлбэрт шаардаж байгаа нь хүндрэлтэй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжтэй түрэмгий харьцдаг тул иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд гуйж, загнуулж, байнга хянуулдаг байдал үүсдэг гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой цахимжилт, түүний үр нөлөөний тухайд авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлтийг 2021 оноос эхлэн цахимаар буюу e-mongolia, e-business.mn, eic.mn зэрэг сайтаар дамжуулан гаргадаг болсноор аж ахуй эрхлэгчдийн цаг хугацааг ихээхэн хэмнэж байгааг дурдсан бөгөөд нийт ярилцлагад оролцогчдын дийлэнх нь сэтгэл хангалуун байсан. Харин цахимаар хүсэлтээ өгөхөөс гадна цаасаар давхар өгч байгаа нь хүндрэл учруулдаг гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл олгоход ямар баримт бичиг бүрдүүлэх болон ямар шат дарааллаар явах нь иргэн, аж ахуйн нэгжид тодорхойгүй байдаг. Үүний улмаас зарим тохиолдолд өөр мэдээлэл шаардах, дараа нь бичиг баримтын бүрдэл дутуу гэх мэтчилэн хүндрэл гардаг. Цахим систем нь цаасан материалыг PDF болгон цахимаар явуулдаг, шийдвэрлэлтийн процесс ямар шатандаа явж байгаа нь тодорхойгүй зэрэг цахимжуулалтын байдал хангалтгүй, тусгай зөвшөөрлийг E-business.mn цахим системээр авдаг бөгөөд бичиг баримтын бүрдэлд төрд байгаа мэдээлэл буюу ДАН системээс авах боломжтой мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг нь хүндрэлтэй байдаг байна. Тусгай зөвшөөрлийн хүсэлт нь цаасаар авдаг зүйлээ л цахимаар илгээх процесс байгаа тул цахимжуулалтыг сайжруулах, эргэх холбоотой, уялдаатай болгох шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой үйл ажиллагааны шат дамжлагын тухайд авч үзвэл:

Үйл ажиллагааны шат дамжлагын хувьд Ойн газар байгуулагдахаас өмнө Байгаль орчны ямаар дамждаг, сайдын тушаал хүлээдэг, цаасаар аваачиж өгдөг, орон нутгийн Засаг даргаас бичиг авдаг, яамнаас бичиг авдаг зэрэг хүндрэлүүд байсан. Харин Ойн газар байгуулагдсанаар олон шат дамжлага цөөрсөн гэж үзэж байсан. Мөн 2021 оноос цахимаар хүсэлт авдаг болсонтой холбоотойгоор олон байгууллагад материал өгдөг шат дамжлага цөөрсөн байна.

Цахимаар хүсэлтээ өгч цаг хугацааг хэмнэж байгаа ч тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад шаардлагатай материалыг бүрдүүлэхэд олон төрийн байгууллагаас тодорхойлолт авахтай холбоотой цаг хугацаа, зардал гардаг асуудал байсаар байгааг дурдсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд бүх асуудал төвлөрдөг, шийдвэр гаргах, гарын үсэг зурах, тамга дарах процесс маш удаашралтай байдаг байна. Хариуцсан алба хаагчид нь маш хариуцлагагүй ханддаг. Гаднаас оруулж ирж байгаа бүтээгдэхүүний нэр, марк, орж ирэх гааль, боомтын мэдээлэл зэргийг гэрчилгээ дээр буруу бичдэгээс аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулдаг байна. Иймд гар ажиллагааг багасгасан, хүний алдаанаас хамааралгүйгээр үйл ажиллагааны процессыг сайжруулах шаардлагатай байна.

Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүрдүүлбэрийг аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт эхлээд өгдөг. Аймгийн Байгаль орчны газар аймаг, нийслэлийн Засаг дарга руу явуулдаг. Аймаг, нийслэлийн Засаг дарга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу явуулдаг. Энэ их шат дамжлагыг багасгах хэрэгтэй гэж үзэж байна.

Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авч байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцахгүйгээр зөвхөн цаасан материалын

бүрдлээр тусгай зөвшөөрөл олгож байгаа нь учир дутагдалтай. Шалгуур дээр мэргэжлийн хүн байх ёстой гээд заасан байдаг. Жишээ нь: ажилд томилсон тушаал гаргасан байх, нийгмийн даатгалын шимтгэлийг 3 сар төлсөн байх зэрэг шалгуур байдаг. Тэр нь гэхдээ зөвхөн цаасан дээрх бүрдлээ хангах боломжтой, харин тусгай зөвшөөрөл олгож байгаа зөвлөл, шийдвэр гаргагч нь аж ахуйн нэгжүүдэд газар дээр нь очиж үзэж, боломж, чадамжийг тодорхойлдог байх ёстой гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой зарцуулж буй хугацаа, зардал, хүсэлтийн хугацаандаа шийдвэрлэж буй байдал, төрийн байгууллага, албан тушаалтнаас шалтгаалж хугацаандаа шийдэгдээгүйгээс гарсан эдийн болон эдийн бус хохирлын тухайд авч үзвэл:

Бүлгийн ярилцлагад оролцогчдын хувьд тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад хамгийн багадаа 7 хоног, хамгийн ихдээ 1 хүртэл жилийн хугацааг зарцуулсан талаар дурдсан. Энэ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж цаг хугацаанаас үүдэлтэй эдийн бус хохирол учруулсан гэсэн байна. Тусгай зөвшөөрөл авах болон сунгуулах асуудалд дийлэнх нь хуулийн хугацаандаа шийдэгддэг гэсэн байна.

Мөн тэмдэгтийн хураамжид 10,000-28,000 төгрөг, шинээр тусгай зөвшөөрөл авах үед 300,000, сунгуулах үед 150,000 төгрөгийг тус тус тушааж байсан гэсэн байна. Энэ нь үйл ажиллагааг эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл болдоггүй гэжээ.

Баримт бичиг бүрдүүлэлтэд их хугацаа зарцуулсан бөгөөд нэмэлтээр авах шаардлагатай баримт бичгийн мэдээллийг яамнаас холбогдож хэлдэггүй, харин өөрийн биеэр лавладаг. Сунгалт хийлгэхэд шинээр авахтай адил баримт бүрдүүлдэг нь хүндрэлтэй байдаг гэсэн байна.

Техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад 20 сая төгрөг шаарддаг боловч өөрсдөө боловсруулж, тэд тамга л дарж өгдөг. Баримт бичиг бүрдүүлээд тусгай зөвшөөрөл авах гэж 1 жил зарцуулсан. 3 жилийн хугацаанд 20 гаруй сая төгрөг зарцуулсан бөгөөд цагдаа, эмнэлгийн байгууллагатай гуравласан гэрээ байгуулах гэж төрийн байгууллага болгоны хаалгыг тогшиж, гуйж явдаг. Зөвхөн ерөнхий үнэлгээ хийлгэхэд 14 хоног болдог бөгөөд барилгын зураг зэрэгт 15 сая төгрөг зарцуулдаг.

Тусгай зөвшөөрөл авах үйл явцад 14 хоногийн дотор хариу өгнө гэж заасан байдаг. Гэвч хэдэн зуун материалыг нэг мэргэжилтэн уншиж судлах боломжгүй байдаг тул тодорхой хугацааны дараа материалуудыг буцааж өгөх шаардлага гардаг.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой хяналт шалгалтын үйл ажиллагаа болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгч буй байдлын тухайд авч үзвэл:

Аж ахуй эрхэлж буй байгууллагад БОУАӨЯ, аймгийн БОГ-аас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, Экологийн цагдаагийн алба, Тагнуулын газар, Онцгой байдлын газар мөн хөндлөнгийн хяналт шалгалтыг төрийн болон төрийн бус байгууллагууд зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой зөвлөмж чиглэл өгдөг гэсэн байна. Мөн жил бүр ямар нэг байдлаар хяналт шалгалтууд ирдэг бөгөөд зарим тохиолдолд хугацааны хувьд ойрхон давхардаж ирэх тохиолдол гардаг гэсэн байна.

Яам, агентлагаас жил бүр, тус тусдаа асуумж бэлтгэсэн цаастай, газар дээрх нөхцөл байдлыг шалгах байдлаар хяналт хийгддэг. Төрийн байгууллагуудын зүгээс хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа төрийн албан хаагчид хууль, дүрэм, журамд заагдаагүй материал, техник хэрэгсэл шаардах, асуудалд хувийн үзэмжээр хандах, нэгдсэн удирдамж чиглэлгүй байх, мэргэжлийн бус байх зэрэг асуудлууд гардаг талаар дурдсан.

Хяналт шалгалтын үр дүнд зөвлөмж өгөх байдал нэг ижил хэлбэр, агуулгатай байдаг талаар дурдаж байсан, харин зөвлөмжийг мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжсэн, бүтээлч байдал, инноваци, шинэ санаачилгыг бусад байгууллагад

танилцуулсан зэрэг мэргэшсэн, шинэлэг ажлуудыг зохион байгуулбал аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжирна гэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахтай холбоотой гарсан хүндрэл бэрхшээлийн тухайд авч үзвэл:

Байгаль орчны холбогдолтой мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах болон сунгуулахад тусгай нарийн мэргэжил эзэмшсэн, төгсөгчид багассан, улирлын чанартай үйл ажиллагаанаас хамаарч тогтмол орлоггүйгээс тогтвортой ажиллах мэргэшсэн хүний нөөцийн дутагдалд орсон, улирлын чанартай үйл ажиллагаа явагддаг тул орон нутагт ажиллах туслах ажилтнууд нийгмийн даатгал төлөх хүсэлгүй байдаг, үйлчилгээ явуулахтай холбоотой ойлгомжгүй арга зүй шаарддаг, үйл ажиллагаа явуулахтай холбоогүй мэргэжилтний шаардлага тавигддаг, төрийн байгууллагуудын албан хаагчдын мэргэжлийн ур чадвар муу, давхардсан олон хяналт шалгалт хийгддэг, мэргэжил арга зүйгээр дэмжих байдал муу зэрэг хүндрэлүүдийг дурдаж байсан.

Мөн төрийн байгууллагын үйл ажиллагаа, шат дамжлагаас шалтгаалан аж ахуйн нэгж, байгууллагын хийж буй ажлууд үр дүнгүй болох тохиолдол их гардаг талаар дурджээ. Учир нь байгаль орчныг хамгаалах, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэг хийх, хортон шавжаас хамгаалах, ойд арчилгаа цэвэрлэгээ хийх зэрэг үйл ажиллагаа нь манай орны байгаль, цаг уурын өвөрмөц онцлогоос шалтгаалан байгалийн нөөцийн менежментийг зөв тооцох, тодорхойлох, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Баримт бичиг бүрдүүлэлтийн зарим агуулга нь ямар байгууллагаас авах нь тодорхой биш, химийн бодис импортлох, үйлдвэрлэх, экспортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрлүүдийн бүрдүүлбэрийн ялгаа тодорхойгүй, зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүйн улмаас импортлогч аж ахуйн нэгж, байгууллагын хувьд барааг гааль дээр хонуулж төлбөр төлөх, бодисоо устгуулах зэрэг хүндрэл гардаг.

Төрийн албаны хүнд суртал, албан хаагчдын мэргэшлийн ур чадваргүй байдлаас шалтгаалж, цаг их алдаж байна. Үнэлгээ хийж байгаа компаниудын хувьд, аудитын зөвшөөрөл болон нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байх ёсгүй ч тусгай зөвшөөрлийг төрийн албан хаагчид үзэмжээрээ өгдөг асуудал үүсч байна. Энэ нь тусгай зөвшөөрөл олгох үйл явцад тодорхойгүй байдал, шударга бус шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Тусгай зөвшөөрөл авах үед бусад байгууллагуудын материалыг нэгтгэж, хурлаар шийдвэрлэдэг нь цаг алдах гол шалтгаан болдог. Түүнчлэн, техник, тоног төхөөрөмжийн шаардлага өндөр байдаг нь бичиг баримтын бүрдүүлэлтийг хийхэд хүндрэлтэй асуудал болдог. Төрийн захиргааны төв байгууллагаас илүү Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас (НЗДТГ) тусгай зөвшөөрөл авахад их хэмжээний цаг хугацаа зарцуулдаг. Нэг баримт бичгийг хоёр байгууллагад өгч байсан нь төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоогүй байдлыг илтгэдэг. Мөн тусгай зөвшөөрөл авсан ч ажлаа бүрэн дуусгаагүй байхад, эсвэл ажил эхэлж байх үед зөвшөөрлийн хугацаа дуусах тохиолдол гардаг.

Яамны хүний нөөцийн хувьд мэдээ, мэдээлэл дутмаг байгаа нь хүсэлт гаргасан баримт материалыг дахин өгөх шаардлага гаргахад хүргэдэг. Зарим тохиолдолд нэг баримт бичгийн бүрдүүлбэрийг дахин өгөх шаардлагатай болдог бөгөөд төрийн байгууллагууд хоорондын эргэх холбоо байхгүй нь төвөгтэй байдлыг үүсгэдэг. Тусгай зөвшөөрөл авахад нийт 17 баримт бичиг бүрдүүлдэг бөгөөд тус бүрт нь ойролцоогоор сар гаруй хугацаа зарцуулдаг. Тайланг жилд 2 удаа гаргадаг бөгөөд 5 жилийн хугацаатай сунгуулдаг. Сунгуулахад өмнөх баримт бичгийг мөн адил бүрдүүлдэг. Цаасан хэлбэрээр хүсэлт гаргахад зөвшөөрлийг цуцлах үед ямар учраас, эсвэл цуцалсан талаарх мэдээлэл өгдөггүй. Нарийвчилсан болон ерөнхий үнэлгээг ихэнхдээ бизнесийн талаас хийгддэг бөгөөд ихэнх тохиолдолд яаманд ажиллаж байсан хүмүүс энэ үйл явцад оролцдог.

Судалгааны материал алдагдах нь мэргэжилтнүүдийн хариуцлагагүй байдалтай холбоотой. Цаашид цахимжуулалтын процессыг сайжруулахад мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь

чухал ач холбогдолтой. Мөн E-Mongolia, E-business платформ дээр хүсэлт, материал бүрдүүлсний дараа ямар нэг шалтгааны улмаас материал буцаагдвал, эхнээс нь бүх материалыг хавсарган шинээр бүртгүүлж, хүсэлт гаргах шаардлагатай болдог нь цаг хугацаа алдах, процессыг удаашруулах нэг шалтгаан болж байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой арга замын тухайд авч үзвэл:

УИХ, Засгийн газар, яам, агентлаг зэрэг төрийн байгууллагаас гаргаж буй салбарын хууль, дүрэм, журам, сайдын тушаал болон бусад захиргааны хэм хэмжээний актууд нь салбарын үйл ажиллагаа, бодит нөхцөл байдалтай нийцээгүй, хэт нэг талыг барьсан гэх зэрэг асуудлуудтай батлагдаж байсан. Мөн батлагдсан эрх зүйн баримт бичигтэй холбоотой шийдлийг яам, агентлаг зөвхөн холбоодоор дамжуулан шийдэх гэдэг гэтэл холбоод нь хоорондоо асуудлаа хэлэлцэж ярьдаггүй, холбоодод ороогүй аж ахуйн нэгжүүд олон байдаг тул мэдээлэл тэр бүр хүрдэггүй талаар дурдаж байсан.

Иймд яам, агентлаг шийдвэр гаргахдаа мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй бүх аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас санал авдаг тогтолцоонд шилжих шаардлагатай. Мөн эрх зүйн баримт бичгийн шинэчлэл болон цахимжилттай холбоотой шинэчлэлийг хийхдээ хугацаа тулгаж мэдээлэл хүргэдэг гэсэн байна.

Төрийн байгууллагууд нь мэргэжлийн байгууллагуудаар хийлгэх үйлчилгээг өөрсдөө хийх тохиолдол гарч, энэ нь мэргэжлийн байгууллагыг үнэгүйдэлд хүргэж, өрсөлдөөнийг хязгаарлах асуудал үүсгэж байна. Үүнийг засах, мэргэжлийн байгууллагуудыг дэмжихийн тулд тусгай зөвшөөрлийн шаардлагыг сайжруулах хэрэгтэй.

Мөн тусгай зөвшөөрөл авсан байгууллагын мэдээллийг нээлттэй байлгах, давхардаж байгаа хүний нөөцийг шалгах шаардлагатай. Аймгуудын уул уурхайн байгууллагууд техникийн нөхөн сэргээлтийг өөрсдөө хийж байгаа нь мэргэжлийн байгууллагуудын үнэ цэнийг унагаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд санхүүгийн эх үүсвэр гаргаж, нөхөн сэргээлт хийлгэх шаардлагатай.

Мэргэжлийн байгууллагуудыг дэмжих, тэдний үнэ цэнийг хадгалах, мэргэшсэн хүмүүст цол зэрэг олгох асуудлыг шийдэх шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар, яамнаас энэ тал дээр ямар ч бодлого хэрэгжүүлж байгаагүй, төрийн байгууллагууд нь мэргэжлийн байгууллагуудтай өрсөлдөх шаардлага гарч байна.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай бөгөөд энэ нь төрийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, ажил үүргийн үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй.

Нэг тусгай зөвшөөрөл авах үед дараагийн бусад тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай болдог. Тайланг олон удаа нэхэхээс илүүтэйгээр, даатгалын мэдээллийг нэг удаа шалгаж, хяналт тавихад хангалттай байвал илүү тохиромжтой байна. Жил бүр олон удаа тайлан нэхэх нь хүндрэл учруулж байна. Мөн 5 жилийн хугацаа үйл ажиллагаа эрхлэхэд хангалтгүй бөгөөд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул байдаг.

Удаан хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах процесс нь анх тусгай зөвшөөрөл авахтай адил байдаг. Энэ нь цаг хугацаа, хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлж байгаа төдийгүй байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Иймд, тусгай зөвшөөрлийн сунгалтын шат дамжлага, шаардлагыг багасгах, илүү хялбаршуулах шаардлагатай.

Мэргэжлийн зөвлөлд мэргэшсэн эрдэмтэн, судлаачдыг хамруулах нь чухал бөгөөд цаашид мэргэшүүлэх талаас анхаарч, мэргэжлийн мэдлэгтэй, туршлагатай хүмүүсийг оролцуулах шаардлагатай байна. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа сайжирснаар шийдвэр гаргалтын чанарыг сайжруулж, хариуцлагатай мэргэжлийн хяналтыг бий болгоход тусална.

Хог хаягдалтай холбоотой татварын хөнгөлөлт, төрийн бодлогоор дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй. Тухайлбал, хог хаягдлыг дахин боловсруулах үйл явцад төр бодлогоор дэмжих буюу

дахин татвар авахгүй болгох хэрэгтэй. Өнөөдөр хог хаягдлыг боловсруулахад нэмэлт мөнгө, татвар төлөх шаардлагатай болж байгаа нь байгууллагуудын хувьд хүндрэл үүсгэж байна. Энэ асуудлыг төрийн бодлогоор дэмжих шаардлагатай.

E-Business, E-Mongolia системээр тухайн байгууллагын захирал эсвэл хувьцаа эзэмшигч орж, баримт бичиг бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг. Иймд, захирлын хүсэлтээр нэмэлт эрх үүсгэж ашиглах саналтай байна. Мөн албан бичиг болон нийтлэг баримт бичгийг цахимаар автоматаар үүсгэх, дахин бүртгүүлэхгүйгээр “нэмэлт материал” өгөх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Иймээс бүрэн цахимжуулалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд энэ нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, цаашдын шалтгааныг бууруулахад туслах болно гэсэн байна.

2.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа байгууллагууд EIC.mn мэдээллийн санг ашиглаж байгаа бөгөөд тус мэдээллийн сан нь нийт 23 суурь мэдээллийн сантай, эдгээр нь 53 дэд мэдээллийн сангаас бүрдэж байна. (Хавсралт Хүснэгт Байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл)

Байгаль орчны мэдээллийн сан нь дараах хуулиуд, журмаар зохицуулагддаг. Үүнд:

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль** (7-р бүлэг)
- **Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 85-р тогтоол** – “Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам”

Түүнчлэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын баталсан дараах журмууд байна.

- 2013 оны А/53 тушаалын хавсралт – “Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, хөтлөх журам”
- 2014 оны А/86 тушаал – “Улсын нөөцийн мэдээллийн сангийн үзүүлэлт, хөтлөх журам”
- 2018 оны А/428 тушаал – “Хог хаягдлын мэдээллийн сангийн тогтолцоо, бүрдэл”
- 2022 оны А/324 тушаал – “Генетик нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах журам”

Байгаль орчны мэдээллийн сан болон цахим хуудас, дэд системүүдийн хүртээмж, агуулгын шинэчлэлт, мэдээллийн чанарт дараах нийтлэг асуудлууд илэрч байна.

Хүснэгт 61. Илэрч байгаа асуудлууд

№	Асуудлууд	Асуудлын тоо
1	Мэдээллийн шинэчлэл, баяжилт хийгдээгүй	17
2	Мэдээлэл байхгүй	12
3	Системийн хөгжүүлэлт шаардлагатай	11
4	Статистик, тайланд хугацааны мэдээлэл байхгүй	8
5	Мэдээлэл хэт ерөнхий	6
6	Бусад	7

Байгалийн гамшгийн сан, цөлжилтийн мэдээллийн сан, зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, ан агнуурын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан, Байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сангийн зарим мэдээлэл шинэчлэл, баяжилт хийгээгүй 2-9 жил болсон.

Одоогийн байдлаар байгаль орчны мэдээллийн сангуудад мэдээллийн давхардал их байна. Жишээлбэл:

- Байгаль орчны мэдээллийн сангийн 53 дэд сангийн 24-т нь статистик болон тайлангийн цэс байдаг ч үүнээс гадна тусдаа **Байгаль орчны статистикийн мэдээллийн сан** ажиллаж байна.
- Мөн 30 дэд сан нь газарзүйн цэстэй боловч **тусдаа Гео-мэдээллийн сантай**.

- 13 дэд сан нь хууль, эрх зүйн цэстэй ч **тусдаа Байгаль орчны эрх зүйн мэдээллийн сан** ажиллаж байна.

Түүнчлэн, **Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санд** орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл орсон байдаг ч энэ төрлийн мэдээллийг агуулсан **тусдаа мэдээллийн сан** бий.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн статистик тайланд байгаа

- зөрчилгүй орон нутгийн ТХГН,
- хууль, эрх зүйн зөрчилтэй орон нутгийн ТХГН,
- газарзүйн байршлын давхцсан зөрчилтэй мэдээний тайлангийн мэдээллийг **улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санд нэгтгэж**, мэдээллийн сангуудыг цэгцэлж, нэг болгох нь ач холбогдолтой юм.

Байгаль орчны статистик мэдээллийн сангийн "БОХ маягт" цэс болон статистикийн тайлангийн "БОХ маягт" хэсэгт ижил агуулгатай мэдээллийг хоёр өөр хэлбэрээр оруулсан нь хэрэглэгчдэд ойлгомжгүй байдал үүсгэж, мэдээлэл ашиглахад хүндрэл учруулж байна. Түүнчлэн, Байгаль орчны мэдээллийн сангуудаас байгаль орчны салбарын үндсэн үзүүлэлтүүдийг шууд харах боломжгүй байгаа нь мэдээллийн нээлттэй байдал, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Одоогийн байдлаар систем хоорондын уялдаа холбоо хангалтгүй, өгөгдлийн бүтэц задгай бөгөөд нэгдсэн бус байна. Энэ нь мэдээллийн хэрэглээ, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд салбарын шийдвэр гаргалт, бодлого боловсруулалтад шаардлагатай мэдээллийн сан бүрдүүлж чадахгүй байна.

Мэдээллийн сан дахь өгөгдөл нь салбарын харьяа байгууллагуудаас тус тусдаа оруулж байгаа нь нэгдсэн бүтэц бий болоход саад болж, салбарын нэгдсэн статистик, анхан шатны мэдээллийг харахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна. Үүний улмаас дараах асуудлууд илэрч байна:

- Өгөгдлийн уялдаа холбоо хангалтгүй: Өгөгдлийн мэдээлэл хоорондоо уялдаагүй бөгөөд энэ нь өгөгдлийг интеграцилах, нийцүүлэхэд хүндрэлтэй болгож байна.
- Өгөгдөл бүрэн ашиглагдахгүй: Өгөгдлийн цуглуулалт, боловсруулалт нь **дутмаг** бөгөөд бүрэн ашиглах боломжгүй, үр дүнгүй.
- Нэгдсэн үзүүлэлт гаргахад хүндрэлтэй: Тухайлбал, олон байгууллагаас нэгтгэсэн мэдээллийг үзүүлэлтээр харуулахад шаардлагатай мэдээллийн бүтээмж, боловсруулалт дутагдаж байна.
- Байгаль орчны бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээлэл хангалтгүй: Шийдвэр гаргах, бодлого боловсруулахад мэдээллийн хомсдол үүссэн нь оновчтой, зөв шийдвэр гаргахад саад болж байна.

Байгаль орчны мэдээллийн сангийн менежментийн бүтцийн хувьд дараах байдалтай байна.

1. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт

- Байгаль орчны мэдээлэл нь хуулиар тогтоосон бүтэцтэй байна.
- Мэдээллийг цуглуулах үүргийг хуулиар тогтоосон байгууллагууд хариуцна.
- Орон нутгийн мэдээллийг тухайн шатны Засаг дарга нар зохион байгуулна.
- Мета өгөгдлийг MNS 5774:2007 стандартаар бүрдүүлнэ.

2. Мэдээллийн боловсруулалт

- Мэдээлэл өгсөн байгууллага анхан шатны боловсруулалт, үнэн зөвийг хариуцна.
- Улсын санд төвлөрсөн мэдээллийг Байгаль орчны мэдээллийн төв нэгтгэн боловсруулна.

3. Мэдээллийг түгээх, ашиглах

- Мэдээллийг Байгаль орчны мэдээллийн төв түгээнэ.
- Мэдээлэл ашиглахдаа эх сурвалжийг заавал дурдана.
- Зарим мэдээллийг үнэ төлбөртэйгээр түгээж болно.

4. Мэдээллийг хадгалах, хамгаалах

- Аюулгүй байдлыг хангаж, мэдээллийг жил бүр нөөцөлж хадгална.

- Мэдээлэлтэй харьцдаг төхөөрөмжүүдэд аюулгүй байдлын хатуу шаардлага тавина.
- Хандалт бүрт хяналт, тайлагнал хийгдэнэ.

Өгөгдлийн менежментийн хөгжлийн түвшин

Өгөгдлийн менежментийн процесс нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтад өгөгдлийг хэрхэн үр ашигтай ашиглаж байгааг үнэлэх чухал шалгуур үзүүлэлт болдог. Дэлхий дахинд нийтлэг ашигладаг өгөгдлийн менежментийн хөгжлийн таван түвшинг дараах байдлаар тодорхойлдог.³⁹ Үүнд:

1. Эхлэлийн түвшин (Ad hoc): Өгөгдлийн менежмент нь бүтэцгүй, системгүй, эмх замбараагүй байдалтай байна. Үйл ажиллагаа хувь хүний санаачилга, нөөц бололцоонд тулгуурладаг.
2. Удирдлагатай түвшин (Managed): Зарим тодорхой процесс, журам хэрэгжиж эхэлсэн боловч байгууллагын хэмжээнд стандарт, хариуцлага, хяналт сул байна.
3. Тодорхой түвшин (Defined): Өгөгдлийн менежменттэй холбоотой бодлого, журмууд албан ёсоор боловсруулагдаж, байгууллагын хэмжээнд хэрэгжиж эхэлдэг.
4. Тоон үзүүлэлтэд суурилсан удирдлагын түвшин (Quantitatively Managed): Өгөгдлийг тогтмол хэмжиж, чанарт хяналт тавьж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад үр дүнтэй ашигладаг.
5. Оновчлох түвшин (Optimizing): Өгөгдлийн ашиглалтад суурилсан тасралтгүй сайжруулалт, инновац нэвтэрч, байгууллагын үр нөлөө, уян хатан байдал нэмэгддэг.

Энэхүү загварыг ашиглан БОУАӨЯ-ны харьяа мэдээллийн системүүдийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагыг үнэлэх боломжтой.

Зураг 123. Өгөгдлийн менежментийн процессын төлөвшлийн үе шат



³⁹ Мэдээллийн менежментийн төлөвшлийн загвар (Data management maturity model) <https://cmmiinstitute.com/data-management-maturity>

retrieved from

Дүгнэлт

Байгаль орчны салбарын мэдээллийн менежментийн өнөөгийн түвшинд хийсэн шинжилгээгээр тус яамны өгөгдөлтэй холбоотой үйл ажиллагаа нь өгөгдлийн менежментийн боловсронгуй байдлын таван түвшний эхний шат болох “Эхлэлийн түвшин (Initial/Ad hoc)”-д байгаа нь тогтоогдлоо. Энэ түвшинд өгөгдлийн менежмент нь эмх цэгцгүй, тогтсон бодлого, стандартгүй, харилцан уялдаагүй, хувь хүний туршлага, санаачилга дээр суурилсан байдлаар явагддаг.

Тухайлбал:

- EIC.mn мэдээллийн систем нь тайлан болон өгөгдлийг хадгалах боломжтой боловч бүрэн ашиглагдахгүй, өгөгдөл боловсруулахад хүндрэлтэй байна.
- Систем хоорондын уялдаа хангалтгүй, өгөгдөл нь нэгдмэл бус, задгай бүтэцтэй байгаа нь мэдээллийн хүртээмж, ашиглалтад сөргөөр нөлөөлж байна.
- Салбарын байгууллагууд өгөгдлийг тус тусдаа оруулдаг тул өгөгдлийг нэгтгэх, нэгдсэн дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй нөхцөл үүсэж байна.
- Байгаль орчны төлөв байдлын үндсэн үзүүлэлтүүд хугацаандаа шинэчлэгдэхгүй, хоцрогдсон байдалтай байна (жишээлбэл, 2019–2020 оны тайлан 2023 онд мэдээллийн санд нэмэгдсэн).

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1-8 дахь хэсэгт Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацааг хуульчилан заасан боловч хуулийн хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт тавих асуудал хангалтгүй байна.

Эдгээр нөхцөл байдал нь бодлого боловсруулалт, төлөвлөлт, шийдвэр гаргалтад шаардагдах нотолгоонд суурилсан мэдээллийг цаг хугацаанд нь бүрдүүлж, үр дүнтэй ашиглах боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн өгөгдөлд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний систем бүрэлдээгүй байгаа нь байгууллагын дотоод засаглал, гүйцэтгэлийн удирдлагад сөргөөр нөлөөлж байна.

Иймд цаашид дараах чиглэлүүдэд анхаарч, өгөгдлийн менежментийг “Удирдлагатай” (Level 2) болон “Тодорхой” (Level 3) түвшин рүү шат ахиулах шаардлагатай байна:

- Байгууллагын хэмжээнд өгөгдлийн менежментийн бодлого, журам, стандарт боловсруулж хэрэгжүүлэх;
- Нэгдсэн мэдээллийн системийн архитектур бий болгох, систем хоорондын уялдааг сайжруулах;
- Өгөгдлийн чанар, бүрэн бүтэн байдал, уялдаатай байдалд хяналт тавих тогтолцоо хөгжүүлэх;
- Өгөгдлийг бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад үр дүнтэй ашиглах чадварыг бэхжүүлэх, хэрэглэгчдийг чадавхжуулах.

Байгаль орчны мэдээллийн сан нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулагдсан мэдээллийн сангийн дэд бүтэц нь хөгжсөн УИХ, Засгийн газар, салбарын яам болон хэрэглэгчдийг судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах мэдээллийн эх үүсвэр байх шаардлагатай бөгөөд иргэдийн мэдэх эрхийг хангах хүрээнд олон төрлийн мэдээллийг өөртөө агуулсан байх тул мэдээллийн аюулгүй байдал, хөгжүүлэлт, боловсруулалт, үйлчилгээ үзүүлэх зэргийг хариуцах оновчтой бүтцийг хийх хэрэгцээ, бодит шаардлага үүссэн байна.

Эдгээр алхмуудыг хэрэгжүүлснээр БОУАӨЯ нь өгөгдөлд суурилсан ухаалаг удирдлагын шинэ шатанд гаргаж, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах зорилтуудаа илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийн мэдэх эрхийг хангах боломжийг бүрдүүлэх болно.

2.6. “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний эхний үе шатны бодлого, эрх зүй, зохион байгуулалтын талаар тавьсан зорилт амжилттай хэрэгжиж, хөдөлгөөнийг хэрэгжүүлэх стратеги үйл

ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, түүний биелэлтийг хариуцах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газар байгуулагдсан, төсвийн бус хөрөнгийн эх үүсвэрийг дайчлан хөдөлгөөнд оролцох уул уурхайн аж ахуйн нэгж, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, банк, санхүүгийн байгууллагууд, цэрэг цагдаа, хүчний хүчний байгууллагууд мод тарих амлалт өгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай 3 талт гэрээ байгуулсан байна. Дэлгэрэнгүй тоо мэдээллийг доорх хэсэгт дурдав.

Холбогдох эрх зүйн орчин:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (UNFCCC) ба Парисын хэлэлцээр-2015 (2016.09.01)
- Монгол Улсны Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд үг хэлэхдээ "... уур амьсгалын өрчлөлт, цөлжилтийг сааруулах хамгийн үр ашигтай арга бол мод тарих явдал мөн гэдгийг онцолж, 2030 он гэхэд Монгол Улс тэрбумаар тоологдох хэмжээний мод тарих хөдөлгөөнийг эхлүүлнэ" гэдгээ мэдэгдсэн.
- Монгол Улсын Ерөнхийлөгч "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлиг гаргасан. (2021.10.04)
- Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон. (2022.06.03)
- Засгийн газрын хуралдаанаар "Тэрбум" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Ойн газар"-ыг байгуулахаар шийдвэрлэсэн. (2022.07.05)
- Монгол Улсын Шадар сайдын ахалсан "Уур амьсгалын Үндэсний хорооноос баталсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө" батлагдсан. (2023, №01)

Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг 2021-2024 онууд хүртэл "бэлтгэл", 2025-2027 онуудыг "эрчимжүүлэх", 2020-2030 онуудыг "тогтвортой үргэлжлэх" гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Тус хөдөлгөөний хүрээнд нийт 1.509.600.000 сая мод тарихаар төлөвлөсөн. Нийт 12,1 их наяд төгрөгөөр тарьж 5 жилд ургуулах зардалд, нэг модыг 7,836 орчим төгрөг болно гэж тооцоолжээ. Гэхдээ Тэрбум үндэсний хөдөлгөөнд зориулсан зардал, төсөв гэж байхгүй. Ойн газар дээр ойжуулах хөтөлбөр гэж явдаг. Энэ зардлаасаа мод тарьж байгаа зардлуудаа Тэрбум модны хүрээнд хийж байгаа гэж тайлагнаж байна.

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай гурвалсан гэрээ байгуулж, доорх амлалтуудаар 1.544.100.000 ширхэг мод тарихаар байна. Үүнд:

- Нийгмийн хариуцлагын хүрээнд 22 Уул уурхайн аж ахуйн нэгжүүд 608.5 сая мод;
- Аймаг, нийслэлийн 22 Засаг дарга нартай (ЗДТГ)-680 сая мод;
- Банк, санхүүгийн 17 байгууллага 88.6 сая мод, үүнээс 11 банк нь 55 сая мод;
- Төрийн байгууллага (8 Цэрэг, цагдаа, хүчний байгууллага) 167 сая мод;

Хүснэгт 62. Суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх тооцоо⁴⁰

Үндсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлын төрөл	Суурь он (2020)	Дунд хугацаанд (2020)	Зорилтод хугацаанд (2020)
Үр бэлтгэх, боловсруулах хүчин чадал, кг	2325	5 дахин	10 дахин
Тарьц, суулгац ургуулах хүчин чадал, сая ширхэг	37,1	2 дахин	5 дахин

⁴⁰ Ц. Банзрагч (PhD), ШУТИС-ын харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн. 2025 он

Ойжуулах хүчин чадал, га	5,000	4 дахин	6 дахин
Мэргэжлийн хүний нөөцийн хэрэгцээ, тоо	1200	5 дахин	10 дахин

Судалгаанаас харахад ойжуулалт, мод үржүүлгийн аж ахуйн суурилагдсан хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ажилчдын тогтвор суурьшил, ажиллах нөхцөлийг хангах замаар ойжуулагч ажилчдын өрсөлдөх чадварыг сайжруулах механизмыг агуулсан зорилтод төлөвлөгөө боловсруулж, тодорхой шийдвэрийг УИХ, Засгийн газрын түвшинд гаргуулж, биелэлтийг ханган ажиллах хэрэгцээ байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж эхлэхэд Монгол Улсын ойн сангийн ойрхог чанар 7.96 хувь байсан бол 2022 онд 8.07 хувь, 2023 онд 8.18 хувь, 2021 оноос 2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 8.28 хувийг эзэлж байна. Ойрхог чанар 2021 оныг 2024 онтой харьцуулахад $8.28 - 7.96 = 0.32$ хувиар нэмэгдсэн дүн гарсан байна. Таримал ой 2021 онд 7.9 мянган га талбайг хамарч байсан бол 2024 оны байдлаар 9.4 мянган га талбайд ургаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж эхэлснээс хойш таримал ойн талбайн 1.5 мянган га талбайгаар нэмэгдсэн байна. Жил бүр иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлэх зорилгоор таримал ойг худалдан авах арга хэмжээг зохион байгуулж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр аймгуудын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр 12197 га талбайд доор дурдсан чиглэлүүдээр газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан байна. Үүнд:⁴¹

- Ногоон байгууламж бий болгох 206 га
- Мод үржүүлгийн газар байгуулах 1029 га
- Ойн зурвас байгуулах 1694 га
- Ойжуулах, нөхөн сэргээх 8233 га

2021-2024 оны хооронд шинээр 18 аймгийн 28 сум, Улаанбаатар хотын 6 дүүргийн хэмжээнд 2,006.35 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 655,438.00 ширхэг мод, сөөгийг тарьж, 11.5 га талбайд зүлэгжүүлэлт, 64,056 м² талбайд 3,202,800.00 ширхэг цэцэгт ургамлаар цэцгийн мандал байгуулаад байна. Эдгээр үйл ажиллагаанд 26.6 мянган иргэн, 1000 орчим аж ахуйн нэгжүүд оролцсон байна.

Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд доорх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь цөлжилт, газрын доройтлыг бууруулах бодит алхам болж байгаа бөгөөд доройтсон газрыг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход тодорхой үр дүнд хүрч байгаа гэж үзжээ. 2024 оны байдлаар 84.0 сая мод тарьж бэлтгэл үе шатны гүйцэтгэл 42.4%-тай байна гэж дүгнэсэн байна.⁴²

Баруун бүсэд мөнх цас, мөсөн гол, мөнх цэвдгийн хайлалт явагдаж байгаад анхаарач Монгол Улсын Засгийн газраас “Нэг сум - Нэг нуур” буюу 333 нуур хөтөлбөрийг Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Мөн ойн сан, намаг бүхий гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамарсан 35.1 сая талбайг тусгай хамгаалалтад авч цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан цаг уурын радиотарын нэгдсэн системийн сүлжээ байгуулахаар ажиллаж байна.

⁴¹ БОУАӨЯ-ны тайлан, 2024

⁴² УИХ-ын нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдын хэлсэн үг 2025/03/28

Гадаргын ус хуримтлуулсан хөв цөөрмийг хамгаалах, голын ай сав татмыг ойжуулах ажлыг 2023-2024 онд 16 байршилд 160 га талбайд зохион байгуулжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 83.9 сая модыг тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна. Хамтран ажиллах гэрээ байгуулсан Улаанбаатар хот, аймгууд 38.4 сая мод модыг тарьж, гүйцэтгэл 5.71%-тай байна. Эдгээрээс Сэлэнгэ аймаг өнгөрсөн хугацаанд 16.7 сая мод тарьж амлалтынхаа 84%-ийг бэлтгэл үе шатандаа гүйцэтгэжээ. Аймгуудаас Говь-Алтай, Дундговь зэрэг аймгууд мод үржүүлгийн газар хүчин чадал, тарьц суулгац, мэргэжилтэй боловсон хүчний нөөц дутмаг, үндэсний хөдөлгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа учир бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр хариуцлагын гэрээ байгуулан амлалт авсан уул уурхайн томоохон 22 аж ахуйн нэгжүүд шууд хэлбэрээр 9.2 сая мод, дүйцүүлэх хэлбэрээр 23.9 сая мод, нийт 33.1 сая мод тарьсан гүйцэтгэл 5.4%-тай байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх, бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг дүйцүүлэх хэлбэрээр хийхээр “Оюу толгой” ХХК болон “Эрдэнэс тавантолгой” ХХК-тай гэрээ болон санамж бичиг байгуулжээ. Хариуцлагын гэрээ байгуулсан уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 4.1 сая мод тарьж ургуулан манлайлан ажиллаж байна. “Алтай хүдэр” ХХК, “Бүрдэл майнинг” ХХК нь мод үржүүлгийн газрын хүчин чадал, тарьц суулгац, мэргэжилтэй боловсон хүчний нөөц дутмаг гэсэн шалтгаанаар хэрэгжилт хангалтгүй байна.


Ойн тухай болон Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу 7 чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрх олгодог. Одоогийн байдлаар 650 гаруй аж ахуйн нэгж мэргэжлийн байгууллагын эрх авч үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү үзүүлэлт нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш **32.3 хувиар** нэмэгдээд байна. Мэргэжлийн байгууллагын эрх авсан аж ахуйн нэгжийн 43 хувь нь мод үржүүлэг, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр байна.

Европын Холбооноос олон Улсын хэмжээнд санаачлан гаргасан “Ойн түншлэл”-д Ази тивээс Монгол улс нэгдэн орж 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Ойн түншлэлийн хэрэгжүүлэх арга хэмжээний “Замын зураг”-ийг талууд эцэслэн баталж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагааг эхлүүлжээ.

Монгол Улс, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай” хамтарсан мэдэгдлийн хүрээнд Монгол Улсын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих, Монгол-Хятадын цөлжилтийг сааруулах хамтын ажиллагааг өргөжүүлэхээр болсон. Энэ ажлын эхлэл болгон цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төв байгуулах суурь судалгааны ажлуудыг хийхээр Бээжингийн Их Сургууль томилогдон нарийвчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах хоёр улсын хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихаас гадна ойн санг хамгаалах ажил зайлшгүй хийгдэх шаардлагатай байна. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааны ажлыг 16 аймгийн 132 сумын 2.0 сая га талбайд гүйцэтгэж 490.4 мянган га талбайд голомт үүсээд байгааг тогтоов. Ойн санг хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 341 мян.га талбайд ойн мэргэжлийн 27 байгууллага гүйцэтгэж, 1.9 тэрбум модыг хөнөөлт шавжид өртөн сэргэн ургах чадвараа алдахаас хамгаалаад байна.

Зураг 124. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний биелэлт



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш улсын хэмжээнд 39 зүйлийн мод сөөгийн 12.1 тонн үрийн нөөц бүрдүүлсэн. Энэхүү үзүүлэлт нь өмнөх жилүүдтэй харьцуулахад даруй 4.5 дахин нэмэгдсэн байна. Ойн үрийн чанарын холбогдох стандартуудын дагуу тоймлон үзэхэд дээрх үрийн нөөцөөр 39 төрлийн 291.7 сая ширхэг тарьц, суулгац ургуулах боломжтой юм.

Хүснэгт 63. Мод, сөөгийн үрийн нөөц

№	Зүйлийн нэр	Үрийн нөөц, кг	Ургуулах боломжит тарьц, суулгацын тоо, ширхэг
ДҮН			291,784,486
1	Нарс	628.2	28,044,643
2	Шинэс	1018.5	36,375,000
3	Хуш	664.5	765,553
4	Жодоо	2.4	54,545
5	Гацуур	11.82	579,412
6	Голт бор	363.7	9,092,500
7	Өрөл	361.9	22,618,750
8	Монос	1388.8	5,341,538
9	Долоогоно	200.3	1,925,962
10	Шар хуайс	1595.7	15,957,000
11	Агч	766.15	6,178,629
12	Гүйлс	1816.1	648,607
13	Буйлс	852	532,500
14	Жигд	388.9	1,080,278
15	Заг	377.8	37,780,000
16	Тэхийн шээг	46.45	3,628,906
17	Чацаргана	77.9	1,498,077
18	Далан хальс	13.8	1,150,000
19	Хус	21.9	27,375,000
20	Хайлаас	1146.8	47,783,333
21	Улиас	4.3	5,375,000
22	Нохойн хошуу	30.6	637,500
23	Харгана	24.8	344,444
24	Тавилгана	34	32,692,308
25	Бусад – 14 зүйл	346	4,325,000

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнд хүргэх, амжилттай хэрэгжүүлэх гол үндэс суурь нь мод үржүүлгийн газруудыг дэмжих, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх ажил юм. Улсын хэмжээнд мод үржүүлгийн газруудын бүртгэл, тарьц, суулгацын нөөцийн хэмжээг тодорхойлох ажлыг 2024 онд зохион байгуулжээ. Тооллогоор улсын хэмжээнд 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 76 иргэн, 25 нөхөрлөл, 351 аж ахуй нэгж, байгууллага нийт 21 овог, 52 төрөлд багтах 124 зүйлийн 61.9 сая ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлсэн байна. Энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад даруй 5 дахин өссөн

үзүүлэлт бөгөөд үүнээс дүгнэхэд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх бүрэн боломжтой байна.

Хүснэгт 64. Тарьц, суулгацын нөөц

№	Аймгийн нэр	Тоо хэмжээ				Төрөл зүйл	Тарьц, суулгацын тоо (ш)
		Аж ахуй нэгж	Иргэн	Нөхөрлөл	Нийт дүн		
Нийт дүн		335	76	25	436	-	61,972,429.00
1	Архангай	7	1	1	9	23	192,521.00
2	Баян-Өлгий	4	2	-	6	6	874,500.00
3	Баянхонгор	10	-	-	10	17	380,536.00
4	Булган	21	7	-	28	25	3,870,014.00
5	Говь-Алтай	6	3	-	9	17	374,090.00
6	Говьсүмбэр	5	-	-	5	10	115,467.00
7	Дархан-Уул	16	3	2	21	30	1,559,315.00
8	Дорноговь	4	-	-	4	7	316,790.00
9	Дорнод	17	3	-	20	23	2,585,124.00
10	Дундговь	3	-	-	3	8	522,260.00
11	Завхан	21	2	-	23	26	850,694.00
12	Орхон	8	7	-	15	21	1,442,973.00
13	Өвөрхангай	19	1	-	20	25	5,772,307.00
14	Өмнөговь	16	-	-	16	26	2,956,007
15	Сүхбаатар	5	-	-	5	12	543,510.00
16	Сэлэнгэ	65	10	16	91	35	19,645,432.00
17	Төв	28	-	-	28	81	12,947,114.00
18	Увс	18	32	2	52	25	1,503,782.00
19	Улаанбаатар	32	-	-	32	30	2,965,958.00
20	Ховд	23	5	4	32	23	1,168,470.00
21	Хөвсгөл	13	-	-	13	20	254,870.00
22	Хэнтий	10	-	-	10	25	1,130,695.00

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх цахим сургалтыг БОАЖЯ, БШУЯ, МУИС, ШУА-ын харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран 2022 оны 05 дугаар сард зохион байгуулж, 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нийт 1017 хүнийг хамруулсан байна. Сургалтад хамрагдсан хүмүүст БОАЖЯ болон БШУЯ-ны баталсан сургагч багшийн сертификат болон гарын авлагыг олгосон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлигийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах...” гэж заасан. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үйл ажиллагааныхаа хүрээнд 9 хөтөлбөр, 87 байгууллага 3207 орон тоотой 729.2 тэрбум төгрөгийн төсөвтэй 2024 онд үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 537.4 тэрбум төгрөг буюу 74 хувийг урсгал төсөв, 191.8 тэрбум төгрөг буюу 26 хувийг хөрөнгө оруулалт байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2022 онд ДНБ-ний 0.28 хувь, 2023 онд ДНБ-ний 0.29 хувь, 2024 онд ДНБ-ний 0.35 хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.⁴³

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс Ойн газар, орон нутгийн төсвөөс аймаг, сум, сум дундын нийт 40 ойн ангийн үйл ажиллагаа санхүүжсэн байна. Ойжуулалтын чиглэлд үйл

⁴³ БОУАӨЯ-ны тайлан, 2024

ажиллагаа эрхлэгч байгууллагуудын төсвийн зардлын дийлэнх хувийг ойжуулалт болон үндсэн үйл ажиллагааны зардал эзэлж байна.⁴⁴

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байна.

Улсын төсвөөс:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт ирсэн тайлангуудаас нэгтгэн үзэхэд хамтран ажиллах гэрээ байгуулсан аймгууд тайлант хугацаа болох 2021-2023 онуудад 46.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд зарцуулсан. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн эрчимжиж байгаатай холбоотойгоор улсын төсвөөс "Ойжуулалт хөтөлбөр"-т 2022 онд 1.9 тэрбум төгрөг байсан зардал 2023 онд 15.0 тэрбум төгрөг болж 8 дахин, 2024 онд 45,1 тэрбум төгрөг, 2025 онд 68.3 тэрбум төгрөг болж 2022 онтой харьцуулахад 35.4 дахин өссөн байна.

Орон нутгийн төсвөөс:⁴⁵

• Сумдын болон сум дундын нийт 43 ойн анги болон 1 Засаг даргын Тамгын газарт төсөв хуваарилагдсан байна. Батлагдсан төсвийн 89.3 хувь буюу 8.8 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал, 7.3 хувь буюу 716.4 сая төгрөгийг ойжуулалт, 1.9 хувь буюу 181.9 сая төгрөгийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардалд тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс ойжуулалтын зардал болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлуудыг ангилан харах боломжтой байна.

2024 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон орон нутгийн байгаль орчны байгууллагуудын нийт төсөв 116.5 тэрбум төгрөг батлагдсан байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, ойжуулалт, ойг нөхөн сэргээх, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр олон улсын байгууллагууд болон бусад улс орнуудтай хамтран ажиллах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, дэмжлэг авахаар доор дурдсан төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж байна.⁴⁶

- "Монгол-Хятадын цөлжилттэй тэмцэх хамтын ажиллагааны төв" байгуулах төсөл (2019-2025)-200,0 сая юань
- АХБ, ЕХОБ, Уур амьсгалын ногоон сан хамтран " Аймаг сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" (2023-2033)- 753.0 сая ам.доллар
- АХБ, Ойн зурвас байгуулах, Үр тарианы элеватор байгуулах, төрөлжсөн аж ахуй байгуулах төсөл- 28.4 тэрбум төгрөг
- НҮБ, Агро ойн аж ахуй байгуулах төсөл- 13.5 тэрбум төгрөг
- "Ногоон хэрэм" 3 дугаар шат. Элсний нүүдэл, цөлжилтөөс сэргийлэх, ойжуулалтыг дэмжих зорилготой төсөл, (2022-2027). Төслийн санхүүжилт 6 сая ам доллар
- "Хөдөө аж ахуй болон экосистемийн тогтвортой менежментийг хангах нь" 2 дугаар шат. Ойн тогтвортой менежментийг бэхжүүлэх зорилготой төсөл. (2024-2028). Төслийн санхүүжилт 13.8 сая евро
- "Эрүүл ой" – Рио тинто Монгол ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах зорилготой төсөл. (2022-2025), Төслийн санхүүжилт 4.0 сая ам доллар.

⁴⁴ СЯ, НҮБХХ, "Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээ", 2024

⁴⁵ СЯ, НҮБХХ, Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээ, 2024 он

⁴⁶ БОУАӨЯ-ны тайлан, 2024


- Ойн засаглалыг сайжруулах замаар нэмүү өртөгийг шингээх нь: Ойн тогтвортой менежментийг бэхжүүлэх, ойн салбарыг эдийн засагжуулах зорилготой төсөл. (2024-2028). Төслийн санхүүжилт 2.5 сая ам доллар.
- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний мэдээллийн систем хөгжүүлэх зорилготой Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй төсөл. (2024-2026), Төслийн санхүүжилт 0.65 сая ам доллар.
- Байгаль орчны мэдээллийн сан шинэчлэн хөгжүүлэх зорилготой Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй төсөл. (2024-2026). Төслийн санхүүжилт 0.3 сая ам доллар.
- Азийн Ойн хамтын ажиллагааны байгууллага хамтран хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг дэмжих буцалтгүй тусламжийн төсөл. (2023-2025). Төслийн санхүүжилт 1 сая ам доллар.
- "Ногоон Ази" ОУ-ын ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй Элсний нүүдэл, цөлжилтөөс сэргийлэх, ойжуулалтыг дэмжих зорилготой төсөл. 2016 оноос хойш хугацаанд БНСУ-ын төрийн бус байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж байна.
- Монголын говийн бүсэд заг тарих судалгааны төслийг Япон улстай хамтран Баянхонгор аймагт хэрэгжүүлж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг судлахад дараах асуудлууд байна.

- Нийт 22 гэрээ байгуулсан аймаг, нийслэлээс 9 нь 2030 он хүртэл өөрсдийн аймагтаа зориулсан төлөвлөгөөгүй.
- Мод тарьж ургуулахаар батламж авсан ААН-ээс 14 нь урьдчилсан ерөнхий төлөвлөгөөтэй бусад нь төлөвлөгөөгүй байна. (10 саяаас дээш амлалт).
- “Тэрбум мод” terbummod.mn цахим хуудас, ухаалаг утасны аппликейшн гэсэн систем байгаа боловч ажиллагаа тааруу, мэдээлэл муутай.
- Нийт 61,0 сая мод бодитоор тарьсан гэсэн тоон мэдээлэл байгаа боловч мэдээ, тайлан, хэдэн төгрөгийн санхүүжилтээр тарьсан нь тодорхойгүй.
- Ихэнх аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод тарих газрыг тусгайлан оруулж өгөөгүй.
- Стратеги төлөвлөгөөнд хүрэх түвшинг бодиттой, хэмжигдэхүйц байдлаар оруулаагүй байна.
- Тэрбумаар тоологдох мод ургуулах ажлын суурь үндэс болсон технологийн үр бэлтгэх, боловсруулах, тарьц суулгацын материал, ургуулах, ойжуулах зэрэг процессын ажилбарууд нь бүтээмж багатай, гар хөмөрмөр зонхилсон, өрсөлдөх чадваргүй байна.
- Мод ургуулах ажил нь улирлын чанартай, үндсэн ажил 4-10 сарын хооронд явагддагаас мэргэжилтэй ажилчид тогтвор, суурьшилтай ажиллахад хүндрэлтэй байдаг байна.
- Одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн багууллагууд нь хөрөнгө оруулалт хийх замаар хүчин чадлаа нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэргүй, зээл авах барьцаа хөрөнгөгүй, үйлдвэрлэлээ өргөтгөж, мэргэжилтэй ажилчдаа тогтвор, суурьшилтай ажиллуулах чадамжгүй байна.
- Одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн багууллагууд нь хөрөнгө оруулалт хийх замаар хүчин чадлаа нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэргүй, зээл авах барьцаа хөрөнгөгүй, үйлдвэрлэлээ өргөтгөж, мэргэжилтэй ажилчдаа тогтвор, суурьшилтай ажиллах чадамжгүй байна.
- Ойжуулалт, ойн мэдээллийн сантай холбоотой нэгдсэн цогц дата тайлан байхгүй, үр дүнг тооцох механизмгүй, ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүн тодорхойгүй, ойн арчилгаа цэвэрлэгээний чиглэлийн байгууллагууд нь ойгоос мод бэлтгэсэн талбайдаа нормативын дагуу нөхөн сэргээлт хийсэн эсэх болон хуулиар хүлээсэн бусад үүрэг хариуцлагын биелэлт тодорхойгүй, ойжуулалт хийгдсэн талбайд гурван жилийн хугацаанд арчилгаа хийгдэж байгаа эсэх нь тодорхойгүй нэгдсэн бүртгэлгүй,

мэргэжлийн байгууллагууд болон ойн ангиудын тайлан шаардлага хангахгүй, тайлан нь нэгдсэн нэг загвараар батлагдсан стандартгүй, ойн нөөцийн болон нөхөн сэргээлтийн ажлын тайлагнал туршлага сул байна.

Зураг 125. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний процессын ерөнхий зураглал



Дүгнэлт:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, эрхзүй, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлсэн хэдий ч ургуулж буй модны бодит гүйцэтгэлээс үзэхэд уг хөдөлгөөн эхэлсэнээс хойших хугацаанд 83.9 /61,0 сая ширхэг мод тарьсан, 22,9 дүйцүүлсэн/сая модыг шууд болон дүйцүүлэх хэлбэрээр тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна.

Мод тарих төлөвлөгөөг тарьсан модны тоотой харьцуулан үзэхэд гүйцэтгэл 24.4 хувьтай байна. Хэрэв энэ хурдаар ажиллавал 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарих амлалтаа биелүүлж чадахгүйд хүрэхээр байгаад бүх талууд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.7. ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

БНХАУ, Япон, Казахстан, ХБНГУ, Шинэ Зеландын байгаль орчны яамны бүтэц, чиг үүрэг, салбарын тогтолцоог Монгол Улстай харьцуулан судлав (**Хүснэгт 63**). Хэдийгээр төрийн тогтолцоо харилцан адилгүй боловч бүс нутаг, Байгаль орчны яамны тогтолцоо, уур амьсгалын хувьд төстэй байдал, байгаль орчны гүйцэтгэл (EPI index), уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлж буй санаачилга, бусад онцлогийг харгалзсан болно. Үүнд:

- Монгол Улсын оршин буй Зүүн Хойд Азийн бүс нутагт БНХАУ, Японы байгаль орчны яамны тогтолцоо нэгдмэл бол Байгаль орчны гүйцэтгэлийн индексээр Азидаа Япон тэргүүлдэг.
- Далайд гарцгүй, эрс тэс уур амьсгалтай болон нүүрс үйлдвэрлэгч Төв Азийн бүс нутгаас Казахстаныг сонгож авсан.
- Ногоон шилжилт, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, экосистемийг хамгаалах зэрэг үндсэн чиглэлүүдэд тулгуурлан урт дунд богино хугацааны уялдаа холбоотой бодлоготой ХБНГУ-ыг сонгосон.
- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах, мониторинг хяналт тавих байдлаар Шинэ Зеландын жишээг авсан болно.


Хүснэгт 65. Улс орнуудын харьцуулсан байдал

Улсын нэр	Бүс нутаг	Төрийн тогтолцоо	Хүн ам (2025 он)	Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар, 2023 он Дэлхийн банк)	Яамны нэр	EPI index (2024 он) Оноо 180 улсаас эзлэх байр
Монгол Улс	Зүүн Хойд Ази	Парламент	3,517,100	5,838	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	37.2 оноо 143-р байр
БНХАУ	Зүүн Хойд Ази	Нэг намын тогтолцоо	1,416,096,094	12,614	Экологи, Байгаль орчны Яам (MEE)	35.4 оноо 156-р байр
Япон	Зүүн Хойд Ази	Үндсэн хуульт хаант засаглал, парламент	123,103,479	33,766	Байгаль орчны яам (MOE)	61.4 оноо 27-р байр
Казахтан	Төв Ази	Ерөнхийлөгчийн засаглал, бүгд найрамдах улс	20,843,754	12,918	Экологи, байгалийн нөөцийн яам, Усны нөөц, усжуулалтын яам	47.8 оноо 72-р байр
ХБНГУ	Европ	Холбооны Парламентын бүгд найрамдах улс	84,075,075	53,528	Байгаль орчин, Байгаль хамгаалал, Цөмийн аюулгүй байдал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах яам (BMUV)	74.5 оноо 3-р байр
Шинэ Зеланд	Номхон далай	Үндсэн хуульт хаант засаглалтай парламент	5,223,100	48,280	Байгаль орчны яам	57.3 оноо 33-р байр

Эх сурвалж: Дэлхийн банк болон холбогдох эх сурвалжаас эмхтгэв.

Ерөнхийд нь харвал, байгаль орчны салбарт ДНБ-ий эзлэх⁴⁷ хувиар Япон хамгийн их зардал зарцуулдаг бол Монгол Улсын хувьд ДНБ-ий 0.32 хувийг байгаль орчны салбарт зарцуулж байна.

Зураг 126. ДНБ-д эзлэх байгаль орчны салбарын зардал, хувиар



Улс орнуудын байгаль орчны яамны чиг үүрэг, салбарын тогтолцоо

⁴⁷ World Bank. (n.d.). Government Expenditure on environment protection, Percentage of GDP (Local government), Prosperity Data360. Retrieved April 13, 2025, from https://data360.worldbank.org/en/indicator/IMF_COFOG_GEN_GF05?view=trend&unitMeasure=PT_GDP&country=MNG%2CJPN%2CNZL%2CCHN%2CKAZ%2CDEU&compBreak1=IMF_SEC_GG

1. БНХАУ

БНХАУ-ын Экологи, байгаль орчны яам (Ministry of Ecology and Environment) 2018 онд шинэчлэгдэн байгуулагдсан бөгөөд байгаль орчны асуудлыг ерөнхийд нь удирддаг. Тус яам улсын хэмжээнд байгаль орчны бодлого, хууль журам, стратеги боловсруулах, хүлэмжийн хийн хяналт, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа удирдах, олон улсын хамтын ажиллагааг зохицуулах, экологийн үлгэр жишээ бүсийг байгуулах чиг үүрэгтэй.

Хүснэгт 66. БНХАУ-ын Экологи, байгаль орчны яамны бүтэц, салбарын тогтолцоо

Газар	Ерөнхий чиг үүрэг
Ерөнхий газар	Яамны удирдлагыг хариуцдаг.
Экологи, байгаль орчны хяналт шалгалтын төв алба	Байгаль орчны хяналт шалгалтыг зохион байгуулдаг.
Ерөнхий асуудал хариуцсан хэлтэс	Яамны үйл ажиллагааны ерөнхий бодлогыг хариуцдаг.
Хууль, журам, стандартын хэлтэс	Байгаль орчны хууль, дүрэм, стандартыг боловсруулдаг.
Байгууллагын удирдлага, хүний нөөцийн хэлтэс	Хүний нөөц, удирдлагын бодлогыг хариуцдаг.
Шинжлэх ухаан, технологи, санхүүгийн хэлтэс	Байгаль орчны судалгаа, санхүүгийн асуудлыг удирддаг.
Усны экологи, байгаль орчны хэлтэс	Усны экосистемийг хамгаалах, хяналт тавих үүрэгтэй.
Далайн экологи, байгаль орчны хэлтэс	Далайн орчныг хамгаалах, бохирдлоос сэргийлэх чиг үүрэгтэй.
Агаар мандлын орчны хэлтэс	Агаарын бохирдлын хяналт, сайжруулах бодлого боловсруулдаг.
Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтэс	Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлого боловсруулж хэрэгжүүлдэг.
Хөрсний экологи, байгаль орчны хэлтэс	Хөрсний бохирдлын хяналт, нөхөн сэргээлтийг хариуцдаг.
Цацрагийн хяналтын хэлтэс	Цацрагийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс	Гадаад хамтын ажиллагааг хариуцдаг.
Нийтийн харилцаа, боловсролын хэлтэс	Байгаль орчны боловсрол, сурталчилгааг хариуцдаг.
Тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний төв	Албан хаагчдын нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийг зохицуулдаг.
Харьяа байгууллага	Үүрэг
Хүрээлэн буй орчны мониторингийн үндэсний төв	Агаар, ус, хөрсний бохирдлын мониторинг
Байгаль орчны үнэлгээний төв	Төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх
Уур амьсгал өөрчлөлтийн стратегийн судалгааны төв (NCSC)	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг стратеги, бодлого, судалгаа хийх, стандартыг судлахаас гадна уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлдэг
Байгаль орчны шинжлэх ухааны хүрээлэн (CRAES)	Нийгэм эдийн засгийн хөгжлийн улмаас тулгарч буй байгаль орчны асуудал шийдвэрлэх, байгаль орчны шинжлэх ухаан, технологийн чиглэлээр судалдаг
Байгаль орчин, эдийн засгийн бодлогын судалгааны төв	Эдийн засаг, ногоон хөгжлийн уялдаа холбоог судалдаг

Эх сурвалж: 中华人民共和国生态环境部 (БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас), <https://www.mee.gov.cn/>

Яамны бодлогыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх муж, бүсийн 19 товчоод аж ахуйн нэгж, үйлдвэрт байгаль орчны үнэлгээ хийх, зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийхээс гадна иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, шийдвэрлэдэг байна⁴⁸. Түүнчлэн шинжлэх ухаан судалгааны хүрээлэнгүүдээс гадна мониторингийн болон үнэлгээний төв зэрэг 20 гаруй

⁴⁸ 中华人民共和国生态环境部. БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас (n.d.). Яамны тухай [关于我们], <https://www.mee.gov.cn/zjhb/?name=1>

байгууллага салбарт өөр өөрийн үүрэг оролцоотой. Мөн байгаль орчны шинжлэх ухааны нийгэмлэг, байгаль хамгаалах сан, мэдээллийн нийгэмлэг, цөмийн аюулгүй байдал, байгаль орчны соёлын нийгэмлэг зэрэг иргэний нийгэмлэг байдаг.

Шинжлэх ухаан, технологийн инновац

2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөл экологи, байгаль орчны салбарт шинжлэх ухаан, технологийн инновацыг нэвтрүүлэх удирдамж гаргасан⁴⁹. Энэ нь Хятадын Коммунист Нам (цаашид ХКН гэх)-аас дэвшүүлсэн зорилт бөгөөд 2035 он гэхэд чинээлэг, хүчирхэг, үзэсгэлэнтэй, орчин үеийн социалист улс болох зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ юм. Чингэхдээ байгаль орчны салбарт шинжлэх ухаан, технологийн дэвшил, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх замаар салбарын үйл ажиллагааг үр ашигтай, шинэлэг болгох аж. Тодруулбал, 2035 он гэхэд хиймэл дагуул, алсын мэдрэгч, нисгэгчгүй онгоц зэрэг орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан хяналтын системийн чадавхыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэхээр⁵⁰ тусгажээ. Мөн АНУ-ын "Microsoft" корпорац 2017 оноос БНХАУ-ын Шан Шуй төвтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн "AI for Earth" төсөл⁵¹ 2021 онд дэлхийн 100 шилдэг төслийн нэгээр шалгарчээ. Түүнчлэн хиймэл оюун ухааныг эрчим хүчний салбарт ашиглах чиглэлээр судлан хөгжүүлсээр байна.

2. Япон улс

Дэлхийн дөрөв дэх том эдийн засаг, үндсэн хуульт хаан засаглалтай Японы Ерөнхий сайд Засгийн газрыг төлөөлөн хуулийн төсөл өргөн барих ба Сайд нарын танхимаа бүрдүүлдэг. Эдгээр яамны нэг Байгаль орчны яам (MOE) байгаль орчны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий төв байгууллага байна. 1971 оноос 2001 он хүртэл байгаль орчны агентлаг байсан бол дэлхий нийтэд тулгарч буй байгаль орчны асуудлыг илүү үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор яам болгосон байна.

Байгаль орчны тухай хууль (1993 он), Байгаль орчны үндсэн төлөвлөгөө (1994 он) байгаль орчны суурь баримт бичиг болдог. Эдгээр баримт бичигт байгаль орчныг хамгаалахад төр, хувийн хэвшил, иргэдийн үүргийг тодорхойлдог бөгөөд 2024 оны 5 дугаар сард Байгаль орчны 6 дугаар төлөвлөгөө батлагджээ. Түүнчлэн Ази Номхон далайн бүс нутагт оршин буй улс орнуудад тулгарч буй нийтлэг бэрхшээлийг даван туулахад "Эко Ази" зэрэг бүс нутгийн яриа хэлэлцээ, төсөл хөтөлбөрт идэвхтэй оролцож, нэгдмэл байдлыг хангахад анхаарч ирсэн.

Байгаль орчны яам нь бодлого боловсруулах, уялдуулах, хууль, стандартыг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоог хангах, ухуулан сурталчлах, технологийн нэвтрүүлэлт, судалгаа шинжилгээ хийх зэрэг үндсэн үүрэгтэй⁵².

Хүрээлэн буй орчны олон талт асуудлыг шийдвэрлэх зорилготой төрөлжсөн газар нэгжтэй бөгөөд цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч дараах үндсэн газраас бүрддэг⁵³. Үүнд: Сайдын хэрэг эрхлэх газар, Байгаль орчны бодлогын газар, Дэлхийн байгаль орчны товчоо, Байгаль орчны менежментийн газар, Байгаль хамгаалах газар, нөхөн сэргэлт зэрэг газартай байдаг.

⁴⁹ 生态环境部等部门联合印发意见加强生态环境领域科技创新. 中国政府网, 2025-02-24, БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны салбарт шинжлэх ухаан, инновацийг нэвтрүүлэх нь, https://www.gov.cn/lianbo/bumen/202502/content_7005251.htm

⁵⁰ 专家解读 | 强化数智化理念, 扎实推进国家生态环境监测网络转型任务落实. БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас (n.d.). 2025-03-28. https://www.mee.gov.cn/zcwj/zcjd/202503/t20250328_1104874.shtml

⁵¹ Microsoft AI for Earth named as one of "100+ Outstanding Biodiversity Positive Practices and Actions Around the World", October 11, 2021, <https://www.cenews.com.cn/news.html?aid=1205259>

⁵² Ministry of the Environment, Japan. (n.d.). *Environmental protection and policy overview*. Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/content/000288877.pdf>

⁵³ Ministry of the Environment, Japan. (n.d.). *Ministry of the Environment, Japan: Introduction* (Appendix 07). Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/en/chemi/pops/Appendix/07-MOE-Introduction/MOE.pdf>

Хүснэгт 67. Японы байгаль орчны яамны бүтэц, салбарын тогтолцоо

Газар/хэлтэс	Үндсэн чиг үүрэг
Сайд нарын нарийн бичгийн дарга	Захиргааны зохион байгуулалт, яамны бүх үйл ажиллагааг зохицуулах
Байгаль орчны бодлогын газар	Байгаль орчны үндсэн бодлого төлөвлөлтийг боловсруулахаас гадна байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийдэг
Дэлхийн байгаль орчны газар	Олон улсын хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлого
Байгаль орчны менежментийн газар	Ус, агаарын чанар, бохирдлын хяналт
Байгаль хамгаалах газар	Биологийн олон янз байдал, байгалийн нөөцийн хамгаалалт
Нөхөн сэргээх, дахин боловсруулах газар	Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах бодлого
Харьяа байгууллага	Үндсэн чиг үүрэг
Үндэсний байгаль орчны судалгааны хүрээлэн (NIES)	Уур амьсгалын өөрчлөлт, озоны давхарга, хог хаягдлын менежмент, агаарын бохирдол зэрэг чиглэлээр олон улсын болон улсын түвшинд судалж, мэдээллийн сан бүрдүүлж, судалгааны тайлангаа нээлттэй түгээдэг.
Үндэсний Минамата өвчний хүрээлэн	Минамата өвчний талаар мэдээллийн сан үүсгэх, олон улсын түвшинд судалгаа хийдэг ДЭМБ-ын хүрээнд байгуулсан хүрээлэн
Биологийн олон янз байдлын төв	Үндэсний хэмжээнд санал асуулга авч, биологийн олон янз байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд ухуулан таниулдаг.
Глобал Байгаль орчны мэдээллийн төв	Байгаль орчны судалгааны номын сантай бөгөөд ТББ-уудад зөвлөгөө өгдөг.
Глобал байгаль орчны стратегийн хүрээлэн (IGES)	Олон улсын түвшинд судалгаа хийхээс гадна сургалтын хөтөлбөрөөр хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд анхаардаг

Эх сурвалж: Ministry of the Environment, Japan. (n.d.). About the Ministry of the Environment. Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/en/aboutus/index.html>

Японы байгаль орчны үндсэн төлөвлөгөө

Японы Байгаль орчны үндсэн төлөвлөгөө⁵⁴ (Basic Environment Plan) (Ministry of Environment, 2024) -ний хүрээнд тогтвортой хөгжил, биологийн олон янз байдлыг хамгаалахад үндэсний болон орон нутгийн засаг захиргааг чиглүүлж, салбарын уялдаа холбоог цогцоор хангадаг. Уг төлөвлөгөөнд стратегийн дүн шинжилгээ хийвэл, дараах байдлаар үр дүнд хүрэх юм.

Хүснэгт 68. Японы байгаль орчны үндсэн төлөвлөгөө

Хүрэх үр дүн (Ends)		Арга зам (Ways)	Хэрэгсэл (Means)
Уур амьсгалын өөрчлөлт	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах	<ul style="list-style-type: none"> Ногоон эдийн засагт шилжих Газрын зохистой ашиглалт, гамшигт тэсвэртэй байдал 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны асуудлыг бусад салбарын бодлоготой уялдуулах
Биологийн олон янз байдал алдагдах	Экологийн тэнцвэрийг хадгалах	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн санаачилгыг дэмжих Тогтвортой хэрэглээг урамшуулах 	<ul style="list-style-type: none"> Төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаа Үр дүнг шалгуур үзүүлэлтээр тодорхойлох
Бохирдол	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах замаар хүн амын эрүүл	<ul style="list-style-type: none"> Байгальд ээлтэй технологийг хөгжүүлэх Хил дамнасан асуудлыг олон улсын түвшинд шийдвэрлэх 	<ul style="list-style-type: none"> Тогтвортой хөгжлийг дэмжсэн хууль, стандарт Татварын хөнгөлөлтөөр байгальд ээлтэй арга хэмжээг дэмжих

⁵⁴ Ministry of the Environment, Japan. (2024, May 21). The Basic Environment Plan. <https://www.env.go.jp/content/000288877.pdf>

МЭНДИЙГ
хамгаалах

Ministry of the Environment, Japan. (2024, May 21). *The Basic Environment Plan*.

<https://www.env.go.jp/content/000288877.pdf> эх сурвалжаас эмхэтгэв.

Үүнээс харахад, Япон улсын эдийн засаг, газар нутаг, орон нутаг, иргэд, шинжлэх ухаан технологи, олон улсын хамтын ажиллагаа гэх үндсэн 6 чиглэлээр төр, иргэн, хувийн хэвшил оролцогч талуудын оролцоог хангаж, уур амьсгалын өөрчлөлт, бохирдол, биологийн олон янз байдлыг асуудлыг цогцоор шийдвэрлэхээр тусгажээ.

3. Казахстан

Дэлхийд газар нутгийн хэмжээгээр 9 дүгээр байранд ордог Бүгд Найрамдах Казахстан улс хамгийн том далайд гарцгүй орон бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэлийн 56 орчим хувьд нүүрс ашигладаг дэлхийн томоохон нүүрс үйлдвэрлэгч орнуудын нэг юм. Монгол улстай газар зүй, уур амьсгалын хувьд төстэй өргөн удам тал хээрээс өндөр уулсын нуруу үргэлжилсэн газар нутагтай, эрс тэс уур амьсгалтай.

Арал тэнгисийн доройтол, усны нөөцийн хомсдол, газар тариалан усалгааны системийг шинэчлэх шаардлагатай зэрэг устай холбоотой тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд 2023 онд Экологи, геологи, байгалийн нөөцийн яаманд бүтцийн өөрчлөлт хийж Экологи, байгалийн нөөцийн яам ба Усны нөөц, усжуулалтын яам болгон өөрчилжээ.

Экологи, байгалийн нөөцийн яам байгаль орчныг хамгаалах, цаг уур, усыг хянах, ногоон эдийн засгийг хөгжүүлэх, хог хаягдлын менежмент (эмнэлэг, биологи, цацраг идэвхт хог хаягдлыг оруулахгүй), байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэрийг хамгаалах, ой болон зэрлэг амьтадыг хамгаалах, өсгөж үржүүлэх зэрэг чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлдэг⁵⁵.

Хүснэгт 69. Экологи, байгалийн нөөцийн яам

Газар/хэлтэс	Үндсэн чиг үүрэг
Удирдлагын хэлтэс	Яамны албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж, удирдлагын шийдвэрүүдийг хэрэгжүүлдэг.
Стратегийн төлөвлөлт ба шинжилгээний хэлтэс	Яамны стратегийн бодлогыг хэрэгжүүлж, төслийн удирдлагыг зохион байгуулдаг
Хууль зүйн хэлтэс	Яамны үйл ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, хууль тогтоомжийн дагуу ажилладаг.
Байгаль орчны бодлого ба тогтвортой хөгжлийн хэлтэс	Байгаль орчны чанарыг сайжруулах, байгалийн нөөцийг хамгаалах, ногоон эдийн засагт шилжих бодлогыг хэрэгжүүлдэг.
Төрийн өмчийн удирдлага, төсвийн бодлого хэлтэс	Төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийн удирдлагыг зохицуулдаг.
Олон нийттэй харилцах хэлтэс	Мэдээллийн орчныг шинжилж, яамны эерэг имиджийг бий болгох, олон нийтийн итгэлийг хадгалах чиглэлээр ажилладаг.
Хог хаягдлын удирдлагын төрийн бодлогын хэлтэс	Хатуу ахуйн хог хаягдал, үйлдвэрийн хог хаягдлын менежментийг хариуцаж, өргөтгөсөн үйлдвэрлэгчийн хариуцлагын хөтөлбөрийг дэмждэг.
Цаг уурын бодлого ба ногоон технологийн хэлтэс	Цаг уур болон озоны давхаргын хамгаалалтыг дэмжих, технологийн шилжилтэд ногоон өсөлтийг дэмжиж ажилладаг.
Дотоод аудитын хэлтэс	Яамны удирдлагыг дэмжих, төсвийн хөрөнгө, төрийн өмчийн аюулгүй байдлыг хянаж, үр ашигтай удирдлагаар хангадаг.
Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс	Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлж, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулах, байгаль орчны салбарт хамтран ажилладаг.
Дижитал шилжилтийн хэлтэс	Яамны дижитал шилжилтийг зохион байгуулж, төрийн мэдээллийн системүүдийг хөгжүүлж, иргэдэд үйлчлэх үйл явцыг сайжруулдаг.

⁵⁵ Ministry of Ecology and Natural Resources of the Republic of Kazakhstan. (n.d.). *Structure*. GOV.KZ. Retrieved April 13, 2025, from <https://www.gov.kz/memleket/entities/ecogeo/about/structure/2/1?lang=en>

Хүний нөөцийн хэлтэс

Хүний нөөцийн удирдлагын тогтолцоог бий болгож, ажилтнуудын сургалт, бүтээмжийн үнэлгээг хийдэг.

Усны нөөц, усжуулалтын яам усны нөөцийг ашиглах, хамгаалах, ус хангамж, усжуулалтын чиглэлээр төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр манлайлдаг⁵⁶.

Хүснэгт 70. Усны нөөц, усжуулалтын яам

Газар/хэлтэс	Үндсэн чиг үүрэг
Хууль зүйн үйлчилгээний хэлтэс	Яамны хууль зүйн үйл ажиллагааг удирддаг.
Төрийн өмчийн удирдлага ба төсвийн бодлогын хэлтэс	Төрийн өмч, төсвийн бодлогыг зохицуулдаг яамны нэгж.
Дотоод аудитын хэлтэс	Яамны үйл ажиллагааг хянаж, дотоод аудитын үүргийг гүйцэтгэдэг.
Хүний нөөцийн хэлтэс	Яамны хүний нөөцийн удирдлага, сургалт, үйл ажиллагааг зохицуулдаг.
Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс	Гадаад улс орнуудтай байгаль орчны болон бусад салбарын хамтын ажиллагааг зохицуулдаг.
Шинжлэх ухаан ба шинэ технологийн хэлтэс	Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дэмжих, инновацийн үйл ажиллагааг зохицуулдаг.
Усны бодлогын хэлтэс	Усны нөөц, хэрэглээ, бодлогыг зохицуулдаг хэлтэс.
Гүний усны хэлтэс	Гүний усны нөөц, менежментийг хариуцдаг хэлтэс

Эх сурвалж: Committee on Water Resources of the Ministry of Ecology and Natural Resources of the Republic of Kazakhstan. (n.d.). Structure. GOV.KZ. Retrieved April 13, 2025, from <https://www.gov.kz/memleket/entities/water/about/structure/2/1?lang=en>

Казакстаны Экологийн тухай хууль

Байгаль орчинд учруулсан хохирлыг багасгах, хойч үедээ экосистемийг хадгалах зорилготой 2021 онд баталсан тус хуулийг⁵⁷ Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD)-ын зөвлөмжийн дагуу ЕХ-ны туршлага болон олон нийтийн санал асуулгаар 2000 гаруй иргэд, бизнесийн төлөөллийн санал бодлыг тусгажээ. Тухайлбал, "Бохирдуулсан нь төлөх" (Polluter pays) зарчмаар хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр компаниудад торгууль ноогдуулаад зогсохгүй нийт хүлэмжийн хийн ялгаруулалтын 80 хувийг эзэлж буй ААН-ийн тоог 2600 хүртэл бууруулах, үүнээс олсон орлогоо хийн ялгаруулалтыг бууруулахад зарцуулах аж. Мөн ашиглаж буй техник технологид нь үнэлгээ хийж, байгаль орчинд хамгийн ээлтэй хувилбар⁵⁸ руу шилжиж буй ААН-ийг I ангилал буюу уул уурхай, аж үйлдвэр зэрэг байгаль орчинд нөлөөлөл ихтэй ангилалд багтаан торгуулиас чөлөөлнө. Үүнээс гадна байгаль орчинд хохирол учруулсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авах, эдгээр зөрчилд ногдуулах торгууль 10 дахин нэмэгдүүлэх зохицуулалтыг оруулжээ.

Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах, устгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан ба "Хог хаягдлаас эрчим хүч гаргах" (Waste to Energy)-ийн тогтолцоог нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь хог хаягдлаас цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, орлого олох боломжийг олгоно.

4. ХБНГУ

ХБНГУ-ын Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яам (*Bundesministerium für Umwelt, Naturschutz, nukleare Sicherheit und Verbraucherschutz, BMUV*) тус улсын байгаль орчныг хамгаалах, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлдэг голлох төрийн захиргааны байгууллага юм. Тус яам нь Засгийн газрын бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд

⁵⁶ CACIP – Central Asia Climate Information Portal. (n.d.). *The Ministry of Water Resources and Irrigation has been established in Kazakhstan.* Sep 11, 2023

⁵⁷ European Union – Central Asia Water, Environment and Climate Change Cooperation (WECOOP). (2021). *Environmental Code of the Republic of Kazakhstan* (Unofficial translation). https://wecoop.eu/wp-content/uploads/2021/04/2021-KZ-ENV-Code_full-text_en.pdf

⁵⁸ ЕХ-ны туршлага "ВАТ" буюу best available techniques байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хамгийн бага түвшинд байлгах хамгийн дэвшилтэт, үр дүнтэй аргыг хэлэх бөгөөд технологи төдийгүй тухайн үйлдвэрийн төлөвлөлт, барилга, ашиглалт зэрэг бүх үе шатыг хамарсан арга, техник, дадал, зохион байгуулалттай холбоотой.

нийгмийн тогтвортой хөгжил, байгаль орчны аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Уг яамны гол зорилго ус, агаар, хөрс, ой, экосистем, биологийн олон янз байдал зэрэг байгалийн баялгийг хамгаалж, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үр дүнтэй бодлого боловсруулан хэрэгжүүлэх, байгальд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжих явдал юм. Түүнчлэн цөмийн эрчим хүчний аюулгүй ажиллагааг хангах, атомын цахилгаан станцуудыг шат дараатайгаар хаах, үүссэн цөмийн хаягдлыг аюулгүй, урт хугацааны турш хадгалах, зохистой аргаар устгах бодлогыг хэрэгжүүлдэг.

2021 онд хийсэн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон хүнсний аюулгүй байдлын асуудлыг хамруулах болж цар хүрээгээ улам өргөтгөсөн⁵⁹. Ингэснээр зөвхөн байгаль орчны асуудал бус, иргэдийн өдөр тутмын хэрэглээ, эрүүл мэнд, аюулгүй байдлыг ч хамгаалах чиглэлд нөлөө бүхий үүрэгтэй болсон.

Олон улсын хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, тогтвортой хөгжил, байгаль орчны олон улсын гэрээ, хамтын ажиллагаанд оролцохоос гадна Европын Холбооны хүрээнд байгаль орчны хууль тогтоомжийг мөрдөх, шинэчлэн сайжруулахад чухал нөлөө үзүүлдэг.

Хүснэгт 71. ХБНГУ-ын Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яамны бүтэц

Байгууллага	Үүрэг оролцоо
BMUV (Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яам)	Байгаль орчны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. Цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлого хариуцна. Шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж, судалгаа гаргаж, яамны бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг. Агаар, ус, хөрсний чанар, хаягдал зэрэгт хяналт тавина.
UBA (Umweltbundesamt - Холбооны Байгаль Орчны Агентлаг)	Тогтвортой газар тариалан, ус ашиглалт, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр байгаль орчинд нөлөөлөх бодлого хэрэгжүүлдэг.
BMEL (Хөдөө аж ахуй, хүнсний яам)	Тээврийн салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ногоон дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг.
BMDV (Дэд бүтцийн ба тээврийн яам)	Холбооны бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг зохицуулдаг.
Муж улсын Байгаль орчны яамдууд (Länder)	Байгаль хамгааллын асуудлаар олон нийтийн оролцоо, хяналт, сурталчилгаа, бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцдог.
Иргэний нийгмийн байгууллагууд (BUND, NABU гэх мэт)	Байгаль орчны судалгаа, дата боловсруулалт, технологийн инновациор дэмжлэг үзүүлдэг.
Шинжлэх ухааны байгууллагууд ба их сургуулиуд	

Эх сурвалж: Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). Administrative authorities at state and federal level. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/ministry/tasks-and-structure/federal-and-laender-authorities>

ХБНГУ-ын бодлогын төлөвлөлт

ХБНГУ-ын Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яам (BMUV) нь урт, дунд, богино хугацааны бодлогоо уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, ногоон шилжилт, экосистемийн хамгаалал зэрэг үндсэн чиглэлд тулгуурлан боловсруулдаг. Тухайлбал:

- **Богино хугацаа** (1–3 жил) - Эко инновацийг дэмжих санхүүжилт, Хог хаягдлын менежментийг сайжруулах, энергийн үр ашиг нэмэгдүүлэх болон ногоон технологи хөгжүүлэх төслийг дэмжих, хуванцар хэрэглээг бууруулах, барилгын салбарт ногоон

⁵⁹ Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). *Tasks and structure*. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/ministry/tasks-and-structur>

шийдэл нэвтрүүлэх зэрэг богино хугацаанд хэрэгжих боломжтой зорилтуудыг төлөвлөдөг.

- **Дунд хугацаа** (4–10 жил) - 2030 он⁶⁰ гэхэд эко тээвэр, цахилгаан хөдөлгүүрийг өргөн нэвтрүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах стратеги, хүлэмжийн хийн ялгарлыг 1990 оныхоос 65%-иар бууруулах, ус, хөрсний чанарыг сайжруулах, эко бүс нутгийн тоог нэмэгдүүлэх зэрэг уур амьсгалын зорилтыг хэрэгжүүлэх аж.
- **Урт хугацаа** (10+ жил) - 2045 он гэхэд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний стратегийн⁶¹ хүрээнд нүүрснээс бүрэн татгалзаж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 100%-д хүргэх, уур амьсгалд тэсвэртэй болгох, усны нөөцийн аюулгүй байдлыг хангахаар төлөвлөжээ.

Үүнээс гадна “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний төлөвлөгөө 2050”, “Бидний орчин, бидний ирээдүй” зэрэг стратеги бодлогын баримт бичигт онлайнаар санал авах платформ, залуучуудын дунд уулзалт хийх байдлаар олон шинэлэг аргаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг иргэдийг татан оролцуулдаг⁶² байна.

5. Шинэ Зеланд

5.2 сая хүн амтай Шинэ Зеланд улсын EPI буюу олон улсын байгаль орчны гүйцэтгэлийн индекс⁶³ үзүүлэлтээр 2024 онд 180 улсаас 26-р байранд жагссан байна. Үүнээс ангилал тус бүрийн үзүүлэлтээр дэлгэрэнгүй үзвэл, уур амьсгалын өөрчлөлтийн бодлогоор 88-р байр, агаарын чанар 11-р байр, хог хаягдлын менежмент-32, экосистемийн бат бөх байдлаар 32-р байранд тус орсон.

1986 оны Байгаль орчны тухай хуулийн дагуу Байгаль орчны яам (MfE)-ыг байгуулсан бөгөөд байгаль орчны бодлого, уур амьсгалын өөрчлөлт болон тулгамдсан асуудлаар Засгийн газарт зөвлөгөө өгдөг. Энэ хүрээнд байгаль орчны хууль тогтоомж, стандарт, дүрэм батлуулах, хэрэгжилтэд хяналт тавихаас гадна үндэсний түвшинд байгаль орчны стратеги, бодлогын чиглэлийг тодорхойлдог. Мөн байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудлаар тайлан боловсруулах замаар олон нийтийг мэдээллээр хангадаг (the Ministry for the Environment, New Zealand, 2023).

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг салбар хоорондын уялдаа холбоог хангах, уур амьсгалын өөрчлөлтийн комисс болон Байгаль орчныг хамгаалах газарт /*Environmental Protection Authority*/ хяналт тавьж, зөвлөгөө өгдөг. Шинэ Зеландын Засгийн газрын агентлаг Байгаль орчныг хамгаалах газар үндэсний түвшний хүрээлэн буй орчны зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг⁶⁴ бөгөөд улсын төсөв болон хураамжаас санхүүждэг. Мөн химийн бодис ашиглах зөвшөөрөл олгодог бол химийн бодисын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судалдаг цорын ганц байгууллага юм. Тус газар хэд хэдэн зөвлөх бүлэг, шийдвэр гаргах хороодтой. Үүнд:

- Зөвлөл: Удирдах зөвлөлийг Байгаль орчны сайд томилдог бөгөөд Вайтанги болон Тиканга Маори (Маоригийн заншлын үнэ цэнэ, практик)-т туршлагатай дор хаяж нэг гишүүнтэй байхыг шаарддаг.
- Ngā Kaihautū Tikanga Taiao: Байгаль орчныг хамгаалах газрын Удирдах зөвлөлөөс хууль ёсоор томилогдсон Маори улсын хууль ёсны зөвлөх хороо нь Маоричуудын хэтийн төлөвийг харгалзан Байгаль орчныг хамгаалах газар -д зөвлөгөө өгдөг

⁶⁰ “Klimaschutzgesetz” (Уур амьсгалын хамгааллын хууль) – 2030 он гэхэд хүлэмжийн хийг 65%, 2045 он гэхэд 100% бууруулах зорилт тавьжээ.

⁶¹ “Klimaanpassungsstrategie” – Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний стратеги, үер, ган, халуун уур амьсгалаас иргэд, дэд бүтцээ хамгаалах арга хэмжээ.


⁶² Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). *Citizen participation*. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/citizen-participation/overview-citizen-participation/citizen-participation>

⁶³ EPI нь улс орныг хүрээлэн буй орчны эрүүл мэнд, экосистемийн бат бөх байдал болон уур амьсгалын өөрчлөлтийг эсрэг чиглэсэн үндэсний хүчин чармайлтыг гүйцэтгэлийн 40 үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлдэг юм.

⁶⁴ Environmental Protection Authority. (n.d.). Our legislation. Environmental Protection Authority. <https://www.epa.govt.nz/about-us/our-legislation/>

- Аюултай бодис ба шинэ организмын хороо: аюултай бодис импортлох, үйлдвэрлэх, Шинэ Зеландад шинэ организм нэвтрүүлэх асуудлыг хариуцдаг.
- Эдийн засгийн онцгой бүс, үндэсний ач холбогдол бүхий зөвлөлүүд: Удирдах зөвлөлийг Байгаль орчны сайд томилдог бөгөөд Байгаль орчин хамгаалах газар болон сайдаас хараат бус юм. Байгаль орчныг хамгаалах газар аливаа сонголт, тээвэр, логистикийг зохион байгуулалт болон мэргэжилтнийг томилох зэргээр захиргааны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Зураг 127. Шинэ Зеланд Улсын байгаль орчны яамны бүтэц



Тусгай зөвшөөрлийн кейс

Озон задлагч бодис импортлох өргөдөл гаргах процесс дараах үе шаттай байна. Үүнд:

1. Бодисыг тээвэрлэх нөхцөлийг хангаж байгаа эсэхийг шалгана. Метил бромидыг импортлох зөвшөөрөл авахын тулд метил бромидын өргөдлийн маягтыг татаж аваад бөглөнө. Түүнчлэн импортыг Шинэ Зеландад хууль ёсны хорио цээрийн дэглэм эсвэл тээвэрлэхээс өмнө утах зорилгоор ашиглах болно гэдгийг анхааруулна.
2. Озон задалдаг бусад бодисыг импортлохын тулд импортын хөнгөлөлт авах хүсэлт гаргана. Тухайлбал, эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс импортлох үндэслэл бүхий аэрозол эсвэл гал унтраагч зэрэг үүнд багтана.

Хэрэв озон задлагч бодис импортлох зөвшөөрлийг урьдчилан аваагүй тохиолдолд, хил дээр 200,000 шинэ зеланд долларын торгуулийг төлөх болно.

Дүгнэлт

Зүүн хойд Азийн бүс нутагт байгаль орчны тулгамдсан гурван асуудал болох уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, биологийн олон янз байдал алдагдахад экологийн тэнцвэрийг хадгалах, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаа нэн чухал юм. Иймд дараах жишгийг онцолж байна. Үүнд:

Нэгдүгээрт, залуучуудын дунд уулзалт зохион байгуулах, онлайн платформоор үндэсний бодлогын баримт бичигт санал авах зэрэг шинэлэг аргаар иргэдийг татан оролцуулдаг.

Хоёрдугаарт, яамны харьяа судалгааны байгууллагууд байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал, олон улсын чиг хандлагаар тайлан боловсруулж, олон нийтийг мэдээллээр хангахын зэрэгцээ шинжлэх ухааны судалгаанд суурилсан богино, урт, дунд хугацаанд хэрэгжих боломжтой зорилтууд болон хүрэх үр дүн, арга зам, нөөцөө баримт бичигт тодорхой тусгаж өгдөг.

Гуравдугаарт, хиймэл оюун, алсын мэдрэгч, нисгэгчгүй онгоц зэрэг орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан байгаль орчны хяналтын системийг нэвтрүүлж байна.

Дөрөвдүгээрт, "Бохирдууллагч нь төлөх" зарчмаар торгох болон байгаль орчинд хамгийн ээлтэй (BAT) технологийг ашиглаж буй ААН-ийг хөнгөлөлт үзүүлэх зэрэг урамшуулал, хариуцлагыг хослуулдаг.

Тавдугаарт, уул уурхай, эрчим хүч, ХАА, гадаад харилцаа, дэд бүтцийн салбар хооронд уялдаа холбоотой ажиллахаас гадна бие даасан болон харъяа байгууллагууд зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох (Шинэ Зеланд), олон улсын гэрээ хэлэлцээрийг (Япон) хэрэгжүүлдэг.

Зураг 128. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын байгаль орчны салбарын бодлого




3. ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН САНАЛ БУЮУ ТО-ВЕ

БОУАӨЯ болон түүний харьяа Ойн газарт хийж гүйцэтгэсэн Процессын дахин инженерчлэлийн судалгааны дүнд байгаль орчны салбарын одоогийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон. Энэхүү судалгааг боловсруулахдаа Дэлхийн банкнаас 2022 онд танилцуулсан “Төрийн албаны шинэчлэлийн дөрвөн үе шат” загварыг жишиг болгон ашигласан бөгөөд үндсэн зорилго нь төрийн захиргааны төв байгууллагын бүтэц, удирдлага, үйл ажиллагааны загварыг шинэ үеийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл байдал, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт⁶⁵ (NDC, 2019), НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030, ногоон шилжилтийн бодлогын хүрээнд Монгол Улсад байгаль орчны салбарын бодлого, институтын зохион байгуулалтад шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд БОУАӨЯ нь зөвхөн байгаль хамгаалах бус, уур амьсгалын тэсвэртэй хөгжил, нөхөн сэргээлт, эрсдэлийн удирдлага, инновац, төр-хувийн хэвшлийн түншлэл, тоон шийдэл, шинэ санхүүжилтийн механизм зэрэг олон чиглэлд нэгдсэн бодлогын хэрэгжүүлэгч болон Ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай болжээ.

Зураг 129. Ирээдүйн төлөв загвар (To-be framework)



Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд олон улсын амлалт, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC), НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон ногоон

⁶⁵ Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (2019) Nationally determined

шилжилтийн бодлогын хүрээнд шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байна. Энэ хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын яам нь зөвхөн байгаль хамгаалах бус, **уур амьсгалын тэсвэртэй хөгжил, нөхөн сэргээлт, эрсдэлийн удирдлага, инновац, төр-хувийн хэвшлийн түншлэл, тоон шийдэл, шинэ санхүүжилтийн механизм** зэрэг олон чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй болж байна.

Иймд яамны **бүтэц, зохион байгуулалт, удирдлага, дотоод процесс, харьяа агентлагуудтай уялдаа холбоо** зэргийг системийн түвшинд шинэчлэн загварчлах шаардлага үүссэн.

Framework-ийн бүтэц ба үндсэн зарчим

I. Удирдлагын түвшин:

Засгийн газар – Үндэсний бодлого, хөрөнгө оруулалт, чиглэл өгөгч

Сайд болон төрийн нарийн бичгийн дарга – Стратегийн шийдвэр гаргах, төлөвлөлт, хариуцлагын гүйцэтгэлийг хянах

Сайдын зөвлөл – Салбар хоорондын зохицуулалт, хамтын шийдвэр

II. Үндсэн процессууд:

Бодлого төлөвлөлт ба мониторинг – Шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалт, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Засаглалын бүтэц / Тамгын газар – Үйл ажиллагааны зохион байгуулалт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо

Нэгжүүдийн үйл ажиллагаа ба дэмжих системүүд:

Хүний нөөц ба чадамж – Шинэ үүргийн дагуу чадавхжуулалт, институцийн сургалтын тогтолцоо

Цахим шилжилт – Үндэсний мэдээллийн сангуудтай уялдсан дижитал процесс

Санхүү ба худалдан авалт – Байгальд ээлтэй төсөвлөлт, Ногоон худалдан авалт (Green Procurement)

Эрсдэлийн удирдлага – Байгалийн болон уур амьсгалын эрсдэлийн зураглал, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ

Хууль эрх зүй – Шинэчилсэн зохицуулалтууд, эрх зүйн шинэ орчин

III. Салбар дундын зохицуулалт - Гадаад оролцогч талуудтай уялдаа:

Харьяа байгууллагууд: Усны газар, Ойн газар, ЦУОШГ гэх мэт агентлагуудын хариуцлага, датаны нэгдмэл байдалд анхаарах;

Орон нутгийн засаг захиргаа – Нутаг дэвсгэрийн нөөц ашиглалт, оролцоо;

Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд – Зохицуулалттай төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олголтын үр дүн;

Үндэсний хороо, зөвлөлүүд – Улс төрийн болон олон нийтийн оролцооны механизмууд;

Төрийн үйлчилгээний шинэ загвар

Зөвшөөрөл олголт – Уур амьсгалын нөлөөллийг тооцсон интеграцчилсан зөвшөөрлийн систем;

Нэгдсэн мэдээллийн бааз – Байгалийн баялгийн менежмент, нөхөн сэргээлтийн хяналтын систем;

Иргэд, байгууллагад чиглэсэн шуурхай, цахим үйлчилгээ;

Тусгай зөвшөөрөл олголтын шинэчлэл ба бодлогын нөлөө

Одоогийн нөхцөлд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь олон улсын стандартад суурилагүй, уур амьсгалын эрсдэлийг тусгадаггүй, экосистемийн чадавхтай уялдаагүй

хэлбэрээр явагдаж байна. Ингэснээр зөвшөөрөл нь **зөвхөн эрх олгох механик үйлдэл** төдий болж, бодлогын хэрэгжилт болон үр нөлөөг хангаж чадахгүй байна.

Ирээдүйн загвар: Зөвшөөрөл олголтыг бодлогын хэрэгжилтийн хэрэгсэл болгох

Шинэ framework-д тусгай зөвшөөрөл олголтыг тусгайлан салгаж, дараах стратегийн өөрчлөлтүүдийг тусгасан:

Экосистемийн нөөцийн даацад суурилсан зөвшөөрлийн бодлого – газрын доройтол, усны хомсдол, ой хомсдох эрсдэлийг харгалзан зөвшөөрлийн тоо, цар хүрээ, нөхцөл тавих

Уур амьсгалын нөлөөллийн үнэлгээ (ССА)-г тусгах – зөвшөөрөл бүрийн шийдвэрт уур амьсгалын тэсвэртэй байдлын шалгуур оруулах

Хяналт, тайлагналын үр дүнд суурилсан зөвшөөрлийн хугацаа, сунгалт, цуцлалт – зөвхөн эхний бичиг баримтад тулгуурлах биш, гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоо нэвтрүүлэх

Харьяа агентлагуудын нэгдсэн цахим платформ – зөвшөөрлийн мэдээллийг төвлөрүүлж, давхардсан, эсвэл зөрчилтэй зөвшөөрлөөс сэргийлэх

Зөвшөөрлийн бодлогыг шинэ бүтцэд уялдуулах нь

Тусгай зөвшөөрөл нь одоо нэгдсэн бодлогын хэрэгжилтийн хэсэг болон байршиж байна. Энэ хүрээнд:

Усны газар, Ойн газар, ЦУОШГ зэрэг харьяа агентлагуудын дүн шинжилгээ, тоон мэдээлэл дээр суурилан зөвшөөрлийн шийдвэр гаргах

Яам нь өөрөө бодлого-шийдвэрийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох бус зөвшөөрөл олголтын стратегийг хянан баталгаажуулдаг болох

Бодлогын дэмжих нэгжүүд (эрсдэл, хууль, цахим шилжилт, хүний нөөц гэх мэт) зөвшөөрлийн хяналтын систем, дотоод аудит, мэргэжлийн стандарт бий болгоход оролцоно.

Энэхүү загварыг цаашид ашиглах нь:

- Яамны албан ёсны бүтэц, орон тооны шинэчлэлийн суурь болгон ашиглах;
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах гурван үетэй удирдлагын загвар нэвтрүүлэх;
- Төсвийн төлөвлөлт болон хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг уг загварт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Институцийн шилжилт хийх үе шаттай аргачлал (phased institutional reform approach) хэрэгжүүлэх;

3.1. Институци, манлайлал, бодлогыг бэхжүүлэх.

3.1.1. Хууль, стратеги ба бодлого:

Одоо	Шийдэл	Хугацаа
<ul style="list-style-type: none"> ▪ Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он), тус суурь хуулийн шинэчлэл сүүлийн 30 жилд хийгдээгүй. ▪ Бодлогууд хоорондоо уялдаа-59.0% (Алсын хараа-2050-тай харьцуулахад) ▪ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын үйл ажиллагаанд нийт 44 хууль, 94 эрх зүйн акт /дүрэм, 	<p>Байгаль орчны салбарын суурь хууль, түүнд нийцүүлэн бусад хуулийг нийгмийн шилжилт, олон улсын чиг хандлага, цаг үеийн нөхцөл шаардлагад тулгуурлан салбарын бодлого, эрх зүйн болон засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Дунд ба урт хугацаанд</p>

журам, бусад хэм хэмжээний акт/ мөрдөгдөж байна.		
---	--	--

Монгол Улсын Байгаль орчны салбарын хуулиудыг ерөнхийлөн ангилж, жагсаалтыг тоймлон доорх хүснэгтэд харуулав (2024 он)

Хүснэгт 72. Монгол Улсын Байгаль орчны салбарын хуулиуд (2024 он)


№	Хуулийн ангилал	Хуулийн нэр	Тайлбар / Зэрэглэл
Суурь хууль			
1	Суурь хууль	Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)	Нийтлэг үндэслэл, зарчим, төрийн болон иргэний оролцоог зохицуулна
Байгалийн нөөцийн тухай хуулиуд			
2	Усны нөөц	Усны тухай хууль	Усны хамгаалалт, зохистой ашиглалт
3	Ойн нөөц	Ой, түүний тухай хууль	Ойг хамгаалах, нөхөн сэргээх
4	Газар	Газрын тухай хууль	Газрын менежмент, ашиглалт
5	Газрын хэвлий	Газрын хэвлийн тухай хууль	Ашигт малтмал, баялгийн зохицуулалт
6	Бэлчээр	Бэлчээр ашиглалтын тухай хууль (төсөл)	Хөдөө аж ахуйн нөөцийн зохистой хэрэглээ
7	Амьтан	Амьтны тухай хууль	Зэрлэг амьтны хамгаалалт
8	Ургамал	Ургамлын тухай хууль	Ургамлын нөөцийн хамгаалалт
9	Усны төлбөр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Ус ашиглалтын төлбөрийн зохицуулалт
10	Ойн төлбөр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Төлбөрийн тогтолцоо
11	Агаар	Агаарын тухай хууль	Агаарын чанар, бохирдлын хяналт
Байгаль орчны нөлөөлөл ба хяналт, нөхөн сэргээлт			
12	Байгаль орчны үнэлгээ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	Үйл ажиллагааны байгальд нөлөөллийг урьдчилан үнэлэх
13	Аудит	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	Байгаль орчны хяналтын хэлбэр
14	Нөхөн сэргээлт	Хууль, журам, аргачлал, стандарт	Акт байдлаар хэрэгждэг журам
15	Хог хаягдал	Хог хаягдлын тухай хууль	Хогийн менежмент, дахин ашиглалт
16	Химийн бодис	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	Аюултай бодисын бүртгэл, хяналт
Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулиуд			
17	Хамгаалалт	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	Үндэсний паркууд, дархан цаазтай газар
18	Соёлын өв	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	Байгалийн дурсгалт газар багтана
Уур амьсгал, ногоон хөгжил			
19	Уур амьсгал	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль (төсөл)	Цаг уурын эрсдэлтэй тэмцэх хууль
20	Ногоон хөгжил	Алсын хараа-2050 бодлогын баримт бичиг	Стратеги баримт бичиг
Хариуцлага, оролцоо, хамтын ажиллагаа			
21	Мэдээлэл	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Ил тод байдал, дата хуваалцах
22	Иргэдийн оролцоо	БОНБУ-ний тухай хууль, дагалдах журам, бусад	Олон нийтийн оролцоог зохицуулна
23	Зөрчил	Зөрчлийн тухай хууль	Байгаль орчны зөрчил, шийтгэл

		Төрийн хяналт шалгалтын тухай хууль	
24	Зөрчил шалгах	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Хяналт, мөрдөн шалгах ажиллагаа

3.1.2. Бүтэц, зохион байгуулалт:

Одоо	Шийдэл	Хугацаа
<ul style="list-style-type: none"> ▪ Хэрэгжүүлэгч нэгжийн зохион байгуулалттай: Нийт арга хэмжээний 80 орчим хувь нь захиргааны шинжтэй үйл ажиллагаанд зарцуулагдаж байна. ▪ Салбарын тусгайлсан харилцааг зохицуулсан 8 хууль болон Зөвшөөрлийн тухай хуулиар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийн зохист харьцаа алдагдсан. ▪ Шинжилгээгээр одоогийн мөрдөгдөж байгаа яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт 55 зорилгоор 135 чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас 19 буюу 14.1 % нь бодлого боловсруулах, 32 буюу 23.7% нь бодлого, хууль хэрэгжүүлэх, 15 буюу 11.1% нь хяналт тавих, 66 буюу 48.9% нь захиргааны, үлдсэн нь бусад чиг үүрэг байна. ▪ Нэгдмэл бодлого, төлөвлөлт алдагдсан: Нэг бодлогыг хэд хэдэн байгууллага, бүтцээр хэрэгжүүлж байгаагаас чиг үүргийн ойлгомжгүй байдал, давхардал, тодорхойгүй байдал үүсгэсэн байна. ▪ Стратеги нь салбарын бодлоготой уялдаагүй: Судалгаа, нотлогоонд суурилсан стратеги төлөвлөлт, өгөгдөл, мэдээллийн ашиглалт дутмаг. 	<ul style="list-style-type: none"> ▪ Төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, үр дүнд чиглэсэн, үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, олон улсын цомхон удирдлагын (lean management) аргачлалын дагуу бүтцийг зохион байгуулах; /Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохист харьцааг хангах, экосистемийг цогцоор судлах, хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зорилгоор яамны хэрэгжүүлэх чиг үүргийг шилжүүлж, харьяа байгууллагуудыг нэгтэх, өөрчлөн зохион байгуулах байдлаар Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд Байгаль орчны ерөнхий газрыг тохируулагч агентлаг болгох байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх ▪ Яамны харьяа судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, салбарын болон бодлого зохицуулалтад дэмжлэг үзүүлэх чадамжтай байхаар өөрчлөн зохион байгуулах. ▪ УИХ, ЗГ, салбарын бодлого, шийдвэрийг судалгаа, шинжилгээ, нотолгоонд суурилан гаргах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, ашиглах боломжийг хангах зорилгоор БО-ны мэдээллийн сангийн удирдлага, хөгжүүлэлт, боловсруулалт, хөтөлөлтийг хариуцах Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан төвийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн шинэчлэн зохион байгуулах. 	<p>Шууд болон дунд хугацаанд</p>

Зураг 130. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бүтцийн санал



Тайлбар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлэх чиг үүргийг шилжүүлэн өөрчлөн зохион байгуулах хувилбарын санал.

Зураг 131. Байгаль орчны газрын бүтцийн санал



Тайлбар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Ойн газрыг нэгтгэж (орон тоо-76), яамны хэрэгжүүлэх чиг үүргийг шилжүүлэн Засгийн газрын тохируулагч агентлаг Байгаль орчны ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулах хувилбарын санал.

3.1.3. Манлайлал ба оролцоо:

Одоо	Шийдэл	Хугацаа
<ul style="list-style-type: none"> Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбар нь Засгийн газрын тухай хуульд заасан Нийтлэг харилцаа буюу Ногоон хөгжлийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, Усны нэгдсэн бодлого, Биологийн олон янз байдлын бодлого зэргүүд болон Олон улсын 17 гэрээ, конвенцоор 	<ul style="list-style-type: none"> Салбарын манлайлыг хангах: Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан Ногоон хөгжлийн бодлого Засгийн газрын тухай хуулиар тусгайлан заасан 3 бодлого, 6 асуудал, үндэсний хэмжээний хөдөлгөөн, Олон улсын чиг хандлагад Ногоон шилжилт, уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд тухайн улсын бодлогын яамны дотоод, гадаад манлайлал 	<p>Шууд болон дунд хугацаанд</p>

<p>хүлээсэн үүрэг амлалт зэргийг нэгтгэн зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Цэнхэр алт үндэсний арга хэмжээ болон Засгийн газрын хэрэгжүүлэх 14 мега төсөлд байгаль орчин, бодлогын дэмжлэг, шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт, манлайлыг хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна. Засгийн газрын тухай хуулиар эрхлэх асуудалд нь хуульчилан тусгасан “Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал 16 яамнаас 5 яам нь буюу 31 хувь нь стратеги, өөрчлөлтийн хөтөлбөрт тусгасан. 	<p>чухал байр суурийг эзэлдэг, нөгөө талаар Засгийн газрын манлайлал, бодлогын удирдамжаар хангах, салбар дундын зохицуулалт хийх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэгт үндэслэн БОУАӨЯ-ЫГ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ЯАМ БОЛГОХ;</p> <ul style="list-style-type: none"> Чиг үүргийн хуваарилалтыг дахин авч үзэх: Яамны бодлого боловсруулах, зохицуулах үйл ажиллагаанд чиглэсэн бүтэц, нэгжүүдийн ажлын чиг үүргийг тодорхой болгож, хэрэгжүүлэх чиг үүргүүдийг агентлаг, харьяа газрууд руу шилжүүлэх, бүрэн цахимжуулах; Дижитал шийдэл нэвтрүүлэх: Захиргааны ажлуудыг автоматжуулж, ажилтнуудын бодлого боловсруулахад төвлөрөх нөхцөлийг бүрдүүлэх, 	
---	--	--

3.1.4. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх:

Одоо	Шийдэл	Хугацаа
<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн бодлого нь салбарын зорилго, бодлоготой уялдаагүй бөгөөд бодлого боловсруулах чадамж дутагдалтай. Салбарын хүний нөөцийн бодлого байхгүй. Салбарын чиг үүрэгт нийцсэн хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлээгүй. БОУАӨЯ нь 2018-2024 оны хоорондох хүний нөөцийн хөдөлгөөнөөс харахад тухайн яаманд ажиллаж буй албан хаагчид өөрийн хүсэлтээр болон захиргааны санаачилгаар ажлаас чөлөөлөгдөх байдал сүүлийн 5 жилд анхаарал татахуйц өндөр буюу 24.1-56.4 хувь өөрчлөгдсөн. Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулах зохицуулалтыг бий болгосон ч 2013 онд төрийн албан хаагчийн 11.5 хувь нь, 2017 онд 15.5 хувь нь 2019 онд 22.3 хувь, 2022 онд 23.8 хувь нь солигдсон байна.⁶⁶ Байгууллагын нийт албан хаагчийн жилд 5-10 хувь нь халагдаж, солигдож байхыг хэвийн буюу тогтвортой гэж үзэхэд 20 орчим хувь буюу төрийн захиргааны таван албан хаагч тутмын нэг нь ажлаас халагдаж эсвэл чөлөөлөгдөж байгаа нь төрийн албаны ой санамж алдагдах, мэдлэг туршлагын дутагдал үүсгэх эрсдэлийг дагуулж байна.⁶⁷ 	<ul style="list-style-type: none"> Чадамжид суурилсан, стратегийн хүний нөөцийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх: Салбарын зорилго, хүрэх үр дүнд чиглэсэн албан тушаал бүрийн хэрэгцээт ур чадварыг тодорхойлж, сонгон шалгаруулалт болон сургалт хөгжлийг нийцүүлэх. Тасралтгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх: Бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, ирээдүйн өөрчлөлт, боломж, эрсдэлүүд, олон улсын чиг хандлага судлах арга зүйн чиглэлээр төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулах. Гүйцэтгэл, чадамжид суурилсан тогтолцоог бий болгох: Чадвар, гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем нэвтрүүлж, сайн гүйцэтгэлийг дэмжих. Судалгаанд суурилсан арга хэмжээ: Энэхүү судалгааны тайлангийн дүгнэлт, санал, зөвлөмжид тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх. 	<p>Шууд болон дунд хугацаанд</p>

⁶⁶ Үндэсний аудитын газар. (2024) Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө аудитын тайлан. УБ хот.

⁶⁷ Мөн тэнд

3.1.5. Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах:

Одоо	Шийдэл	Хугацаа
<ul style="list-style-type: none"> Орон нутгийн ЗД, ИТХ-аас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бууруулж төлөвлөх, төсвийг өөр зориулалтаар зарцуулах, аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны уялдаа холбоо байхгүй Тус салбарын ном, норматив эдийн засгийн өсөлттэй уялдуулж шинэчлэл хийгдээгүй. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилсан төсөвлөлтөд үндэслэн тодорхойлж улсын болон орон нутгийн төсөвт хөтөлбөрийн хүрэх үр дүнг ижил хэмжигдэхүүнээр хэмжиж салбарын нэгдсэн төсвийн хүрэн дэх үр дүнгүүдийг оновчтой тодорхойлодоггүйгээс төсвийн үр өгөөжийг хэмжих боломжгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэхийг үүрэг болгосон ч "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2022 онд ДНБ-ний 0.28 хувь, 2023 онд ДНБ-ний 0.29 хувь, 2024 онд ДНБ-ний 0.35 хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.⁶⁸ Монгол орны ойн хүлэмжийн хийн шингээлт, ялгаруулалтын суурь үзүүлэлтийг тогтоожт ойн доройтол, хомсдлыг бууруулах, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсаас санхүүгийн дэмжлэг авах, нүүрстөрөгчийн худалдааны зах зээлд оролцох боломж нээгдэж байна. 	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэх; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу "Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувиар тооцон төлөвлөхөр заалтын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих; Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилж шинэчлэх; Байгаль орчны чиглэлийн норматив, стандартуудыг шинэчлэн тогтоох ажлыг нийгэм, эдийн засаг, инфляц, байгаль цаг уур, газарзүйн бүс бүслүүр болон өөрийн орны онцлогт тулгуурлан шинэчлэн боловсруулах Экосистемийн динамик тэнцвэрт байдлыг хадгалсан ойн тогтвортой менежмент нь ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ойн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ганц биш олон эх үүсвэрээс санхүүжих боломжтой "ногоон бизнес" хөгжих боломж бүрдэх юм. Байгаль орчин, уур амьсгалын сангийн менежментийг сайжруулж, байгаль орчны салбарын олон эх үүсвэр (байгалийн нөөц ашигласны, бохирдуулагчийн, экосистемийн үйлчилгээний төлбөр болон ашигт малтмалын экспортын орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зорилгоор тодорхой мөнгөн дүнг төвлөрүүлэх өмнөх туршлага г.м) бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх институт болгон хөгжүүлэх; 	<p>Шууд болон дунд хугацаанд</p>

3.2. Шинэлэг хүртээмжтэй govtech шийдлүүдийг нэвтрүүлж, иргэн-төвтэй хөгжүүлэлтийг нэвтрүүлэх

Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны оновчит процесс

⁶⁸ ЗГХА, Ойн газрын 2024 оны тайлан

Тайлангийн өмнөх хэсэгт дурдсанчлан алив үйл ажиллагааны оновчит процессыг загварчлах (To-Be mapping) ажлын үр дүнтэй байдлын суурь үзүүлэлт нь чанартай гүйцэтгэсэн одоо явагдаж буй процессын зураглал (As-Is mapping) болно. Тайлангийн энэ хэсэгт багийн бусад гишүүдээс хүлээн авсан одоо явагдаж буй процессын мэдээлэлд үндэслэн оновчит процессын ерөнхий загварыг үйлдсэн болно.

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2-т “Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно”. гэж заасан бөгөөд зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаа нь зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс зөвшөөрөл хүсэгчийн хүсэлт болон холбогдох баримт бичиг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, зөвшөөрөл олгох, сунгах, эсхүл зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзах шийдвэр гаргах болно. Иймд, тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаа нь холбогдох баримт бичиг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг баримтаар хянан шийдвэрлэхэд чиглэсэн харилцаа гэж үзсэн.

Процессийн зураглалын баг болон судалгаанд оролцогч талуудаас хүлээн авсан мэдээллээс үзвэл Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас **нийт 101 төрлийн** баримт бичгийг зөвшөөрөл хүсэгч буюу өргөдөл гаргагчаас шаарддаж байна. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд шаардагдаж буй баримт бичгийн жагсаалтанд хийсэн шинжилгээний үр дүн (**Хавсралт 1**)-ээс үзвэл:

- 1) баримт бичгийг үнэлэх ажиллагаа бүрийг цахимаар гүйцэтгэх боломжтой;
- 2) нийт 71 төрлийн баримт бичгийг үнэлэхэд Хэрэглээний програмчлалын интерфейс (API) ашиглахаар байна. Энд дурдагдсан эхний үр дүн нь загварчилсан оновчит процессын ерөнхий загварын суурь нөхцөл болсон бол удаах нь тэрхүү загварыг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардагдах суурь нөхцөл болно. Тайлбарыг дарааллын дагуу өгч байна.

Оновчит процессын ерөнхий загвар.

Оновчит процессын ерөнхий загварыг тодорхойлохдоо одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулалгүйгээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах зарчмыг баримтлав. Загварын дагуу хүсэлт гаргасан этгээдийн эрх бүхий албан тушаалтан:

- 1) нэвтрэлтийн нэгдсэн систем ашиглан зөвшөөрлийн цахим системд нэвтрэн
- 2) холбогдох нөхцөл, шаардлагатай танилцан хүлээн зөвшөөрч байгаагаа тоон гарын үсгээр баталгаажуулмагц
- 3) системээс тухайн этгээдтэй холбогдох шаардлагатай төрд байгаа мэдээлэлд хандан хүний оролцоогүй үнэлгээ хийнэ. Энэ процессын дараагаар,
- 4) зохих шаардлагыг хангасан хүсэлт гаргагч нь төрд байхгүй шаардагдах мэдээллийг цахим маяганд оруулах бөгөөд хүсэлт гаргагчид зориулан харгалзах утга бүрийн тайлбар байх ба тогтоосон шалгуурын дагуу хүний оролцоогүй системээс үнэлнэ.
- 5) Төрд байгаа болон байхгүй мэдээллийг хүний оролцоогүй үнэлэх учир энэхүү загварыг хэрэглээнд нэвтрүүлснээр хүсэлтийг хянан шийдвэрлэх чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуульд **заасан 15 хүртэлх тооны ажлын өдрийг системийн ачааллаас хамааран 15 хүртэлх минутад шийдвэрлэх боломжтой болж байна** (**Дэлгэрэнгүйг хавсралт хэсгийн хүснэгт-ээс үзнэ үү**). Энэ загвар нь Bain & Company компаниас тодорхойлсон бизнесийн процессын дахин инженерчлэлийн үндсэн 4 шалгуурт нийцсэн. Тодруулбал:

Илүү чанартай харилцагчийн үйлчилгээний удирдлага (Better customer service). Зөвшөөрөл хүсэгчийн холбогдолтой төрд байгаа шаардагдах мэдээллийг зөвшөөрөл хүсэгчээс шаардахгүй, зөвшөөрөл хүсэгчээс шаардах төрд байхгүй мэдээллийг холбогдох

тайлбарын хамт байршуулан оруулсан утгыг хүний оролцоогүйгээр үнэлдэг учир төрийн үйлчилгээний хүнд суртал, авилгын эрсдлээс сэргийлсэн.

Илүү үр дүнтэй, зардал хэмнэсэн (Lower cost and impact). Процесс бүрээр үнэлгээг гүйцэтгэх учир холбогдох шалгуурт нийцэж буй эсэхийг тухай бүр нь мэдэгддэг, хүсэлт гаргагчаас шаардах үйлдлийг бууруулсан.

Илүү чанартай үйлчилгээ (Improved service quality). Далд процессыг арилгаж, хүсэлтийг шуурхай, хүний оролцоогүйгээр бодит цагийн горимын дагуу шийдвэрлэх бололцоог бүрдүүлсэн.

Илүү сэтгэл ханамж дээшилсэн албан хаагч (Happier employees). Зөвшөөрлийг шийдвэрлэх ажиллагааг бүрэн автоматжуулснаар холбогдох төрийн албан хаагч хэмнэгдсэн хугацааг ажлын бусад чиг үүргээ хэрэгжүүлэх (жишээлбэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих гэх мэт)-эд илүү төвлөрч ажиллах боломжтой болохын зэрэгцээ аливаа маргаан, хардалтаас ангид байх бололцоотой болно.

Анхаарал хандах талбар:

- 1. Мэдээллийн нэгдсэн систем (IIS).** Шинжилгээний үр дүнгийн талаар танилцуулахад дурдсанчлан процессыг дахин загварчлах чиглэлээр санал болгосон шийдлийн 70% нь ямар нэг хэмжээгээр Хэрэглээний програмчлалын интерфэйс (API) ашиглахуйц байгаа нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас мэдээллийн нэгдсэн системийн үр дүнтэй байдал загварын үр дүнтэй байдалд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэхийг илтгэж байна. Мэдээллийн нэгдсэн систем гэсэн ойлголтонд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд шийдвэр гаргахад шаардагдах тус яамны мэдээллийн сан болон чиг үүргийн хүрээнд хамаарах бусад төр-хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн санг нэгтгэсэн системийг авч үзэж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэдээллийн санг холбогдох чиг үүргийн хүрээнд бусад төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн сантай холбосноор Оновчит процессын ерөнхий загвар ажиллах үндсэн нөхцөл бүрдэх ач холбогдолтой. Тухайлбал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэдээллийн системд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан аж ахуйн нэгжийн мэдээллийн санг холбосноор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг зөвшөөрөл хүсэгчээс авах шаардлагагүй болно. Мөн гүйцэтгэсэн ажлын мэдээлэлтэй танилцах, цаашилбал газар зүйн мэдээллийн санд бүртгэн бодлого боловсруулахад ашиглах зэргээр зөвхөн зөвшөөрлийн үйл ажиллагаа бус бусад чиглэлээр ч ашиглах бололцоо бүрдэх болно.
- 2. Хэрэглээний програмчлалын интерфэйс (API).** Хэрэглээний програмчлалын интерфэйс нь програм хоорондоо холбогдож, өгөгдөл солилцох бололцоог олгодог тусгай зориулалтын програм бөгөөд зөвхөн холболт хийх бус өгөгдлийг боловсруулан хэрэгцээнд нийцүүлэх үүрэг гүйцэтгэдэг учир төрд байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах зорилгыг хангах үндсэн хэрэгсэл болно.
- 3. Цахим маягт.** Зөвшөөрлийн үйл ажиллагаанд бизнес эрхлэгчээс шаардаж буй мэдээллийг цахи маягтаар бүрдүүлэх нь мэдээллийг цахим өгөгдөл болгон магадлан үнэлэх ажиллагааг хүний оролцоогүйгээр гүйцэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ бодлогын шийдвэрийг оновчтой гаргахад хэрэглэх их өгөгдлийн санг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нийт 39 тусгай зөвшөөрөл олгох процесс буюу хариуцагчаар ангилвал Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хариуцан олгож байгаа 32 болон Ойн газрын хариуцан олгож байгаа 7 тусгай зөвшөөрлийн бүрийн ирээдүйн (TO-BE) загвараар дараах нэгтгэсэн үр дүнд хүрэх боломжтой байна.


Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл



Дээрх зургаас харахад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хариуцан олгож байгаа 32 тусгай зөвшөөрөлд өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээгээр 554 алхамыг давхардсан тоогоор 253 албан хаагч хэрэгжүүлж байгааг өмнө нь дурдсан зарчимаар ирээдүйн (TO-BE) загвараар дахин инженерчлэлийг хийснээр


- 405 алхам болж давхардсан тоогоор 190 албан хаагч оролцож хүний процесс багасч байна.
- Төрийн үйлчилгээ дэх цахимжилт 23 хувиас 65 хувьд хүрэх боломжтой байна.
- Иргэн, аж ахуйн нэгжээс тусгай зөвшөөрөл хүсэхтэй холбоотой тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарч 4-17 төрлийн баримт бичгийн бүрдүүлэх шаардлага үүсч байгаа буюу нийт 32 төрлийн тусгай зөвшөөрлийн хувьд давхардсан тоогоор 248 баримт бичиг буюу давхардаагүй 112 төрлийн баримт бичиг гаргуулах авч байгааг төр өөрт байгаа мэдээллийг ялган үзэхэд ирээдүйн (TO-BE) загвараар дахин инженерчлэлийг хийснээр иргэн, аж ахуйн нэгжээс бүрдүүлэх бичиг баримт шаардахгүй байх нөхцлийг бүрдүүлэх бүрэн боломжтой байна.

Ойн газраас олгож байгаа тусгай зөвшөөрөл



Ойн газрын хувьд хариуцан олгож байгаа 7 тусгай зөвшөөрөлд өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээгээр 147 алхамыг давхардсан тоогоор 63 албан хаагч хэрэгжүүлж байгааг өмнө нь дурдсан зарчимаар ирээдүйн (TO-BE) загвараар дахин инженерчлэлийг хийснээр 91 алхам болж давхардсан тоогоор 42 албан хаагч оролцож хүний процесс багасч байна. Төрийн үйлчилгээ дэх цахимжилт 29 хувиас 100 хувьд хүрэх боломжтой байна. Түүнчлэн иргэн, аж ахуйн нэгжээс тусгай зөвшөөрөл хүсэхтэй холбоотой тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарч 9-11 төрлийн баримт бичгийн бүрдүүлэх шаардлага үүсч байгаа буюу нийт 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хувьд давхардсан тоогоор 73 баримт бичиг буюу давхардаагүй 11 төрлийн баримт бичиг гаргуулах авч байгааг төр өөрт байгаа мэдээллийг ялган үзэхэд ирээдүйн (TO-BE) загвараар дахин инженерчлэлийг хийснээр иргэн, аж ахуйн нэгжээс бүрдүүлэх бичиг баримт шаардахгүй байх нөхцлийг бүрдүүлэх бүрэн боломжтой байна.

Зураг 132. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааны оновчилсон ерөнхий процесс



Хүснэгт 73. Оновчтой процессын ерөнхий загварын тайлбар

№	Процессын нэр	Үйлдлийн эзэн	Тайлбар
A1	Нэвтрэх	Өргөдөл гаргагч	<p>Өргөдөл гаргагч (тусгай зөвшөөрөл авахаар эрх бүхий байгууллага буюу энэ тохиолдолд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хандан өргөдөл гаргаж буй хуулийн этгээд) нь нэвтрэлтийн нэгдсэн систем ашиглан зөвшөөрлийн цахим системд нэвтэрнэ.</p> <p>Нэвтрэлтийн нэгдсэн систем нь хэрэглэгч нэг бүртгэлийн эрхээр олон систем рүү зэрэг хандах боломжтой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Identity and Access” систем бөгөөд өргөдөл гаргагчид нэг нэвтрэлтээр олон систем рүү (жишээлбэл, цахим татварын систем, цахим төлбөрийн баримтын систем гэх мэт) зэрэг нэвтрэх бололцоог бүрдүүлсэн, нэг удаагийн нууц үгийг давхар ашиглах боломжтой /OTP/ зэрэг аюулгүй байдлын нөхцлийг бүрдүүлсэн шийдэл юм.</p>
A2	Мэдүүлэг бөглөх	Өргөдөл гаргагч	<p>Өргөдөл гаргагч нь тусгайлан загварын дагуу бэлдсэн мэдүүлэгтэй танилцан тавьж буй нөхцөл (өргөдөлд дурдагдах мэдээллийн үнэн зөв байдлыг батламжлах, хэрэв худал мэдээлэл өгсөн тохиолдолд олгосон зөвшөөрлийг цуцлах зэрэг)-ийг хүлээн зөвшөөрч байгаагаа батламжлан тоон гарын үсэг (tridumkey эсвэл monpass)-ээр баталгаажуулна.</p> <p>Тоон гарын үсэг нь энгийн гарын үсэгтэй адил ашиглагдах ба гарын үсэг, тамга тэмдгийг орлох цахим баримт бичиг юм.</p>
Б1	Төрд байгаа мэдээллийг үнэлэх	“ХУР” систем	<p>Өргөдөл гаргагч нь мэдүүлгийн талбартай танилцан нөхцлийг хүлээн зөвшөөрч байгааг өөрийн тоон гарын үсгээр баталгаажуулмагц системээс өргөдлийн гаргагчийн регистрийн дугаараар “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системд холбогдон Хэрэглээний програмчлалын интерфэйс (API) ашиглан холбогдох төрийн байгууллагын мэдээллийн системд нэвтрэн өгөгдлийг хүний оролцоогүйгээр үнэлэх. Жишээлбэл, өргөдөл гаргагчийн тоон гарын үсгээр нэвтэрч байгаа тул API ашиглан УБЕГ-ын цахим мэдээллийн сангаас тухай өргөдөл гаргагчийн улсын бүртгэлийн мэдээллийг автомат үйлдлээр баталгаажуулах боломжтой.</p> <p>“ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем нь төрөөс иргэд рүү чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг илүү хялбарчлах зорилгоор төрд байгаа мэдээллийг тасалдалгүй ажиллагаатай, төвлөрсөн удирдлага бүхий платформуур дамжуулан иргэд аж ахуй нэгжид хүрэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилготой мэдээлэл солилцооны систем юм.</p>
Б2.1	Өргөдлийг зөвшөөрөх	“ХУР” систем	<p>ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан өргөдөл гаргагчийн талаарх төрд байгаа мэдээллийг өөрөөс нь шаардалгүйгээр хүний оролцоогүй үнэлж, зохих шаардлагыг</p>

			хангаж буйг тогтоомогц өргөдөл гаргагчид системд дараагийн алхам хийх зөвшөөрлийг өгнө.
B2.2	Өргөдлийг буцаах	“ХУР” систем	ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан өргөдөл гаргагчийн талаарх төрд байгаа мэдээллийг өөрөөс нь шаардалгүйгээр хүний оролцоогүй үнэлж, зохих шаардлагыг хангаагүй тохиолдолд холбогдох тайлбарын дагуу өргөдлийг буцаана. Ингэснээр өргөдөл гаргагчийн хугацаа, хүчин чармайлтыг хэмнэнэ.
A3	Мэдүүлгийн цахим маягт бөглөх	Өргөдөл гаргагч	Өргөдөл гаргагч нь энэ алхамд тусгай зөвшөөрлийн өргөдлийг үнэлэхэд шаардагдах төр байхгүй мэдээллийг цахим маягтын харгалзах талбар бүрээр бөглөнө.
B1	Мэдээллийг үнэлэх	Зөвшөөрлийн цахим систем	Цахим маягтын талбар бүрд өргөдөл гаргагчаас оруулсан мэдээллийг өмнө нь тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ. Жишээлбэл, өргөдөл гаргагч өөрийн байгууллагын ажилтны регистрийн дугаарыг оруулмагц системээс тухайн ажилтан руу зурвас илгээн иргэний мэдээлэлд хандах зөвшөөрөл авах ба үүний дараагаар системээс Хэрэглээний програмчлалын интерфэйс (API) ашиглан НДЕГ-ын мэдээллийн системд хандан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллээс ажилтан нь тухайн байгууллагад бүртгэлтэй эсэх, Цахим үйлчилгээний нэгдсэн портал (E-Mongolia)-аас тухайн ажилтны боловсролын мэдээллийг батламжлах (Хэрэв 2014 оноос хойш мэргэжлийн диплом авсан бол боловсролын цахим санд бүртгэлтэй) зэрэг үйлдлийг гүйцэтгэнэ.
B2.1	Өргөдлийг зөвшөөрөх	Зөвшөөрлийн цахим систем	Зөвшөөрлийн цахим систем нь цахим маяганд бөглөсөн мэдээллийг автоматаар үнэлж, зохих шаардлагыг хангаж буйг тогтоомогц өргөдөл гаргагчид системд дараагийн алхам хийх зөвшөөрлийг өгнө.
B2.2	Өргөдлийг буцаах	Зөвшөөрлийн цахим систем	Зөвшөөрлийн цахим систем нь цахим маяганд бөглөсөн мэдээллийг автоматаар үнэлж, зохих шаардлагыг хангаагүй тохиолдолд холбогдох тайлбарын дагуу өргөдлийг буцаана.
A5	Төлбөр төлөх	Өргөдөл гаргагч	Өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрөл авахад шаардагдах зохих шалгуурыг хангаж буй системээс баталгаажуулмагц улсын тэмдэгтийн хураамж төлөх талбарт холбогдох арга хэрэгслээс сонголт хийн улсын тэмдэгтийн хураамжийг төлнө. Улсын тэмдэгтийн хураамж нь төрийн эрх бүхий байгууллагаас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.
B3	Зөвшөөрлийг олгох	Зөвшөөрлийн систем	Системээс Хэрэглээний програмчлалын интерфэйс (API) ашиглан төлбөрийн системээс гүйлгээний мэдээллийг автоматаар баталгаажуулан үндсэн системд мэдэгдмэгц өргөдлийн шийдвэрлэж, тусгай зөвшөөрөл

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

			олгохоор болсон мэдэгдлийг Зөвшөөрлийн нэгдсэн санд мэдэгдэнэ.
Г1	Зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгэх	Зөвшөөрлийн нэгдсэн сан	Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн системээс өргөдөл гаргагч нь холбогдох баримт бичиг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан тухай мэдэгдлийг Хэрэглээний програмчлалын интерфейс (API)-ээр дамжуулан хүлээн авмагц зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгэж, холбогдох зөвшөөрлийн мэдээллийг агуулсан дахин давтагдашгүй QR код бүхий зөвшөөрлийн гэрчилгээг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигч рүү цахим хэлбэрээр илгээнэ.
А6	Зөвшөөрлийн гэрчилгээг хүлээн авах	Өргөдөл гаргагч	Зөвшөөрлийн мэдээллийг агуулсан дахин давтагдашгүй QR код бүхий зөвшөөрлийн гэрчилгээг хүлээн авна.

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Бодлогын уялдаа, төлөвлөлтийн талаар

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын чиг үүрэгтэй холбоотой 4 зорилго, 8 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Судалгаагаар дээрх 74 арга хэмжээг 15 шалгуур үзүүлэлтээр гүйцэтгэлийг үнэлэхээр заасан нь арга хэмжээ бүрийн гарц, үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуурыг оновчтой тодорхойлоогүйг харуулж байна.

2. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилгыг хэрэгжүүлэхээр дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг уялдуулан боловсруулсан эсэхийг судалж үзэхэд 59 хувийн уялдаатай төлөвлөсөн байгаа бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 7 бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр 55.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

3. Байгаль орчны салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо харьцангуй сайн хэдий ч шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн үр дүн, хэрэгжилтийн түвшин ил тод бус байна. Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд салбарын бодлогыг “Ногоон хөгжлийн бодлого”-оор тодорхойлж, зорилт, зорилгууд тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшнийг тодорхой баталсан ч “Ногоон хөгжил”-ийн бодлого ямар түвшинд хэрэгжиж байгаа нь тодорхой бус байна.

4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам дээрх баримт бичигт туссан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын чиг үүрэгт хамааруулан 4 багцад буюу а) Эрх зүйн орчинг боловсронгуй болгох 10 хувь б) чадавхи бэхжүүлэх 22 хувь в) удирдлага зохион байгуулалт 41 хувь г) төсөл хөтөлбөрийн чиглэлээрх арга хэмжээ 17 хувь тус тус төлөвлөгдсөн нь тус салбарын чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээ нь салбар дундын хамтын ажиллагаа, оролцоо, манлайллын хүрээнд бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

5. Засгийн газрын тухай хуулиар Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд нь хуульчилан тусгасан “Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудал”-ыг 16 яамнаас 11 нь үйл ажиллагааныхаа стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртөө тусгаагүй, хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

7. Байгаль орчны салбарын тухайлсан харилцааг зохицуулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Газрын хэвлийн тухай, Хувиргасан амьд организмын тухай, Генетик нөөцийн тухай зэрэг 8 хуульд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон агентлагийн түвшиний хэрэгжүүлэх чиг үүргүүдийг яамны эрхэд хамааруулан хуульчилсан нь яам бодлого тодорхойлох, боловсруулах, зохицуулах чиг үүргээсээ илүү цаг хугацааг үйл ажиллагаа хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэгт зарцуулж байгаа нь Яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасан яамны эрхлэх нийтлэг чиг үүрэгт нийцэхгүй байна.

8. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт яам өдөр тутмын үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлэхээр заасан нийт чиг үүргийн ердөө 14.1% нь бодлого боловсруулах чиг үүрэг, эсрэгээр, 48.9% нь захиргааны чиг үүрэг байгаа нь яамны чиг үүргийн 80 орчим хувь нь бодлого тодорхойлох, боловсруулах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байхаар заасан хуулийн үзэл баримтлалыг гажуудуулж байна.

Эрх зүйн орчны талаар

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд салбарын нийтлэг харилцааг зохицуулсан 22 хуулиар оноосон чиг үүргийн 50 орчим хувь нь бодлого боловсруулах, тодорхойлох чиг үүрэг байгаа нь хуулиар тодорхойлсон яамны эрхлэх нийтлэг чиг үүргийн харьцаатай нийцэж байгаа бөгөөд яамны эрхлэх асуудалд хамаарах салбарын бодлогыг төвлөрүүлэн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2. Байгаль орчныг салбарын харилцааг зохицуулж буй суурь хууль болох Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг 1995 онд баталснаас хойш Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, шинэчлээгүйгээс салбарын бодлого, эрх зүйн зохицуулалтын эрэмбэ алдагдсан гэж үзэхээр байна. Иймд нийгмийн шилжилт, олон улсын чиг хандлага, цаг үеийн нөхцөл шаардлагад тулгуурласан бодлого, эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх болон засаглалын оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгох агуулгын хүрээнд шинэчлэх шаардлага үүссэн гэж үзэж байна.

3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулсан 35 эрх зүйн баримт бичиг /дүрэм, журам, заавар гэх мэт/ батлагдаагүй, мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд бусад салбарын сайдтай хамтран батлахаар холбогдох хууль, тогтоомжид тусгагдсан 8 эрх зүйн баримт бичиг /дүрэм, журам, заавар, жагсаалт, хөтөлбөр, бусад хэм хэмжээний акт/-ийг холбогдох субъекттэй хамтран баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлээгүйгээс байгаль орчны салбарын үйл ажиллагаатай уялдах бусад салбар дундын зохицуулалтыг хангахад хүндрэл учруулах, оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах боломжгүй нөхцөлийг бүрдүүлж болзошгүй байна.

4. Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.” гэж заасан, мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт зааснаар хүчин төгөлдөр эрх зүйн акт мөн боловч байгаль орчны салбарын 24 буюу 25.5 % нь хуулиас давсан зохицуулалтыг тусгажээ. Энэ нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа Ойн газар, Усны газар болон байгаль орчны холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим үйлчилгээ, үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж, доголдол үүсгэх нөхцөл, шалтгаан болох талтай байна.

5. Ойн газрын хувьд Ойн тухай хууль болон Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт тусгагдсан Ойн газрын чиг үүргийн дийлэнх нь хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх болон захиргааны чиг үүрэг байгаа нь хуулиар тодорхойлсон Засгийн газрын агентлагийн эрхлэх нийтлэг чиг үүргийн зохист харьцаа, үзэл баримтлалтай нийцэж байна.

6. Ойн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудад нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ хамгийн ихээр тусгагджээ. Тодруулбал, Ойн тухай хуулиар нийт 108 бүрэн эрх олгогдож, нутгийн өөрийн удирдлагын байгууллага ойн чиглэлээр нийт олгогдсон бүрэн эрхийн 19%-ийг бодлого боловсруулах, 12%-ийг бодлого, хууль хэрэгжүүлэх, 7%-ийг зохицуулах, зөвшөөрөл олгох, хязгаарлах, 16%-ийг хяналт тавих, 44%-ийг захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд тус тус зарцуулж байна.

Бүтэц, зохион байгуулалтын талаар

1. Судалгаагаар одоогийн мөрдөгдөж байгаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт 55 зорилтоор 135 чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас 19 буюу 14.1 % нь бодлого боловсруулах, 32 буюу 23.7% нь бодлого, хууль хэрэгжүүлэх, 15 буюу 11.1% нь хяналт тавих, 66 буюу 48.9% нь захиргааны, үлдсэн нь бусад чиг үүрэг байна.

2. Нэгдмэл бодлого, төлөвлөлт алдагдсан: Нэг бодлогыг хэд хэдэн албан тушаалаар хэрэгжүүлэх чиг үүргийн ойлгомжгүй байдал, давхардал, тодорхойгүй байдал үүсгэсэн байна.

3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяанд “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” УТҮГ, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ, “Уур

амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ТӨААТҮГ гэсэн 3 судалгаа хийх чиг үүрэг бүхий байгууллага байдаг хэдий ч үндэсний хэмжээний суурь судалгаа байдаггүй, бодлогын яамны судалгаанд суурилсан шийдвэр гаргалтад үзүүлэх хувь нэмэр хангалтгүй байна.

4. Туршилт, судалгаанд үндэслэн дэвшилтэт техник, технологийг Монгол орны байгаль, цаг уур, газар зүйн болон ой, ургамалжлын онцлогт тохируулан нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, судалгаанд суурилсан шийдвэр гаргалтыг бүрдүүлэх зорилгоор одоогийн ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Ой хамгаалал, ойжуулалтын салбар, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Ойн фитоценологийн лаборатори, ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэнг нэгтгэж, нэмэлт зардал гаргахгүйгээр төрөлжсөн Ойн эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын хүрээлэнг байгуулах боломжийг судалж, шийдвэрлэх шаардлагатай байна.

Салбар дундын зохицуулалтын талаар

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа байгууллагууд Усны Үндэсний зөвлөл, Уур амьсгалын Үндэсний хороог байгуулсан үндсэн зорилго болох Үндэсний хэмжээний болон салбар дундын зохицуулалт шаардсан асуудал болон зөвлөл, хорооны ажиллах журамд заасны дагуу тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, жилд 2-оос доошгүй удаа хуралдах, хагас жил дутамд ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь танилцуулж, шийдвэрлүүлэх хөшүүргийг бүрэн ашиглахгүй байна.

2. Дээрх үндэсний зөвлөл, хорооны үйл ажиллагаа нь тухайн салбарын яам, агентлагтай чиг үүргийн давхардал байгаа эсэхийг дахин нягталж, шаардлагагүй үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах эсхүл өөрчилж салбарын сайд, Засгийн газрын гишүүнээр ахлуулан бодлогын нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй байна.

3. Холбогдох хуулиар тодорхойлсон яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Сайдын зөвлөл зэрэг шинжлэх ухааны үндэслэлтэй, олон талын оролцоотой шийдвэр гаргах дотоодын механизмын үйл ажиллагааг идэвхжүүлж, бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулж, оновчтой болгох замаар салбар дундын зохицуулалтыг хангах шаардлагатай байна.

Хүний нөөцийн талаар

1. Засгийн газрын тогтворгүй байдал, улс төрийн нөлөөллөс шалтгаалан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэр, бүтэц зохион байгуулалт 2012 оноос хойш 5-6 удаа өөрчлөгдөж, 9 дэх Засгийн газрын гишүүн буюу сайд томилогдон ажиллаж байна. Эдгээр өөрчлөлт бүрт удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг өөрчилснөөс хүний нөөцийн бодлого алдагдаж, салбарын албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах боломжийг хязгаарласан байна.

2. Мэргэжлийн хүний нөөцийн дутагдалд орсон байна. Байгаль орчны салбар нь өргөн цар хүрээг хамарсан шинжлэх ухаан ч мэдлэг, нарийн мэргэжил, олон улсын болон салбар дундын бодлогыг боловсруулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр төв, орон нутгийн байгууллагыг хангах хүний нөөцийн нарийн бодлого, төлөвлөлт шаардсан салбар боловч өнөөдрийн байдлаар хүний нөөцийн бодлогын баримт бичиг, нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөгүй байна.

3. Байгаль орчны салбарын болон БОУАӨЯ, Ойн газрын албан хаагчдаас авсан судалгаагаар байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэгжийн чиг үүргийн хувиарлалт, удирдлагын ур чадвар, арга барил, ажиллах орчин, ажлын жигд бус хувиарлалт зэрэг асуудлуудад судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын сэтгэл ханамж дунджаас доогуур, 4 албан хаагч дутмын 1 нь өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байна. Энэ нь албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах, ажилдаа үнэнч хандах, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2018-2024 оны хоорондох 7 жилийн хүний нөөцийн хөдөлгөөнөөс харахад тухайн яаманд ажиллаж буй албан хаагчид өөрийн хүсэлтээр болон захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлөгдөх байдал сүүлийн 5 жилд анхаарал татхуйц өндөр буюу 24.1-56.4 хувь өөрчлөгдсөн байна. Тухайлбал:

- 2022 он 110 албан хаагч ажилласны 39 буюу 35.5 хувь нь өөрийн хүсэлтээр, 23 буюу 20.9 хувь нь захиргааны санаачлагаар нэгтгэж үзвэл 62 албан хаагч буюу 56.4 хувь нь өөрчлөгдсөн, мөн 2023 он 133 албан хаагч ажилласны 29 буюу 21.8 хувь нь өөрийн хүсэлтээр, 32 буюу 24.1 хувь нь захиргааны санаачлагаар нийтдээ 61 албан хаагч буюу 45.9 хувь нь өөрчлөгджээ.

- Байгууллагын нийт албан хаагчдын 5-10 хувь нь халагдаж солигдож байхыг хэвийн тогтвортой гэж үздэгтэй Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүний нөөцийн хөдөлгөөн буюу ажлаас халагдах эсвэл чөлөөлөгдөх байдлыг харьцуулж үзвэл 24.1-56.4 хувь буюу 2-оос 5 дахин өндөр байна.

Энэхүү хүний нөөцийн хөдөлгөөн нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баримталж буй төрийн албаны тогтвортой байдал, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны залгамж чанарыг хадгалах, салбарын хүний нөөц, ойн санамжийг хадгалах, мэргэжлийн байх бодлого, зорилттой нийцэхгүй байна.

5. Яамны төрийн захиргааны эрхэлсэн, ахлах, дэс түшмэлийн албан тушаалд ажиллах 98 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод байгаль орчны чиглэлийн мэргэжлийг шууд заасан 41, холимог буюу байгаль орчин, бусад мэргэжлийн чиглэл заасан 37, байгаль орчноос өөр мэргэжлийн чиглэл заасан 20 албан хаагч ажиллахаар боловсруулжээ.

6. “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т Хуулийн асуудал хариуцсан бүтцийн нэгжтэй байхаар зохион байгуулагдсан боловч дээр дурдсан нийт 98 албан хаагчийн 51 албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагад “Эрх зүй”-ч мэргэжлийг оруулсан байгаа нь салбарын онцлог, хүний нөөцийн бодлоготой уялдахгүй байна.

7. Дээрх албан тушаалын тодорхойлолтод байгаль орчны салбарт шууд хамааралтай бус “Уул уурхайн олборлолт”, “Газар тариалан, мал аж ахуй”, “Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар дундын чиглэл”, “Био-ангаах ухаан” гэсэн мэргэжлүүдийг оруулсан нь Байгаль орчны салбарын онцлог болох шинжлэх ухаанд суурилсан, Олон улсын хамтын ажиллагаа, салбар дундын онцлогыг харгалзан байгаль орчны чиглэлийн нарийн мэргэжил, туршлагад тулгуурлан бодлого боловсруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харьяа болон төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах боломжийг хязгаарлаж байна.

8. Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах хамгийн гол нөхцөлийн нэг ажлын байрны орчин, тав тухтай байдал, байршил байдаг. 2022 оны төгсгөл, 2023 оны эхэнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ыг тодорхой судалгаа, албан хаагчдын хүсэл сонирхол, саналыг үл харгалзан өвлийн улиралд яармаг руу нүүлгэсэн тухайн жилд яамны албан хаагчид хамгийн олноор өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Эндээс үзвэл Төрийн захиргааны төв байгууллагыг нүүлгэхдээ бодит судалгаа, албан хаагчдын санал хүсэлтийг харгалзан шийдвэрлээгүйгээс салбар хүний нөөцийн дутагдалд орох, төрийн бодлогын залгамж чанар, ойн санамж алдагдах нөхцөлийг үүсгэсэн байна.

Тусгай зөвшөөрлийн талаар

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь бодлого боловсруулах, зохицуулах үндсэн чиг үүрэгтэй боловч Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу бусад төрийн захиргааны төв байгууллагуудтай харьцуулахад хамгийн олон буюу 28 тусгай зөвшөөрлийг өөр дээрээ төвлөрүүлэн олгож байна. Энэ нь байгаль орчны салбарын эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээгээр яам нь бодлого боловсруулах, зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй ч хэрэгжүүлэгч агентлаг, бусад этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой арга хэмжээг гүйцэтгэж байгааг харуулж байна.

2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож буй 18 тусгай зөвшөөрлийн 9 буюу 52.9%, энгийн 8 зөвшөөрлийн 8 буюу 100% нь цахимжуулаагүй, 10 буюу 58.8% нь зохих зөвлөлөөр хэлэлцүүлдэггүй, тусгай 3, энгийн 1, нийт 4 зөвшөөрөл буюу 16% нь Захиргааны хэмжээний актыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон, 1 тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрлөөр олгож байна.

3. Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 41.2 хувь нь төрийн үйлчилгээг авахад ямар нэгэн хүндрэл учирсан бөгөөд олонхи нь хугацаандаа үйлчилгээгээ авч чаддаггүй,

салбарын байгууллагуудын хоорондын уялдаа байхгүй, нэг бичиг баримтыг цаасаар, цахимаар, олон давтамжтай авдаг, гомдол санал шийдэгдэхгүй байна гэжээ.

4. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож буй тусгай зөвшөөрлөөс Ойн чиглэлийн зөвшөөрлийн хувьд авч үзвэл зөвшөөрөл олгох үйл явц нийт 21 үе шаттай явагддаг бөгөөд 10 оролцогч талтай байна. Зөвшөөрөл олгох үйл явцын 52.3% нь цаасан, 28.5% нь цахим бол үлдсэн 19.2% нь цаасан болон цахим хэлбэрээр явагдаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зөвшөөрлийг олгох үйл явцын 71.5 % нь цаасан суурьтай байна.

5. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлүүдийг төвлөрүүлэн олгож байгаа болон зөвшөөрөл агуулсан дүгнэлт, тайлан, төлөвлөгөө батлах зэргээр аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага буюу яамны хамаарал өндөр байгааг дээрх харьцуулсан судалгаа, хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ харуулж байна.

6. Яам нь байгаль орчны чиглэлээр олгож буй тусгай болон энгийн зөвшөөрлийг задлах, хуваах, зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг бүрдлийн хянан магадалгааг бүрэн гүйцэт хийхгүй, албан бичиг хэлбэрээр олгох, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах, бүрэн цахимжуулаагүйгээс зөвшөөрөл олгох үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж, доголдол үүсгэх нөхцөл, шалтгаан болох боломжтой.

Иргэд, аж ахуйн нэгжээс авсан судалгааны талаар

1. Цахим судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 17.6 хувь нь иргэн, 82.4 хувь нь аж ахуй нэгж байгууллага байна. Байгаль орчны чиглэлээр хамгийн сүүлд ямар байгууллагаас үйлчилгээ авсан эсэхийг нь тодруулахад 82.4 хувь нь төрийн байгууллага, 11.8 хувь нь мэргэжлийн байгууллага, 5.9 хувь нь бусад байгууллагаас үйлчилгээ авсан байна.

2. Эдгээр иргэн, ААНБ-уудын 47.1 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 29.4 хувь нь Ойн газар, 11.8 хувь нь Усны газар, 35.3 хувь нь аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, 17.6 хувь нь Сум болон сум дундын ойн ангиас давхардсан тоогоор үйлчилгээ авсан байна.

3. Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ-уудын 41.2 хувь нь үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл учирсан, 58.8 хувь нь хүндрэл гараагүй гэж хариулсан байна. Хүндрэл учирсан гэж хариулсан иргэн, ААНБ-уудын ихэнх нь хугацаандаа үйлчилгээ авч чаддаггүй, салбарын байгууллагуудын хоорондын уялдаа байхгүй, нэг бичиг баримтыг цаасаар, цахимаар, олон давтамжтай авдаг, хянан шалгах үйл ажиллагааны гомдол гаргаад түүний араас олон удаагийн шат дараалсан албан бичиг өгч гомдол санал шийдэгдэхгүй байна гэж хариулсан байна.

Салбарын албан хаагчдаас авсан судалгааны талаар

1. Салбарын албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж буй 10 үзүүлэлтийг харахад 5 үзүүлэлт нь албан хаагчдыг идэвхжүүлэхтэй, 3 нь материал, техник хэрэгсэл, программ хангамжтай, 1 нь ажлын зохион байгуулалт, хуваарилалттай, 1 нь удирдлагын ур чадвар, манлайлалтай холбоотой үзүүлэлтүүд байна.

2. Судалгаанд хамрагдсан 4 албан хаагч тутмын нэг нь өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байгаа нь ажлын зохион байгуулалт, ажиллах орчин, нөхцөл байдалтай холбоотой юм. Сэтгэл ханамжгүй нэг албан хаагч бусдад сөргөөр нөлөөлөх нөлөө өндөр тул ажиллах орчин, нөхцөл байдлыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

3. Судалгаанд хамрагдсан 10 албан хаагч тутмын дөрөв (43.8 хувь) нь байгууллагын бүтэц оновчгүй, 10 албан хаагч тутмын дөрөв (40.1 хувь) нь байгууллагын нэгжийн чиг үүрэг оновчгүй, 10 албан хаагч тутмын дөрөв (48.3 хувь) нь нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал байгаа гэж хариулсан байна.

4. Албан хаагчдын мэдээллээс харахад байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэгжийн чиг үүргийн оновчгүй байдлаас болж нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал үүссэн байх магадлалтай юм. Иймд бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, чиг үүргийг тодорхой болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Эрсдэлийн удирдлагын талаар

1. Процессын дахин инженерчлэлийн судалгаа шинжилгээний хүрээнд ярилцлага, баримт бичиг, процесс зураглал бүхий үндсэн 3 төрлийн эх сурвалжийн хүрээнд нийт 905 асуудал бүртгэгдсэн бөгөөд нийт асуудлын 55.4 хувь аж ахуйн нэгж, байгууллагын фокус бүлгийн ярилцлагаас, 17.9 хувь процесс зураглал, 14.6 хувь баримт бичиг, 6.1 хувь ганцаарчилсан ярилцлага, 4.5 хувь Төрийн албан хаагчийн фокус бүлгийн ярилцлага, 1.5 хувь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас бүртгэсэн байна. Тухайлбал:

- Ярилцлагын явцад бүртгэгдсэн 611 асуудлын 81.9 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, 9.0 хувийг ганцаарчилсан ярилцлага, 2.3 хувийг олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн төлөөлөлтэй хийсэн ярилцлага, 6.7 хувийг Төрийн албан хаагчийн фокус бүлгийн ярилцлагаас бүртгэсэн байна.

- Баримт бичгийн хүрээнд бүртгэгдсэн 132 асуудлын 72.7 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 18.2 хувь Ойн газар, 9.1 хувь Булган аймгийн Байгаль орчны газрын баримт бичгээс бүртгэсэн байна.

- Процесс зураглалаас бүртгэгдсэн 162 асуудлын 86.4 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 13.6 хувь нь Ойн газрын процесстоос бүртгэсэн байна.

2. Бүртгэсэн 905 асуудлаас хамгийн их буюу 18.8 хувь нь байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой (дотоод), 9.2 хувь нь салбарын дүрэм, журмаас үүдэлтэй (гадна), 8.5 хувь нь аж ахуй нэгжид тулгамдаж буй хүндрэл бэрхшээл (гадаад), 8.3 хувь хууль тогтоомжоос үүдэлтэй, 8.0 хувь нь тусгай зөвшөөрөл авах, сунгуулах процесстой холбоотой асуудал хамгийн их бүртгэгдсэн байна.

3. Эрсдэлийн ангиллын хувьд үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл 56.2 хувь, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл 19.5 хувь, төсөв санхүүгийн эрсдэл 12.2 хувь, бодлогын буюу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц эрсдэл 9.9 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд Эрсдэлийн дэд ангиллын хувьд төсөв, санхүүжилтийн эрсдэл, байгууллагын дотоод, үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой, салбарын дүрэм, журмаас үүдэлтэй, салбарын болоод салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохион байгуулалттай холбоотой эрсдэлүүд 24.2-72.8 хувийг эзэлж байна.

4. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээ болох зөвшөөрөл олгох процесстой холбоотой бүртгэгдсэн эрсдэлийг авч үзвэл байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл хамгийн их буюу нийт эрсдэлийн 22.0 хувийг эзэлж байна. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээ болох зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хувьд хамгийн олон эрсдэл бүртгэгдсэн нь 1/Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх, 2/Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, 3/Озон задалдаг дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох худалдах, ашиглах, 4/Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, 5/Ургамлыг гадаад улсад гаргах, 6/ Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, 7/Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 8/Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл байна.

5. Фокус бүлэг болон ганцаарчилсан ярилцлагаар бүртгэсэн асуудлууд нь хууль тогтоомжийн хэрэгжилт, уялдаа холбоо, хүний нөөцийн бодлогын талаар байх бөгөөд эдгээр асуудлууд нь хуулийг өөрөөр хэрэглэх, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, журмын зохицуулалт нь практикт нийцэхгүйгээс улбаалж иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулах,

салбарын хүний нөөцөд нөлөөлөх, тухайн салбарт төрөөс баримтлах бодлого хэрэгжихгүй байх эрсдлийг дагуулж байна.

Санхүүжилтийн талаар

1. БОУАӨЯ нь бодлогын хүрээнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу БНАТ-ын төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаар болох 85 хувийг орон нутгийн төсвөөс “Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувиар тооцон төлөвлөхөр заасан байдаг ч орон нутгийн ЗД, ИТХ-аас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бууруулж төлөвлөх, төсвийг өөр зориулалтаар зарцуулах, аймаг, сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны уялдаа холбоо байхгүй зэрэг асуудлууд байна.

2. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилсан төсөвлөлтөд үндэслэн тодорхойлж улсын болон орон нутгийн төсөвт хөтөлбөрийн хүрэх үр дүнг ижил хэмжигдэхүүнээр хэмжиж салбарын нэгдсэн төсвийн хүрэн дэх үр дүнгүүдийг оновчтой тодорхойлодоггүйгээс төсвийн үр өгөөжийг хэмжих боломжгүй байна.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэхийгүүрэг болгосон ч “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш 2022 онд ДНБ-ний 0.28 хувь, 2023 онд ДНБ-ний 0.29 хувь, 2024 онд ДНБ-ний 0.35 хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.

Процессын шинжилгээ, нийтлэг тулгамдсан асуудлуудын талаар

Процессын дахин инженерчлэлийн хүрээнд бүх оролцогч талуудын оролцоог харгалзан, “Асуудлын мод” болон “5 Яагаад” аргачлалыг хослуулан ашиглаж, дараах нийтлэг асуудлуудыг тодорхойлж, дүгнэлт хийлээ.

- *Мэдээллийн үнэн зөвийг шалгах тогтолцооны дутагдал:* Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа цахимжсан боловч ирүүлсэн мэдээллийг бусад төрийн байгууллагын мэдээллийн сантай тулгах систем байхгүй тул албан хаагчид гар аргаар нягтлах шаардлагатай байна. Энэ нь баримт бичгийн бүрдлийг хангасан гэх хуурамч нөхцлийг бүрдүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байна.

- *Баримт бичгийн боловсруулалтын хүндрэл:* Хүсэлтүүдийг цахимаар хүлээн авч байгаа хэдий ч олон хуудастай тайлан, үнэлгээний баримтуудыг албан хаагчид гар аргаар уншиж танилцах шаардлагатай байна. Үүний улмаас албан хаагчдын ажлын бүтээмж буурч, цаг хугацааны хувьд ихээхэн ачаалал үүсгэж байна.

- *Хүний нөөцийн хэт ачаалал:* Албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс илүүтэйгээр тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажилд ихээхэн цаг зарцуулж байна.

- *Шийдвэр гаргах үйл явцын тодорхойгүй байдал:* Хуралдааны хугацаа тодорхойгүй, процессын шат дамжлага ойлгомжгүй байгаа нь шийдвэр гаргах хурдыг удаашруулж байна.

- *Баримт бичгийн шаардлагын уялдаа холбоогүй байдал:* Төрийн байгууллагууд иргэд, аж ахуйн нэгжүүдээс шаардлагатай мэдээллээ давхардуулан авч байгаа нь процессын үр ашиггүй байдлыг нэмэгдүүлж байна. Тухайн зөвшөөрлийг авахын тулд аж ахуйн нэгжүүд олон төрлийн нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай болдог нь санхүүгийн болон цаг хугацааны хувьд ихээхэн хүндрэл учруулж байна.

- *Давхардсан хяналтын шатлал:* Процесс тус бүр дунджаар 7 хяналтын шат дамжлагатай байгаа нь хэт их хяналттай байгааг харуулж байна. Ихэнх хяналтын шатууд зөвхөн гарын үсэг зурах хэлбэртэй бөгөөд бодитой шийдвэр гаргахад нөлөөлдөггүй.

- Хууль, эрх зүйн журмалсан байдал: Тусгай зөвшөөрөл бүрийг нэг бүрчлэн задалж журамлаагүй тул цар хүрээ, давтамжаас үл хамааран нэг шаардлага тавьдаг нь хүндрэл учруулдаг.

RACI шинжилгээгээр яамны чиг үүргийн хэрэгжилт, хариуцлага, уялдаа холбоо, мэдээлэл солилцоог тодорхойлоход бүх газар, хэлтэс өөрсдийн чиг үүргийн хэрэгжилтэд бүрэн оролцож, гүйцэтгэгчийн үүрэгтэй ажиллахын зэрэгцээ өөр өөрийн үндсэн чиг үүрэгт хариуцлага хүлээж, шийдвэр гаргалтад оролцдог. Хэдий тийм боловч зарим тохиолдолд хэт олон зөвлөлдөх оролцоотой байгаа нь шийдвэр гаргалтыг удаашруулж, хариуцлагыг сулруулах эрсдэлтэй байна. Мөн давхар мэдээлэл дамжуулах, мэдээлэл хоцроох, хэт төвөгтэй сүлжээ бий болох хандлага ажиглагдаж байна.

Мэдээллийн сангийн талаар

1. Байгаль орчны мэдээллийн санг байгуулж, 23 системийг нэг талбарт нэгтгэхээр зорин ажиллаж байгаа нь эерэг алхам хэдий ч дараах хүндрэлүүд байсаар байна. Үүнд: Мэдээллийн урсгал хангалтгүй, мэдээлэл тогтмол шинэчлэгддэггүй, салбарын болон бусад байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох механизм сул, хуримтлагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа хязгаарлагдмал, өгөгдлийн чанарт хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

2. Байгаль орчны салбарын дээд, доод шатны байгууллага хоорондын мэдээлэл солилцоо маш муу байгааг судалгаанд хамрагдсан албан хаагчид онцолсон байна. Иймээс тухайн салбарт нэгдсэн мэдээллийн тогтолцоо бий болгох, сайжруулах, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, ашиглалт, мэдээлэл солилцоог сайжруулах шаардлагатайг салбарын болон төрийн үйлчилгээ авагч, бусад эдгээд нотолж байна.

3. Мэдээллийн системийн бүтэц, үйл ажиллагаатай холбоотой баримт бичигт хийсэн дүн шинжилгээгээр өгөгдлийн менежментийн процессын эхний шат болох "Эхлэлийн үе" буюу хөгжлийн анхан шатанд байгаа нь тогтоогдсон байна. Өгөгдлийн менежментийн процесс бүрэн төлөвшихөд нийт таван үе шат (Эхлэлийн үе, Удирдах үе, Тодорхой үе, Нотолгоонд суурилсан удирдах үе, Оновчлолын үе) байдаг бөгөөд одоогийн нөхцөл байдал нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй түвшинд байгааг харуулж байна.

4. EIC.mn мэдээллийн сан нь тайлан, өгөгдөл бүртгэх, тэдгээрийг дахин харах боломжийг олгож байгаа ч бүрэн ашиглагдахгүй, өгөгдлийг боловсруулахад хүндрэлт гардаг байна. Одоогийн байдлаар систем хоорондын уялдаа хангалтгүй, өгөгдөл нэгдсэн бус, задгай бүтэцтэй байгаа нь мэдээллийн хэрэглээ, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, байгаль орчны төлөв байдлын үзүүлэлт нь хоёр жил тутам шинэчлэгдэх ёстой боловч 2025 оны гуравдугаар сарын байдлаар хамгийн сүүлийн үзүүлэлт болох 2019-2020 оны тайлан нь 2023 онд мэдээллийн санд нэмэгдсэн байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 84.0 сая модыг тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна. Бэлтгэл үе шатны гүйцэтгэл 42.4%-тай байна. Мод тарих төлөвлөгөөг тарьсан модны тоотой харьцуулан үзэхэд гүйцэтгэл 24.4 хувьтай байгаа нь одоогийн нөхцөл байдлаар ажиллавал 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарих амлалтаа биелүүлж чадахааргүй байна.

2. Судалгаагаар ойжуулалт, мод үржүүлгийн аж ахуйн нэгжийн суурилагдсан хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах замаар ойжуулагч, ажилчдын өрсөлдөх чадварыг сайжруулах механизмыг агуулсан зорилтод төлөвлөгөөг боловсруулж, шийдвэрийг УИХ, Засгийн газрын түвшинд гаргуулах шаардлагатай байна.

Төсөл, хөтөлбөрийн талаар

1. Монгол Улсад олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдээс байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, болон хүлэмжийн хийг бууруулах, экосистемийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн иргэдийн амьжиргааг сайжруулах, чадавхжуулах, төрийн бодлогыг байгальд ээлтэй болгох зэрэгт чухал хувь нэмэр оруулж байна.

3. Төслийн хэрэгжилт, ахиц дэвшлийг үнэлэхэд ашиглагддаг үзүүлэлтүүд болон шалгуур стандартууд салбар бүрт өөр өөр, олон улсын болон үндэсний түвшинд ч ялгаатай тул нийтлэг үнэлгээний аргачлал, индикаторын тогтолцоо бүрдээгүй байна. Үүний улмаас төсөл, хөтөлбөрүүдийн бодит үр нөлөөг харьцуулах, нэгтгэх, нөлөөллийн дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байна.

4. БОУАӨЯ, Эдийн Засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), мөн олон улсын болон дотоодын төслийн нэгжүүд бодлогын уялдаа, үнэлгээ, хяналт шинжилгээтэй холбоотой үүрэг гүйцэтгэж байгаа ч эдгээр байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагын хуваарилалт тодорхой бус, хөндлөнгийн зохицуулалт сул байгаагаас зорилтод бодлого, хөтөлбөр хэрэгжихгүй байх нөхцөл бүрдэж байна.

5. Тогтвортой хөгжлийн зорилт, “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого, салбарын дунд хугацааны төлөвлөлт, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл нь нэгдсэн мэдээллийн тогтолцоонд холбогдоогүй, тус тусдаа платформ, мэдээллийн сан ашиглаж байгаа нь мэдээллийн урсгалыг хааж, уялдаа, хяналт алдагдахад хүргэж болзошгүй байна.

Олон улсын туршлагын талаар

1. Зүүн хойд Азийн бүс нутагт байгаль орчны тулгамдсан гурван асуудал болох уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, биологийн олон янз байдал алдагдахад экологийн тэнцвэрийг хадгалах, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаа нэн чухал болохыг тодорхойлсон байна.

2. Уг бодлогоо хэрэгжүүлэхдээ залуучуудын дунд уулзалт зохион байгуулах, онлайн платформоор үндэсний бодлогын баримт бичигт санал авах, яамны харьяа судалгааны байгууллагууд байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудал, олон улсын чиг хандлагаар тайлан боловсруулж, олон нийтийг мэдээллээр хангахын зэрэгцээ шинжлэх ухааны судалгаанд суурилсан богино, урт, дунд хугацаанд хэрэгжих боломжтой зорилтууд болон хүрэх үр дүн, арга зам, нөөцөө баримт бичигт тодорхой тусгаж, хиймэл оюун, алсын мэдрэгч, нисгэгчгүй онгоц зэрэг орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан байгаль орчны хяналтын системийг нэвтрүүлж, "Бохирдуулагч нь төлөх" зарчмаар торгох болон байгаль орчинд хамгийн ээлтэй (BAT) технологийг ашиглаж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлт үзүүлэх зэрэг урамшуулал, хариуцлагыг хослуулдаг байна.

3. Уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, гадаад харилцаа, дэд бүтцийн салбар хооронд уялдаа холбоотой ажиллахаас гадна бие даасан болон харьяа байгууллагууд зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох (Шинэ Зеланд), олон улсын гэрээ хэлэлцээрийг (Япон) хэрэгжүүлдэг.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

БОУАӨЯ болон оролцогч талуудын цаашдын хамтын ажиллагааг илүү үр дүнтэй, уялдаа холбоотой болгохын тулд дараах зорилтод суурилсан бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Хүн төвтэй үзэл хандлагаар салбарын бодлогыг боловсруулах
- Олон салбарын хамтын ажиллагаагаар үйл ажиллагаа нь амжилтад хүрэх салбар дундын онцлогийг харгалзаж үзэх,
- Мэргэжлийн боловсон хүчин чадавхажсанаар салбарын чадамж сайжирна. Улмаар төрийн бүтээмж нэмэгдэнэ.

Судалгааны ажлын хүрээнд авагдсан мэдээлэл, судалгаа шинжилгээний үр дүн болон оролцогч талуудын ирүүлсэн мэдээлэл, баримтад тулгуурлан дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

Бодлого, эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтын чиглэлээр

1. Шинээр болон шинэчлэн батлагдсан Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр нэгдэн орж, соёрхон баталсан конвенц, протоколд нийцүүлэн Байгаль орчны салбарын хуулийг цогцоор шинэчлэх;

2. Байгаль орчны салбарын эрх зүйн орчинд хийсэн шинжилгээгээр бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх чиг үүргийн зохист харьцаа Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг шаардлагыг хангахгүй байна. Яам нь бодлого тодорхойлох, боловсруулах, зохицуулах чиг үүргээ хэрэгжүүлдэг байхаар салбарын эрх зүйн орчныг цогцоор нь өөрчлөх, БОУАӨЯ-ыг ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ЯАМ БОЛГОХ;

2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд байгаль орчны чиглэлээр туссан зорилго, зорилтуудыг салбарын бодлого, төлөвлөгөөнд уялдаа холбоотой, шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйцээр төлөвлөж, хэрэгжүүлэх;

3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц, ургамал, ус, ойн нөөц, биологийн олон янз байдал, орчны бохирдол, агаарын бохирдол, амьдрах орчин гэх зэргээр өөр өөрөөр нэршлээр оруулсныг олон улсын чиг хандлага, салбарын онцлогын дагуу нэг мөр ойлгохоор томъёолж, сайжруулах;

4. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын Ногоон хөгжлийн бодлогын Эх байгаль анхдагч экосистемтэй холбогдох зорилтыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс өөр баримт бичигт тусгаагүй байна. Энэ зорилт нь байгаль хамгааллын суурь үндэс, цогцоор нь авч үзэх, судлах өргөн агуулга бүхий зорилт тул бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах;

5. Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн салбарын нийтлэг харилцааг зохицуулж буй суурь хууль болох Байгаль орчныг хамгаалах тухай хуульд Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, шинэчлэх;

6. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам болон бусад эрх зүйн хэм, хэмжээний актыг боловсронгуй болгох, мөн хууль, журмаар зохицуулаагүй үйл ажиллагаа, эрх зүйн харилцааг журамлах замаар тус салбарын хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

шаардлагатай байна. Эрх зүйн шинэчлэлийг хийхдээ эрх зүйн системчлэлийн аргуудаас консолидаци эсхүл кодификацийн аргыг ашиглах боломжтой гэж үзэж байна. Үүнд:⁶⁹

6.1. Кодификаци бол хуучирсан хэм хэмжээ, зарчмыг халах, хийдлийг арилгах, шинэ хэм хэмжээг тогтоох үндсэн зорилтыг агуулдаг бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээнүүдийг агуулгын хувьд нэгтгэн боловсруулах үндсэн дээр шинэ эрх зүйн актыг бүтээн төрөлжүүлэх ажиллагаа юм. Энэ аргыг сонгосон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан 1) газар, түүний хэвлий; 2) ой; 3) ус; 4) амьтан; 5) ургамал; 6) бусад баялаг; гэсэн дарааллын дагуу төрөлжүүлэн нэгтгэх боломжтой.

6.2. Консолидаци нь өнгөрсөн хугацаанд бий болсон нэг салбарын харилцааг зохицуулж байгаа олон тооны хуримтлагдсан олон дахин давтагдсан, үл зөвшилцсөн, зөрчилдсөн актуудын олонлогийг устгах буюу тэдгээрийг нэгтгэн нэг томоохон хууль болгох нэгтгэн төрөлжүүлэх арга ажиллагаа бөгөөд ннэ тохиолдолд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд бусад хэм хэмжээг нэгтгэх хувилбар байж болох юм.

7. Салбарын тухайлсан харилцааг зохицуулсан 8 хуульд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд оноосон 132 хэрэгжүүлэх чиг үүргийг “Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай” хуульд заасан бодлого боловсруулах, тодорхойлох нийтлэг шаардлагад нийцүүлж өөрчлөх;

8. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын батлах 35, бусад салбарын сайдтай хамтран батлах 8, Ойн газрын дарга батлах 1 эрх зүйн баримт бичиг /дүрэм, журам, заавар, жагсаалт, бусад хэм хэмжээний акт/-ийг батлаагүй байх тул яаралтай боловсруулан баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх;

9. Яам нь салбарын тухайлсан харилцааг зохицуулсан өмнөх бүлэгт дурдсан 8 хууль болон яамны үйл ажиллагааны стратеги, хөтөлбөрт хэрэгжүүлэгч байгууллагын түвшинд гүйцэтгэх боломжтой арга хэмжээг харьяа байгууллагад шилжүүлэх, зарим тусгай зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу ашиглах хуулийн зохицуулалттай тул оновчтой бүтэц зохион байгуулалтын хувилбарыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

10. Хуулиар төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ашиглахаас бусад тусгай зөвшөөрөл, үйлчилгээг салбарын тухайн асуудлыг хариуцах чадамжтай төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоонд шилжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, тухайн шилжүүлэх байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан төрийн бус байгууллага, холбоо болон салбарын албан хаагчид, аж ахуйн нэгжийн төлөөлөл өнөөдрийн байдлаар эдгээр байгууллагын чадавх бүрдээгүй байгаа гэж дүгнэсэн.

11. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хийх судалгаа, шинжилгээг хөгжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг шинжлэх ухааны байгууллагууд, мэргэжилтнүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, шаардлагатай судалгааг гүйцэтгэх;

12. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, салбарын болон бодлого зохицуулалтад дэмжлэг үзүүлэх чадамжтай байхаар өөрчлөн зохион байгуулах.

Төсвийн санхүүжилт, үр дүнг сайжруулах чиглэлээр

1. Агаарын бохирдол, нөхөн сэргээлт, хог хаягдлын хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг сайжруулах, Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилж шинэчлэх;

⁶⁹ "Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа" 2023 он

2. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.0 хувьтай тэнцэх хөрөнгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон байгаль хамгаалах ажилд зориулж, зарцуулах механизмыг бүрдүүлэх;

3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахад хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

4. Байгаль орчны чиглэлийн норм норматив, стандартуудыг шинэчлэн тогтоох ажлыг нийгэм, эдийн засаг, инфляц, байгаль цаг уур, газарзүйн бүс бүслүүр болон өөрийн орны онцлогт тулгуурлан шинэчлэн боловсруулах;

5. Экосистемийн динамик тэнцвэрт байдлыг хадгалсан ойн тогтвортой менежмент нь ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ойн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ганц биш олон эх үүсвэрээс санхүүжих боломжтой "ногоон бизнес" хөгжих боломж бүрдүүлэх;

6. Байгаль орчин, уур амьсгалын сангийн менежментийг сайжруулж, байгаль орчны салбарын олон эх үүсвэр (байгалийн нөөц ашигласны, бохирдуулагчийн, экосистемийн үйлчилгээний төлбөр болон ашигт малтмалын экспортын орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зорилгоор тодорхой мөнгөн дүнг төвлөрүүлэх өмнөх туршлага г.м) бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх институт болгон хөгжүүлэх;

Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх чиглэлээр

1. Байгаль орчны салбарт ажиллаж буй төр, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн байгууллага, Их, дээд сургууль, хувийн хэвшил, нөхөрлөл болон ирээдүйд ажиллах мэргэжилтнүүдийн тоо, чадвар, мэргэшил, хуваарилалт зэрэгт тулгуурлан салбарын хүний нөөцийн бодлого, зохицуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг яаралтай хийж, хэрэгжүүлэх, гүйцэтгэл, чадамжид суурилсан тогтолцоог бүрдүүлэх;

2. "Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц"-ийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулах;

3. Судалгаанд хамрагдсан 10 албан хаагч тутмын 4 (43.8 хувь) нь байгууллагын бүтэц оновчгүй, 10 албан хаагч тутмын 4 (40.1 хувь) нь байгууллагын нэгжийн чиг үүрэг оновчгүй, 10 албан хаагч тутмын 4 (48.3 хувь) нь нэгж, албан хаагчдын ажил үүргийн давхардал байгаа гэж хариулсан нь байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой зохион байгуулж, ажил үүргийн давхардлыг арилгах шаардлагатайг нотолж байна.

4. Тасралтгүй хөгжүүлэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх: Бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, ирээдүйн өөрчлөлт, боломж, эрсдэлүүд, олон улсын чиг хандлагыг судлах арга зүйн чиглэлээр төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулах;

5. Салбарын зорилго, хүрэх үр дүнд чиглэсэн албан тушаал бүрийн хэрэгцээт ур чадварыг тодорхойлж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

6. Байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх бүтээлч ажил, албан хаагчдын шинэ санал санаачилга, мэдлэг, ур чадварыг бодитоор дэмжих арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвших;

7. Боломжит бүх төрлийн урамшууллын системийг нэвтрүүлж, сайн гүйцэтгэлийг дэмжих, албан хаагчдыг мэргэжлээрээ тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх;

8. Процессын дахин инженерчлэл хийгдсэн БОУАӨЯ болон Ойн газар нь одоогийн байдлаар 2 тусдаа байранд байрлаж байгаа нь албан хаагчдын ажиллах нөхцөлөөр хангуулах эрхээ эдэлж чадахгүй, нөгөө талаар төрийн үйлчилгээний бүтээмжид сөргөөр

нөлөөлөх үндсэн шалтгаан болж байгаа тул ойрын хугацаанд яам, агентлагийн ажлын байрныг асуудлыг шийдвэрлүүлэх;

9. Хуулиар ажил олгогч нь албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг албан хаагчдын судалгаа, санал хүсэлтэд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх хүлээдэг. Иймд уг хөтөлбөрийг яаралтай шинэчлэн боловсруулж, жил бүрийн төлөвлөгөөнд бодитой арга хэмжээ, санхүүжилтийг тусган хэрэгжүүлэх.

Зөвшөөрөл олгох чиглэлээр

1. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, сангийн хөгжүүлэлтийг хийх, мэдээллийг бусад төрийн байгууллагын холбогдох сантай тулгаж, шалгах цахим систем нэвтрүүлэх;

2. Процессын шат дамжлагыг оновчтой болгох, давхардлыг арилгах, шийдвэр гаргах хугацаа, процессын шат дамжлага ойлгомжгүй байгааг тодорхой болгож, үйлчилгээ авагчдад ойлгомжтой нээлтэй байршуулах;

3. Тусгай зөвшөөрөл олгох баримт бичигт тавих шаардлага, бүрдүүлбэрийг иргэд, аж ахуйн нэгжүүдээс төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг шаардахгүй байх;

4. Төрийн үйлчилгээний цахимжуулалтын үр дүн, ач холбогдолтой байдалд судалгаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын 21.4 хувь нь сайн, 35.7 хувь нь дунд, 42.9 хувь нь муу гэж үнэлсэн нь төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилгээ авагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор цахимжуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

5. Зөвшөөрлийн тухай хууль болон байгаль орчны салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад эрх зүйн хэм, хэмжээний актыг боловсронгуй болгох, мөн хуулиар хориглосон, давсан зохицуулалттай захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох;

6. Яам нь бодлого боловсруулах, зохицуулах үндсэн чиг үүрэгтэй боловч Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу бусад төрийн захиргааны төв байгууллагуудтай харьцуулахад хамгийн олон буюу 28 тусгай зөвшөөрлийг өөр дээрээ төвлөрүүлэн олгож байна. Иймд хэрэгжүүлэгч агентлаг, бусад этгээдээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж шилжүүлэх.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр

1. Бүртгэгдсэн 905 асуудлаас 817 эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийхэд эрсдэлийн түвшний хувьд аюултай түвшний эрсдэл 1.1 хувийг, өндөр түвшний эрсдэл 7.1 хувийг, дунд түвшний эрсдэл 56.7 хувийг, бага түвшний эрсдэл 35.1 хувийг тус тус эзэлж байна. Хэдийгээр нийт тодорхойлогдсон эрсдэлийн 56.7 хувь нь дундаж түвшний буюу тэсэж болохуйц эрсдэлүүд боловч тухайн эрсдэлүүдийн үр нөлөөллийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авах, эдгээр эрсдэлүүдийн нөлөөлөл өөрчлөгдсөн эсэхийг тогтмол хянах;

2. Байгууллагын эрсдэлийн менежментийн тогтолцоо, үр нөлөөний байдалд хийсэн судалгааны дүнгээс харахад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газрын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байгаа тул тухайн эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, урт хугацаандаа нөлөөллийг хянах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх;

Мэдээллийн сан хөгжүүлэлтийн чиглэлээр

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.”, 2 дахь хэсэгт “Байгаль орчны

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.” гэж хуульчилсан байх тул энэ хуулийн хэрэгжилтийг хангаж, судалгаа, мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, иргэд, олон нийтийн мэдэх, мэдээлэл авах эрхийг хангах;

2. Өгөгдлийн чанарын стандартыг батлах: Бүх төрлийн байгаль орчны мэдээлэлд хамаарах чанарын шалгуур үзүүлэлт, формат, дүн шинжилгээний аргачлалын стандартуудыг боловсруулан мөрдүүлэх;

3. Мэдээлэл солилцох протокол, систем бий болгох: Байгууллага дотор, харьяа байгууллага хооронд, цаашлаад төрийн бусад байгууллагуудын хооронд өгөгдөл дамжуулах нэгдсэн техник, протокол боловсруулах, хэрэгжүүлэх;

4. Мэдээллийн дүн шинжилгээнд чиглэсэн аналитик чадамжийг нэмэгдүүлэх: GIS, big data, AI зэрэг дэвшилтэт технологи ашиглах нөхцөл бүрдүүлэх, мэргэжилтнүүдийг бэлтгэх.

Цахим шилжилт - Өгөгдлийн менежментийн процессын чиглэлээр

1. Цахим шилжилт хийхэд салбарын өгөгдөлд цаашид шинжилгээ хийн мэдээллийн урсгалын оновчтой, шуурхай болгох хэрэгтэй. Ингэхийн тулд богино хугацаанд төлөвшлийн 2-р шатруу шилжих, цаашид удаан хугацаандаа 5-р шат руу алхам алхамаар (3, 4-р шатны шалгуурыг биелүүлж) шилжих;

Зураг 133. Өгөгдлийн төлөвшлийн үе шат



2. Дата анализын чадамж, төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлснээр дата ашигладаг тогтолцоо бий болгох нь цахим шилжилтийг бэхжүүлэхэд чухал алхам болж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хангах;

3. Мониторинг, судалгааны мэдээллийн сан - биологийн олон янз байдлын нөхцөл байдлыг мэдэх -> нэгдсэн системээр боловсруулсан датаг салбарын яам шалгах, олон нийтийн хүртээл болгоход зөв зохистой менежментийг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжих шаардлагатай.

Ойн чиглэлээр

1. Монгол Улсын ойн тогтвортой менежмент нь зөвхөн хэрэгжилтийн ажлаар бус, шинжлэх ухаанд суурилсан, үндэслэлтэй бодлогын шийдвэрээр хангагдах шаардлагатай. Судалгааны байгууллагуудын оролцоог системтэй, стратеги түвшинд тусгаж, уур амьсгалд тэсвэртэй, хариуцлагатай ойн менежментийг хөгжүүлэх;

2. Ойн газраас “Тэрбум мод” хөдөлгөөнийг удирдан зохион байгуулахдаа мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан хувийн хэвшлийн мод үржүүлгийн аж ахуйн материаллаг баазыг сайжруулах, мод ургуулах ажлыг механикжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, ойжуулагч ажилчдын тогтвор суурьшлыг хангах;

3. Дөрвөн улирлын турш ажиллах ажлын байр бий болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг санхүүгийн механизмыг ашиглах замаар “Тэрбумаар тоологдох мод ургуулах байнгын, суурилагдсан хүчин чадлыг бий болгох”-ход чиглүүлэх бодлогын өөрчлөлт хийх;

4. Олон улсын байгууллага, гадаад орнуудаас хэрэгжүүлж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг технологи, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулахад чиглүүлэх;

6. Тэрбум мод хөдөлгөөний зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мод тарих амлалт өгсөн байгууллагуудыг уялдуулан зохицуулах, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын Шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд, мэргэжилтнүүдийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх;

7. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг тогтмол үнэлэх, амьдрах чадварын хувь хэмжээг тооцох, гүйцэтгэлийн чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх;

8. Модыг үнэлгээжүүлэх /үл хөдлөхөөр тооцох/ экосистемд үзүүлэх үнэ цэнээр тооцож үнэлгээжүүлэх;

Олон улсын төсөл хөтөлбөр

1. ОУ-ын төсөл, хөтөлбөрүүд, төслүүд хоорондын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтад оруулах, бодлого тодорхойлдог байгууллагуудын дотоод зохин байгуулалт, нөөцийн хуваарилалтыг сайжруулах;

2. Төсөл хөтөлбөрүүдийн дотоод платформ, мэдээлэл тогтмол солилцох талбарыг бий болгох. Тухайлбал, төсөл хөтөлбөрүүдийн тогтмол уулзалт, мэдээлэл солилцох арга хэмжээ зохион байгуулах;

3. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хяналт үнэлгээний мэдээллийн урсгалыг нэгтгэх нэгдсэн дата бааз, хяналт-шинжилгээний цахим системийг хөгжүүлж, олон улсын байгууллагууд болон холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг төвлөрүүлсэн, ил тод, ашиглахад хялбар орчин бүрдүүлж, төсөл, хөтөлбөрийн ахиц дэвшил, туршлага, сургамжийг харьцуулж, бодит нөхцөлд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх.

4. Казакстан улсын туршлага болох "Бохирдуулсан нь төлөх" (Polluter pays) зарчмаар хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр компаниудад торгууль ноогдуулаад зогсохгүй нийт хүлэмжийн хийн ялгаруулалтын 80 хувийг эзэлж буй ААН-ийн тоог бууруулах, үүнээс олсон орлогоо хийн ялгаруулалтыг бууруулахад зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Энэхүү судалгааны ажлын хүрээнд авагдсан мэдээлэл, харьцуулсан дүн шинжилгээ, хэсэг бүрт хийгдсэн болон нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжүүдийг тодорхой төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлснээр Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн уялдаа, хэрэгжилт сайжрах, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүрдэх, эрх зүйн орчин боловсронгуй болох, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах, мэдээллийн сан, түүний хөгжүүлэлт, ашиглалтад ахиц гарах, төсөл, хөтөлбөрийн бодит үр нөлөө нэмэгдэж, бодлого тодорхойлох болон хэрэгжүүлэх түвшинд хамтран ажиллах, мэдлэгт суурилсан, олон талын оролцоог хангасан орчин бүрдэх, төрийн үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр, дэмжлэг болно гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Эх сурвалжийг эшлэлээс:

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Block, S., Emerson, J. W., Esty, D. C., de Sherbinin, A., Wendling, Z. A., et al. (2024). 2024 Environmental Performance Index. New Haven, CT: Yale Center for Environmental Law & Policy. Epi.yale.edu Retrieved from <https://epi.yale.edu/>
- Block, S., Emerson, J. W., Esty, D. C., de Sherbinin, A., Wendling, Z. A., et al. (2024). 2024 Environmental Performance Index. New Haven, CT: Yale Center for Environmental Law & Policy. <https://epi.yale.edu/measure/2024/EPI>
- World Bank. (n.d.). Expenditure on environment protection, Percent of GDP. Prosperity Data360. Retrieved April 13, 2025, from https://prosperitydata360.worldbank.org/en/indicator/IMF+GFSCFOG+GEN_G14_GDP_PT
- 中华人民共和国生态环境部 (БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас), <https://www.mee.gov.cn/>
- 中华人民共和国生态环境部. БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас (n.d.). Яамны тухай [关于我们], <https://www.mee.gov.cn/zjhb/?name=1>
- 生态环境部等部门联合印发意见加强生态环境领域科技创新. 中国政府网, 2025-02-24, БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны салбарт шинжлэх ухаан, инновацыг нэвтрүүлэх нь, https://www.gov.cn/lianbo/bumen/202502/content_7005251.htm
- 专家解读 | 强化数智化理念, 扎实推进国家生态环境监测网络转型任务落实. БНХАУ-ын Экологи, Байгаль Орчны Яамны албан ёсны цахим хуудас (n.d.). 2025-03-28 https://www.mee.gov.cn/cwjj/zcjd/202503/t20250328_1104874.shtml
- Ministry of the Environment, Japan. (n.d.). Environmental protection and policy overview. Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/content/000288877.pdf>
- Ministry of the Environment, Japan. (n.d.). Ministry of the Environment, Japan: Introduction (Appendix 07). Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/en/chemi/pops/Appendix/07-MOE-Introduction/MOE.pdf>
- Ministry of the Environment, Japan. (n.d.). About the Ministry of the Environment. Retrieved April 10, 2025, from <https://www.env.go.jp/en/aboutus/index.html>
- Policy Coordination/Evaluation and Public Relations Division, Minister's Secretariat, Ministry of the Environment, Japan. (n.d.).
- Microsoft AI for Earth named as one of “100+ Outstanding Biodiversity Positive Practices and Actions Around the World”, October 11, 2021, <https://www.cenews.com.cn/news.html?aid=1205259>
- The State Council of the People's Republic of China. (n.d.). Official website of the Chinese government. Retrieved April 10, 2025, from <https://www.gov.cn/>
- Ministry of Ecology and Environment of the People's Republic of China. (n.d.). About the Ministry. Retrieved April 10, 2025, from <https://www.mee.gov.cn/zjhb/>
- Microsoft Asia News Center. (2021, October 11). Microsoft AI for Earth named as one of 100 outstanding biodiversity-positive practices and actions around the world. Retrieved from <https://news.microsoft.com/apac/2021/10/11/microsoft-ai-for-earth-named-as-one-of-100-outstanding-biodiversity-positive-practices-and-actions-around-the-world/>
- State Council of the People's Republic of China. (2025, March). 生态环境部：健全生态保护补偿机制 推动生态产品价值实现 [Ministry of Ecology and Environment: Improve ecological protection compensation mechanism and promote realization of ecological product value]. Retrieved from https://www.gov.cn/yaowen/liebiao/202503/content_7016523.htm
- NIC Energy. (n.d.). NIC Energy official website. Retrieved April 10, 2025, from <https://www.nicenergy.com/>
- Yale Center for Environmental Law & Policy. (2024). Environmental Performance Index: China – 2024 Country Profile. Retrieved from <https://epi.yale.edu/country/2024/CHN>
- Zhang, Y., Wang, C., & Li, H. (2024). Carbon emission efficiency and its influencing factors in China's provincial industrial sector: An empirical study based on the super efficiency SBM model. Sustainability, 16(17), 7574. <https://doi.org/10.3390/su16177574>
- World Economic Forum. (2025, January). Why China matters to the world's green transition. Retrieved from <https://www.weforum.org/stories/2025/01/why-china-matters-to-the-worlds-green-transition/>
- Kostka, G., & Nahm, J. (2018). Reform of China's environmental governance: The creation of a Ministry of Ecology and Environment. ResearchGate.

https://www.researchgate.net/publication/326793043_Reform_of_China%27s_Environmental_Governance_The_Creation_of_a_Ministry_of_Ecology_and_Environment

- Li, X., Zhou, D., & Han, B. (2024). Assessing China's policy impacts on carbon neutrality pathways using a CGE model. *Journal of Environmental Management*. Advance online publication. <https://doi.org/10.1016/j.jenvman.2024.118021>
- Ministry of Ecology and Natural Resources of the Republic of Kazakhstan. (n.d.). *Structure*. GOV.KZ. Retrieved April 13, 2025, from <https://www.gov.kz/memleket/entities/ecogeo/about/structure/2/1?lang=en>
- CACIP – Central Asia Climate Information Portal. (n.d.). The Ministry of Water Resources and Irrigation has been established in Kazakhstan. Sep 11, 2023
- Committee on Water Resources of the Ministry of Ecology and Natural Resources of the Republic of Kazakhstan. (n.d.). *Structure*. GOV.KZ. Retrieved April 13, 2025, from <https://www.gov.kz/memleket/entities/water/about/structure/2/1?lang=en>
- European Union – Central Asia Water, Environment and Climate Change Cooperation (WECOOP). (2021). Environmental Code of the Republic of Kazakhstan (Unofficial translation). https://wecoop.eu/wp-content/uploads/2021/04/2021-KZ-ENV-Code_full-text_en.pdf
- Министерство водных ресурсов и ирригации РК. (n.d.). Оценка эффективности Государственных органов [Evaluation of Government Agencies].
- Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). *Tasks and structure*. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/ministry/tasks-and-structur>
- Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). Administrative authorities at state and federal level. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/ministry/tasks-and-structure/federal-and-laender-authorities>
- Ministry for the Environment. (2023, December 8). About the Ministry for the Environment. Retrieved from <https://environment.govt.nz/about-us/ministry-for-the-environment/>
- Federal Ministry for the Environment, Nature Conservation, Nuclear Safety and Consumer Protection. (n.d.). *Citizen participation*. BMUV. Retrieved April 13, 2025, from <https://www.bmuv.de/en/citizen-participation/overview-citizen-participation/citizen-participation>
- Environmental Protection Authority of New Zealand. (n.d.). Our legislation. Retrieved April 10, 2025, from <https://www.epa.govt.nz/about-us/our-legislation/>
- Low-Carbon Power. (n.d.). Understand low-carbon energy in Kazakhstan through data. Retrieved April 10, 2025, from <https://www.lowcarbonpower.org/>
- The Astana Times. (2019, December). Kazakh government approves new draft ecology code to toughen penalties for environmental offenses. Retrieved from <https://astanatimes.com/2019/12/kazakh-government-approves-new-draft-ecology-code-to-toughen-penalties-for-environmental-offenses/>
- United Nations Environment Programme. (n.d.). Nationally Determined Contribution of the Republic of Kazakhstan to the global response to climate change. UNEP Law and Environment Assistance Platform. Retrieved April 10, 2025
- CACIP – Central Asia Climate Information Portal. (n.d.). The Ministry of Water Resources and Irrigation has been established in Kazakhstan. Sep 11, 2023
- Министерство водных ресурсов и ирригации РК. (n.d.). Оценка эффективности Государственных органов [Evaluation of Government Agencies].
-

ХАВСРАЛТ

1. Төслийн удирдлагын багийн бүрэлдэхүүн

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА, БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 12 дугаар сарын 05-ний өдөр

Дугаар.../173, А/484

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийн 4.3 дахь заалт, "Процессын дахин инженерчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүний харьяа Ойн газарт процессын дахин инженерчлэл хийхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт судалгааг нэгтгэн бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Баярмаа	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн Ахлах судлаачийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ажлын хэсгийн дэд ахлагч:	Х.Мөнхзул	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга
Гишүүд:	Б.Отгонсүрэн	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн Үр дүнгийн шинжилгээний багийн Ахлах судлаач
	Н.Баясгалан	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн Төлөвлөлт, зохицуулалтын багийн Ахлах судлаачийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Аз	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн Зөвлөх
	Д.Дэлгэрбат	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн

		захиргааны удирдлагын газрын дарга
	Б.Буяннэмэх	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хяналт, үнэлгээ аудитын газрын дарга
	Б.Оюунсанаа	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Анаңд	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн Судлаач, ахлах мэргэжилтэн
	Г.Оюунгэрэл	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн

2.Процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд салбарын асуудлаар мэргэжил, арга зүй, мэдээ мэдээлэл, баримт, судалгаагаар тасралтгүй хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Баярмаа)-т даалгасугай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН
ДАРГА
Ч.ӨНӨРБАЯР
9023010230 СТС3950 6975747

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Э.БАТТУЛГА
902407000 1185084 СБТ-23022

Хавсралт 1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын төслийн удирдлагын багийн жагсаалт


Төслийн удирдлагын багийн ахлагч:	Н.Баярмаа	Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга	
Гишүүд: БОУАӨЯ-ны ажлын хэсэг	Ё. Отгонсүрэн	ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, <i>БОУАӨЯ-ны Ажлын хэсгийн ахлах</i>	
Ойн газрын ажлын хэсэг	Н.Баясгалан	ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн дарга, <i>Ойн газрын ажлын хэсгийн ахлах</i>	
Чиг үүргийн багуудын ахлахууд	Б.Аз	Хууль, эрх зүйн газрын дарга, <i>Эрсдэлийн удирдлагын багийн ахлах</i>	
	Д.Шижир-Эрдэнэ	Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Ахлах референт, <i>Стратегийн багийн ахлах</i>	
	Т.Энхбаатар	Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Ахлах референт, <i>Процесс зураглалын багийн ахлах</i>	
	Ё.Отгонжаргал	Хяналт шалгалтын газрын Хянан шалгагч, референт, <i>Хуулийн багийн ахлах</i>	
	З.Болор	ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн Референт, <i>Олон улсын туршлага судлах багийн ахлах</i>	
	М.Энхзориг	ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн шинжээч, <i>Судалгааны багийн ахлах</i>	
	Чиг үүргийн багийн гишүүд	Ц.Идэрбат	Хяналт шалгалтын газрын Хянан шалгагч, Ахлах референт, <i>Хуулийн багийн гишүүн</i>
		Х.Оюунчимэг	ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Референт, <i>Эрсдэлийн удирдлагын багийн гишүүн</i>
		Б.Дунгармаа	ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн Референт, <i>Чанарын судалгааны багийн гишүүн</i>
		Б.Мөнхболор	ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн Референт, <i>Стратегийн багийн гишүүн</i>
		С.Эрдэнэсүвд	ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн Референт, <i>Стратегийн багийн гишүүн</i>
		С.Энхжаргал	Үнэлгээ, мониторингийн газрын Референт, <i>Процесс зураглалын багийн гишүүн</i>
		Ё.Нурбулан	Хууль, эрх зүйн газрын Референт, <i>Хуулийн багийн гишүүн</i>
		М.Энхмөнх	ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн Ахлах шинжээч, <i>Судалгааны багийн гишүүн</i>
		Б.Доржханд	ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Ахлах шинжээч, <i>Чанарын судалгааны баг</i>
	Д.Ган-Оюун		

Төслийн зөвлөх	Д.Бат-Эрдэнэ	ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлстийн Ахлах шинжээч, <i>Чанарын судалгааны баг</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн ахлах шинжээч, <i>Олон улсын туршлага судлах баг</i> ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлстийн Шинжээч, <i>Процесс зураглалын багийн гишүүн</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, <i>Ойн газрын ажлын хэсгийн нарийн бичиг</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, <i>Процесс зураглалын багийн гишүүн</i> ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, <i>Эрсдэлийн удирдлагын багийн нарийн бичиг</i> Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, <i>Чанарын судалгааны баг</i> Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, <i>Хуулийн багийн гишүүн</i> ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн гэрээт судлаач, <i>Эрсдэлийн удирдлагын багийн гишүүн</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн гэрээт судлаач, <i>Стратегийн багийн гишүүн</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн гэрээт судлаач, <i>Процесс зураглалын багийн гишүүн</i> ТСБТГ-ын Төлөвлөлт, дахин инженерчэлийн хэлтсийн гэрээт судлаач, <i>Олон улсын туршлага судлах баг</i> Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын гэрээт зөвлөх, <i>Стратегийн баг</i> Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын гэрээт зөвлөх, <i>As-is болон To-be, процесс зураглал</i> Гэрээт зөвлөх, доктор (PhD) Гэрээт зөвлөх Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын Зөвлөх (гэрээт) ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн Референт, <i>Судалгааны багийн гишүүн</i> ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Референт, <i>Эрсдэлийн удирдлагын баг</i> ТСБТГ-ын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн Ахлах шинжээч, <i>Судалгааны баг</i> ТСБТГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн гэрээт судлаач, <i>Судалгааны баг</i>
	М.Марал	
	С.Эрдэнэсүх	
	О.Мөнхзориг	
	М.Анхзаяа	
	Ц.Маралмаа	
	Д.Гантуяа	
	О.Отгонбаяр	
	А.Ганцэцэг	
	Г.Дониддагва	
	Р.Түшиг	
	М.Мөнх-Үйлс	
	Ц.Мөнхтуяа	
	Э.Цогбаяр	
	Ц.Базрагч	
С.Шинэцэцэг		
М.Чанцалсүрэн		
Н.Лхам		
Р.Нарантуяа		
Ц.Ананд		
Д.Хулан		
Төслийн зохицуулагч		
Нарийн бичгийн дарга нар:		

2. Тусгай зөвшөөрлийн процесс зураглал

Процесийн дугаар: 1	Гүйцэтгэх ажилтан: Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжлийн газрын агаарын хяналтын хэлтэстэй харьцах
Огноо: 2024.02.24	Хувилбар: 6
Хувиартай дугаар: V.04	Оролцогч тал: 8
Процесийн нэр: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйлдлийн процесс	Процесийг зохиосон хөгж: БОАМЯ

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ ХИЙСЭН: М.АНХЗАЯА


1. **Процессын нэр, дугаар:** 1. Нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах тусгай зөвшөөрөл
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Амьтны тухай хууль,
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас нийтлэг шаардлага гаргана.
3. **Оролцогч тал-8:**
 - Шинжлэх ухааны зөвлөл,
 - Конвенцид нэгдэн орсон улс,
 - Шинжлэх ухааны байгууллага,
 - Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын амьтны ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн,
 - Хуулийн хэлтэс,
 - Яамд,
 - Засгийн газар,
 - БОУАӨЯ-ны ажлын хэсэг.
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-16
 - Тус процесс нь 100% цаасаар явагдаж байна.
 - Хяналтын процесс: 6
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ:
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Өргөдөл, хүсэлт;
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3	Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар
4	Судалгаа хийх гэж байгаа газрын нэр, хаяг, байршил, хугацааг хүсэлт дээрээ тэмдэглэсэн байх
5	Судалгааны арга зүй
6	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
7	Гэрчилгээний үнэ төлсөн баримт

Процессын дугаар: 2	Гүйцэтгэх ажилтан: Байгалийн нөөцийн бодлогын сурталчилгээний газрын мэргэжилтэн Б.Хандармаа
Огноо: 2025.01.27	Хөнгөл: 5
Хувиарын дугаар: V.05	Оршил/Тайлбар: 6
Процессын нэр: Амьтан гадгаарийн гаралтай эд зүйлийг эхлүүлэх, илгэрлэх	Процессын гэржүүлсэн нэвч: BOYABR

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

- Эхлэл
- Төгсгөл
- Хөнгөл
- Цэвэр
- Цас
- Цас болон цэвэр



ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ ХИЙСЭН: Т.ЭНХБААТАР


1. **Процессын нэр, дугаар:** 2. Амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Амьтны тухай хууль,
 - БОАЖ-ын сайдын 2011 оны 5 дугаар сарын 02-ны А/44, ОУ-ын CETIS зөвшөөрөл
3. **Оролцогч тал-б:**
 - Бичиг хэрэг
 - Төрийн Нарийн бичгийн дарга
 - Газрын дарга
 - Мэргэжилтэн
 - Биологийн хүрээлэн
 - Нэг цэгийн үйлчилгээ
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-8
 - Тус процесс нь хүсэлт хүлээн авах нь цаас болон цахим хэлбэрийг хослуулан хийж байгаа бол үлдсэн 7 алхам нь 100% цаасан суурьтай явагдаж байна
 - Хяналтын процесс: 5
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ:
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Албан хүсэлт
2	Зориулалтын дагуу загас агнах эрх олгосон Засаг даргын захирамж
3	ААН, Засаг даргын хооронд байгуулсан гэрээ
4	Гарал үүслийн тодорхойлолт
5	Судалгааны арга зүй
6	Худалдан авагч талтай ААН байгуулсан гэрээ

Процессын дугаар: 3	Гүйцэтгэх ажилтан: Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжүүлэх газрын аймагны ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
Огноо: 2024.01.14	Хэлбэл: 3
Хувиартай дугаар: V.05	Оршилчлалт: 8
Процессын нэр: Аж, амьтны нөөцийн байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх	Процессын хариуцаж өгөх: БОУАЯА

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ


● Эхлэл
○ Төгсгөл
△ Хэнцэг
Цэвэр
Цахил
Цэвэр болон цахил



ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ ХИЙСЭН: М.АНХЗАЯА

1. **Процессын нэр, дугаар:** 3. Ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Амьтны тухай хууль,
 - Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоол
3. **Оролцогч тал-8:**
 - ААНБ
 - Сайд
 - Аймаг, нийслэлийн Засаг дарга
 - Орон нутгийн байгаль орчны хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн
 - Бичиг хэрэг
 - Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын амьтаны ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
 - Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
 - Нэг цэгийн үйлчилгээ
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-12
 - Тус процесс нь 79% нь цаас, 21% нь цахимаар явагдаж байна.
 - Хяналтын процесс: 3
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ: Able
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Аж ахуй нэгжийн танилцуулга
2	ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
3	Мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын дүгнэлт болон түүнээс үндэслэсэн Засаг даргын тодорхойлолт
4	Өргөдөл, хүсэлт
5	Тухайн чиглэлийн хүний нөөцтэй эсэх батлах лавлагаа
6	Аймаг, нийслэлийн Засаг даргын тодорхойлолт



1. **Процессын нэр, дугаар:** 4. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Зөвшөөрлийн тухай хууль
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
 - Хог хаягдлын тухай хууль
3. **Оролцогч тал-13:**
 - ААНБ
 - БОУАӨЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ-ын Уул уурхайн нөхөн сэргээлт, орчны бохирдлын мэргэжилтэн
 - УТҮГ-ын захирал
 - ХХМЗ-ийн нарийн бичиг
 - ХХМЗ-ийн дарга
 - Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Орчны бохирдлын хэлтсийн шинжээч
 - Газрын дарга
 - Хуулийн хэлтсийн дарга
 - ТЗУГ-ын дарга
 - ТНБДарга
 - Сайд
 - Бичиг хэрэг
 - Нэг цэг
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-39
 - Тус процесс нь 79% нь цаас болон цахим хосолсон бол үлдсэн 21% нь цахим суурьтай явагдаж байна.
 - Хяналтын процесс: 22
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ:
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Өргөдөл, хүсэлт;
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ
3	Газрын гэрчилгээ
4	Газрын гэрээ
5	Газрын кадастрын зургийн хуулбар
6	Тухайн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
7	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө;
8	Орон нутгийн цагдаагийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ
9	Орон нутгийн онцгой байдлын газартай аюул ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ;
10	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ.

1. **Процессын нэр, дугаар:** 5. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхлэх
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Зөвшөөрлийн тухай хууль
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
 - Хог хаягдлын тухай хууль
3. **Оролцогч тал-13:**
 - ААНБ
 - БОУАӨЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ-ын Уул уурхайн нөхөн сэргээлт, орчны бохирдлын мэргэжилтэн
 - УТҮГ-ын захирал
 - ХХМЗ-ийн нарийн бичиг
 - ХХМЗ-ийн дарга
 - Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Орчны бохирдлын хэлтсийн шинжээч
 - Газрын дарга
 - Хуулийн хэлтсийн дарга
 - ТЗУГ-ын дарга
 - ТНБДарга
 - Сайд
 - Бичиг хэргийн мэргэжилтэн
 - Нэг цэгийн мэргэжилтэн
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-31
 - Тус процесс нь 74.19% нь цаас болон цахим хосолсон бол үлдсэн 25.8% нь цахим суурьтай явагдаж байна.
 - Хяналтын процесс: 12
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ:
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Өргөдөл, хүсэлт;
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ
3	Газрын гэрчилгээ
4	Газрын гэрээ
5	Газрын кадастрын зургийн хуулбар
6	Тухайн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
7	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө;

1. **Процессын нэр, дугаар:** 6. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Зөвшөөрлийн тухай хууль
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
 - Хог хаягдлын тухай хууль
3. **Оролцогч тал-13:**
 - ААНБ
 - БОУАӨЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ-ын Уул уурхайн нөхөн сэргээлт, орчны бохирдлын мэргэжилтэн
 - УТҮГ-ын захирал
 - ХХМЗ-ийн нарийн бичиг
 - ХХМЗ-ийн дарга
 - Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Орчны бохирдлын хэлтсийн шинжээч
 - Газрын дарга
 - Хуулийн хэлтсийн дарга
 - ТЗУГ-ын дарга
 - ТНБДарга
 - Сайд
 - Бичиг хэргийн мэргэжилтэн
 - Нэг цэгийн мэргэжилтэн

4. **Процессын дүгнэлт**

- Нийт үйл ажиллагаа буюу алхам-39

Тус процесс нь 79% нь цаас болон цахим хосолсон бол үлдсэн 21% нь цахим суурьтай явагдаж байна.

- Хяналтын процесс: 22
- Хурал: 0
- Системийн хэрэглээ:

5. **Оролт буюу бүрдүүлбэр**


д/д	Бүрдүүлбэр
1	Өргөдөл, хүсэлт;
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ
3	Газрын гэрчилгээ
4	Газрын гэрээ
5	Газрын кадастрын зургийн хуулбар
6	Тухайн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
7	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө;
8	Орон нутгийн цагдаагийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ
9	Орон нутгийн онцгой байдлын газартай аюул ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ;
10	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллахаар байгуулсан гэрээ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

Процессын дугаар: 7	Гүйцэтгэх ажилтан: Хуралын гүйцэтгэл үйлдвэрийн хэлтэсийн дарга
Огноо: 2024.04.22	Хэмжээ: 10
Тусламжлагч дугаар: 1001	Эрхэмлэгч: 10
Процессын нэр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн үйлдвэр	Тусламжлагчийн нэр: БОУАЯА

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

- Эхлэл
- Төгсгөл
- X Хилээр
- Цэцэг Цэцэг
- Цэцэг Цэцэг
- Цэцэг Цэцэг



ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ ХИЙСЭН: Р. ТУШИГ

1. **Процессын нэр, дугаар:** 7. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх
2. **Хууль, дүрэм, журам:**
 - Зөвшөөрлийн тухай хууль
 - Байгаль орчныг хамгаалах тухай хууль
 - Байгаль орчинд нөлөөллөх байдлын үнэлгээний тухай хууль
3. **Оролцогч тал-12:**
 - ААНБ
 - Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн үйлдвэрлэл, үйлчилгээний төсөл хариуцсан мэргэжилтэн бөгөөд шинжээч
 - БОУАХ-ийн дарга
 - ХБОБХГ-ын дарга бөгөөд Ерөнхий шинжээч
 - Хуулийн хэлтсийн дарга
 - Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
 - ТЗУГ-ын дарга
 - Төрийн нарийн бичгийн дарга
 - Сайдын зөвлөх
 - Сайд
 - Нэг цэг
 - Сайдын туслах
4. **Процессын дүгнэлт**
 - Нийт үйл ажиллагаа буюу алхам-39
 - Тус процесс нь 83% нь цаас болон цахим хосолсон бол үлдсэн 17% нь цахим суурьтай явагдаж байна.
 - Хяналтын процесс: 10
 - Хурал: 0
 - Системийн хэрэглээ:
5. **Оролт буюу бүрдүүлбэр**

д/д	Бүрдүүлбэр
1	Өргөдөл, хүсэлт;
2	ААН-ийн үйл ажиллагааны танилцуулга;
3	Байгууллагын захирлын танилцуулга;
4	Байгууллагын захирлын НДШ төлөлтийн лавлагаа;
5	Үндсэн ажилчдын танилцуулга;
6	Үндсэн ажилчдын НДШ төлөлтийн лавлагаа/ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээ;
7	Гэрээт ажилчдын танилцуулга
8	Гэрээт ажилчдын НДШ төлөлтийн лавлагаа/ажилд томилсон тушаал;
9	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх судалгааны арга зүй;
10	Улсын гэрчилгээний хуулбар/түрээсийн гэрээ;
11	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газрын процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ

